


ХУУЛЬЧ БЭЛТГЭХ
ГАДААД ОРНУУДЫН
ТУРШЛАГА



АНУ, БНСУ, ХБНГУ



ХУУЛЬЧ БЭЛТГЭХ ГАДААД ОРНУУДЫН ТУРШЛАГА

Улаанбаатар хот
2021

ННА 67
ДАА 340
С-95



ХУУЛЬЧ БЭЛТГЭХ ГАДААД ОРНУУДЫН ТУРШЛАГА

АМЕРИКИЙН НЭГДСЭН УЛСЫН ХУУЛЬЧ БЭЛТГЭХ ТОГТОЛЦООНЫ ТАЛААРХ
ТОЙМ СУДАЛГАА

Судлаач: А.СЭРГЭЛЭНТУЯА

ХОЛБООНЫ БҮГД НАЙРАМДАХ ГЕРМАН УЛСЫН ХУУЛЬЧ БЭЛТГЭХ ТОГТОЛЦОО

Судлаач: Д.СҮНЖИД

МЭРГЭШСЭН ХУУЛЬЧ БЭЛТГЭХ БҮГД НАЙРАМДАХ СОЛОНГОС УЛСЫН
ТОГТОЛЦОО, ТҮҮНИЙ ХӨГЖЛИЙН ЧИГ ХАНДЛАГА

Судлаач: Ш.ЧУЛУУНБАТ

Тус тайлангийн үр дүн, санал зөвлөмж нь судлаачдын дүгнэлт бөгөөд
Нээлттэй Нийгэм Форумын албан ёсны байр суурийг илэрхийлэхгүй болно.

ISBN: 978-9919-9742-9-9

© Нээлттэй Нийгэм Форум, 2021

Хаяг: Жамьян гүний гудамж
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар-14240
Утас: 976-76113207
Вэб: <http://www.forum.mn>
И-мэйл: osf@forum.mn

ӨМНӨХ ҮГ

Шударга ёсны тогтолцоог бэхжүүлэхэд мэргэшсэн, ёс зүйтэй, хариуцлагатай хуульч бэлтгэх асуудал нэн чухал. Монгол Улс эрх зүйн бакалаврын хөтөлбөрөө шинэ эрх зүйн орчинд нийцүүлэн шинэчлэх, сургалтын арга зүй, чанарыг дээшлүүлэх, хуульчийн шалгалт, давтан сургалтын тогтолцоог бүрдүүлэх зэрэгт ихээхэн анхаарч ирсэн хэдий ч хуульч бэлтгэх тогтолцоог улам бүр төгөлдөржүүлэх хэрэгцээ шаардлага тулгамдсан хэвээр байна.

Хуульч бэлтгэх тогтолцооны шинэчлэлийн асуудлыг хөндөж буй энэ цаг үед судалгаа шинжилгээний ач холбогдол өндөр хэмээн үзэж Нээлттэй Нийгэм Форумас санаачлан манай улсын хуульчид бакалаврын дараах хөтөлбөрт нь өргөнөөр хамрагддаг гадаадын зарим улсын хуульч бэлтгэх тогтолцоог сонирхон судалснаа эмхэтгэн Танд толилуулж байна. Үүнд АНУ-ын туршлагыг судлаач А.Сэргэлэнтуяа (LL.M), БНСУ-ын туршлагыг доктор, дэд профессор Ш.Чулуунбат, ХБНГУ-ын туршлагыг доктор Д.Сүнжид нар судаллаа. Эдгээр судалгааны хүрээнд хуульч болох үе шат, хуулийн сургуульд элсэн суралцахад тавигдах шаардлага, хичээлийн хөтөлбөр, кредит цаг, сургуулийн магадлан итгэмжлэл, хуульчийн шалгалтын агуулга, бүтэц зэрэг нийтлэг асуудлыг улс бүрээр авч үзсэн болно.

Нээлттэй Нийгэм Форум манай улсад өрнөж буй Эрүүгийн эрх зүйн шинэчлэлийг бодлогын судалгаа, мониторингоор дэмжихийг зорьж ирсэн бөгөөд эдүгээ 30 орчим судалгаа олны хүртээл болоод байна. Мөн бид дээрх судалгааны үр дүнг олон нийтэд танилцуулах, бодлого шийдвэрт тусгуулах зорилгоор цуврал хэлэлцүүлэг эхлүүлээд байгаа бөгөөд хэлэлцүүлгийн видео бичлэгийг манай байгууллагын цахим хуудас, нийгмийн сүлжээнээс олж үзэх боломжтойг дуулгахад таатай байна.

ННФ-ын Гүйцэтгэх захирал П. Эрдэнэжаргал

АГУУЛГА

АМЕРИКИЙН НЭГДСЭН УЛСЫН ХУУЛЬЧ БЭЛТГЭХ ТОГТОЛЦООНЫ ТАЛААРХ ТОЙМ СУДАЛГАА	1-54
МЭРГЭШСЭН ХУУЛЬЧ БЭЛТГЭХ БҮГД НАЙРАМДАХ СОЛОНГОС УЛСЫН ТОГТОЛЦОО, ТҮҮНИЙ ХӨГЖЛИЙН ЧИГ ХАНДЛАГА	55-122
ХОЛБООНЫ БҮГД НАЙРАМДАХ ГЕРМАН УЛСЫН ХУУЛЬЧ БЭЛТГЭХ ТОГТОЛЦОО	123-170

АМЕРИКИЙН НЭГДСЭН УЛСЫН
ХУУЛЬЧ БЭЛТГЭХ ТОГТОЛЦООНЫ
ТАЛААРХ ТОЙМ СУДАЛГАА

А.СЭРГЭЛЭНТУЯА (LL.M)

ТАЛАРХАЛ

Энэхүү тойм судалгааг бэлтгэхэд бүхий л талын дэмжлэг, туслалцаа үзүүлсэн Нээлттэй Нийгэм Форумд талархлаа илэрхийлье.

ГАРЧИГ

Нэг. УДИРТГАЛ	5
Хоёр. ХУУЛЬЧ БОЛОХ ҮЕ ШАТ	8
2.1. Боловсролын шаардлага	10
2.2. Мэргэжлийн хариуцлагын шаардлага.....	12
2.3. Зан байдал, тохирох байдлын шаардлага.....	13
2.4. Хуульчийн шалгалт	14
Гурав. ХУУЛИЙН СУРГУУЛЬ	19
3.1. Хуулийн сургуульд элсэн суралцагчдад тавих шаардлага	23
3.2. Хуулийн сургуулийн элсэлтийн шалгалт	23
3.3. Сургалтын хөтөлбөр, зохион байгуулалт	26
3.4. Дадлага туршлага олгох сургалт: Загвар сургалт, хууль зүйн клиник, дадлагын сургалт	29
3.5. Сургалтын кредит цаг, хугацааг тооцох	31
3.6. Сургалтын хөтөлбөрийн санхүүжилт	32
3.7. Зайн сургалт	32
3.8. Багшлах бүрэлдэхүүн	33
3.9. Хуулийн сургуулийн захиргаа	35
3.10. Мэдээллийн ил тод байдал	35
3.11. Хуулийн сургуулийн номын сан	36
3.12. Сургалтын бааз, тоног төхөөрөмж	38
3.13. Хуульчийн шалгалтад тэнцсэн байдал	38
3.14. Хуулийн сургуулийн хүлээх хариуцлага	39

3.15. Хуулийн сургуулийг магадлан итгэмжлэх эрх бүхий байгууллага	40
3.16. Хуулийн сургуулийн магадлан итгэмжлэл	41
3.17. Магадлан итгэмжлүүлэх тухай хүсэлт гаргах	42
3.18. Магадлан итгэмжлэл хийх үйл явц	43
3.19. Хөтөлбөр, бүтэц зохион байгуулалтад өөрчлөлт оруулах	44
3.20. Салбар кампус байгуулах, өөр байршилд сургалт явуулах	45
 Дөрөв. ДҮГНЭЛТ: МОНГОЛ УЛСАД ХЭРЭГЖҮҮЛЖ БОЛОХУЙЦ ТУРШЛАГА	 47
4.1. Хуульч болох үе шат, үйл явц	47
4.2. Хуулийн сургууль	49
 АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ	 52

Нэг. УДИРТГАЛ

Үндсэн хуульт ардчилал, хууль дээдлэх ёс, чөлөөт зах зээлийн эдийн засгийн тогтолцоог бэхжүүлэх; хүний эрх, эрх чөлөөг хамгаалахад хуульчийн үүрэг, оролцоо чухал. Хуульчид мэдлэг, ур чадвараа бүрэн дайчилж мэргэжлийнхээ үнэт зүйлс, ёс зүйг ухамсарлаж ажилласнаар энэхүү үүрэг оролцоо нь биелдэг. Сайн хуульч бэлтгэн гаргах тогтолцоо нь олон хүчин зүйлээс хамааралтай боловч хамгийн чухал нь мэргэшсэн, чадварлаг, ёс зүйтэй хуульчдыг бэлтгэн гаргахад анхаарах явдал юм.

Монгол Улс ардчилсан тогтолцоонд шилжсэнээс хойш эрх зүйн шинэтгэлийн хүрээнд хууль зүйн мэргэжилтэн бэлтгэх чиглэлээр багагүй ажил хийгдсэн ба үүнд эрдэмтэн судлаач, хуульч, бодлогын шийдвэр гаргагч, хууль зүйн их, дээд сургууль, багш, оюутны тодорхой хүчин чармайлт оржээ. Тухайлбал, эрх зүйч мэргэжилтнийг төрийн болон хувийн хэвшлийн сургуулиудад бэлтгэн гаргах болж,¹ хуульчийн сонгон шалгаруулалт, мэргэшлийн шалгалтын тогтолцоог бүрдүүлэн, хуульчийн мэргэжлийн өөрөө удирдах ёсыг төлөвшүүлэх талаар арга хэмжээ авч хэрэгжүүлэн, мэргэжлийн хариуцлагын тогтолцоог зарим талаар бэхжүүлсэн зэрэг үйл ажиллагааг дурдаж болно.

Гэсэн хэдий ч аливаа шинэтгэлийн үйл явцыг тасралтгүй үргэлжлүүлж, бодит үр дүнг хүртэх нь чухал юм. Хууль зүйн ухааны доктор Б.Чимид бүтээлдээ “...эрх зүйн шинэтгэлийн тусагдахууны талаар таван үндсэн чиглэл баримтлах ёстой” гээд “...хууль тогтоомжийг шинэтгэх, хууль тогтоох, хуулийн гүйцэтгэлийг хангах, хууль хэрэглэх тогтолцоо, арга

¹ 2017-2019 оны байдлаар авч үзвэл жилд дунджаар 2,200 гаруй оюутан эрх зүйч мэргэжлээр их, дээд сургууль төгсдөг бөгөөд энэ нь дээд боловсролын байгууллагын нийт төгсөгчийн 10 орчим хувь юм. Суралцагчдын тоогоор авч үзвэл дунджаар 12,100 орчим бөгөөд энэ нь нийт оюутны 8-10 хувийг эзэлж байна. Үндэсний статистикийн хороо, Статистикийн мэдээллийн нэгдсэн сан http://www.1212.mn/tables.aspx?tbl_id=DT_NSO_2001_014V1&A1_select_all=0&A1SingleSelect=_104_1&YearY_select_all=0&YearYSingleSelect=_2019_2018_2017&viewtype=table

ажиллагааг шинэтгэх, хууль зүйн мэргэжлийн боловсролыг шинэтгэх, хууль зүйн эрдэм шинжилгээний ажлын зохион байгуулалт, арга зүйг шинэтгэх, нийгэмд эрх зүйн шинэ ухамсар төлөвшүүлэх” зэргийг дурджээ.²

Сүүлийн гурван жилийн байдлаар авч үзвэл Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуульд заасны дагуу жил бүр хуульчийн мэргэжлийн шалгалтад 1,200 гаруй эрх зүйч оролцдог ооос дунджаар 17-23 хувь нь тэнцдэг байна.³ Хууль зүйн бакалаврын түвшний сургалтад “Эрх зүйч” мэргэжлийн D380100 индекстэй, MNS 5323-39:2007 дугаар бүхий стандарт⁴ 2008 оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс мөрдөгдөж эхэлсэн. Гэвч Монголын хуульчдын холбооноос 2016 онд хийсэн судалгаагаар уг стандартын хэрэгжилт сургуулиудад харилцан адилгүй байгаа бөгөөд хангалтгүй дүн гарчээ.⁵ Дээрх нөхцөл байдал нь хуульч бэлтгэж буй өнөөгийн байдал, ялангуяа хууль зүйн дээд боловсрол, хуульчийн шалгалтын өнөөгийн тогтолцоог судалж, үнэлэлт дүгнэх өгөх шаардлага байгааг харуулж байна.

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 онд хэрэгжүүлэх мөрийн хөтөлбөрт хуульчийн мэргэжлийн болон үргэлжилсэн сургалт, хууль зүйн чиглэлийн дээд боловсролын сургалтын байгууллагын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийг зохион байгуулах чиг үүргийг хэрэгжүүлэх, хуульчдын мэргэжлийн өөрөө удирдах ёсны байгууллагыг бэхжүүлэх талаар тусгасан.⁶ Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуульд Монголын хуульчдын холбоо нь Дээд боловсролын тухай хуульд заасан

² Б.Чимид, “Төр, нам, эрх зүйн шинэтгэлийн эгзэгтэй асуудал”, Хоёрдугаар дэвтэр, УБ., 2008, 16 дахь тал.

³ Үндэсний статистикийн хороо, Статистикийн мэдээллийн нэгдсэн сан https://www.1212.mn/tables.aspx?tbl_id=DT_NSO_2300_037V5&CR008_select_all=0&CR008SingleSelect=_2_3&YearY_select_all=0&YearYSingleSelect=_2020_2019_2018&viewtype=table

⁴ Стандартчилал, хэмжил зүйн үндэсний зөвлөлийн 2007 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн 36 дугаар тогтоолоор батлагдсан. <https://estandard.gov.mn/standard/reader/5128#0-mqmkjpyoynwqwmic.jpg>

⁵ П.Нарантуяа, “Хууль зүйн боловсролын тогтолцоонд шинэ стандарт үйлчилнэ” (Ярилцлага), Монголын Хуульчдын холбоо, 2017, <https://www.mglbar.mn/news/2450>

⁶ Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.4.3, <https://www.legalinfo.mn/annex/details/11219?lawid=15586>

шаардлагаас гадна хууль зүйн боловсролын зохистой хөтөлбөрийн стандарт, хууль зүйн сургуулийн багшлах бүрэлдэхүүн, боловсролын орчин, оюутны заавал эзэмшсэн байх мэдлэг, ур чадварын стандарт зэргийг баталж мөрдүүлэхээр, хууль зүйгээр сурч буй оюутан 120 кредит цагийн сургалтыг дүүргэсэн байх, магадлан итгэмжлэлийг зургаан жил тутамд явуулахаар тус тус заасан байна.⁷

Энэхүү тойм судалгаа нь дээрх хууль тогтоомжийг хэрэгжүүлж, хууль зүйн сургуулийг магадлан итгэмжлэх, хяналт тавих, хуульчийн мэргэжлийн шалгалт зохион байгуулах зэрэг үйл ажиллагаанд холбогдох бодлого, дүрэм, журмын төсөл боловсруулахад мэдээлэл өгөх, эх сурвалж болох юм. Уг судалгаагаар АНУ-ын хууль бэлтгэх тогтолцоо нь Монгол Улсын эрх зүйн болон дээд боловсролын тогтолцоонд тохирох эсэх талаар аливаа үнэлэлт, дүгнэлт өгөхгүй. Харин цаашид хууль зүйн дээд боловсролын бакалаврын зэрэг олгож буй өнөөгийн сургалтын тогтолцоог цогцоор судалж үнэлэлт дүгнэлт хийх, төрийн болон хувийн өмчийн сургуулиуд нь хуульчийн мэргэжлийн зорилго, зорилтыг хангахуйц чанартай эрх зүйчдийг бэлтгэж чадаж байгаа эсэх, түүнд бодитой үнэлгээ, дүгнэлт хийдэг эсэх, хуульчийн мэргэжлийн шалгалтыг үр дүнтэй зохион байгуулдаг эсэх талаар тухайлсан судалгааны эх сурвалж болгон ашиглах боломжтой. Нэмж дурдахад эдгээр асуудлыг жич судлах хэрэгцээ шаардлага байгаа нь энэхүү судалгааг хийх явцад ажиглагдсан болно.

Уг тойм судалгаагаар АНУ-ын хуульч бэлтгэх тогтолцоо, хууль зүйн мэргэжлийн зэрэг олгодог сургалт, түүний сургалтын хөтөлбөр, магадлан итгэмжлэл, хуульчийн шалгалт, түүний агуулга, тэдгээрт холбогдох зохицуулалтын талаар танилцуулж, Монгол Улсад хэрэгжүүлж болохуйц зарим туршлагыг санал болгоно.

⁷ Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2.1-58.2.4, 58.7.

Хоёр. ХУУЛЬЧ БОЛОХ ҮЕ ШАТ

Дэлхийн улс орнууд хуульч бэлтгэх өөрийн гэсэн онцлогтой тогтолцоог хөгжүүлжээ. АНУ-ын хувьд муж бүр хуульч бэлтгэх өөрийн уламжлал, онцлог бүхий эрх зүйн тогтолцоотой тул тэдгээр нь харилцан адилгүй байдаг. Жишээ нь, боловсролын хувьд тавигдах шаардлагыг авч үзвэл ихэнх муж хууль зүйн мэргэжлийн зэрэг (*Juris Doctor*) эзэмшсэн байхыг шаарддаг бол зарим мужид үүнээс гадна гадаадын улс оронд хууль зүйн дээд боловсрол эзэмшсэн эсхүл практикийн хуульчийн удирдлага дор тодорхой хугацаанд дадлагажиж ажиллан, суралцсан хүнд хуульчийн шалгалт өгөх эрх нь нээгдэнэ.

Мөн Барын холбоо (*Bar Association*)-ны эрх зүйн байдлын хувьд муж бүр харилцан адилгүй зохицуулалттай. Тухайлбал, Нью-Йоркийн, Аризонагийн, Арканзасын, Колорадогийн, Делаверын Барын холбоод, мөн Америкийн болон Виржиниагийн Барын холбоод зэрэг нь сайн дурын гишүүнчлэлтэй, хувийн эрх зүйн хуулийн этгээд байдаг. Эдгээр Барын холбоо гишүүдийнхээ нийгмийн асуудалд анхаарах, мэргэжлийн хөгжлийг нь дэмжих, тодорхой лобби үйл ажиллагаа явуулах зэрэг чиглэлээр ажилладаг. Харин Виржиниа, Алабама, Аляск, Жиоржиа муж болон Колумбиагийн дүүргийн Бар нь заавал гишүүнчлэлтэй, хуульчдад мэргэжлийн дүрэм, ёс зүйн хяналт тавьж хариуцлага тооцдог нийтийн эрх зүйн шинжтэй субъект байдаг.⁸ Цаашилбал Техас мужийн Бар нь тус мужийн Дээд шүүхийн харьяанд ажилладаг. Сайн дурын гишүүнчлэлтэй Барын холбоо бүхий мужуудын хувьд мужийн Дээд шүүх нь холбогдох дүрэм, журмаа батлан гаргах, хэрэгжүүлэх зэрэг чиг үүргийг хэрэгжүүлдэг.⁹ Жишээ нь, Нью-Йорк мужид Давж заалдах шүүхийн харьяа Нью-Йорк мужийн хуульчийн шалгалтын зөвлөл нь хуульчийн шалгалтыг зохион байгуулдаг бол хуульчдын сахилга

⁸ Lawyer Legion, State Bar Associations
<https://www.lawyerlegion.com/associations/state-bar>

⁹ National Conference of Bar Examiners, Comprehensive Guide to Bar Admission Requirements
<https://reports.ncbex.org/comp-guide/charts/chart-1/#1610142352111-e56b1dc2-06b5>

хариуцлагын асуудлыг нь тус шүүхийн харьяа хороод хариуцдаг ажээ.¹⁰

Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа явуулах эрхтэй болсон нь Холбооны шүүх (*Federal Court*)-д шууд төлөөлөх эрх үүсгэхгүй. Үүний зэрэгцээ тухайн мужид ажиллах эрхтэй хуульч өөр мужийн дүүргийн шүүхэд төлөөлж оролцох тохиолдолд зөвшөөрөгдсөн байх шаардлага тавигддаг. Зарим мужийн шүүх тусгайлсан сургалтад хамруулсны дараа уг зөвшөөрлийг олгодог.

Дээрх нөхцөл байдлаас хамаараад хуульчаар ажиллахыг зөвшөөрөх байдал нь харилцан адилгүй байна. Холбооны дүүргийн шүүхийн 60 гаруй хувь буюу 56 нь тухайн шүүх байрлаж буй мужид хуульчаар ажиллахад эрх авсан байхыг шаарддаг. Харин 40 гаруй хувь буюу 39 дүүргийн шүүх тодорхой нөхцөлтэйгөөр өөр мужид ажиллах зөвшөөрөл авсан хуульч шүүхийн өмнө төлөөлөхийг зөвшөөрдөг. Үүнээс 13 дүүргийн шүүх АНУ-ын аль нэг мужид зөвшөөрөлтэй хуульчийг хүлээн зөвшөөрдөг.¹¹ Жишээ нь, Канзас мужийн дүүргийн шүүх зөвхөн тухайн мужид болон Миссури мужийн Баруун дүүргийн шүүхэд төлөөлөх эрхтэй хуульчийг зөвшөөрдөг.¹² Колумби мужийн дүүргийн шүүх тухайн хуульчийн тогтвортой суурьшин ажиллах газрын байршлыг нь харгалзан үздэг¹³ бол Нью-Йоркийн хойд дүүрэг, Коннектикут, Винсконсин мужийн зүүн дүүрэгт харьцангуй уян хатан буюу аль нэг мужид хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа явуулах эрхтэй байхыг шаарддаг байна.¹⁴

Муж улсуудын ялгаатай нөхцөл байдлаас үл хамааран хуульч болох, хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авахад нийтлэг тавигддаг шаардлага болох боловсрол (*Legal Education*), мэргэжлийн хариуцлагын шалгалт (*Professional Responsibility Exam*), хувь хүний зан байдлын шаардлага (*Character and Fitness Requirement*), хуульчийн шалгалт (*Bar Exam*)-ын талаар дараах хэсэгт авч үзнэ.

¹⁰ Нью-Йорк мужийн давж заалдах шатны шүүхийн албан ёсны цахим хуудас <http://ww2.nycourts.gov/attorneys>

¹¹ Survey of Admission Rules in Federal District Courts (PDF), U.S. District Court for the District of Maryland, 2015.

¹² Мөн тэнд, 8 дахь талд.

¹³ Мөн тэнд, 9 дэх талд.

¹⁴ Мөн тэнд, 11 дэх талд.

2.1. БОЛОВСРОЛЫН ШААРДЛАГА

Боловсролын хувьд дийлэнх муж хуульчийн үйл ажиллагаа явуулах эрхтэй болоход хууль зүйн мэргэжлийн дээд боловсролын зэрэг (J.D.)-тэй байхыг шаарддаг бөгөөд уг зэргийг Америкийн Барын холбооноос магадлан итгэмжлэгдсэн хуулийн сургуульд суралцаж авсан байх ёстой.¹⁵

Түүнчлэн Нью-Йорк зэрэг зарим мужид гадаад улсад хууль зүйн дээд боловсрол эзэмшсэн хүнийг шалгалт өгөхийг зөвшөөрдөг бөгөөд үүний тулд тухайн эзэмшсэн боловсрол нь хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа явуулахад тавигддаг шаардлагыг хангаж байгаа эсэх, суралцсан хөтөлбөр нь магадлан итгэмжлэгдсэн эсэх, хугацааны хувьд тус улсад тавигдаж буй шаардлагыг хангасан эсэх, агуулгын хувьд нийтлэг эрх зүйд суурилсан бөгөөд тус улсын хуулийн сургуулиудад үздэг хичээлтэй дүйцэхүйц эсэхэд тухайлан дүгнэлт гаргаж, шалгалтад оруулах эсэхийг шийддэг.¹⁶ Зарим тохиолдолд тус улсын магадлан итгэмжлэгдсэн сургуульд хууль зүйн магистрын зэргийн сургалтад хамрагдсан байхыг шаарддаг байна.

Калифорни, Виржиниа, Баруун Виржиниа зэрэг мужид гадаад улсад суралцсан хуульч эсхүл хууль зүйн мэргэжлийн зэргээр суралцаагүй боловч практикийн хуульчийн удирдлага дор ажиллан суралцсан болон тухайн мужийн Барын холбооноос магадлан итгэмжлэгдсэн сургуульд дөрвөн жилийн хугацаанд суралцсан хуульч шалгалт өгөх боломжтой.^{17,18}

Америкийн эрх зүйн тогтолцооны нэг онцлог нь хуульчийн шалгалт өгөх эсхүл Барын холбоонд гишүүнээр элсэхийн өмнө ямар нэг мэргэжлийн дадлага эсхүл клиник сургалтад хамрагдсан байхыг шаарддаггүй. Зөвхөн Делавер мужид хуульчийн шалгалт өгөхийн өмнө практикийн хуульчийн хяналт дор шүүхэд дадлагажих шаардлага

¹⁵ Law School Admission Council, “Thinking About Law School?” (PDF), p. 4, Archived from the original (PDF) on November 3, 2010, Retrieved October 29, 2010.

¹⁶ New-York State Board of Law Examiners, Foreign Law Education <https://www.nybarexam.org/foreign/foreignlegaleducation.htm>

¹⁷ The State Bar of California, Admissions <https://www.calbar.ca.gov/Admissions/Requirements/Education>

¹⁸ <https://barexam.virginia.gov/>

тавигддаг. Уг дадлага нь таван сар буюу 21 долоо хоногийн хугацаатай.¹⁹

Дийлэнх мужид хууль зүйн мэргэжлийн зэрэг авахын өмнө ямар нэг мэргэжлээр бакалаврын зэрэг авсан байхыг шаарддаг бол Калифорни, Мичиган, Миссисипи, Хойд Каролина зэрэг зарим мужид бакалаврын зэргийн болон өмнө хамрагдсан байвал зохих сургалтын хугацаа, кредит зэрэгт тодорхой шалгуур тавьжээ.²⁰ Хууль зүйн мэргэжлийн зэргийн сургалтын талаар дараагийн бүлэгт дэлгэрэнгүй авч үзнэ.

Мөн Калифорни, Мэйн, Нью-Йорк, Виржиниа, Вермонт, Вашингтон, Баруун Виржиниа зэрэг мужид практикийн хуульчийн удирдлага дор ажиллаж тодорхой туршлага хуримтлуулсан бол хуульчийн шалгалт өгөх боломжтой.²¹ Энэ нь хуулийн сургууль байгуулагдаагүй байх үед хууль зүйн боловсролыг хуулийн фирм, оффист дагалдан ажиллаж олж авдаг байсан уламжлалтай холбоотой.

Эдгээрээс Нью-Йорк мужийн зохицуулалтыг жишээ болгон авч үзвэл шалгалт өгч буй иргэн нь магадлан итгэмжлэгдсэн хуулийн сургуульд нэг жил суралцаж 28-аас доошгүй кредит цагийн сургалтад хамрагдсан, 18 насанд хүрснийхээ дараа дадлагын сургалтаа эхлүүлсэн, сургуулиас ямар нэг анхааруулга аваагүй, Нью-Йорк муж дахь хуулийн оффист нэг болон хэд хэдэн практикийн хуульчийн удирдлага дор 36 сарын хугацаанд хуульчийн ажлаар дадлагажиж суралцсан бол шалгалт өгөх эрхтэй болдог байна.²² Сургалтын агуулгын хувьд байнгын орон тоонд нарийн бичиг, дадлагажигч зэрэг хэлбэрээр ердийн ажлын цагаар ажилласан, хуулийн сургуульд заадаг агуулгын хэмжээнд зааварчилгаа авсан байхыг шаарддаг.²³

¹⁹ Уг дадлагыг хуулийн оффис, шүүхэд эсхүл мужийн хууль зүйн газар, улсын өмгөөлөгчийн газар, прокурорын газар, хууль зүйн туслалцааны төв зэрэг нийтийн байгууллагад хийх боломжтой. The Supreme Court of Delaware, Rules of the Supreme Court of the State of Delaware, Rule 52(8)

<https://www.courts.delaware.gov/rules/pdf/SupremeCourtRules-July2021.pdf>

²⁰ National Conference of Bar Examiners, Comprehensive Guide to Bar Admission Requirements, 2020

https://www.ncbex.org/pdfviewer/?file=%2Fassets%2FBarAdmissionGuide%2FCompGuide2020_021820_Online_Final.pdf

²¹ Мөн тэнд, 9-10 дахь талд.

²² Rules of the Court of Appeals for the Admission of Attorneys and Counselors at Law, 520.4 (a), <https://www.nybarexam.org/Rules/Rules.htm#520.4>

²³ Мөн тэнд, 520.4 (b).

2.2. МЭРГЭЖЛИЙН ХАРИУЦЛАГЫН ШААРДЛАГА

Висконсин, Пуэрто-Рикоогоос бусад бүх мужид Мэргэжлийн хариуцлагын муж хоорондын шалгалт²⁴ өгсөн байх шаардлага тавьдаг. Барын шалгагчдын Үндэсний конференц хэмээх байгууллага тус шалгалтыг жилд гурван удаа зохион байгуулдаг байна. Шалгалтад оролцогч нь олон хариулттай нийт 60 гаруй асуултыг хоёр цагийн хугацаанд бөглөдөг. Тэнцэх оноо нь мужуудаар ялгаатай бөгөөд 75-86 хувиар тогтоодог. Оноог зөв хариултын тоогоор тооцно.

Агуулгын хувьд хуульчийн мэргэжлийн дүрэм (6-12%), хуульч-үйлчлүүлэгч хоорондын харилцаа (10-16%), үйлчлүүлэгчийн нууц хадгалах (6-12%), ашиг сонирхлын зөрчил (12-18%), мэргэжлийн чадвар, зохисгүй байдал, хуульчийн хүлээх иргэний эрх зүйн хариуцлага (6-12%), шүүхэд төлөөлөх болон өмгөөллийн бусад үйл ажиллагаа (10-16%), үйлчлүүлэгчээс бусад этгээдтэй харилцах, хэлцэл хийх (2-8%), бусад үйл ажиллагаанд оролцох (4-10%), үйлчлүүлэгчийн болон бусдын хөрөнгийг итгэмжлэн хадгалах, бусад өмч хөрөнгийн харилцаа (2-8%), хууль зүйн үйлчилгээнд бусадтай харилцах (4-10%), хуульчийн олон нийтийн өмнө болон эрх зүйн тогтолцооны өмнө хүлээх үүрэг (2-4%), шүүгчийн сахилга, ёс зүй (2-8%) зэрэг байна.^{25,26} Хуульчийн эрх авах хүсэлт гаргахаасаа өмнө дээрх шалгалтыг өгсөн байх бөгөөд зарим мужид шалгалт өгснөөс хойш таван жилийн хугацаанд уг шалгалтын дүнг хүчинтэйд тооцдог.²⁷

Сорилыг бэлтгэхдээ Үндсэн хуулийн жишиг тогтоосон шийдвэр, холбооны болон мужийн нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн зарчим, процессын хэм хэмжээ, Америкийн Барын холбооноос гаргасан Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагааны загвар дүрэм, Шүүгчийн ёс

²⁴ Англ., Multistate Professional Responsibility Examination (MPRE).

²⁵ National Conference of Bar Examiners, Jurisdictions Requiring the MPRE <https://www.ncbex.org/exams/mpre/>

²⁶ National Conference of Bar Examiners, MPRE Subject Matter Outline, 2013 <https://www.ncbex.org/pdfviewer/?file=%2Fdmsdocument%2F2>

²⁷ National Conference of Bar Examiners, Comprehensive Guide to Bar Admission Requirements, 2020, p. 26 https://www.ncbex.org/pdfviewer/?file=%2Fassets%2FBarAdmissionGuide%2FCompGuide2020_021820_Online_Final.pdf

зүйн загвар дүрэм гэх мэт нийтлэг шинжтэй баримт бичгийг эш үндэс болгодог. Асуултын хувьд жижиг тохиолдол байх бөгөөд оролцогч уг тохиолдолтой сайтар танилцсаны эцэст өөрийн зөв гэж үзсэн нэг болон хэд хэдэн хариулт сонгоно.²⁸ Уг шалгалтыг ихэнх тохиолдолд оролцогч хуулийн сургуульд хуульчийн мэргэжлийн хариуцлагын хичээл үзсэнийхээ дараа өгдөг байна.

2.3. ЗАН БАЙДАЛ, ТОХИРОХ БАЙДЛЫН ШААРДЛАГА

Ихэнх мужид хуульч болоход өндөр ёс суртахуунтай байхыг шаарддаг бөгөөд энэ үүднээс шалгуулагчийг хүнийх нь хувьд судалж үздэг. Нийт 51 мужаас 41-д нь хуульч болох хүний зан байдлын тодорхой стандартыг зааж өгчээ.²⁹ Тухайлбал, дөрвөн мужид өмнө нь хүнд гэмт хэрэгт ял шийтгэгдсэн бол хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх боломжгүй.³⁰ Зан байдлын шалгуур тавьдаг мужуудаас Калифорнийн туршлагыг сонгож судалсан бөгөөд тус муж нь ёс суртахууны төлөвшлийг зургаа хүртэлх сарын хугацаанд судалдаг байна. Уг судалгаа урт хугацаанд үргэлжилдэг учраас оролцогч нь хуулийн сургуульд суралцаж байх хугацаандаа хүсэлтээ өгч болдог ажээ.

Калифорни мужийн Барын дүрмийн 4.40-д “ёс суртахууны сайн чанар” гэдэгт чигч, шударга, итгэл даахуйц, хариуцлагатай, хуульд хүндэтгэлтэй хандаж сахидаг, бусдын эрх болон шүүхийн процессыг хүндэтгэдэг байх гэж заасны дагуу мужийн Барын холбооноос оролцогчийн түүхийг дээрх чиглэлээр судалдаг.³¹ Ийнхүү судлахдаа оролцогч баривчлагдаж эсхүл яллагдагчаар татагдаж байсан эсэх, сургуулийн академик

²⁸ Жишээ сорилыг англи хэлээр дараах эх сурвалжаас үзнэ үү.
<https://www.ncbex.org/pdfviewer/?file=%2Fdmsdocument%2F3>

²⁹ National Conference of Bar Examiners, Comprehensive Guide to Bar Admission Requirements, 2020, p. 5-6.
https://www.ncbex.org/pdfviewer/?file=%2Fassets%2FBarAdmissionGuide%2FCompGuide2020_021820_Online_Final.pdf

³⁰ Мөн тэнд.

³¹ The State Bar of California, Factors and Conduct Relevant to a Moral Character Determination
<https://www.calbar.ca.gov/Admissions/Moral-Character/Factors-and-Conduct>

дүрэм, журмыг зөрчсөн эсэх, өр төлбөрт орсон³² эсхүл санхүүгийн хариуцлагагүй байдал, дампууралд орж байсан эсэх, донтолт, сэтгэцийн эмгэгтэй эсэх, бэлгийн зүй бус үйлдэл хийж байсан эсэх, иргэний хэрэгт хариуцагчаар орсон эсэх, тээврийн хэрэгсэл жолоодохдоо гаргаж байсан зөрчил зэрэг өргөн хүрээг хамруулан шалгалт хийдэг байна.³³

Сүүлийн жилүүдэд хуулийн сургуулийн төлбөр өндөр, оюутнууд нь сургалтын зээлээр төлбөрөө төлдөг болсны улмаас их хэмжээний өр төлбөрт орох болсон байна. Үүний улмаас энэхүү шалгалтаар тухайн оролцогчийн санхүүгийн чадавхыг анхаардаг болсон. Тухайлбал, 2020 онд Охио мужийн дээд шүүхээс нэгэн оролцогчийг өөрөө 300,000, түүний нөхөр 600,000 ам.доллар тус тус, нийтдээ 900,000 ам.долларын сургалтын өр төлбөртэй, түүнийгээ төлөх талаар хүчин чармайлт гаргаагүй, төлөх эрмэлзэлгүй болохыг өөрийнх нь өгсөн мэдүүлэг зэрэгт үндэслэн тогтоон, санхүүгийн сахилга батгүй хэмээн үзэж, хуульчийн эрх олгоогүй байна.³⁴

2.4. ХУУЛЬЧИЙН ШАЛГАЛТ

АНУ-ын ихэнх мужид хуульчийн эрх авахаар горилогчид хуульчийн шалгалт өгсөн байх шаардлага тавигддаг. Зөвхөн Висконсин мужид магадлан итгэмжлэгдсэн сургуулийг төгссөн тохиолдолд дипломын давуу эрх (*Diploma privilege*)-тэй гэж үзэн, хуульчаар ажиллахыг шууд зөвшөөрдөг байна.³⁵ Энэ нь тус улсад хуулийн сургуулиуд дөнгөж байгуулагдаж байсан 1870-1920-иод оны үед хуулийн сургууль төгссөн нь хуульчаар ажиллах шууд нөхцөл болж байсан уламжлалтай

³² Өр төлбөрт орж байсан нь дангаараа дээрх шаардлагыг хангахгүй гэж үзэхэд хүргэхгүй. Харин хайхрамжгүйгээсээ төлбөрийн чадваргүй байдалд хүрсэн эсхүл төлбөр авагчдыг хууран мэхлэх үүднээс дампуурсан эсхүл итгэмжлэн хариуцсан өмч хөрөнгийг залилсан зэрэг нь уг шаардлагыг хангахгүй гэж үзэхэд хүргэдэг байна, мөн тэнд.

³³ Мөн тэнд.

³⁴ Adam S. Minsky, Court Cites Student Loans As Reason To Deny Bar Admission To New Lawyer, *Forbes*, Jan 23, 2020.
<https://www.forbes.com/sites/adamminsky/2020/01/23/court-denies-bar-admission-to-new-lawyer-due-to-student-loans/?sh=3fb76b09548f>

³⁵ Wisconsin Court System, *Diploma Privilege*
<https://www.wicourts.gov/services/attorney/bar.htm>

холбоотой. 1921 онд Америкийн Барын холбоо хуульчийн шалгалтыг бичгээр авч, эрх олгох нь зүйтэй гэж үзсэний дараа энэ давуу эрхийг зөвшөөрдөг мужийн тоо эрс цөөрчээ.³⁶

Хуульчийн шалгалтыг ихэвчлэн мужийн Барын холбоо эсхүл Дээд шүүхээс томилогддог эрх бүхий байгууллага зохион байгуулдаг. Сүүлийн жилүүдэд хуульчийн шалгалтыг нэгдмэл болгох үйл явц эрчимтэй өрнөж байна. Тодруулбал, Барын шалгагчдын Үндэсний конференц байгууллагаас Хуульчийн нэгдмэл шалгалт (*Uniform Bar Examination*)-ыг бий болгожээ. Үүнд, Муж дундын хуульчийн, Муж дундын эссе бичлэгийн, Муж дундын гүйцэтгэлийн гэсэн гурван шалгалт багтдаг. Калифорни, Невада, Өмнөд Дакота, Канзас, Мичиган, Жиоржиа зэрэг хэд хэдэн мужид дээрх гурван шалгалтыг бүхэлд нь бус, харин тодорхой төрлийг нь сонгон тооцдог.³⁷ Мөн зарим мужид нэгдмэл шалгалтаас гадна тухайн мужийн холбогдолтой агуулгыг тусгасан тодорхой хичээл, шалгалтыг урьдчилан эсхүл хуульчийн эрх авснаас хойш тодорхой хугацааны дотор өгсөн байх шаардлага тавьдаг байна.

Муж дундын хуульчийн шалгалт (*Multistate Bar Exam*)-ыг Луйзана (эх газрын эрх зүйн тогтолцоотой), Пуэрто Рикагаас бусад бүх муж хүлээн зөвшөөрдөг. Уг шалгалт нь 200 асуулттай, олон сонголттой хариутай, зургаан цагийн хугацаанд хоёр хэсэгтэй авдаг сорилоос бүрдэнэ. Эдгээрээс 175 нь оноотой, үлдсэн 25 нь урьдчилан бэлтгэхэд чиглэсэн оноогүй сорил байдаг. Оноотой 175 сорил нь иргэний процесс, үндсэн хуулийн эрх зүй, гэрээ, эрүүгийн эрх зүй, эрүүгийн процесс, нотлох баримт, үл хөдлөх хөрөнгө, гэм хор гэсэн агуулга тус бүрээр 25 сорилыг багтаасан байдаг.^{38,39} Сорилд тодорхой тохиолдол өгөх бөгөөд хариултын

³⁶ Daniel R. Hansen, Do We Need the Bar Examination—A Critical Evaluation of the Justifications for the Bar Examination and Proposed Alternatives?, 45 Case W. Rsrv., L. Rev. (1995), p. 1192, <https://scholarlycommons.law.case.edu/caselrev/vol45/iss4/32>

³⁷ National Conference of Bar Examiners, Jurisdictions That Have Adopted the UBE, <https://www.ncbex.org/exams/ube/>

³⁸ National Conference of Bar Examiners, Preparing for the MBE <https://www.ncbex.org/exams/mbe/preparing/>

³⁹ Дэлгэрэнгүй агуулгыг эндээс үзнэ үү. <https://www.ncbex.org/pdfviewer/?file=%2Fdmtdocument%2F226>

дөрвөн хувилбараас хамгийн зөв гэж үзсэн нэгийг л сонгох ёстой.⁴⁰ Тус шалгалтыг жилд хоёр удаа авах бөгөөд жил бүрийн 2 болон 7 дугаар сарын сүүлийн долоо хоногийн Лхагва гарагт зохион байгуулдаг. Хуульчийн шалгалт зохион байгуулж буй муж бүр уг шалгалтын оноог нийт оноонд хэрхэн дүйцүүлэх талаар бодлогоо тогтоодог. Хуульчийн нэгдмэл шалгалтыг хүлээн зөвшөөрдөг мужуудад оноог 50 хувь гэж дүйцүүлэн тооцдог байна.⁴¹

Муж дундын эссе бичлэгийн шалгалт (*Multistate Essay Examination*)-ыг арваас бусад бүх муж хүлээн зөвшөөрдөг. Жил бүрийн 2 болон 7 дугаар сарын сүүлийн долоо хоногийн Мягмар гарагт тогтмол авдаг ба 30 минутын хугацаанд бичих эссе бичлэгийн зургаан даалгавартай. Агуулгын хувьд бизнесийн байгууллагын төрөл, хэлбэр, иргэний процесс, зөрчилдөөний эрх зүй, үндсэн хуулийн эрх зүй, гэрээ, эрүүгийн болон эрүүгийн процессын эрх зүй, нотлох баримт, гэр бүлийн эрх зүй, үл хөдлөх хөрөнгө, зөрчил, траст, Худалдааны нэгдмэл кодекс (*Uniform Commercial Code*) зэрэг хүрээнд байх^{42,43} ба нэг чиглэлээр хэд хэдэн асуулт ирж болно. Муж бүр уг шалгалтын оноог хэрхэн дүйцүүлж тооцох талаар өөрийн бодлогыг тогтоодог ба Хуульчийн нэгдмэл шалгалтыг хүлээн зөвшөөрдөг мужуудад дунджаар 30 хувиар тооцдог. Уг шалгалтаар шалгуулагчийн хоёрдмол үйл баримтаар гаргасан нөхцөл байдлаас хууль зүйн асуудлыг таньж олох, хамаарал бүхий үйл баримтыг тогтоож тусад нь авч үзэх, уг асуудалд тодорхой, цэгцтэй, ухаалаг дүн шинжилгээ хийх, тухайн асуудалд холбогдох эрх зүйн суурь зарчмыг ойлгосон эсэхийг шалгадаг. Энэ шалгалт нь шалгуулагчийн бичгээр үр дүнтэй харилцах ур чадварыг шалгадгаараа сорилын шалгалтаас ялгаатай.⁴⁴

⁴⁰ Загвар сорилыг эндээс үзнэ үү.

<https://www.ncbex.org/pdfviewer/?file=%2Fdmsdocument%2F17>

⁴¹ National Conference of Bar Examiners, Jurisdictions Administering the MBE

<https://www.ncbex.org/exams/mbe/>

⁴² Дэлгэрэнгүй агуулгыг эндээс үзнэ үү.

<https://www.ncbex.org/pdfviewer/?file=%2Fdmsdocument%2F227>

⁴³ 2016 оны шалгалтын асуулт, түүнд хийсэн загвар дүн шинжилгээг эндээс үзнэ үү.

<https://www.ncbex.org/pdfviewer/?file=%2Fdmsdocument%2F294>; 2021 оны шалгалтын асуултыг эндээс үзнэ үү.

<https://www.ncbex.org/pdfviewer/?file=%2Fdmsdocument%2F295>

⁴⁴ National Conference of Bar Examiners, Multistate Essay Test, <https://www.ncbex.org/exams/mee/>

Муж дундын гүйцэтгэлийн шалгалт (*Multistate Performance Test*)-ын хувьд тус бүр 90 минутын хугацаанд авдаг хоёр үндсэн хэсэгтэй. Гаргаж өгсөн нийтлэг агуулгын хүрээнд муж тус бүр зохион байгуулах бөгөөд шалгуулагчийн хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх чадвартай эсэхийг шалгахад чиглэдэг. Энэ хүрээнд тодорхой хэрэгт хамаарал бүхий үйл баримтыг ялгаж салгаж авч үзэх, эрх зүйн хэм хэмжээ, зарчим, захиргааны шинжтэй баримт бичигт дүн шинжилгээ хийх, үйлчлүүлэгчийн тодорхой асуудлыг шийдвэрлэх хүрээнд холбогдох хууль тогтоомж, үйл баримт хэрэглэх, хэрэв ямар нэг ёс зүйн шинжтэй асуудал байгаа бол үүнийг олж тогтоох, санаагаа бичгээр үндэслэлтэй, цэгцтэй илэрхийлэх, цагийн хязгаарлагдмал байдалд хуульчийн мэргэжлийн ур чадвараа хэрэглэх зэргийг шалгадаг. Шалгалтын материал нь тодорхой хэрэг болон түүнд холбогдох эх сурвалжууд байна. Хэргийн файл дотор үйл баримтыг тодорхой дурдсан баримт, мэдүүлгийн тэмдэглэл, хуралдааны тэмдэглэл, тайлбар, үйлчлүүлэгчийн баримт бичиг, гэрээ, хэвлэлийн мэдээ, эрүүл мэндийн баримт бичиг, цагдаагийн рапорт, хуульчийн тэмдэглэл зэрэг байж болно. Зарим тохиолдолд үйл баримт тодорхойгүй, бүрэн биш эсхүл бүр зөрчилдөөнтэй байх ч боломжтой. Ингэснээр практикт өөрийг нь ахалж буй хуульчийн зүгээс өгч буй мэдээлэл эсхүл үйлчлүүлэгчдээс нь гаргаж буй баримт сэлт зэрэг нь зарим тохиолдолд алдаа мадагтай эсхүл дутуу байдаг бодит нөхцөл байдлыг шалгалтын нэг хэсэг болгож оруулсан байна. Энэ тохиолдолд шалгуулагч нь үйл баримт дутуу эсхүл зөрчилдөөнтэй байгааг заавал бичиж үлдээх шаардлагатай. Эх сурвалжид жишиг шийдвэр, хууль тогтоомж, зохицуулалт, дүрэм журам байх бөгөөд зарим нь тухайн хэрэгт хамааралгүй байна. Шалгуулагч нь тухайн үйл баримтад хамааралтай зарчим, хэм хэмжээг тусгасан эх сурвалжийг сонгож, зөв ашиглах сорилттой тулгардаг.⁴⁵

Шалгалтын даалгавар нь ахлах хуульчийн зүгээс өгсөн даалгавар, үйлчлүүлэгчээс ирүүлсэн хүсэлт, үйл баримтын талаарх мэдэгдэл, гэрээний заалт, гэрээслэл, өмгөөллийн ажлын төлөвлөгөө, хэргийг хялбаршуулсан журмаар шийдвэрлүүлэх тухай хүсэлт, гэрчээс мэдүүлэг авах төлөвлөгөө, маргааныг хаах тухай хэлэлцээр зэрэг ямар ч хэлбэртэй байж болох бөгөөд шалгуулагч юу хийхийг тодорхой заасан

⁴⁵ National Conference of Bar Examiners, Multistate Performance Test
<https://www.ncbex.org/exams/mpt/preparing/>

байна.^{46,47} Хуульчийн нэгдмэл шалгалтыг хүлээн зөвшөөрдөг мужууд уг шалгалтын оноог дунджаар 20 орчим хувиар дүйцүүлж тооцдог.

Хуульчийн нэгдмэл шалгалтыг хүлээн зөвшөөрөөгүй 16 мужийн хувьд мөн л олон хариутай сорил, эссе, гүйцэтгэлийн шалгалт авдаг. Мөн эдгээр мужийн цөөнгүй нь Барын шалгагчдын Үндэсний конференцоос гаргасан аль нэг шалгалтыг шууд ашигладаг байна.

⁴⁶ 2021 оны шалгалтын даалгаврыг эндээс дэлгэрүүлэн үзнэ үү.
<https://www.ncbex.org/pdfviewer/?file=%2Fdmsdocument%2F296>

⁴⁷ 2016 оны шалгалтын даалгавар, загвар дүн шинжилгээг эндээс дэлгэрүүлэн үзнэ үү.
<https://www.ncbex.org/pdfviewer/?file=%2Fdmsdocument%2F293>

Гурав. ХУУЛИЙН СУРГУУЛЬ

АНУ-ын хууль зүйн дээд боловсролын тогтолцоо, түүний онцлогийг танилцуулахын өмнө түүхээс нь товч дурдах нь зүйтэй. 1700-аад оны сүүл хүртэл хуульчдыг Английн аргаар бэлтгэдэг байв. Энэ арга нь хуульчийг их сургуульд онолын мэдлэг олгож бэлтгэхээс илүүтэй практикийн мэргэшсэн хуульчийн удирдлага дор мэргэжлийн дадлага хийлгэх зарчмаар буюу Лондоны Иннсийн шүүхийн харьяанд бэлтгэдэг уламжлалтай байсан. Тиймээс Америкт ийм аргаар бэлтгэгдсэн хуульчдыг Британийн хаант засгийн элч төлөөлөгч гэж үзэн буруутгах, дорд үзэх хандлага ч байв. Дөнгөж бие даасан колониудын аж амьдрал өдөр тутмын шинжтэй, хүн хооронд гардаг маргаан нь ээдрээ төвөггүй, энгийн хялбар байсан учир түүнийг ариун библи, хүмүүсийн нийтлэг мэдрэмж, шударга ёсны суурь үзэл, ойлголт зэрэгт тулгуурлан шийддэг байсан тул мэргэжлийн хуульчийн хэрэг тэр бүр байсангүй.⁴⁸ Төд удалгүй 18 дугаар зуун гарч, колониуд эд баялгийн хувьд ч хэмжээний хувьд ч үлэмж томорч, арилжаа наймаа нэмэгдэхийн хэрээр нийгэмд худалдаачдын давхарга үүссэн. Үүний улмаас аж ахуйн шинжтэй гэрээ хэлэлцээр, худалдааны баримт бичгийн ач холбогдол нэмэгдэж, үүнийг дагаад хууль зүйн тоо томшгүй олон асуудал үүсэж, улмаар хуульчийн ач холбогдол, хэрэгцээ шаардлага өссөн байна.

Энэ дагуу колониуд Бар (англ. *Bar*)-тай болж хуульчид бий болов. Зарим нь Англи руу явж уламжлал ёсоор дадлага хийн суралцаж байсан бол үлдсэн нь бие даан суралцах, төрийн болон шүүхийн байгууллагад туслахаар ажиллах эсхүл хуульчийн дор дадлага хийх гэсэн гурван сонголттой тулгарсан.⁴⁹ Зарим суралцагч хуулийн чиглэлээр хэвлэгдсэн цөөн тооны бүтээл, хэм хэмжээг судалж тухайн колониос томилогдсон шалгагчдаар шалгуулан тэнцэж байсан бол ихэнх нь практикийн хуульчийн удирдлага, хяналт дор ажиллангаа суралцаж байв. Гэсэн хэдий ч уншиж судлах зүйл хомс, хуульчийн

⁴⁸ Lawrence M. Friedman, *A History of American Law* (1973), p. 82.

⁴⁹ Charles E. Consalus, *Legal Education During the Colonial Period, 1663-1776*, 29 J. LEGAL EDUC., 295, 307 (1978).

эрэлт хэрэгцээ нэн өндөр байсан тул хуульчид нь үндсэн ажилдаа тэр бүр цаг зав гаргаж чаддаггүй, түүнчлэн хуульчдын заах арга барил харилцан адилгүй, оффисын захиргааны шинжтэй ажилд байнга дайчлагддаг зэрэг нь суралцагчдад хүндрэлтэй байсан. АНУ-ын гурав дахь Ерөнхийлөгч Томас Жефферсон өөрөө уг дадлагаар бэлтгэгдсэн хуульч хэдий ч уг тогтолцоо үр дүнгүй байгааг шүүмжилж, хуулийн мэргэжилтэн бэлтгэх бие даасан систем байх ёстой хэмээн байр сууриа илэрхийлж байжээ.

Энэ бүхнээс үүдэн хуульч бэлтгэх тогтолцоог шинэчлэх алхам тавигдаж эхэлсэн бөгөөд анхны эрх зүйн бакалаврын зэргийг 1793 оноос Уиллиам Мэригийн коллеж олгож эхэлжээ.⁵⁰ Үүнээс хойш Литчфелдийн зэрэг хэд хэдэн сургууль байгуулагдаж, гол төлөв эрх зүйн онолын мэдлэг олгохыг эрмэлзэж байсан ч хуучны дадлагын тогтолцоо байр сууриа хадгалсаар байсны улмаас элсэн суралцагчдын тоо нэмэгдэхгүй байсаар хаалгаа барьсан байна. Энэ үеийн хуулийн боловсрол олгох тогтолцооны дутагдалтай тал нь нэг бол онолыг практикаас эсхүл эсрэгээрээ дадлагыг онолоос салгаж байсан явдал юм.⁵¹ 1826 онд Иелийн их сургууль хоёр жилийн сургалттай “Практикийн мэргэжилтнүүдийн анги” нээснээс⁵² хойш 1870 он гэхэд нийтдээ хуулийн 31 сургууль байгуулагдсан байна. Үүнээс 12 нь нэг жил, хоёр нь нэг жил хагас, 17 нь хоёр жилийн сургалттай байсан ба ихэнх сургууль элсэлтийн шалгалтгүй байжээ. Эдгээр сургуулийн оюутнууд олон төрлийн онолын сурвалж уншиж судлахын тулд номын санд ихэнх цагаа өнгөрүүлдэг байв.

Харвардын хуулийн сургуулийн захирлаар 1870-1895 онд ажиллаж байсан Кристофер Колумбус Лангдель эрх зүйн судалгааны тохиолдол шинжлэх арга зүй (*Case Method*)-г анхлан нэвтрүүлсэн нь Америкийн эрх зүйн боловсролын тогтолцооны хамгийн чухал

⁵⁰ Marion R. Kirkwood and William B. Owens (n.d.), A Brief History of the Stanford Law School, 1893–1946 (PDF), S.U. School of Law (Report), p. 1, Marion R. Kirkwood and William B. Owens
<https://web.archive.org/web/20120407053200/http://www.law.stanford.edu/school/history/historysls.pdf>

⁵¹ <https://core.ac.uk/download/pdf/233178562.pdf>, p. 620.

⁵² Moline, Brian J., Early American legal education, Washburn Law Journal, Vol. 42, p. 42
<https://contentdm.washburnlaw.edu/digital/collection/wlj/id/6369/>

хувьсал өөрчлөлтийн эхлэл байсан гэж үздэг.⁵³ Мөн Лангдель хуульчдыг бакалаврын түвшинд бус, харин ахисан түвшний боловсрол эзэмшүүлэхийн тулд өөрчлөлт, шинэчлэлийн шинжтэй олон ажил санаачилжээ. Тухайлбал, жишиг болсон шүүхийн шийдвэрүүдийг судлах (*Case Method*), судалсан шийдвэрээ хэлэлцэн тунгаах Сократын арга (*Socratic Method*)-ыг хослуулан, ийм боловсролыг ахисан түвшинд буюу хууль зүйн мэргэжлийн боловсролын зэргийн түвшинд суралцахыг санал болгож байлаа.⁵⁴

Ийнхүү хуулийн сургуулиуд ээлж дараалан байгуулагдаж байсан ч уламжлалт дадлагын хэлбэр түгээмэл хэвээр байсныг дурдах нь зүйтэй. 1900 он гэхэд Америкийн хуульчдын тал нь ямар нэг сургууль, коллежид хамрагдаагүй байв.⁵⁵ Гэвч дадлагын сургалт нь практикт хэт төвлөрсөн, нэгдсэн системгүй байгааг Канзас, Виржиниа зэрэг зарим муж анзаарч, нэг жилийн хугацаанд заавал сургууль, коллежид суралцсан байх, удирдагчийн хувьд өдөрт нэг цагаас доошгүй хугацаанд хууль зүйн асуудлаар ярилцаж, мэдлэг ойлголт өгсөн байх шаардлага тавьж эхэлсэн байна.

Өмнө дурдсан хууль зүйн мэргэжлийн зэрэг олгох сургалтыг анх санаачилсан нь Харвард бус, харин Чикагогийн хуулийн сургууль 1902 онд эхлүүлжээ. Чикагогийн хуулийн сургууль нь тухайн үед элсэн суралцагчдаасаа коллежийн боловсрол эзэмшсэн байхыг шаарддаг таван сургуулийн нэг байсан.⁵⁶ Гэвч Харвард, Иель, Колумба зэрэг нөлөө бүхий сургуулиуд хуульчийн сургалт явуулахыг цааргалсаар байлаа. Үүнээс хойш багагүй хугацаанд хуульчийг бакалаврын болон мэргэжлийн зэргийн сургалтаар нэгэн зэрэг бэлтгэж байсан бөгөөд нэгдсэн стандартгүй явж ирсэн.

⁵³ Charles R. McManis, *The History of First Century American Legal Education: A Revisionist Perspective*, *Washington University Law Quarterly* (Vol. 59:597), p. 598. <https://core.ac.uk/download/pdf/233178562.pdf>

⁵⁴ Harno A., *Legal Education in the United States*, New Jersey, Lawbook Exchange, p. 50.

⁵⁵ James M. Concannon, *The Other Law Schools of Early Day Kansas*, *J. KAN B.ASS'N*, Nov. 1996, p. 24.

⁵⁶ The Harvard Law School Library, "What is the difference between the LL.B. degree and the J.D. degree?" <https://asklib.law.harvard.edu/faq/115308>

АНУ-ын Боловсролын яам Америкийн Барын холбооны Хууль зүйн боловсрол, тус холбоонд гишүүнээр элсүүлэх асуудал хариуцсан Зөвлөл (цаашид “Зөвлөл” гэх)-д хууль зүйн мэргэжлийн дээд боловсролын зэрэг (*J.D.*)-ийг магадлан итгэмжлэх бүрэн эрхийг 1952 онд олгожээ. Үүнээс хойш тус холбоо нь хууль зүйн сургуулийг магадлан итгэмжлэхэд тавих шаардлагыг тогтоох, хэрэгжилтэд хяналт тавих зэрэг олон талын чиг үүргийг хэрэгжүүлэх болж, хууль зүйн мэргэжлийн зэрэг олгох сургалтад голлох этгээд болсон байна.

1960-аад он гартал их сургуулиуд хууль зүйн бакалаврын болон хууль зүйн мэргэжлийн зэргийн аль алинаар сургалт явуулж байв.⁵⁷ Хуулийн сургуульд элсэн суралцагчдын тоо 1950-1960-аад оны хооронд үлэмж нэмэгдсэний зэрэгцээ өмнө нь коллеж төгссөн хүмүүс хуулийн сургуульд элсэн орох явдал түгээмэл болжээ. 1962, 1963 онд Америкийн Барын холбооноос *J.D.* зэргийг мэргэжлийн зэрэг болгон олгохыг хуулийн сургуулиудад уриалсан байна. Улмаар Америкийн Барын холбоо 1969 онд Хууль зүйн боловсролын талаарх стандарт баталж, дээд боловсрол эзэмшсэн суралцагчийг элсүүлэх, гурван жилийн хугацаанд суралцуулах зэрэг шаардлага тавьжээ.⁵⁸

Америкийн Барын холбоо нь хуулийн сургуулийг магадлан итгэмжлэх стандартыг жил бүр шинэчлэн баталж, мөрдүүлдэг. Магадлан итгэмжлэгдсэн хуулийн сургуулиуд уг стандартад нийцүүлэн ажиллах үүрэгтэй. Энэ бүлэгт АНУ дахь хууль зүйн мэргэжлийн зэрэг олгох сургалтын тогтолцоо, сургуулиудад тавигддаг шаардлага, магадлан итгэмжлэх үйл явц зэргийг авч үзэх болно.

⁵⁷ 1961 он гэхэд Америкийн Барын холбооноос магадлан итгэмжлэгдсэн 15 сургууль эдгээр зэргийг хамтад нь олгож байсан.

⁵⁸ American Bar Association, Standards of the American Bar Association for Legal Education, 1969, 1(a), 1(b)
https://www.americanbar.org/content/dam/aba/publications/misc/legal_education/Standards/standardsarchive/1969_aba_standards.pdf

3.1. ХУУЛИЙН СУРГУУЛЬД ЭЛСЭН СУРАЛЦАГЧДАД ТАВИХ ШААРДЛАГА

Америкийн Барын холбооноос магадлан итгэмжлэгдсэн 190 гаруй хуулийн сургуульд 2018 онд 111,561; 2019 онд 112,882; 2020 онд 114,520 оюутан шинээр элсэн суралцжээ.⁵⁹

Хууль зүйн мэргэжлийн зэргийн сургалтад элсэн суралцахын тулд АНУ-ын Боловсролын яамнаас хүлээн зөвшөөрөгдсөн сургалтын байгууллагад суралцаж, бакалаврын зэрэг авсан байхыг шаарддаг.⁶⁰ Түүнчлэн тус яамнаас магадлан итгэмжилсэн сургалтын байгууллагын бакалаврын сургалтын дөрөвний гурвыг дүүргэсэн эсхүл тус улсын нутаг дэвсгэрээс гадна үйл ажиллагаа явуулдаг сургуулийг дүүргэсэн бөгөөд уг сургууль нь тус яамнаас тавигддаг шалгуурыг хангасан гэж үзвэл элсэн суралцах боломж нээлттэй.

Мөн онцгой тохиолдолд элсэн суралцагчийн чадвар, туршлага, бусад шаардлага шалгуур хангасан тохиолдолд элсүүлэн суралцуулах боломжтой бөгөөд үүнийг нотлох баримтыг тухайн оюутны хувийн хэрэгт заавал хадгалах ёстой. Суралцагчийн хувийн хэргийг үүсгэж, өмнөх сургалтын диплом, дүн зэргийг хавсаргадаг.⁶¹

3.2. ХУУЛИЙН СУРГУУЛИЙН ЭЛСЭЛТИЙН ШАЛГАЛТ

АНУ-д хуулийн сургуульд элсэн суралцахад элсэлтийн шалгалт өгсөн байх ёстой. Магадлан итгэмжлэгдсэн хуулийн сургуулиуд бүгд хүлээн зөвшөөрдөг шалгалт нь “Хуулийн сургуулийн элсэлтийн шалгалт”⁶²

⁵⁹ American Bar Association, Enrollment Data, 2018-2020.

https://www.americanbar.org/groups/legal_education/resources/statistics/

⁶⁰ American Bar Association, 2021-2022, Standards and Rules of Procedure for Approval of Law Schools, Chapter 1, Standard 502 (a).

⁶¹ Мөн тэнд, 502 (a), (b), (c).

⁶² Англ. Law School Admission Test (LSAT).

юм.⁶³ Уг шалгалтыг “Хуулийн сургуулийн элсэлтийн зөвлөл”-өөс⁶⁴ жилд дөрвөн удаа зохион байгуулдаг бөгөөд дунджаар 130,000 хүн шалгалтад ордог ажээ. Энэ шалгалт нь хуулийн сургуульд эхний жилдээ амжилттай суралцахад зайлшгүй шаардагдах чадварыг шалгахад чиглэдэг. Эдгээрт унших, үндэслэл гаргах, бичих чадвар багтдаг.⁶⁵ Шалгалт нь хоёр үндсэн хэсэгтэй. Эхний хэсэг цогцоор нь унших (*Reading comprehension*), шүүмжит (*Analytic reasoning*) болон логик үндэслэл (*Logical reasoning*) гаргах чадварыг шалгах гурван төрлийн, олон сонголтот сорил байдаг.⁶⁶ Уг шалгалтын хэсэг тус бүр 35 минут үргэлжлэх бөгөөд нийтдээ 120-180 оноогоор дүгнэнэ. Цогцоор нь унших чадварыг шалгах сорилын хувьд хуулийн сургуульд үздэг сурах бичиг, хууль тогтоомж, бүтээлийг уншиж ойлгох, онцлох хэсгийг тэмдэглэн авч үлдэх, түүнчлэн хоёр хэсэг бичвэрийг хооронд нь харьцуулах зэрэг чадварыг шалгадаг байна. Харьцуулах чадварыг шалгахдаа ерөнхий болон тусгай, зарчим болон хэрэглээ гэх мэтээр жишиж харьцуулна. Сэдвийн хувьд нийгэм, хүмүүнлэг, нийгмийн шинжлэх ухаан, биологи, физикийн шинжлэх ухаан болон эрх зүй зэрэг өргөн хүрээг хамардаг. Шүүмжит үндэслэл гаргах чадварыг хэд хэдэн үйл баримт, хэм хэмжээ өгч, түүнээс аль нь үнэн болохыг тогтоох чадвараар нь үнэлнэ. Жишээ нь, ажилтнуудыг ээлжийн дараалалд зөв байрлуулах, багш нарт анги хуваарилах, ээлж дараалал гаргах зэргээр тодорхой бүлэг юмсын алийг эхний ээлжид авч үзэх вэ гэдгээр шалгадаг. Энэ төрлийн сорил нь эрх зүйн хэм хэмжээний эрэмбийг зөв

⁶³ American Bar Association, 2021-2022 Standards and Rules of Procedure for Approval of Law Schools, Chapter 1, Standard 503.

⁶⁴ Англиар Law School Admissions Council. Анх 1945 оны 5 дугаар сарын 17-ны өдөр Колумбийн хуулийн сургуулийн элсэлт хариуцсан захирлын зүгээс Коллежийн элсэлтийн зөвлөлд хандан “Хууль зүйн чадавх” шалгах сорил бий болгож, элсэлтийн шийдвэр гаргахад ашиглах тухай санал дэвшүүлсэн. 1945 оны 8 дугаар сарын 15-ны өдөр Колумби, Харвард, Йелийн их сургууль болон Коллежийн зөвлөлөөс нийт их сургуульд хандан хуулийн сургуульд элсэхэд уншиж ойлгох, үндэслэл гаргах чадварыг шалгах сорил авах, мөн уг сорилыг авах тусгай чиг үүрэг бүхий байгууллага байгуулж, санхүүжүүлэх тухай санал гаргажээ. Улмаар 1948 оны 2 дугаар сарын 28-ны өдөр анхны элсэлтийн шалгалт зохион байгуулжээ.

⁶⁵ Law school admission Test LSAT: The Law School Admission Council, LSAC. (n.d.), Retrieved September 11, 2021, from <https://www.lsac.org/lSAT>.

⁶⁶ Жишиг сорилыг дараах холбоосоор орж үзэх боломжтой. <https://www.lsac.org/sites/default/files/legacy/docs/default-source/jd-docs/sampletjune.pdf>

олох, хэм хэмжээ хоорондын зөрчилдөөнийг тогтоох, шийдэх зэрэг хуулийн сургуулийн оюутны хувьд байнга хийдэг даалгаврыг хийж чадах эсэхийг шалгадаг.⁶⁷ Логик үндэслэл гаргах сорилын хувьд аливаа мэдээлэл нь тодорхой үйл баримт эсхүл аргументтай холбогдолтой эсэх, хэрэв тийм бол түүний нотолгоог олох зэргээр асуудлыг шинжлэх, дүн шинжилгээ хийх, үнэлж дүгнэх чадварыг шалгана. Жишээ нь, хэвлэлд гарсан мэдээ, эрдэм шинжилгээний өгүүлэл, зар сурталчилгаа зэрэгт гарсан богино хэмжээний аргументыг ашиглах бөгөөд энэ нь уг чанартаа хууль зүйн үндэслэл гаргах чадвартай эсэхийг үнэлж байгаа хэрэг юм.

Шалгалтын хоёр дахь хэсэг нь эссе бичих ба оролцогч өөрийн компьютероос тусгай программын тусламжтай (*proctoring software* буюу оролцогчийн дэлгэц, вэб камер, аудио хянадаг программ хангамж)-гаар онлайнаар эссегээ бичнэ.⁶⁸ Оролцогч сорилын шалгалтаас найм хоногийн өмнө эссегээ өгөх ба хүссэн цагтаа 35 минутын хугацаанд тодорхой сэдвээр аргумент дэвшүүлсэн эссе бичдэг. Агуулгын хувьд тодорхой шийдэл шаардсан асуудлыг дэвшүүлэх ба уг сэдвийн хүрээнд хоёр өөр байр суурь илэрхийлэх, уг байр сууриа дэмжсэн үндэслэл боловсруулах ёстой. Уг шалгалтаар оролцогчийн байр суурийг зөв эсхүл буруу гэж, цаашлаад эрх зүйн ерөнхий мэдлэгийг нь дүгнэхгүй бөгөөд зөвхөн үндэслэлтэйгээр ятган үнэмшүүлэх чадварыг нь шалгадаг байна.^{69,70}

⁶⁷ Law School Admission Council
<https://www.lsac.org/lsat/taking-lsat/test-format/analytical-reasoning>

⁶⁸ Мөн тэнд.

⁶⁹ Law School Admission Council, <https://www.lsac.org/lsat/prep/types-lsat-questions>

⁷⁰ Жишээ нь, тус байгууллагын цахим хуудсанд байрлуулсан жишиг даалгаварт нэгэн хувцасны дэлгүүр үйл ажиллагаагаа өргөтгөхөөр төлөвлөсөн ба үүнд ашигтай байх, урт хугацаанд санхүүгийн хувьд тогтвортой өсөлт хадгалах гэсэн шалгуурыг баримтлах шаардлагатайг дурдаад 1) улсын хэмжээнд ихээхэн эрсдэл гаргаж өргөжүүлэх боловч амжилттай хэрэгжвэл нэн ашигтай хувилбар, 2) орон нутгийн хэмжээнд өргөжүүлбэл тодорхой хэмжээний ашиг олохын зэрэгцээ үнэнч худалдан авагч, ажиллагсад, хамтрагсадтай байх хувилбарыг дэвшүүлж аль нэгийг сонгон эссе бичих тухай заажээ.
<https://www.lsac.org/lsat/lsat-prep/practice-test/writing-sample-topic>

3.3. СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Хуульчийн шалгалт амжилттай өгч, мэргэжлийн үйл ажиллагааг үр нөлөөтэй, ёс зүйтэй, хариуцлагатай хэрэгжүүлэх чадавхтай хуульчийг бэлтгэх сургалтын хөтөлбөр хөгжүүлэх нь хуулийн сургуулийн зорилго бөгөөд үүрэг нь юм.⁷¹ Америкийн Барын холбооноос гаргасан стандартад хуулийн сургуульд 83-аас доошгүй кредит цагийн хичээл судалсан байхаар заажээ. Энэ шаардлага болон сургалтын хөтөлбөрийн агуулгад тавьж буй шаардлага, өөрийн сургуулийн онцлогоос хамааран хуулийн сургуулиуд дунджаар 89 кредит цаг үзэж судалсан байх шаардлагыг тус тусдаа тогтоожээ.⁷²

Америкийн Барын холбооноос гаргасан стандартаар эрчимжүүлсэн хэлбэрээр сургалт явуулахыг зөвшөөрсөн боловч магадлан итгэмжлэгдсэн сургуулиудын ердөө 11 хувь нь л ийм хөтөлбөртэй. Мөн Америкийн Барын холбооноос зөвшөөрсөн тохиолдолд хосолсон зэрэг олгох (Жишээ нь, *J.D./M.B.A*, *J.D./M.S.W.*) хөтөлбөрийг хэрэгжүүлж болно.⁷³

Өмнө дурдсаны дагуу хуулийн сургуулиас санал болгож буй сургалтын хөтөлбөрт суралцагчдад өгч буй үр дүнгийнх нь хувьд дараах шаардлагыг тавьдаг.⁷⁴ Үүнд:

- а. Материаллаг болон процессын эрх зүйн мэдлэг, ойлголтыг эзэмшсэн байх;
- б. Хууль зүйн дүн шинжилгээ, үндэслэл гаргах, хууль зүйн судалгаа, асуудал шийдвэрлэх, хууль зүйн агуулгаар бичгийн болон аман хэлбэрээр харилцах чадварт суралцсан байх;
- в. Эрх зүйн тогтолцооны болон үйлчлүүлэгчийнхээ өмнө мэргэжлийн ёс зүй, сахилгын зохих үүрэг хариуцлагыг хэрэгжүүлж ажиллах;

⁷¹ American Bar Association, 2021-2022 Standards and Rules of Procedure for Approval of Law Schools, Chapter 1, Standard 301 (a).

⁷² American Bar Association, Survey of Law School Curricula 2002-2010, p. 15.

⁷³ Мөн тэнд, p. 16.

⁷⁴ American Bar Association, 2021-2022 Standards and Rules of Procedure for Approval of Law Schools, Chapter 1, Standard 302 (a) – (d).

- г. Хуулийн мэргэжлийн ур чадвар, ёс зүйн бусад шаардлага, шалгуурыг хангахад шаардагдах мэргэжлийн ур чадвар (Жишээ нь, зөвлөх, мэдүүлэг, тайлбар авах, хэлэлцээр хийх, үйл баримт нотлох, дүн шинжилгээ хийх, шүүх хуралдаанд оролцох, баримт бичиг боловсруулах, зөрчилдөөнийг шийдвэрлэх, хууль зүйн ажлын зохион байгуулалт, менежмент, хамтран ажиллах, өөрийгөө үнэлэх, соёлын хувьд зохих шаардлага хангах гэх мэт) зэрэг багтана.

Сургалтын эхний жилд хуульчийн мэргэжлийн үйл ажиллагааны дүрэм, хуульч мэргэжлийн үнэ цэн, хариуцлагын асуудлыг тусгасан мэргэжлийн хариуцлагын хоёроос доошгүй кредит цагийн нэг хичээл, мөн бичих ур чадварыг сайжруулахад чиглэсэн нэг хичээл, дараагийн жилүүдэд бичих ур чадварыг сайжруулах дахин нэг хичээлээс гадна хууль зүйн клиник сургалт эсхүл зургаагаас доошгүй кредит цагийн дадлага туршлага олгох дадлагын хичээл заавал багтаасан байх ёстой. Үүнд хууль зүйн судалгаа болон бичих ур чадварын хичээл зэрэг заавал судлах хичээл, мөн сонголтот бусад хичээлээс бүрдэж болно.⁷⁵ Дадлага туршлага олгох хичээлийн хувьд загвар сургалт (загвар шүүх хуралдаан, дүрд тоглох гэх мэт), хууль зүйн клиник, дадлага зэргийг тооцдог.⁷⁶

Дээр дурдсаны дагуу заавал үзэж судалсан байхаас бусад хичээлийн тухайд Америкийн Барын холбооноос тодорхой шаардлага тавьдаггүй. Иймд тухайн сургууль нь өөрийн онцлог, оюутны эрэлт хэрэгцээ, цаашид хуульчийн шалгалт өгөхөд дөхөм болгох зэргээс хамаарч нэгдүгээр курсийн оюутнуудад заавал үзэх дараах хичээлийг санал болгодог.⁷⁷ Үүнд:

- Иргэний процессын эрх зүй (Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны журам);
- Үндсэн хуулийн эрх зүй (Үндсэн хуулийн баримт бичиг, эх сурвалжийг тайлбарлах);

⁷⁵ Мөн тэнд, 16.

⁷⁶ American Bar Association, 2021-2022 Standards and Rules of Procedure for Approval of Law Schools, Chapter 1, Standard 303 (a).

⁷⁷ Christopher P. Banks, *The American Legal Profession: The Myths and Realities of Practicing Law*, Thousand Oaks: SAGE Publications, ISBN 9781506333137 (2017), p. 54.

- Гэрээ (Хувийн гэрээ хэлэлцээрийг хэрэгжүүлэх);
- Эрүүгийн эрх зүй (Нийтлэг эрх зүй, Загвар Эрүүгийн хууль, муж улсын эрүүгийн хууль тогтоомж);
- Өмч (Хөдлөх, үл хөдлөх хөрөнгө олж авах, шилжүүлэхтэй холбоотой төрөл бүрийн харилцаа);
- Гэм хор;
- Хууль зүйн судалгаа (Хууль зүйн судалгаа хийх ур чадвар);
- Хууль зүйн баримт бичиг боловсруулах (Хууль зүйн шинжтэй баримт бичиг боловсруулах ур чадвар, стратеги).

Эхний жил суралцсаны дараа дээр дурдсан бичих ур чадварыг сайжруулах нэг хичээлээс бусад бүх хичээлийг оюутан өөрөө сонгон судалдаг. Ихэнх сургууль бизнесийн зохицуулалт, шүүх хуралдаанд үйлчлүүлэгчээ төлөөлж оролцох, маргааныг шийдвэрлэх алтернатив хувилбарууд, захиргааны эрх зүй, корпорац, татвар, нотлох баримт, хөдөлмөр, гэр бүлийн эрх зүй, гэрээ хэлэлцээр боловсруулах, өмчийн эрх зүй зэрэг хичээлийг санал болгодог байна.⁷⁸ Харин сүүлийн жилүүдэд суралцагчийг чадваржуулах, ажлын байранд бэлтгэхэд шаардлагатай хичээл санал болгох болсон.

Агуулгын тухайд хуулийн сургуулийн төгсөгч хуульчийн шалгалт хэр өгөхөөс уг сургуулийн хөтөлбөрийн үр дүн, эрэлт хэрэгцээ, элсэгчдийн тоо хамааралтай байдаг тул уг шалгалтын агуулгад анхаардаг. Түүнчлэн хуулийн сургууль нь оюутнаа хууль зүйн клиник болон дадлага хийх, про-боно болон хууль зүйн холбогдолтой нийтийн албаны үйл ажиллагаанд хамруулах боломж бүрдүүлэх үүрэгтэй.^{79,80,81}

⁷⁸ Мөн тэнд, р. 55.

⁷⁹ American Bar Association, 2021-2022 Standards and Rules of Procedure for Approval of Law Schools, Chapter 1, Standard 303 (b).

⁸⁰ Про боно ажлын хувьд Америкийн Барын холбооноос гаргасан Мэргэжлийн үйл ажиллагааны загвар дүрмийн 6.1-д хуульч нь хязгаарлагдмал боломжтой хувь хүн эсхүл байгууллагад зориулан про боно үйлчилгээ эрхлэхийг уриалсан байх ба хуулийн сургуулиуд ч эдгээр байгууллагад чиглэсэн про боног дэмждэг.

⁸¹ Хуулийн холбогдолтой нийтийн үйлчилгээний үйл ажиллагаа гэдэгт иргэний эрх, эрх чөлөө, нийтийн эрхийг хамгаалахаар ажиллаж буй байгууллага, бүлэгт туслалцаа үзүүлэх, хууль зүйн туслалцаа авч үр дүнтэй төлөөлүүлэх боломжгүй

Хуулийн сургууль нь бүрэн хэмжээнд магадлан итгэмжлэгдсэн, Зөвлөлөөс тухайлан зөвшөөрөл олгосон эсхүл хуулийн сургуулийн хууль зүйн дээд боловсролын сургалтын үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөхгүйгээс бусад тохиолдолд *J.D.* зэргээс өөр сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэхийг хориглодог. Энэ нь хууль зүйн магистр, докторын гэх мэт бусад сургалт эрхлэхийн тулд эрх зүйн дээд боловсролтой мэргэжилтэн бэлтгэх үндсэн зорилгоо бүрэн гүйцэд биелүүлсэн байхыг шаарддагтай холбоотой.

3.4. ДАДЛАГА ТУРШЛАГА ОЛГОХ СУРГАЛТ: ЗАГВАР СУРГАЛТ, ХУУЛЬ ЗҮЙН КЛИНИК, ДАДЛАГЫН СУРГАЛТ

Дээр дурдсаны дагуу Хууль зүйн мэргэжлийн дадлага туршлага олгох сургалт нь загвар сургалт, хууль зүйн клиник, дадлагын сургалт байх ба дараах шаардлагыг хангах ёстой. Үүнд:

- Хууль зүйн дээд боловсролын агуулгын шаардлагад дурдсан номнол, онол, ур чадвар, хуульчийн ёс зүйг багтаасан байх, мэргэжлийн ур чадварыг нь сайжруулах ажилд оюутнуудыг оролцуулах;
- Оюутны суралцаж буй хичээлийн дагуу мэргэжлийн чадварыг нь хөгжүүлэх;
- Тухайн ажлыг хийж хэрэгжүүлэхэд нь олон боломж олгох;
- Оюутан тодорхой ажил үүргийг бие даан гүйцэтгэх, өөрийгөө үнэлэх, багш эсхүл дадлага удирдагчаас заавар зөвлөгөө, санал шүүмж авах боломжтой байх;
- Оюутны хийж хэрэгжүүлсэн ажил тус бүрд багш, дадлагын удирдагч шууд хяналт тавих боломж бүрдүүлэх.

сайн үйлс, шашин, иргэний нийгэм, засгийн газар, боловсролын байгууллагад туслалцаа үзүүлэх, хууль зүйн мэдээлэл авах боломжгүй иргэдэд мэдээлэл өгөх, эрх зүй, хуулийн байгууллагын чадавхыг бэхжүүлэх үйл ажиллагаанд оролцох зэрэг байхаар тус дүрмийн тайлбарт тодорхойлжээ. American Bar Association, 2021-2022 Standards and Rules of Procedure for Approval of Law Schools, Chapter 1, Interpretation 303-4.

Загвар хичээл нь багшийн удирдлага дор хийсвэр нөхцөлд үйлчлүүлэгчтэй харилцах, зөвлөгөө өгөх, төлөөлөх зэргээр оюутныг бодит амьдралд мэргэжлийн чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь бэлтгэх зорилготой хичээл юм.⁸² Клиник сургалтын хувьд бодит тохиолдолд багшийн удирдлага дор хөндлөнгийн этгээдийн хувиар үйлчлүүлэгчид зөвлөгөө өгөх, үйлчилгээ үзүүлэх сургалт юм.⁸³ Магадлан итгэмжлэгдсэн сургуулиудын дунд хийсэн судалгаагаар 85 хувь нь клиник сургалтыг өөрийн байранд, 30 хувь (давхардсан) нь сургуулиас гадуур зохион байгуулдаг ажээ. Түүнчлэн суралцагч бүрд дадлага хийх боломж олгодог байна.⁸⁴

Дадлагын сургалтаар хууль зүйн клиник сургалтын бус нөхцөлд оюутан зөвшөөрөлтэй хуульчийн удирдлага дор үйлчлүүлэгчид зөвлөгөө, үйлчилгээ үзүүлж ажилладаг. Дадлага нь дараах шаардлагыг хангасан байна.⁸⁵ Үүнд:

- Дадлагын хүрээнд хуульчийн хийж гүйцэтгэдэг үндсэн үйл ажиллагаанаас хийлгэх, уг үйл ажиллагаанд нь тогтмол үнэлэлт дүгнэлт өгөх, дадлага зохион байгуулах, оюутанд олгох мэдлэг, чадварын талаар сургалтын тэнхим болон дадлага удирдагчийн тус тусын хүлээх үүрэг хариуцлагыг бичгээр харилцан ойлголцсон байна;
- Дадлага удирдагчийг сонгох, оюутныг дадлагажуулах арга, хэлбэр, оюутныг үнэлэх, оюутан болон дадлагын удирдагч хоорондоо харилцах аргатай байх (шаардлагатай гэж үзвэл өөр сургуулийн багшийн удирдлага дор оюутныг дадлагажуулж болно);
- Оюутан тус бүрийн мэдлэг, ур чадвар хэрхэн сайжирсан талаарх багшийн буюу сургалтын тэнхимийн үнэлгээ;

⁸² American Bar Association, 2021-2022 Standards and Rules of Procedure for Approval of Law Schools, Chapter 1, Standard 304 (b).

⁸³ American Bar Association, 2021-2022 Standards and Rules of Procedure for Approval of Law Schools, Chapter 1, Standard 304 (c).

⁸⁴ American Bar Association, Survey of Law School Curricula 2002-2010, 2010, p. 16.

⁸⁵ Мөн тэнд, 304 (d).

- Оюутан дээрх шаардлагыг хангасан хэмжээнд дадлага туршлага олж авсан эсэхийг нотолсон баримт.

Түүнчлэн хуулийн сургууль нь дадлагаас гадна оюутнуудаа загвар шүүх хуралдаанд оролцуулах, хууль зүйн судалгаа хийлгэх, эрдэм шинжилгээний сэтгүүлд өгүүлэл нийтлүүлэх зэрэг хэлбэрээр сургалтын үйл ажиллагаа явуулахыг зөвшөөрдөг.⁸⁶ Сургалтын кредит цагийг тооцохдоо тухайн оюутнаас гаргасан хичээл зүтгэл, зарцуулсан хугацаа, түүний үр дүнд бий болсон сургалтын үр өгөөжийг харгалзах бөгөөд үнэлгээг багш тавина.⁸⁷

3.5. СУРГАЛТЫН КРЕДИТ ЦАГ, ХУГАЦААГ ТООЦОХ

Өмнө дурдсаны дагуу нийт 83 кредит цагийн сургалтад хамрагдсаны үндсэн дээр хуулийн сургуулийг төгсөх боломжтой. Үүний 64-өөс доошгүй кредит цаг нь танхимын эсхүл багшийн шууд удирдлага дор хамрагдах сургалтын үйл ажиллагаа байна.⁸⁸ Энэхүү 64 цагийн кредит сургалтыг танхимын хичээл, багшийн удирдлага дор загвар хичээл, хууль зүйн клиник сургалт, зайн сургалт, хуулийн холбогдолтой судалгаа, сургалтын үйл ажиллагаанд оролцох зэрэг хэлбэрээр цуглуулж болно.⁸⁹

Түүнчлэн хуулийн сургуульд суралцах хугацаа нь хамгийн богинодоо 24 сар байх бөгөөд хүндэтгэн үзэх шалтгаантай бол уг хугацааг 84 сар хүртэл сунгах боломжтой.⁹⁰

Танхимд эсхүл багшийн шууд удирдлага дор хичээллэх нэг цаг, танхимаас гадуурх сургалтын хоёроос доошгүй цагийг нэг кредит цагт тооцдог. Түүнчлэн загвар шүүх хуралдаан, дадлага, хууль зүйн клиник, хууль зүйн судалгаа зэрэг бусад хэлбэрийн тухайд энэ зарчмын дагуу оюутнаас зарцуулсан хугацаа, хүчин чармайлт зэргээр кредит цагийг тооцно.

⁸⁶ Мөн тэнд, 305 (b).

⁸⁷ Мөн тэнд, 305 (c).

⁸⁸ Мөн тэнд, 311 (a).

⁸⁹ Мөн тэнд, 311 (a), Interpretation.

⁹⁰ Мөн тэнд, 311 (b).

Нэг кредит хичээлийн хувьд долоо хоногт танхимаар нэг хичээлийн цаг (50 минут), мөн хоёроос доошгүй цагийн танхимын бус сургалтын үйл ажиллагаагаар тооцох бөгөөд нийт 15 долоо хоног байх ёстой. Нийт дүнгээр авч үзвэл нэг кредит нь 42.5 цаг ($15 \times 50\text{мин} + 15 \times 2\text{цаг}$)-ийн сургалт байна.⁹¹

Үнэлгээний хувьд форматив (явцын) болон нийлбэр (төгсгөлийн) арга ашиглан үнэлэх боломжтой бөгөөд үнэлгээг хэрхэн тогтоохоо тухайн хуулийн сургууль шийддэг.

3.6. СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙН САНХҮҮЖИЛТ

Аливаа үйл ажиллагаа амжилттай, үр дүнтэй хэрэгжих нэг нөхцөл нь санхүүжилт хангалттай байх явдал байдаг тул хуулийн сургууль стандартад нийцсэн үйл ажиллагаа явуулах, сургалтын үйл ажиллагаагаар амжилттай эрхлэхэд шаардлагатай санхүүгийн нөөцийг бүрдүүлсэн байхыг тухайлан шаарддаг.⁹² Их сургуулийн харьяанд байдаг хуулийн сургуулийн хувьд өөрийн орлоготойгоо харьцуулсан байдлаар урсгал зардлаа жил бүр гаргуулж авдаг. Хэрэв хуулийн сургууль нь санхүүгийн хувьд алдагдалтай болсон, энэ нь тухайн сургуулийн сургалтын үйл ажиллагаанд үлэмж нөлөөлсөн эсхүл цаашид ийм нөхцөл байдал үүсэхээр байгаа тохиолдолд уг сургуулийг Барын холбооны стандартад нийцэхгүй гэж үзэх үндэслэл болно.⁹³ Их сургуулийн харьяанд байдаг хуулийн сургууль тухайн их сургуулийн жилийн төсөв батлах үед саналаа өгөх боломжоор хангагдах ёстой.⁹⁴

3.7. ЗАЙН СУРГАЛТ

Америкийн Барын холбооноос гаргасан стандарт шаардлагад нийт хөтөлбөрийн гуравны нэгд 10 хүртэл кредит цагийн хичээлийг зайнаас үзэж болохоор заасан.⁹⁵ Түүнчлэн тус холбооноос зөвшөөрсөн буюу

⁹¹ Мөн тэнд, 310 (a) (b) and its interpretation.

⁹² Мөн тэнд, 202 (a).

⁹³ Мөн тэнд, 202 (c) (d).

⁹⁴ Мөн тэнд, 202 (e).

⁹⁵ Мөн тэнд, 311 (e).

зайн сургалтын дээд хязгаарт хамаарахгүй гэж тогтоосон тохиолдолд бүрэн хэмжээнд зайнаас буюу онлайн хэлбэрээр сургалт явуулах боломжтой. Жишээ нь, Сэйнт Мэригийн их сургуулийн хууль зүйн мэргэжлийн зэргийн бүрэн хэмжээний онлайн хөтөлбөрийг Америкийн Барын холбоо 2021 оны 5 дугаар сард магадлан итгэмжилсэн. Уг сургууль нь эхний ээлжид 25 оюутныг туршилтын журмаар элсүүлэн суралцуулах бөгөөд сургалт нь дөрвөн жилийн хугацаатай байна. Эхний жилийн хичээлийг онлайнаар хэдийд ч үзэх боломжтойгоор явуулах бол дараагийн жилийн сургалтууд нь шууд тогтсон цагаар онлайн хэлбэрээр явагдана.⁹⁶

3.8. БАГШЛАХ БҮРЭЛДЭХҮҮН

Хуулийн сургууль нь мэдлэг, ур чадвар, академик шаардлага шалгуур, заах арга зүйн туршлагыг бүрэн дүүрэн хангасан багшлах бүрэлдэхүүнтэй байх шаардлагатай бөгөөд уг шаардлагыг нарийвчлан тогтоодог.

Нэгд, хуулийн сургууль нь өөрийн хөтөлбөрийн зорилго, зорилтыг бүрэн дүүрэн хэрэгжүүлэхэд шаардагдах үндсэн багштай байх ёстой. Үндсэн багшийн тоог оюутны тоо болон оюутнаас багштай ганцаарчлан уулзах боломж нөхцөл, хууль зүйн дээд боловсролын сургалтын хөтөлбөрийн хүрээ, багшийн зүгээс хичээл заах үүргээ гүйцэтгэхээс гадна эрдэм шинжилгээний судалгаа хийх, хуулийн сургуулийн засаглалын үйл ажиллагаанд оролцох, хууль зүйн мэргэжлийн болон олон нийтийн үйл ажиллагаанд үр дүнтэй оролцох боломж зэргийг харгалзан үзэж тогтоодог.⁹⁷ Нэгэнт үндсэн багшийн орон тоонд хангалттай хүн авч ажиллуулах шаардлагатай учир цагийн багш, өөр сургуулийн багшийг түр гэрээгээр ажиллуулах, хуулийн фирм, оффис зэрэгтэй тогтоосон хамтын ажиллагааны хүрээнд хуульчийг багшлуулах зэрэг нь үндсэн багшид тооцогдохгүй.⁹⁸ Түүнчлэн суралцагчийн

⁹⁶ Reuters, First ABA-approved online J.D. program to debut next fall, September 14, 2021 <https://www.reuters.com/legal/legalindustry/first-aba-approved-online-jd-program-debut-next-fall-2021-09-14/>

⁹⁷ American Bar Association, 2021-2022 Standards and Rules of Procedure for Approval of Law Schools, Chapter 1, Standard 402.

⁹⁸ American Bar Association, 2021-2022 Standards and Rules of Procedure for Approval of Law Schools, Chapter 1, Standard 402 (Interpretation).

суралцах хугацааны эхний гуравны нэгд үндсэн багш заавал хичээл орох ёстой. Мөн хичээлийн жилийн хугацаанд хуулийн сургуулиас санал болгож буй хичээлийн талаас илүү хувьд, мөн суралцагчийн багштай уулзаж зөвлөгөө, чиглэл авах цагийн гуравны хоёроос дээш хувьд үндсэн багш ажиллах ёстой байдаг.⁹⁹ Сургууль нь багш нарынхаа заах арга зүйн үр нөлөөг дээшлүүлэх ажлыг зохион байгуулах үүрэгтэй. Үр нөлөөг дээшлүүлэхийн тулд шинээр томилогдсон багш нарыг чиглүүлэх, зөвлөх, дагалдуулах, заах арга зүйн үр нөлөөг дээшлүүлэх талаар багш нарын түр хороо байгуулж ажиллуулах, хичээлийн анги танхимд байлцах, хичээлийн явцыг видео бичлэгт буулгаж санал шүүмж өгөх, оюутанд тавьсан үнэлгээг хөндлөнгөөс дахин үнэлэх, сургалт семинар зохион байгуулах зэрэг үйл ажиллагааг зохион байгуулж байхаар тухайлан заажээ.¹⁰⁰

Хоёрт, хуулийн сургууль нь багшлах бүрэлдэхүүний талаар дараах чиг үүргийг тусгасан баримтлах бодлоготой байх ёстой.¹⁰¹ Үүнд:

- Хичээлээ бэлтгэх, заах, тухайн хичээлийнхээ хүрээнд болон бусад хичээлийнхээ хүрээнд оюутанд зөвлөгөө, чиглэл өгөх;
- Академик зөвлөгөө өгөх, санал солилцох орчныг бүрдүүлэх, суралцагчийг үнэлэх;
- Сургуулиас тодорхойлж өгсөн эрдэм шинжилгээний ажилд оролцох;
- Сургуулийн засаглал, хөтөлбөрийг боловсронгуй болгох зэрэг сургууль, нийгмийн шинжтэй үйл ажиллагаанд оролцох;
- Шүүгч, практикийн хуульч нартай хамтран ажиллах зэргээр хууль зүйн мэргэжлийн хөгжлийг дэмжих;
- Про боно үйлчилгээнд оролцох зэргээр олон нийтэд үйлчлэх.¹⁰²

Дээрх бодлогыг гаргах нь үндсэн багшийг сургалтаас өөр зорилгоор ажиллуулах, үндсэн ажлаа цалгардуулахгүй байх нөхцөл бүрдүүлж

⁹⁹ Мөн тэнд, 403 (а).

¹⁰⁰ Мөн тэнд, Interpretation 403-1.

¹⁰¹ Мөн тэнд, 404 (а).

¹⁰² Мөн тэнд, 404 (а), (1) – (6).

байгаа хэрэг юм. Багш дээрх чиг үүргээ тухайн сургуулийн бодлого, чиглэлтэй уялдуулан хэрхэн хэрэгжүүлсэн талаар хуулийн сургууль нь тогтмол хугацаанд үнэлж дүгнэнэ.

Хуулийн сургуулиуд сайн багш нарыг татахад чиглэсэн орчин нөхцөл бүрдүүлэх үүрэг хүлээдэг. Үүний дотор багш нартаа академик эрх чөлөөг олгох, энэ талаар өөрийн дотоод бодлогыг гаргасан байх, бүх багшид адил нөхцөл, боломж олгох гэх мэтээр энэ үүргээ гүйцэтгэдэг.

3.9. ХУУЛИЙН СУРГУУЛИЙН ЗАХИРГАА

Америкийн Барын холбооноос хуулийн сургуулийн удирдлага, зохион байгуулалтын талаар нарийвчилсан шаардлага тавьдаг. Сургуулийн захирал, тэнхим нь хичээлийн хөтөлбөр, заах арга зүй, үнэлгээ, суралцагч элсүүлэх бодлого, журам, академик стандарт зэрэг тухайн сургуулийн сургалтын үйл ажиллагааг хариуцан явуулах үүрэгтэй.

Сургуулийн багшлах бүрэлдэхүүнийг сонгон шалгаруулах, дэвшүүлэх, ажиллуулахтай холбоотой асуудлыг захирал болон тэнхим нь шийдвэрлэнэ. Түүнчлэн хуулийн сургууль харьяалагдаж байгаа их сургуулийн бодлого нь Америкийн Барын холбооноос тавигдаж буй шаардлагад нийцсэн байхыг шаарддаг. Их сургуулийн харьяанд байдаггүй хуулийн сургуулийн хувьд Америкийн Барын холбооноос тавьж буй стандартыг хангуулах чиг үүрэг бүхий зөвлөл удирдлага, хяналтын чиг үүргийг хэрэгжүүлэх ёстой гэсэн шаардлага тавьдаг.

3.10. МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ

Хуулийн сургуулиас гаргаж буй аливаа мэдээлэл нь үнэн зөв, бодитой, суралцахаар хүсэж буй хүн, оюутнуудыг төөрөгдүүлэхээргүй тодорхой байх хэрэгтэй. Мэдээллээ үнэн зөв гаргаагүй нь сургуульд хариуцлага хүлээлгэх үндэслэл болно. Хуулийн сургууль дараах мэдээллийг цахим хуудсандаа тогтоосон хугацаанд байршуулж байх үүрэг хүлээдэг.¹⁰³ Үүнд:

¹⁰³ American Bar Association, 2021-2022 Standards and Rules of Procedure for Approval of Law Schools, Chapter 1, Standard 509.

- Элсэлтийн мэдээлэл;
- Сургалтын төлбөр, хураамж, амьдрах зардал, санхүүгийн тусламж, нөхцөлт тэтгэлэг;
- Элсэн орохтой холбоотой мэдээлэл;
- Үндсэн болон цагийн багш, мэргэжлийн номын санч, захиргааны ажилтны тоо;
- Үзэх хичээлийн тоо, семинар, хууль зүйн клиник, дагалдах сургалтын үйл ажиллагааны тоон мэдээлэл;
- Төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлт;
- Төгсөгчдийн хуульчийн шалгалтад тэнцсэн байдал.

3.11. ХУУЛИЙН СУРГУУЛИЙН НОМЫН САН

Хуулийн сургууль нь хууль зүйн боловсролын хөтөлбөрийг хэвийн тасралтгүй явуулах эх сурвалжтай, хууль зүйн судалгаа, эрдэм шинжилгээний үйл ажиллагааг дэмждэг, багш, суралцагч, сургуулийн захиргаатай шууд хамтран ажилладаг буюу үйл ажиллагаа нь уялдаа холбоотой, үйл ажиллагааныхаа үр нөлөө, зорилго, зорилтоо тогтмол үнэлдэг мэргэжлийн номын сантай байх үүрэгтэй.¹⁰⁴ Номын сангийн удирдлага, ажилтан нь мэргэжлийн байхыг шаардах бөгөөд ийм мэргэжлийн хүмүүсийг ажиллуулахад шаардагдахуйц төсөв хөрөнгийг сургууль шийдвэрлэх үүрэгтэй.

Түүнчлэн номын сангийн үйлчилгээ нь сургалтын хөтөлбөрийн дагуу багшлах, эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийх эрэлт хэрэгцээнд бүрэн нийцсэн байх ёстой. Үүний тулд номын сан нь шаардлагатай эх сурвалж бүхий фондтой байхаас гадна номын сангийн каталог, индекстэй, хайлтын хялбар системтэй, тухайн хайсан бүтээл байхгүй тохиолдолд өөр номын сангаас түр хугацаанд авах боломж бүрдүүлсэн байхыг шаарддаг.¹⁰⁵

¹⁰⁴ American Bar Association, 2021-2022 Standards and Rules of Procedure for Approval of Law Schools, Chapter 1, Standard 601.

¹⁰⁵ Мөн тэнд, Standard 605.

Хуулийн сургуулийн номын сан нь үндсэн болон бусад гэсэн фондтой байх ба үндсэн фонд нь дараах эх сурвалжийг заавал багтаасан байна. Үүнд:

- Холбооны шүүхийн шийдвэрүүд, муж тус бүрийн дээд шүүхийн шийдвэр;
- Холбооны түвшинд үйлчилдэг хуулиуд;
- АНУ-ын нэгдэн орсон, хэвлэн нийтлэгдсэн олон улсын гэрээ, хэлэлцээрүүд;
- Холбооны Засгийн газраас болон тухайн хуулийн сургуулийн үйл ажиллагаа явуулж байгаа мужийн засаг захиргаанаас батлан гаргасан хэм хэмжээний актууд;
- Хуулийн сургуулийн хөтөлбөрийн агуулгад хамаарах Конгрессын хууль тогтоох ажиллагааны холбогдох материал, захиргааны шинжтэй шийдвэрүүд;
- Хууль зүйн мэдээллийг шинэчлэх, хайж олоход шаардагдах бусад эх сурвалж.

Дээрхээс гадна хуулийн сургууль нь дараах шаардлагыг хангасан бусад эх сурвалж, материалыг өөрийн өмчлөлөөр эсхүл найдвартай эх үүсвэрийн үндсэн дээр бүрдүүлсэн байна.¹⁰⁶ Үүнд:

- Оюутны судалгаа шинжилгээний эрэлт хэрэгцээ, сургалтын хөтөлбөрийн агуулгад тохирсон байх;
- Багш нарын хичээлээ заах, эрдэм шинжилгээ, судалгааны ажил эрхлэхэд дэмжлэг болохуйц байх;
- Сургуулийн өөрийн онцлог заах арга барил, эрдэм шинжилгээ, судалгаа, боловсролын үйлчилгээний онцлогт тохирсон байх;
- Тоо хэмжээний хувьд хангалттай, бүрэн бүтэн, цаг үедээ нийцсэн байх.

¹⁰⁶ Мөн тэнд, Standard 606 (b).

Дээр дурдсан найдвартай эх үүсвэр гэдэг нь тухайн сургуулийн ашигладаг мэргэжлийн онлайн өгөгдлийн сан, олон нийтэд нээлттэй найдвартай өгөгдлийн сан, ховор эсхүл тухайн номын санд байдаггүй бүтээлийг бусад байгууллагаас дамжуулан хэрэглэх албан ёсны тохиролцоотой байхыг ойлгодог байна. Ихэнх сургууль *LexisNexis*, *WestLaw*, *Heinonline* зэрэг онлайн дата баазыг оюутнууддаа нэг бүрчлэн ашиглуулдаг.

Хуулийн сургууль нь номын фондынхоо нөхцөл байдлыг тогтмол үнэлж, баяжуулах, хөгжүүлэх чиглэлээр төлөвлөгөө гарган ажиллах үүрэгтэй. Түүнчлэн номын сан нь зориулалтын уншлагын танхим, техник тоног төхөөрөмжийг бүрдүүлсэн байна.

3.12. СУРГАЛТЫН БААЗ, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ

Хуулийн сургууль хангалттай тооны лекцийн болон семинарын анги танхим, зохих шаардлага хангасан номын сан, оюутанд туслах үйлчилгээний зай талбай, өрөө тасалгаа, багш нарын өрөө, эрүүл ахуй, аюулгүй байдлын тоног төхөөрөмж, хууль зүйн клиник сургалт явуулах (үйлчлүүлэгчтэй уулзах, хэрэг дээр нь ажиллах, нууцлалыг хадгалах нөхцөлийг бүрдүүлсэн) өрөө тасалгаа, оюутнууд, багш нарын дангаар судалгаа хийх, суралцах чимээгүй орчин нөхцөлийг бүрдүүлсэн анги танхим, өрөө тасалгаа, мөн багаар ажиллах анги танхим, өрөө тасалгаа зэрэг нөхцөлийг бүрдүүлсэн байх шаардлагатай. Эдгээр нь өөрийн өмчлөлийн болон түрээсийн хэлбэртэй байж болох ч хэрэв түрээсэлдэг бол тогтвортой хугацаанд түрээслэх санхүүгийн чадамжтай байхыг шаардана.¹⁰⁷

3.13. ХУУЛЬЧИЙН ШАЛГАЛТАД ТЭНЦСЭН БАЙДАЛ

Хуулийн сургуулийн үйл ажиллагааг үнэлэх нэг чухал шалгуур нь төгсөгчдөөс хуульчийн шалгалт өгч тэнцсэн байдал юм. Америкийн Барын холбооноос гаргасан шаардлагын дагуу сургуулиа төгссөнөөс хойш хоёр жилийн дотор хуульчийн шалгалт өгч байгаа төгсөгчдийн 75-аас доошгүй хувь нь тэнцсэн байх ёстой.¹⁰⁸ 2020 оны шалгалтын

¹⁰⁷ American Bar Association, 2021-2022 Standards and Rules of Procedure for Approval of Law Schools, Chapter 1, Standard 702 (b).

¹⁰⁸ Мөн тэнд, Standard 316.

дүнг авч үзвэл хуулийн сургууль төгсөгчдийн 83 хувь нь анхны оролдлогоороо хуульчийн шалгалтад тэнцжээ. Энэ нь өнгөрсөн онтой харьцуулбал гурван хувиар өссөн үзүүлэлт бөгөөд хоёр дахь жилийнхээ дотор шалгалт өгч буй оролцогчдын 89.9 хувь нь мөн тэнцсэн байна.¹⁰⁹

3.14. ХУУЛИЙН СУРГУУЛИЙН ХҮЛЭЭХ ХАРИУЦЛАГА

Хуулийн сургуульд тавьж буй олон шаардлагыг нэг мөр хэрэгжүүлэх, биелэлтийг нь хангуулах нэг нөхцөл нь хяналт, хариуцлагын тогтолцоо юм.

Америкийн Барын холбооноос тавьж буй шаардлагыг үлэмж хэмжээгээр эсхүл нэг болон түүнээс дээш стандарт зөрчсөн, тус холбооноос тавьж буй стандартыг хэрэгжүүлэх чиглэлээр төлөвлөгөө гаргаж өгөөгүй эсхүл газар дээрх үзлэгт мэдээлэл гаргаж өгөөгүй, төөрөгдүүлсэн мэдээлэл өгсөн, урьдчилж зөвшөөрөл авалгүйгээр хөтөлбөрт өөрчлөлт оруулсан, заавал ил тод мэдээлэх үүрэгтэй мэдээллийг оруулаагүй эсхүл буруу зөрүү оруулсан бол хариуцлага хүлээлгэх үндэслэл болдог.¹¹⁰

Дараах төрлийн хариуцлага хүлээлгэдэг. Үүнд:

- Мөнгөн торгууль;
- Оюутны төлсөн төлбөрийг бүхэлд нь эсхүл хэсэгчлэн хурааж авах;
- Нээлттэй сануулах, хаалттай сануулах;
- Уучлал хүссэн эсхүл залруулга мэдээлэл гаргахыг тухайн сургуульд даалгах;
- Тодорхой хугацаагаар шинэ хөтөлбөр гаргахыг хориглох;
- Тодорхой шаардлага шалгуур хангах хүртэл хяналтын хугацаа тогтоох;

¹⁰⁹ American Bar Association, New data show bar passage scores increased during pandemic (May 21, 2021).
<https://www.americanbar.org/news/abanews/aba-news-archives/2021/05/bar-passage-scores/>

¹¹⁰ American Bar Association, 2021-2022 Rules of Procedure, Rule 15(a).

- Магадлан итгэмжлэлийг хүчингүй болгох зэрэг болно.¹¹¹

Давтан зөрчил гаргасан, асуудалд илт хайхрамжгүй хандсан, мэдсээр байж зөрчил гаргасан, зөрчлийг нуун дарагдуулах оролдлого хийсэн, шударга бус, хувиа хичээсэн сэдэлтийн улмаас зөрчил гаргасан, хяналт шалгалт, үзлэгийн үйл ажиллагаанд саад учруулсан, хуурамч нотлох баримт гаргаж өгсөн, хууран мэхэлсэн эсхүл буруутай үйл ажиллагаагаа хүлээн зөвшөөрөхөөс татгалзаж хаацайлсан, төгсөгч, оюутан, ирээдүйн суралцагчдад бодитой гэм хор учруулсан, зөрчлийн улмаас мөнгөн хөрөнгө, стратеги, нэр хүндийн хувьд ашигтай байдал бий болгосон, зөрчил илрүүлэх хангалттай арга хэмжээ аваагүй, байгууллагын зүгээс зохион байгуулалттайгаар зөрчил гаргах нөхцөлийг бүрдүүлсэн зэрэг тохиолдолд зөрчлийн хэр хэмжээг хүндрүүлэн авч үздэг.¹¹²

Харин эсрэгээр өмнө зөрчил гаргаагүй, ялимгүй хайхрамжгүй хандсан, зөрчлийн улмаас мөнгөн хөрөнгө, стратеги, нэр хүндийн хувьд ашигтай байдал бий болгоогүй, зөрчлийн талаар өөрөө мэдүүлсэн, үр дагаврыг нь хурдан шуурхай арилгах арга хэмжээ авсан, хяналт шалгалтын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлсэн, бусад байдлаар хариуцлага хүлээсэн тохиолдолд хариуцлагыг хөнгөрүүлэн авч үзнэ.¹¹³

Хариуцлагын арга хэмжээг заавал шат дараатай авна гэхгүй ба тавьсан шаардлагыг биелүүлээгүй, хариуцлагын арга хэмжээг зөрчсөн бол нэмж арга хэмжээ авах боломжтой. Хяналтын хугацаа тогтоосон сургууль үйл ажиллагаагаа стандарт шаардлагад нийцүүлж чадаагүй бол магадлан итгэмжлэлийг шууд хүчингүй болгох үндэслэл болно.

3.15. ХУУЛИЙН СУРГУУЛИЙГ МАГАДЛАН ИТГЭМЖЛЭХ ЭРХ БҮХИЙ БАЙГУУЛЛАГА

АНУ-ын Боловсролын яамнаас дээд боловсролын магадлан итгэмжлэх байгууллага нь тухайн мэргэжлийн холбооноос хараат бус, бие даасан (англ. “*separate and independent*”) хэлбэрээр ажиллах шаардлага тавьдаг тул Америкийн Барын холбоо өөрөө бус харин Зөвлөл нь магадлан

¹¹¹ Мөн тэнд, Rule 15(b).

¹¹² Мөн тэнд, Rule 15(d).

¹¹³ Мөн тэнд.

итгэмжлэх чиг үүргийг хэрэгжүүлдэг байна. Тус Зөвлөл нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлдэг. Үүнд:

- Хуулийн сургуулийг түр болон бүрэн хэмжээгээр магадлан итгэмжлэх, буцаах;
- Америкийн Барын холбооны стандарт шаардлагад заасны дагуу үлэмж өөрчлөлт хийх зөвшөөрлийг хуулийн сургуульд олгох;
- Хичээлийн төлөвлөгөөг батлах, батлахаас татгалзах шийдвэр гаргах;
- Хариуцлага хүлээлгэх, алдааг засах тодорхой арга хэмжээ авахыг даалгах;
- Магадлан итгэмжлэх үйл ажиллагааны хураамжийн хэмжээг тогтоох.¹¹⁴

Хуулийн сургуулийг түр болон бүрэн магадлан итгэмжлэхээс татгалзсан, магадлан итгэмжлэлийг буцаасан шийдвэрт тухайн сургууль давж заалдах гомдол гаргах эрхтэй.

Америкийн Барын холбоо нь тус Зөвлөлийг чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь санхүү төсөв, зохион байгуулалтын зэрэг олон талын дэмжлэг үзүүлдэг хэдий ч хуулийн сургуулийг магадлан итгэмжлэх, тус холбооноос баталсан стандартыг мөрдүүлэх, хариуцлага тооцох зэрэг магадлан итгэмжлэлтэй холбоотой асуудлуудад үл оролцох зарчимтай.¹¹⁵

3.16. ХУУЛИЙН СУРГУУЛИЙН МАГАДЛАН ИТГЭМЖЛЭЛ

Хуулийн сургуулийн магадлан итгэмжлэл нь бүрэн буюу түр гэсэн хэлбэртэй байна. Их сургууль, коллеж зэрэг дээд боловсролын байгууллагыг эхний ээлжид түр магадлан итгэмжлэх¹¹⁶ бөгөөд ийнхүү магадлан итгэмжилснээс хойш гурван жилийн дараа бүрэн магадлан

¹¹⁴ American Bar Association, 2021-2022 Rules of Procedure, Rule 2.

¹¹⁵ Preface, ABA Standards and Rules of Procedure for Approval of Law Schools 2021-2022.

https://www.americanbar.org/content/dam/aba/administrative/legal_education_and_admissions_to_the_bar/standards/2021-2022/2021-2022-aba-standards-and-rules-of-procedure-preface.pdf

¹¹⁶ Түр магадлан итгэмжлэлтэй сургууль нэг байгаа нь *UNT Dallas College of Law* юм.

итгэмжлэлд хамруулдаг.¹¹⁷ Сургалтын байгууллага нь хуулийн сургуулийн стандартыг бүрэн хэмжээнд хангахаа нотолсон тодорхой төлөвлөгөө гаргаж, түр магадлан итгэмжлэгдсэнээс хойш таван жилийн дотор бүрэн итгэмжлэгдэх ёстой.¹¹⁸

Түр магадлан итгэмжлэгдсэн хуулийн сургууль нь зөвхөн хууль зүйн мэргэжлийн дээд боловсрол буюу *Juris Doctor* зэрэг олгох сургалт эрхлэн явуулна. Мөн түр магадлан итгэмжлэгдсэн тухайгаа өөрийн байгууллагын танилцуулга, цахим хуудас зэрэгт тодорхой дурдана.¹¹⁹ Энэ хугацаанд бүрэн магадлан итгэмжлүүлэх талаар хангалттай хүчин чармайлт гаргаагүй, стандартад заасан шаардлагыг хангаагүй гэж үзсэн тохиолдолд түр магадлан итгэмжлэлийг хүчингүйд тооцож болно. Түр магадлан итгэмжлэл нь олгосон цагаас эхлэн хүчинтэй бөгөөд өмнө төгссөн суралцагчид хууль зүйн мэргэжлийн дээд боловсролын зэргийг нөхөж олгохгүй.¹²⁰

Хуулийн сургууль Америкийн Барын холбооноос гаргасан стандартыг бүрэн дүүрэн хангасан гэж Зөвлөлөөс үзсэн тохиолдолд бүрэн хэмжээгээр магадлан итгэмжилнэ. Бүрэн магадлан итгэмжлэгдсэн сургуулийг магадлан итгэмжлэгдсэнээс хойш гурав дахь жилд, түүний дараа 10 жил тутамд нэг удаа Зөвлөл газар дээр нь үзлэг хийж, Америкийн Барын холбооноос тавьж буй стандартад нийцэж буй эсэхийг нь шалгадаг.

3.17. МАГАДЛАН ИТГЭМЖЛЭХ ТУХАЙ ХҮСЭЛТ ГАРГАХ

Магадлан итгэмжлүүлэх тухай хүсэлтийг сургалтаа эхлүүлэх хичээлийн жилээс нэг жилийн өмнө 3 дугаар сарын 15-ны өдөр гэхэд бичгээр

¹¹⁷ 2021 оны 9 дүгээр сарын 19-ний байдлаар дээд боловсролын 198 байгууллага бүрэн магадлан итгэмжлэгджээ. Үүнээс 87 нь нийтийн өмчийн сургууль байгаа бол 111 нь хувийн өмчийнх байна. Их сургуулийн харьяанд бус бие даан үйл ажиллагаа явуулдаг сургууль 15 байна. Америкийн Барын холбооны албан ёсны цахим хуудас https://www.americanbar.org/groups/legal_education/resources/aba_approved_law_schools/

¹¹⁸ American Bar Association, 2021-2022 Standards and Rules of Procedure for Approval of Law Schools, Chapter 1, Standard 102 (a).

¹¹⁹ Мөн тэнд, Standard 102 (e).

¹²⁰ Мөн тэнд, Standard 102 (g).

гаргасан байх ба үүний дагуу Америкийн Барын холбооны Зөвлөлөөс томилогдсон экспертүүд газар дээр нь хяналт шалгалт, үзлэг хийнэ.

Дээр дурдсан хүсэлтэд тухайн хуулийн сургууль нь Америкийн Барын холбооноос тавигдаж буй шаардлагыг бүрэн хангасан тухай дурдах ёстой.

Түр магадлан итгэмжлэл хийлгэхэд тухайн сургуулийн хөтөлбөр, зорилт, элсэн суралцах хүсэлтэй оюутнуудын мэдээлэл, хуулийн сургуульд шаардагдах нөөц бүрдүүлсэн талаарх судалгаа, хичээлийн төлөвлөгөө, сүүлийн гурван жил эсхүл үйл ажиллагаа явуулсан хугацааны санхүүгийн тайлан, сургуулийн өмчлөл, их сургуулийн харьяанд ажилладаг эсэх тухай баримт бичиг, газар дээрх хяналт шалгалтын болон бусад төлбөр хураамж төлсөн баримтыг хавсаргана.¹²¹ Мөн үйл ажиллагаа явуулж буй мужаас дээд боловсролын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэйг нь нотолсон байна.

Өмнө хүсэлтээ гаргасан боловч татгалзсан шийдвэр хүлээн авсан сургалтын байгууллага тухайн алдаа дутагдлыг хэрхэн залруулсан тухайгаа хүсэлтдээ тодорхой тусгана.

3.18. МАГАДЛАН ИТГЭМЖЛЭЛ ХИЙХ ҮЙЛ ЯВЦ

Зөвлөл хуулийн сургуулийн магадлан итгэмжлэлтэй холбоотой шийдвэр гаргахдаа үйл баримт нягтлан шалгахгаар томилогдсон этгээдийн тайлан, газар дээр нь хийсэн сүүлийн хяналт шалгалтын дүн, асуулгад ирүүлсэн хариу, тэдгээртэй холбоотой захидал албан бичиг, түр болон бүрэн магадлан итгэмжлэлд хамруулах тухай хүсэлт, үлэмж өөрчлөлт оруулах зөвшөөрөл авах тухай хүсэлт зэрэгт тулгуурлана.

Зөвлөл аливаа шийдвэрээ хуралдааны дүнд гаргана. Хуулийн сургуультай холбоотой шийдвэр гаргахдаа сонсгол хийнэ. Уг сонсголд сургуулийн захирал буюу төлөөлөх эрх бүхий этгээд өмгөөлөгчийн хамтаар оролцох эрхтэй. Сонсголд оролцох тухай мэдэгдлээ 30-аас доошгүй хоногийн өмнө хүргүүлсэн байна.

¹²¹ American Bar Association, 2021-2022 Rules of Procedure, Rule 22 (b).

Сонголын дараа тухайн хуулийн сургууль Америкийн Барын холбооноос тавьсан стандартыг хангаагүй нь тогтоогдвол хариуцлага хүлээлгэх, алдаа дутагдлаа засаж сайжруулахыг даалгасан шийдвэр гаргана.¹²²

Хэрэв Зөвлөлийн шийдвэр үзэмжийн шинжтэй, баримтад тулгуурлаагүй эсхүл магадлан итгэмжлэх журамд нийцээгүй гэж үзвэл шийдвэрийг гардан авснаас хойш 10 хоногийн дотор гомдол гаргах тухай мэдэгдлээ гаргаж болно. Шийдвэр хүлээн авснаас хойш 40 хоногийн дотор давж заалдах гомдлоо бичгээр хүргүүлнэ. Давж заалдах бүрэлдэхүүн нь өмнө Зөвлөлийн гишүүн байсан эсхүл газар дээрх хяналт шалгалт хийдэг туршлагатай таван гишүүнээс бүрдэнэ. Уг бүрэлдэхүүний нэг ба түүнээс дээш тооны гишүүн нь эрдэмтэн, захиргааны эсхүл боловсролын ажилтан, хуульч эсхүл шүүгч, олон нийтийн төлөөлөл байна.¹²³ Давж заалдах бүрэлдэхүүнээс гурван гишүүн бүхий бүрэлдэхүүн томилогдож гомдлыг шийдвэрлэнэ. Уг бүрэлдэхүүн нь шийдвэрийг хүргүүлснээс хойш 100 хоногийн дотор эсхүл хуулийн сургууль давж заалдах гомдол гаргаснаас хойш 60 хоногийн дотор давж заалдах хуралдааныг товлон зарлана. Давж заалдах хуралдаанд хуулийн сургууль нь өөрийн гаргасан гомдлыг нотлох үүрэгтэй оролцох бөгөөд давж заалдах бүрэлдэхүүнээс Зөвлөлийн шийдвэрийг хэвээр үлдээх эсхүл өөрчлөлт оруулах, түр түдгэлзүүлэх шийдвэрийн аль нэгийг гаргана.¹²⁴

3.19. ХӨТӨЛБӨР, БҮТЭЦ ЗОХИОН БАЙГУУЛАЛТАД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ

Хуулийн сургууль өөрийн хөтөлбөр, бүтэц зохион байгуулалтдаа суурь шинжтэй өөрчлөлт оруулахаар бол Зөвлөлийн зөвшөөрлийг урьдчилан авсан байна. Суурь шинжтэй өөрчлөлт гэдэгт хуулийн өөр сургууль, сургалтын байгууллага, тэдгээрийн хөтөлбөрийг нэгтгэх, сургалтын хөтөлбөр, өмч хөрөнгийг хуулийн өөр сургууль, их сургуульд шилжүүлэх, их сургуулиуд хоорондоо нэгдэх, нийлэх, магадлан

¹²² Мөн тэнд, Rule 20.

¹²³ Мөн тэнд, Rule 32.

¹²⁴ American Bar Association, 2021-2022 Rules of Procedure, Rule 39(b).

итгэмжлэгдсэн хуулийн сургууль болон түүний их сургууль хоорондын харилцааг тодорхойлж буй эрх зүйн байдалд өөрчлөлт оруулах, хуулийн сургуулийн удирдлага, хяналт, өмчлөл өөрчлөгдөх, гэрээ хэлцлийн зэрэг арга замаар өөрчлөлт оруулах, хуулийн сургуулийн удирдлага, зохион байгуулалт, захиргаа, оюутан суралцагч, багшлах бүрэлдэхүүнд нөлөөлөхүйц байдлаар сургуулийн байршлыг өөрчлөх, салбар кампус байгуулах, сургуулийн эрхэм зорилго, зорилгод өөрчлөлт оруулах, зайны сургалт, хагас болон бүтэн цагийн шинэ хөтөлбөр гаргах, *J.D.* мэргэжлийн зэргээс өөр сургалт явуулах зэргээр шинэ арга зүй, хөтөлбөр гаргах, хөтөлбөрийн үргэлжлэх хугацааг цагаас кредит цагт шилжүүлэх, үзэх ёстой кредит цагийн хэмжээг үлэмж нэмэгдүүлэх зэргийг тооцдог байна.¹²⁵

Тухайн магадлан итгэмжлэгдсэн хуулийн сургуульд өөрчлөлт орсноор стандарт шаардлага зөрчигдөх эсэхийг Зөвлөл нягтлан шалгасны үндсэн дээр зөвшөөрөл олгоно. Хэрэв тухайн магадлан итгэмжлэгдсэн сургууль нь нэг ба хэд хэдэн стандарт шаардлагыг хангаагүй эсхүл хангаагүй байж болзошгүйн улмаас хяналтад авагдсан бол зөвшөөрөл авах хүсэлт гаргах боломжгүй.

3.20. САЛБАР КАМПУС БАЙГУУЛАХ, ӨӨР БАЙРШИЛД СУРГАЛТ ЯВУУЛАХ

Хуулийн сургууль өөр өөр байршилд сургалтын үйл ажиллагаа явуулах бол байршил бүрд хангалттай хүрэлцэх багшлах бүрэлдэхүүн, номын сан, сургалтын ажилтан, зөвлөх, карьерт нь туслах зэрэг оюутанд дэмжлэг үзүүлэх үйлчилгээ, биеийн тамир, чөлөөт цаг, техник технологийн нөөцийг бүрдүүлж хангасан байх шаардлага тавигддаг.¹²⁶

Салбар кампусын хувьд дээр дурдсанаас гадна уг салбар кампус нь зөвшөөрөл авснаас хойш гурван жилийн хугацаанд Америкийн Барын холбооны стандарт шаардлагыг бүрэн гүйцэд хангах бодит төлөвлөгөө батлан гаргасан байх, заах арга зүйн болон хариуцлагын шаардлагыг хангасан байх, хуулийн сургуулийн бүтэн цагийн хичээлийн хөтөлбөрт

¹²⁵ American Bar Association, 2021-2022 Standards and Rules of Procedure for Approval of Law Schools, Chapter 1, Standard 105 (a).

¹²⁶ Мөн тэнд, Standard 106 (a), (1) - (5).

бүрэн гүйцэд хамрагдах, оюутны үйлчилгээ, хичээлийн хөтөлбөрийн дагалдах үйл ажиллагаа зэрэг нь оюутанд адил хэмжээний үр өгөөж өгөхүйц байх ёстой.¹²⁷ Хуулийн сургууль бүрэн магадлан итгэмжлэгдсэнээсээ хойш дөрвөн жилийн хугацаанд өөр өөр байршилд үйл ажиллагаа явуулахыг хориглосон. Учир нь энэ хугацаанд сургууль Америкийн Барын холбооны стандарт шаардлагад бүрэн нийцэх, үйл ажиллагаагаа жигдрүүлэх шаардлагатай бөгөөд багшлах бүрэлдэхүүн, номын сан, оюутанд үзүүлэх үйлчилгээний нөөцийг алдагдуулахаас сэргийлдэгтэй холбоотой.

¹²⁷ American Bar Association, 2021-2022 Standards and Rules of Procedure for Approval of Law Schools, Chapter 1, Standard 106 (b)(1) - (3).

Дөрөв. ДҮГНЭЛТ: МОНГОЛ УЛСАД ХЭРЭГЖҮҮЛЖ БОЛОХУЙЦ ТУРШЛАГА

Энэхүү тойм судалгааны хүрээнд АНУ-ын хуульч бэлтгэх үе шат, тогтолцоо, хууль зүйн дээд боловсрол гэсэн үндсэн сэдвийн хүрээнд хуульчдад тавигдах шаардлага, хуулийн сургуулиуд, тэдгээрт тавигдах шаардлага, магадлан итгэмжлэх үйл явц зэрэг асуудлыг дэлгэрүүлэн танилцууллаа. Тус улсын хувьд хуульчдын мэргэжлийн өөрөө удирдах ёсны байгууллага нь ирээдүйн хуульчдыг бэлтгэхэд өргөн хүрээтэй оролцдог, бодлогын шинжтэй шийдвэрүүдийг гаргадаг, хууль зүйн боловсролыг мэргэжлийн зэргийн түвшинд олгож хуульчаа бэлтгэдэг, сургалтын агуулга нь практикт түшиглэсэн байдаг зэрэг цөөнгүй онцлогийг дурдаж болно.

Өмнө дурдсаны дагуу энэхүү тойм судалгаа нь мэдээллийн шинжтэй бөгөөд цаашид АНУ-ын хуульч бэлтгэх тогтолцоог нарийвчлан судлах, давуу болон сул талыг дэлгэрүүлэн тодорхойлох, улмаар манай улсын хуульч бэлтгэх тогтолцоотой харьцуулан судлах чиглэлээр тухайлан бодлогын судалгаа хийх шаардлагатай.

Энэ хэсэгт АНУ-ын хуульч бэлтгэж буй тогтолцооноос авч хэрэгжүүлж болох зарим сайн туршлагыг авч үзнэ.

4.1. ХУУЛЬЧ БОЛОХ ҮЕ ШАТ, ҮЙЛ ЯВЦ

АНУ-ын хуульч бэлтгэх үе шат, явц, ирээдүйн хуульчдад тавьдаг шаардлага зэргээс манай улсад авч хэрэгжүүлж болох сайн туршлага цөөнгүй байна. Тухайлбал, Монгол Улсад хуульчийн эрх олгож байгаа хүнээ нягталж, судлах дорвитой арга ажиллагаа байхгүй гэж хэлж болно. Хууль зүйн сургууль төгссөн, хуульчийн шалгалтдаа тэнцсэн, зохих төлбөр хураамжаа төлсөн, сэтгэцийн эрүүл мэндийн хувьд эрүүл, ял шийтгэл эдэлж байгаагүй бол хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх эрх олгодог. Харин АНУ-д хуульчийг хүнийх нь хувьд маш нарийн, нухацтай судалж, зан байдлын хувьд хуульчаар ажиллаж чадах

эсэхийг нь шалгадаг. Тухайлбал, сургуульд суралцаж байхдаа дотоод дүрэм, журам зөрчсөн эсэх, санхүүгийн чадвар, чадамжийн хувьд хэр вэ гэдгээс эхлээд зүй бус авиртай байсан эсэх, төлөгдөөгүй өр төлбөртэй эсэх, замын хөдөлгөөнд хэрхэн оролцдог болох зэрэг хувь хүнийхээ хувьд хуульч байх шаардлагыг хангасан эсэхийг нь маш нарийн шалгаж тогтоодог. Ийнхүү шалгалтыг давсан боловч хувь хүний зан байдлын хувьд хуульчийн мэргэжилд үл тохирох, мэргэжлийн нэр хүндэд халтай байж мэдэх этгээдийг хуульч болохоос нь өмнө зогсоож байгаа нь манай улсад хэрэгжүүлж болохуйц сайн туршлага юм.

Түүнчлэн хуульчийн мэргэжлийн ёс зүй, хариуцлагад чухал ач холбогдол өгч, өндөр түвшинд авч үзэж байна. Энэ хүрээнд мэргэжлийн ёс зүй, хариуцлагыг хуульчийн шалгалтын нэг бүрэлдэхүүн төдий бус, харин бие даасан шалгалтаар үнэлдэг бөгөөд түүнд тэнцэх хувь ч харьцангуй өндөр (75-86%) юм. Мөн уг шалгалтыг хуульчийн шалгалтаас өмнө өгөх бөгөөд ингэснээр мэргэжлийн ёс зүй, хариуцлагын талаар ойлголт төсөөлөлгүй хүн хуульчийн шалгалт өгөх эрхгүй болдог байна. Харин Монгол Улсад хуульчийн мэргэжлийн шалгалтын нэг хэсэг нь хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрэмтэй холбоотой байдаг боловч энэ нь уг шалгалтын нэг бүрэлдэхүүн хэсэг л болдог тул хуульчдын мэргэжлийн ёс зүй, хариуцлагын асуудлыг бүрэн хамарч чаддаггүй. Нөгөө талаар, хуульчийн мэргэжлийн шалгалтын ёс зүйн холбогдолтой хэсгийг хангалтгүй гүйцэтгэсэн ч бусад хэсгээ амжилттай бөглөснөөр тэнцэх магадлалтай. Түүнчлэн уг сорилын агуулга нь багахан хэмжээний тохиолдолд тулгуурладаг, хариу нь олон сонголтот байж болдог зэрэг туршлагыг нэвтрүүлэх боломжтой гэж үзэж байна.

Хуульчийн шалгалтад эссе бичүүлдэг нь тухайн шалгуулагчийн аливаа асуудлыг таньж тогтоох, цэгцтэй, ухаалаг байдлаар дүн шинжилгээ хийх, хамгийн чухал нь бичгээр бусдыг үндэслэлтэйгээр ятган үнэмшүүлэх, үр дүнтэй харилцах чадварыг шалгадгаараа онцлог юм.

Түүнчлэн гүйцэтгэлийн шалгалт хэмээх шалгалт нь манай улсын бодлогын шалгалттай агуулгын хувьд ойролцоо боловч бодит амьдралд тохиолдож болох нөхцөлд илүү ойртуулсан үйл баримтад холбогдох баримт материалтай танилцаж дүн шинжилгээ хийдэг. Мөн тодорхойгүй, зөрчилдөөнтэй эсхүл үйл баримт, мэдээлэл дутуу зэрэг

бодит нөхцөлд тулгарч болох асуудалтай ажилладаг зэрэг нь мөн л манайд хэрэгжүүлж болох сайн туршлага юм.

Сорилын шалгалт нь дийлэнх тохиолдолд танин мэдэхүйн шинжтэй буюу мэдлэг сорих төдий асуулт огт тавьдаггүй бөгөөд голчлон жижиг тохиолдол дээр ажиллуулдгаараа онцлогтой юм.

4.2. ХУУЛИЙН СУРГУУЛЬ

Хуулийн сургуульд тавьдаг стандарт шаардлагыг жил бүр шинэчлэн, цаг үеийн нөхцөл байдал, нийгмийн хөгжлийг тусгадаг ба хуулийн сургууль үүнд нийцүүлэн сургалтын хөтөлбөр, багшлах бүрэлдэхүүн, заах арга барил, сургалтын орчноо сайжруулж байдаг онцлогтой. Манай улсын хувьд эрх зүйч мэргэжилтэн бэлтгэхэд тавигдах стандартыг хамгийн сүүлд 2007 онд батлан гаргаж, 2008 оноос мөрдөж эхэлсэн ба үүнээс хойш 14 жил өнгөрчээ. Энэхүү ялгаатай нөхцөл байдал нь хуулийн сургуулийн магадлан итгэмжлэлийг төрийн байгууллага эсхүл мэргэжлийн холбооны аль нь хэрэгжүүлж байгаагаас хамааралтай байж болох юм.

АНУ-д хуулийн сургуулийн чанарыг тогтоох хамгийн шударга үнэлгээ нь хуульчийн шалгалтад тэнцсэн төгсөгчдийнх нь хувь байдаг. Ийм учраас хуулийн сургуулиуд энэхүү үзүүлэлтээрээ өрсөлддөг. Монгол Улсад хуульчийн мэргэжлийн шалгалт өгч буй хүмүүсийн 17-23 хувь л тэнцдэг бол АНУ-д хуульчийн шалгалт өгч буй төгсөгчдийн 75-аас дээш хувь нь төгссөнөөсөө хойш хоёр жилийн дотор өгсөн шалгалтдаа тэнцсэн байх шаардлага тавьдаг ба шалгалтад тэнцсэн үзүүлэлт нь 80-аас дээш хувьтай байна. Манай улсын хувьд хууль зүйн их, дээд сургуульд энэ төрлийн шаардлага огт тавигдаагүй байгааг дахин авч үзэж, холбогдох хууль тогтоомж, дүрэм журам, стандартад өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзлээ.

Түүнчлэн хуулийн сургуульд элсэхэд авдаг шалгалт тухайлсан онцлогтой байна. Уг шалгалтаар шалгуулагчийн эрх зүйн мэдлэг, ойлголтыг шалгахаас илүүтэйгээр сэтгэн бодох, үндэслэл гаргах, асуудалд шүүмжит сэтгэлгээгээр хандах, дүн шинжилгээ хийх, бичих зэрэг ур чадварыг нь шалгадаг. Энэ төрлийн шалгалтаар оюутан

практикт түшиглэсэн хичээлд үр дүнтэй оролцож чадах эсэхийг шалгадаг байна.

Сургалтын хөтөлбөр, кредит цаг өндөр биш боловч үзэх хичээлийн агуулгын шаардлагыг тухайн төгсөгчийн практикт ажиллах чиглэлтэй нийцүүлж авч үздэгээрээ онцлогтой. Түүнчлэн хуулийн сургуулийн оюутан өөрийн мэргэжлийн замналыг хэрхэн төлөвлөж байгаагаас хамаараад үзэх хичээлээ сонгох боломж нээлттэй байгааг анхаарч үзэх нь зүйтэй.

АНУ-д хуулийн сургуулийн сургалтын хөтөлбөр, орчин нөхцөл, тоног төхөөрөмжийн шаардлагыг маш нарийн тогтоожээ. Хууль зүйн мэргэжлийн зэргийн сургалтаа бүрэн хэмжээнд магадлан итгэмжлүүлж, үйл ажиллагаа нь тогтворжсон, сургуулийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөхгүйгээс бусад тохиолдолд хуулийн сургууль олон салбар байгуулах эсхүл өөр зэргийн сургалт явуулахыг хязгаарладаг. Ингэснээр хуулийн сургууль өөрийн нөөц боломждоо нийцүүлж үндсэн сургалтын үйл ажиллагаагаа өндөр түвшинд явуулах нөхцөл бүрдүүлдэг байна.

Дээр дурдсантай холбоотойгоор АНУ-д хуулийн сургууль сургалтын хөтөлбөрөө хэрэгжүүлэхэд шаардагдах төсөв санхүү, нөөцийг бүрдүүлсэн байх шаардлагыг тогтоож өгчээ. Аливаа сургалтын байгууллага сайн багшлах бүрэлдэхүүнтэй, номын сан, техник тоног төхөөрөмж хангалттай түвшинд байх эсэх нь хөтөлбөрийн санхүүжилттэй шууд холбоотой. Сургалтын байр, танхим түрээсэлдэг бол түрээсийн төлбөрөө ойрын хугацаанд төлөх чадавхтай эсэхийг нь хүртэл шалгаж байж магадлан итгэмжлэх эсэхээ шийддэг нь тус улсад хуулийн сургуулиуддаа хэр зэрэг шаардлага тавьдаг, хуульч мэргэжилтэн бэлтгэх үйл ажиллагаанд хэрхэн анхаардаг болохыг харуулах нэг жишээ юм.

Хууль зүйн боловсролын үйл ажиллагаа амжилттай байх хамгийн чухал нөхцөлүүдийн нэг нь багшлах бүрэлдэхүүн сайтай байх явдал. АНУ-д хуулийн сургуулиуд голчлон үндсэн багштай байх, багшлах боловсон хүчнээ хөгжүүлэх, академик эрх чөлөөг нь бүрдүүлэх, эрдэм шинжилгээ, судалгааны ажил эрхлэхэд нь бүхий л талаар дэмжлэг үзүүлэхэд анхаардаг. Харин Монгол Улсад хууль зүйн их, дээд сургуулиудад ажиллаж байгаа багш нарт ийм нөхцөл боломж бүрдсэн

эсэх, ажлын цагийн хэдэн хувьд нь хичээл зааж эсхүл сургуулийн захиргааны шинжтэй үүрэг даалгаврыг гүйцэтгэн өнгөрүүлдэг, хэдэн хувьд нь өөрийн мэдлэг, чадварыг дээшлүүлэхэд чиглэсэн судалгаа шинжилгээний ажил хийдэг талаар зайлшгүй судалж үзэх шаардлагатай.

Аль ч мэргэжлийн сургалтын үйл ажиллагаанд номын сан чухал үүрэг гүйцэтгэдэг. Хуулийн сургуулийн хувьд ч оюутнууд нь сайн суралцах, багш нар нь мэдлэг, чадвараа гүнзгийрүүлэх, мэргэшсэн түвшинд судалгаа шинжилгээний ажил эрхлэхэд зайлшгүй шаардлагатай зүйл нь мэргэжлийн номын сан юм. Монгол Улсад хууль зүйн их, дээд сургууль номын сантай байх, шаардлагатай ном тодорхой тоотой байх талаар холбогдох стандартад зааснаас өөр шаардлага тавигддаггүй. Харин АНУ-д хуулийн сургуулийн номын санд ямар хууль тогтоомж, шүүхийн шийдвэр, дүрэм журам, мэргэжлийн сэтгүүл, сурах бичиг байх ёстой талаар болон судалгааны цахим бааз ашигладаг, бусад номын сантай хамтран ажилладаг байх зэрэг агуулгын шинжтэй нарийн стандартыг тогтоож өгчээ.

Түүнчлэн хуулийн сургуулийн хүлээх хариуцлага нь чухал нөхцөлийн нэг юм. Манай улсад төгсөгчдийн маш бага хувь хуульчийн шалгалтад тэнцдэг, сургалтын чанар, хүртээмжийн алдаа дутагдал гаргадаг боловч хууль зүйн сургуулиудын хариуцлагын асуудлыг тэр бүр хөнддөггүй. АНУ-д хуулийн сургуулиудад хамгийн өндөр шаардлага тавьж, түүнийхээ хэрэгжилтийг тодорхой хугацаанд тогтмол шалгаж, магадлан итгэмжилдэг, зөрчил илэрсэн тохиолдолд түүнд тохирсон хариуцлагын арга хэмжээг тухай бүрт нь хүлээлгэдэг гэх мэтээр хуульч бэлтгэх тогтолцоонд гарч буй алдаа эндэгдлийг хожим хүний эрхийн зөрчил болохоос сэргийлэх, аливаа зөрчил дутагдлыг цаг тухайд нь залруулах ухаалаг механизмтай.

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

А. Монгол хэлээр

1. Б.Чимид, Төр, нам, эрх зүйн шинэтгэлийн эгзэгтэй асуудал, Хоёрдугаар дэвтэр, УБ., 2008.
2. П.Нарантуяа, “Хууль зүйн боловсролын тогтолцоонд шинэ стандарт үйлчилнэ” (Ярилцлага), Монголын Хуульчдын холбоо, 2017.
3. Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр.
4. Үндэсний статистикийн хороо, Статистикийн мэдээллийн нэгдсэн сан.
5. Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль, 2012.

Б. Англи хэлээр

1. Adam S. Minsky, Court Cites Student Loans As Reason To Deny Bar Admission To New Lawyer, Forbes, Jan 23, 2020, <https://www.forbes.com/sites/adamminsky/2020/01/23/court-denies-bar-admission-to-new-lawyer-due-to-student-loans/?sh=3fb76b09548f>
2. American Bar Association, 1969 Standards of the American Bar Association for Legal Education.
3. American Bar Association, 2021-2022 Standards and Rules of Procedure for Approval of Law Schools.
4. American Bar Association, Survey of Law School Curricula 2002-2010.
5. Charles R. McManis, The History of First Century American Legal Education: A Revisionist Perspective, 59 WASH. U. L. Q. 597 (1981), https://openscholarship.wustl.edu/law_lawreview/vol59/iss3/2
6. Christopher P. Banks, The American Legal Profession: The Myths and Realities of Practicing Law. Thousand Oaks: SAGE Publications, ISBN 9781506333137, 2017.
7. Daniel R. Hansen, Do We Need the Bar Examination—A Critical Evaluation of the Justifications for the Bar Examination and Proposed Alternatives?, 45 Case W. Rsrv. L. Rev. (1995), p. 1192, <https://scholarlycommons.law.case.edu/caselrev/vol45/iss4/32>;

8. Marion R. Kirkwood and Willam B. Owens, (n.d.). A Brief History of the Stanford Law School, 1893–1946 (PDF), S.U. School of Law (Report), p. 1, <https://web.archive.org/web/20120407053200/http://www.law.stanford.edu/school/history/historysls.pdf>
9. James M. Concannon, The Other Law Schools of Early Day Kansas, J. KAN B.ASS'N, Nov. 1996.
10. Lawrence M. Friedman, A History of American Law (1973).
11. Moline, Brian J., Early American legal education, Washburn Law Journal Vol 42, p. 42, <https://contentdm.washburnlaw.edu/digital/collection/wlj/id/6369/>
12. National Conference of Bar Examiners <https://reports.ncbex.org/>
13. Нью-Йорк мужийн давж заалдах шатны шүүхийн албан ёсны цахим хуудас, <http://ww2.nycourts.gov/attorneys>
14. The State Bar of California, <https://www.calbar.ca.gov/>
15. Survey of Admission Rules in Federal District Courts (PDF), U.S. District Court for the District of Maryland, 2015.
16. Rules of the Court of Appeals for the Admission of Attorneys and Counselors at Law 520.4 (a), <https://www.nybarexam.org/Rules/Rules.htm#520.4>
17. Supreme Court of Delaware, Rules of the Supreme Court of the State of Delaware, <https://www.courts.delaware.gov/rules/pdf/SupremeCourtRules-July2021.pdf>

МЭРГЭШСЭН ХУУЛЬЧ БЭЛТГЭХ
БҮГД НАЙРАМДАХ СОЛОНГОС УЛСЫН
ТОГТОЛЦОО, ТҮҮНИЙ ХӨГЖЛИЙН
ЧИГ ХАНДЛАГА

Ш.ЧУЛУУНБАТ
доктор (PhD), дэд профессор

Улаанбаатар
2021

ГАРЧИГ

Нэг. СУДАЛГААНЫ ЗОРИЛГО, АРГА ЗҮЙ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ	59
1.1. Судалгааны зорилго	59
1.2. Судалгааны мэдээлэл, боловсруулалт	59
1.3. Судалгааны арга зүй	59
1.4. Тайлангийн бүтэц, агуулга	60
1.5. Судалгааны товч үр дүн	61
Хоёр. МЭРГЭШСЭН ХУУЛЬЧ БЭЛТГЭХ ТОГТОЛЦООНЫ ШИНЭЧЛЭЛ, ТУРШЛАГА, СУРГАМЖ	62
2.1. Мэргэшсэн хуульч бэлтгэх тогтолцооны шинэчлэлийн өмнөх үе	62
2.2. Мэргэшсэн хуульч бэлтгэх тогтолцооны шинэчлэл	64
2.3. Америк маягийн шинэ тогтолцоог нэвтрүүлсэн туршлага	66
2.4. Мэргэшсэн хуульч бэлтгэх тогтолцооны үндсэн эх сурвалж	69
Гурав. МЭРГЭШСЭН ХУУЛЬЧ БЭЛТГЭХ ТОГТОЛЦООНЫ СУРГАЛТЫН ОНЦЛОГ, ҮНДСЭН ШАЛГУУР	70
3.1. Хуулийн мэргэшсэн сургуулийн бүтэц, зохион байгуулалт, удирдлагын тухай хуулийн нийтлэг үндэслэл	71
3.2. Эрх зүйн боловсролын холбооны бүтэц, зохион байгуулалт	76

3.3. Хуулийн мэргэшсэн сургуулийн үйл ажиллагааны онцлог, тавигдах шаардлага стандарт	77
3.4. Хуулийн мэргэшсэн сургуулийн үйл ажиллагаанд тавих хяналтын тогтолцоо, боловсролын магадлан итгэмжлэл	83
3.5. Эрх зүйн сургалтын хөтөлбөрийн агуулга, багтаамж	89
 Дөрөв. ХУУЛЬЧИЙН ШАЛГАЛТЫН АГУУЛГА, ЭРЭЛТ ХЭРЭГЦЭЭ	 93
4.1. Хуульчийн шалгалтад тавигдах шаардлага, шалгуур	93
4.2. Хуульчийн шалгалтын хэлбэр, агуулга	96
4.3. Хуульчийн шалгалтын хороо, түүний бүтэц, зохион байгуулалт	98
4.4. Хуульчийн шалгалтын журам зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага	100
 Тав. МЭРГЭШСЭН ХУУЛЬЧ БЭЛТГЭХ ТОГТОЛЦООНЫ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ ЦААШДЫН ЧИГ ХАНДЛАГА	 102
5.1. Мэргэшсэн хуульч бэлтгэх тогтолцооны өнөөгийн байдал	102
5.2. Мэргэшсэн хуульч бэлтгэх тогтолцоонд тулгамдаж буй асуудал, ирээдүйн чиг хандлага	107
 Зургаа. ДҮГНЭЛТ, САНАЛ	 111
ЭХ СУРВАЛЖ	114
ХАВСРАЛТ	117

ХҮСНЭГТ, БҮДҮҮВЧИЙН ЖАГСААЛТ

Бүдүүвч 1. Мэргэшсэн хуульч бэлтгэх тогтолцоо	71
Хүснэгт 1. Хуульчийн ур чадварын шалгалтын агуулга, хэлбэр	81
Хүснэгт 2. Олон улсын худалдааны эрх зүйн мэргэжлийн сургалт	92
Хүснэгт 3. Хуульчийн шалгалтын сэдэв	97
Хүснэгт 4. Элсэгчдийн квот (сургуулиар)	104
Хүснэгт 5. Хуулийн мэргэшсэн сургуулийн сургалтын дундаж төлбөр (2020 оны байдлаар)	106
Хүснэгт 6. Хуульчийн шалгалтад оролцсон ба тэнцсэн хүмүүсийн тоон судалгаа, сүүлийн 10 жилийн байдлаар	108

Нэг. СУДАЛГААНЫ ЗОРИЛГО, АРГА ЗҮЙ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

1.1. СУДАЛГААНЫ ЗОРИЛГО

Энэхүү судалгааны ажлаар мэргэшсэн хуульч бэлтгэх Бүгд Найрамдах Солонгос Улс (БНСУ)-ын тогтолцоо, түүний хөгжлийн чиг хандлагыг судлан дүн шинжилгээ хийж, дүгнэлт, санал боловсруулахыг зорилоо. Судалгаанд дараах үндсэн зорилтуудыг тавьж ажиллав. Үүнд:

- БНСУ-ын мэргэшсэн хуульч бэлтгэх тогтолцооны эрх зүйн үндсэн эх сурвалжийг судлах;
- Мэргэшсэн хуульч бэлтгэх сургалтын үйл ажиллагааг судлах;
- Хуульчийн шалгалтын чанар, эрэлт хэрэгцээ, агуулгын талаар судлах;
- Мэргэшсэн хуульч бэлтгэх БНСУ-ын тогтолцооны өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийж, дүгнэлт, санал боловсруулах зэрэг болно.

1.2. СУДАЛГААНЫ МЭДЭЭЛЭЛ, БОЛОВСРУУЛАЛТ

Судалгаанд хоёрдогч эх сурвалжуудыг ашигласан бөгөөд албан ёсны эх сурвалжийг солонгос хэлнээс, нэмэлт мэдээллийг англи хэлнээс орчуулан боловсруулалт хийв.

1.3. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

Энэхүү тайлбар судалгааг 2021 оны 8 дугаар сарын 20-ноос 9 дүгээр сарын 27-ны хооронд явууллаа. Чанарын судалгааны үндсэн зарчмыг баримтлан задлан шинжлэх, харьцуулах, нэгтгэн дүгнэх, баримт бичгийн боловсруулалт хийх аргуудыг уг судалгаанд ашигласан бөгөөд

албан ёсны эх сурвалж ашиглахын өмнө чиглэлийн зарим эрдэмтэнтэй утсаар ярилцлага хийж зөвлөгөө, чиглэл авч ажиллалаа.

1.4. ТАЙЛАНГИЙН БҮТЭЦ, АГУУЛГА

Мэргэшсэн хуульч бэлтгэх БНСУ-ын тогтолцоо, түүний хөгжлийн чиг хандлага сэдэвт энэхүү судалгааны ажлын тайлан зургаан бүлгээс бүрдэх ба тэдгээр нь:

- Судалгааны зорилго, арга зүй, зохион байгуулалт;
- Мэргэшсэн хуульч бэлтгэх тогтолцооны шинэчлэл, туршлага, сургамж;
- Мэргэшсэн хуульч бэлтгэх тогтолцооны сургалтын онцлог, үндсэн шалгуур;
- Хуульчийн шалгалтын агуулга, эрэлт, хэрэгцээ;
- Мэргэшсэн хуульч бэлтгэх тогтолцооны өнөөгийн байдал, цаашдын чиг хандлага;
- Дүгнэлт, санал зэрэг болно.

Судалгааны тайлангийн нэгдүгээр бүлэгт судалгааны зорилго, арга зүй, зохион байгуулалтын талаар; хоёрдугаар бүлэгт мэргэшсэн хуульч бэлтгэх тогтолцооны шинэчлэл, туршлага, сургамжийн талаар; гуравдугаар бүлэгт мэргэшсэн хуульч бэлтгэх тогтолцооны сургалтын онцлог, үндсэн шалгуурын талаар; дөрөвдүгээр бүлэгт хуульчийн шалгалтын агуулга, эрэлт хэрэгцээний талаар; тавдугаар бүлэгт мэргэшсэн хуульч бэлтгэх тогтолцооны өнөөгийн байдал, цаашдын чиг хандлагын талаар болон зургаадугаар бүлэгт судлаачийн дүгнэлт, саналыг багтаалаа.

1.5. СУДАЛГААНЫ ТОВЧ ҮР ДҮН

Энэхүү ажлаар мэргэшсэн хуульч бэлтгэх БНСУ-ын тогтолцооны уламжлал, шинэчлэл, эрх зүйн эх сурвалж, зохицуулалт, хуулийн мэргэшсэн сургуулийн үйл ажиллагааны онцлог, хуульчийн шалгалтын агуулга, тавигдах шаардлага, сургалтын онцлог, хөтөлбөрийн агуулга, багтаамж, мэргэшсэн хуульч бэлтгэх тогтолцооны өнөөгийн байдал түүний хөгжлийн чиг хандлагын талаар судалж судлаачийн зүгээс өөрийн дүгнэлт, саналыг дэвшүүлсэн болно.

Хоёр. МЭРГЭШСЭН ХУУЛЬЧ БЭЛТГЭХ ТОГТОЛЦООНЫ ШИНЭЧЛЭЛ, ТУРШЛАГА, СУРГАМЖ

Мэргэшсэн хуульч бэлтгэх БНСУ-ын тогтолцооны шинэчлэлийн талаарх зарим онцлох үйл явцыг мэргэшсэн хуульч бэлтгэх тогтолцооны шинэчлэлийн өмнөх үе, мэргэшсэн хуульч бэлтгэх тогтолцооны шинэчлэл болон америк маягийн шинэ тогтолцоог нэвтрүүлсэн туршлага, сургамж гэсэн дэд бүлэгт хуваан судаллаа. Мэргэшсэн хуульч бэлтгэх тогтолцооны шинэчлэл 2007 оноос эхэлсэн бөгөөд түүнийг нэвтрүүлэхэд тулгамдаж байсан асуудлууд болон шинэчлэлийн түүхэн ач холбогдол, цаашдын хөгжлийн үндэс суурийн талаар энэхүү бүлэгт орууллаа.

2.1. МЭРГЭШСЭН ХУУЛЬЧ БЭЛТГЭХ ТОГТОЛЦООНЫ ШИНЭЧЛЭЛИЙН ӨМНӨХ ҮЕ

БНСУ нь эрх зүйн боловсролын тогтолцооны шинэчлэлийг тодорхой үе шаттай нэвтрүүлж байгаа бөгөөд шинэчлэлийн өмнөх үеийн эрх зүйн боловсролын тогтолцоо¹ нь хуульчийн улсын шалгалтад бэлтгэх арга барилд тулгуурласан (хуулийг үр дүнгүй цээжлүүлдэг) хуульч болох сонирхолтой цөөн тооны хүнд зориулагдсан байв.

Хуульчийн шалгалтад тэнцсэн бакалаврын зэрэг бүхий цөөн тооны хүн БНСУ-ын Дээд шүүхээс² зохион явуулдаг Шүүхийн сургалт, судалгааны хүрээлэнгийн (ШССХ) буюу засгийн газрын тэтгэлэгт хоёр жилийн сургалтад хамрагдан өмгөөлөгч, шүүгч, прокурор³ хийх эрхтэй болдог байв. ШССХ-гийн үйл ажиллагааны үндсэн зорилго нь ирээдүйн өмгөөлөгч, шүүгч, прокурорыг сургах явдал байсан бөгөөд

¹ Dae-Kyu Yoon, Law and Democracy in South Korea: Democratic Development Since 1987, p. 134 (2010).

² Dae-Kyu Yoon, Law and Democracy in South Korea: Democratic Development Since 1987, p. 136-137 (2010).

³ Kyong-Whan Ahn, Law Reform in Korea and the Agenda of “Graduate Law School,” 24 WIS. INT’L L.J. p.223, p.227 (2006).

тухайн үед хуульчийн шалгалт нь ШССХ-гийн элсэлтийн шалгалт хэлбэрээр зохион байгуулагддаг байжээ. ШССХ-гийн сургалтад эхэн үедээ туршлагатай шүүгч, прокурор, өмгөөлөгчид мэргэжлийн сургалт явуулдаг байсан⁴ бөгөөд уг сургалтад их сургуулийн эрдэмтэн, профессор, багш нарын эзлэх хувь маш бага байжээ. Хуульчийн шалгалтад тэнцэгсдийн тоо өсөхийн хэрээр ШССХ-нд элсэгчид нэмэгдэж төгсөгчдийн дийлэнх нь хувийн өмгөөлөгч, цөөнх буюу ойролцоогоор тавны нэг хувь нь шүүгч, прокурор болдог байжээ. Мэргэшсэн хуульч бэлтгэх тогтоолцоо нь агуулга, бүтцийн хувьд маш олон зөрчилдөөн, хүндрэл, нийгмийн сөрөг үзэгдлийг дагуулах болсон нь салбарын шинэчлэл зайлшгүй хийгдэх шалтгаан болсон.

БНСУ-д мэргэшсэн хуульч бэлтгэх квотын систем (1949 оноос хойш) шинээр “төрөх” хуульчдын тоонд тавих хяналтыг чангатгасан байх бөгөөд улмаар энэхүү систем нь нэг хүнд ногдох хуульчийн тоог цөөрүүлсэн хүчин зүйлүүдийн нэг болсон. БНСУ-ын мэргэшсэн хуульчийн тоо 2008 он гэхэд 10 мянгад хүрсэн боловч хүйсийн харьцаа буюу эмэгтэйчүүд ойролцоогоор 10 орчим хувьд⁵ хүрч байжээ. Тухайн үед мэргэшсэн хуульчийн эрэлт хэрэгцээ, нэр хүнд хурдан өссөн нь нийгэмд хуульчдыг хамгийн эрх мэдэл бүхий давхарга гэж үзэхэд хүргэсэн бөгөөд төлбөр өндрөөс болоод жирийн иргэд эрх зүйн үйлчилгээ авах боломжгүй байдалд хүрсэн. Түүнчлэн үндэсний шилдэг их дээд сургуулиуд, тэр дундаа Сөүлийн үндэсний их сургуулийг төгсөгчид энэ салбарт ноёлох хандлагатай болсон нь дээрх байдлыг улам гүнзгийрүүлж “олигархижсан монополь” хуульч бэлтгэх уламжлал тогтох эрсдэл бий болгосон.⁶

Хуульчийн шалгалтыг нэг хүн хэдэн ч удаа өгч болох ба шалгалт өгөхөд хязгаарлалт тогтоогоогүй нь олон хүн, олон жилийн турш шалгалтад тэнцэх оролдлого хийх, тэр хэрээр их хөрөнгө мөнгө, цаг хугацаа зарцуулах, үр дүнгүй зохиомлоор цээжлүүлэх сургалтын арга барил бүхий сургуульд биечлэн бэлтгэл хийж, амжилт үзүүлнэ гэсэн төөрөгдөлд орох явдлыг өдөөсөн. Өөрөөр хэлбэл, эрх зүйн чиглэлээр

⁴ Dae-Kyu Yoon, *Law and Democracy in South Korea: Democratic Development Since 1987*, p. 136-137 (2010).

⁵ Nathan Schwartzman, *Female Lawyers Increasing in Korea*, ASIAN CORRESPONDENT (2008).

⁶ Rosa Kim, *The “Americanization” of legal Education in South Korea: Challenges and Opportunity*, Brooklyn Journal of International Law, Volume 38-I, 2012, p. 49-75.

суралцагсдын ихэнх нь хууль цээжлүүлэх, бэлэн товчлол, шалгалтын тест өгөх, бөглөх аргачлалд сургах арга барилтай⁷ сургуулиудад багагүй цаг, мөнгөө зарцуулж ирсэн. Мөн бакалаврын түвшний эрх зүйн боловсролын агуулга нь хуульчийн шалгалтын агуулгатай ямар ч уялдаа, залгамж холбоогүй, практик туршлага, мэргэжлийн ур чадвар, мэдлэгийг шалгахаасаа илүүтэй эрх зүйн цээжилсэн онолыг шалгах зорилготой боловсруулагддаг байсан.

Эрх зүйн боловсролын тогтолцоо ба хуульчийн шалгалтын эцсийн үр дүнгийн хооронд ямар нэгэн бодит холбоо байхгүйн улмаас эрх зүйн бакалаврын боловсролоор мэргэжлийн ур чадварт бэлтгэх биш, харин хуульчийн шалгалтад хамруулахад туслах онолын сэдвүүдэд илүү төвлөрөх болсон.

Үүнээс үүдэн төгсөгчдийн дийлэнх олонх нь тухайн салбарт ажиллах дадлага туршлага, ур чадваргүй⁸ байсан. Мөн их сургуульд эрх зүйн багш болохыг хүссэн төгсөгчид хуульчийн шалгалтад бэлтгэхийн оронд гадаад улсад гарч судалгааны ажил хийхийг илүүд үзэх болсноор шүүх эрх мэдлийн байгууллага, их дээд сургууль хоорондоо солилцоо хийх, сэлгэн ажиллуулах боломжийг сулруулж байв.

Түүнчлэн зарим эрэгтэй оюутан хуульчийн улсын шалгалтыг цэргийн алба хаах үүргийг хойшлуулах хэрэгсэл болгон ашиглах нь ихсэх хандлагатай болжээ.

2.2. МЭРГЭШСЭН ХУУЛЬЧ БЭЛТГЭХ ТОГТОЛЦООНЫ ШИНЭЧЛЭЛ

БНСУ-ын Засгийн газар авторитар хэв шинжит засаглалаас ардчилсан тогтолцоонд шилжиж шинэ Үндсэн хууль (1987) баталсан нь шүүх засаглалын шинэчлэлд томоохон алхам хийх урьдчилсан нөхцөлийг бүрдүүлсэн байна. Дэлхий дахинд өрсөлдөх чадвартай мэргэшсэн хуульчдыг бэлтгэх зорилгоор америк хэв маягийн тогтолцоо нутагшуулахыг чухалчлах болсноор олон хүндрэл, бэрхшээл тулгарсан

⁷ Matthew J. Wilson, U.S. Legal Education Methods and Ideals: Application to the Japanese and Korean Systems, 18 Cardozo J.Int'l & Comp.L., p. 295, p. 335 (2010).

⁸ Setsuo Miyazawa et al., The Reform of Legal Education in East Asia, 4 Ann.Rev.L.&SOC. SCI., p. 39-89 (2008).

хэдий ч ерөнхийлөгч Ким Ён Сам 1995 онд шинэчлэлийг эхлүүлж чадсан байна. Улмаар тус улсын хамгийн том гэгдэх “Ардчиллын төлөөх ард түмний нэгдэл” хэмээх ТББ-ын дэргэд *Judiciary Watch* буюу Шүүх эрх мэдлийн хяналтын нэгж байгуулагджээ. Салбарын судлаач, мэргэжилтэн, хэвлэл мэдээлэл, төрийн бус байгууллагын хамтын ажиллагааг уялдуулах зорилго бүхий энэ нэгж нь дараах үүрэг хүлээж ажиллажээ. Үүнд:

- Иргэдэд үзүүлэх хууль зүйн туслалцаа, үйлчилгээний тоо, чанарыг нэмэгдүүлэх;
- Шүүх тогтолцооны хараат бус байдал, тэгш, шударга байдлыг хангуулах;
- Шүүх тогтолцооны үйл ажиллагааны үр дүнг нэмэгдүүлэх, олон нийтийн хандлага, итгэлийг нэмэгдүүлэх зэргээс гадна мэргэшсэн хуульчдын шударга бус зэрэг дэв ахих уламжлалт тогтолцоог халах, тангарагтны тогтолцоог нэвтрүүлэх, мэргэшсэн хуульчийг олон болгох, эрх зүйн боловсролын тогтолцоог сайжруулах, АНУ-ын эрх зүйн боловсролын тогтолцооны загварыг нутагшуулах.

Дээрх үзэл баримтлал нь иргэдийн анхаарал, сонирхлыг ихэд татсан байна. Ерөнхийлөгч Ким Ён Сам мэргэшсэн хуульч бэлтгэх квотыг нэмэгдүүлэх бодлого баримтлан, 1995 оны байдлаар 300 байсан үзүүлэлт 2002 онд 1,000 болж нэмэгдсэн нь нээлттэй хандлага бүрдүүлэх алхмыг тавьжээ. Энэхүү өсөлт бүрэн хэмжээний шинэчлэл хийх зайлшгүй шаардлага үүсэж буйг баталсан байдаг. Гэсэн хэдий ч эрх зүйн боловсролын тогтолцоог өөрчлөх асуудал нь нийгэм, улс төрийн хүрээнд маргаантай байсны улмаас хэрэгжүүлж чадаагүй байна.

Ерөнхийлөгч Ну Му Хёны засгийн газар (2003) шинэчлэлийн хүрээнд шүүхийн эрх мэдлийн салбарыг шинэчлэх тууштай бодлого танилцуулснаар Шүүх эрх мэдлийн шинэчлэлийн хороо байгуулагджээ. Шүүх эрх мэдлийн шинэчлэлийн хороо нь “Шүүх эрх мэдлийн тогтолцоог боловсронгуй болгох, шударга, ардчилсан хууль ёсыг дээдлэх, олон нийтийн итгэлийг нэмэгдүүлэх, чанартай, дэлхийд өрсөлдөх чадвартай мэргэшсэн хуульчдыг бэлтгэх” үндсэн зорилгыг дэвшүүлсэн байна.

Улмаар америк маягийн эрх зүйн боловсролын тогтолцоог бий болгох асуудал олон нийтийн анхаарлыг дахин татах болж, уг шинэчлэлийн "америк" гэдэг үгийг онцлон эсэргүүцэгчид олон улсын нийтлэг чиг хандлагыг баримтлахын тулд Солонгос Улс, үндэсний онцлогоо алдагдуулж байна гэсэн маргааныг өдөөжээ. Гэвч энэхүү маргааны эх сурвалж нь байр суурь, давуу эрх мэдлээ хэвээр хадгалан үлдэх санаархал бүхий цөөн тооны салбарын мэргэжилтэн, зарим сургуулийн профессор багш нараас үүдэлтэй гэж үздэг.

Шинэчлэлийн хүрээнд эрх зүйн чиглэлээр сургалт явуулдаг их сургуулиудын давуу эрх мэдэл, нөлөөг бууруулах, Дээд шүүхээс удирдан явуулдаг мэргэшсэн хуульчийн хоёр жилийн сургалтыг их сургуулийн мэдэлд шилжүүлэх зайлшгүй шаардлага тулгарчээ. Тухайн үед Шүүхийн сургалт, судалгааны хүрээлэнг татан буулгах, мэргэшсэн хуульчдын тоог нэмэгдүүлж, өрсөлдөөн бий болгох нь хуульчийн үйл ажиллагааны чанарыг бууруулах эрсдэлтэй хэмээн маргаан үүсгэж байсан ч энэ нь шинэчлэлийн үйл ажиллагаанд төдийлөн саад болж чадаагүй.

Нийгэм, улс төрийн зөрчилдөөн бүхий хэд хэдэн хэлэлцүүлгийн дараа (2007) Хуулийн мэргэшсэн сургууль байгуулах тухай хууль баталсан бөгөөд эрх зүйн боловсролын шинэ тогтолцоог 2009 оноос хэрэгжүүлж эхэлжээ. Шүүх эрх мэдлийн салбарын шинэчлэл, хууль зүйн туслалцаа, үйлчилгээ болон эрх зүйн боловсролын тогтолцоог шинэчлэх нийгмийн шаардлага нь ийнхүү шинэчлэл хийх нөхцөл бүрдүүлсэн байна.

2.3. АМЕРИК МАЯГИЙН ШИНЭ ТОГТОЛЦООГ НЭВТРҮҮЛСЭН ТУРШЛАГА

БНСУ америк маягийн шинэ тогтолцоог бий болгосноор мэргэшсэн хуульчдыг бэлтгэх, шинэ үеийг төрүүлэх, сургалтын өөр загвар нэвтрүүлэх зорилт дэвшүүлжээ. Эрх зүйн боловсролын тогтолцоонд хийсэн энэхүү томоохон шинэчлэл нь хуульчийн мэргэжлийн боловсролыг чанаржуулах, мэргэшсэн хуульчийн нийгмийн эрэлт хэрэгцээг хангах, хуульчийн ёс зүйг чангатгах, мэргэшсэн хуульчдыг

нэмэгдүүлэх⁹ үндсэн зорилго агуулж байв. Тиймээс эрх зүйн боловсролын тогтолцоонд чанартай сургалт-дадлагыг хослуулсан¹⁰ үйл ажиллагааны чиглэл баримтлахаар төлөвлөжээ.

БНСУ-д мөрдөж байсан хуучин тогтолцоогоор дөрвөн жилийн бакалаврын сургалтын дараа хоёр жилийн мэргэшүүлэх сургалтад хамруулан мэргэшсэн хуульч бэлтгэдэг байсан бол 2007 оны 7 дугаар сард Хуулийн мэргэшсэн сургуулийн бүтэц, зохион байгуулалт, удирдлагын тухай хууль батлагдсанаар Хуулийн мэргэшсэн сургуульд гурван жил суралцаж, магистрын зэрэг хамгаалсны дараа хуульчийн шалгалт өгөх эрх үүсэх зохицуулалттай болж өөрчлөгджээ.¹¹ Хуулийн мэргэшсэн сургуулийн бүтэц, зохион байгуулалт, удирдлагын тухай хуулийн төсөл нь зөвшилцлийн үндсэн дээр 2007 оны 7 дугаар сард Үндэсний Ассамблейгаар хэлэлцэгдэж, уг хуулийг хэрэгжүүлэх тухай Ерөнхийлөгчийн зарлигийн хамтаар 2007 оны 9 дүгээр сард батлагдсан.

Улмаар 2007 оны 10 дугаар сард хуулийн мэргэшсэн сургуулийн нийт оюутны тоог улсын хэмжээнд 2,000, хуулийн мэргэшсэн сургууль улсын хэмжээнд 25 байхаар хуульчлан зохицуулсан байна. Эхний сонгон шалгаруулалтад 41 сургууль оролцсон¹² бөгөөд өрсөлдөөн ихтэй байжээ. 2008 оны 1 дүгээр сард Хууль зүйн боловсролын хорооноос хуулийн мэргэшсэн сургууль байгуулах зөвшөөрлийг 25 сургуульд олгосон байна. Үүнээс 15 их сургуулийг Сөүл хотын бүсэд, орон нутгийг дэмжих зорилгоор 10 их сургуулийг бусад хотоос сонгожээ. Гэхдээ сонгогдсон сургуулиуд хуучин явуулж байсан бакалаврын сургалтаа зогсоох шаардлагатай болсон бөгөөд харин сонгогдоогүй сургуулиуд бакалаврын зэргийн сургалтаа үргэлжлүүлэх боломжтой үлдсэн байна. Шинэ сургуулиуд зөвхөн дөрвөн жилийн бакалаврын хөтөлбөр төгссөн хүнийг

⁹ Dai-Kwon Choi, A Legal Profession in Transformation: The Korean Experience, in *Reorganization and Resistance: Legal Professions Confront a Changing World*, p. 171, p. 193–94 (William L.F. Felstiner Ed., 2005).

¹⁰ Tom Ginsburg, Transforming Legal Education in Japan and Korea, 22 *Penn. St. Int'l L.Rev.*, p. 433, p. 439 (2004).

¹¹ Beophak Jeonmun Daehakwon Seolchi Unyeong-E Gwanhan Beo-Prui (Graduate Law School Act), Act No. 8544, July 27, 2007, Amended By Act No. 8852, Feb. 29, 2008 (S. Kor.).

¹² Young-Cheol K. Jeong, Korean Legal Education for the Age of Professionalism, 5 *E. Asia L.Rev.*, p. 155-157 (2010).

элсүүлэх бөгөөд хөтөлбөрт хамрагдсан оюутнуудын олон талт байдлыг хангах үүднээс шинээр элсэгчдийн гуравны нэгээс доошгүй хувь нь хуулийн бус өөр төрлийн мэргэжлээр төгсөгчдийг элсүүлэх шаардлага тавьсан. Түүнчлэн хуулийн мэргэшсэн сургуульд элсэхэд дэлхийн хөгжил дэвшилд нийцэн ажиллах чадварыг хангах үүднээс англи хэлний мэдлэгийг онцлох болжээ. Хуулийн мэргэшсэн сургуульд элсэхэд Эрх зүйн зүйн боловсролын элсэлтийн шалгалт өгөх ба энэ нь америкийн хуулийн сургуулийн элсэлтийн шалгалтын солонгос хувилбар юм.¹³

Түүнчлэн дадлага, ур чадварт чиглэсэн сургалтын хөтөлбөрийг дэлхийн стандарт жишигт ойртуулах, төрөлжүүлэх үүднээс гадаад орны эрх зүйн тогтолцоо, олон улсын эрх зүй зэрэг зарим хичээлийг англи хэлээр явуулах шаардлага тулгарчээ. Мөн лекц уншиж, хууль цээжлүүлдэг арга барилаасаа татгалзан, АНУ-ын хуулийн сургуулиудын арга барилаас үлгэр жишээ болгон хуульч шиг сэтгэх философи ойлголт, Сократын арга,¹⁴ эрдэм шинжилгээ судалгааны ажил хийх, дүн шинжилгээ, таамаглал дэвшүүлэх зэрэг интерактив арга зүй ашиглах¹⁵ болжээ.

Хуулийн мэргэшсэн сургуульд тавигдаж буй бас нэгэн шалгуур нь тухайн сургуулийн мэргэжлийн багш нарын 20 хувь нь таваас доошгүй жил ажилласан туршлагатай байх, онол практик хосолсон мэргэжлийн сургалт зохион байгуулах туршлагатай байхыг шаардах болсон. Тухайлбал, мэргэжлийн үүрэг хариуцлага, ёс зүй, хууль зүйн судалгааны арга зүй, шүүх хуралдааны дадлага, мэтгэлцээн, мэргэжлийн дадлага гэх мэт шаардлага тавигдана. Өөрөөр хэлбэл, ёс зүй, практик ур чадвар эзэмшүүлж, төлөвшүүлэхэд онцгойлон анхаарч ажиллахыг шаарддаг.¹⁶

Энэхүү шинэчлэл нь хуульчийн ёс зүй, ялангуяа мэргэжлийн үүрэг хариуцлагаа ухамсарлах асуудалд онцгой анхаарал хандуулсныг илтгэх бөгөөд мэргэшсэн хуульчдыг сургаж дадлагажуулахын зэрэгцээ тэдний нийгэмд эзлэх байр суурь, үүргээ ухамсарлах, дасан зохицох чадварыг нь хөгжүүлэхэд чиглэгджээ.

¹³ The Legal Education Eligibility Test

¹⁴ Matthew J. Wilson, U.S. Legal Education Methods and Ideals: Application to the Japanese and Korean Systems, 18 *Cardozo J. Int'l & Comp.L.*, p. 295, p. 335 (2010).

¹⁵ Jasper Kim, *Socrates V., Confucius: An Analysis of South Korea's Implementation Of The American Law School Model*, 10 *Asian-Pac.L.& Pol'y J.*, p. 322-327 (2009).

¹⁶ Young-Cheol K. Jeong, *Korean Legal Education for the Age of Professionalism*, 5 *E. Asia L. Rev.*, p. 155-157 (2010).

2.4. МЭРГЭШСЭН ХУУЛЬЧ БЭЛТГЭХ ТОГТОЛЦООНЫ ҮНДСЭН ЭХ СУРВАЛЖ

Мэргэшсэн хуульч бэлтгэх БНСУ-ын тогтолцооны эрх зүйн үндсэн эх сурвалж нь:

- Үндэсний Ассамблейгаас 2009 оны 4 дүгээр сарын 29-ний өдөр баталж, мөн оны 8 дугаар сарын 28-ны өдрөөс хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн Хуульчийн шалгалтын тухай хууль (таван удаа буюу 2011 оны 7 дугаар сарын 25, 2017 оны 12 дугаар сарын 12, 2018 оны 12 дугаар сарын 18, 2020 оны 6 дугаар сарын 9, 2020 оны 12 дугаар сарын 8-нд тус тус нэмэлт, өөрчлөлт оруулсан);
- 2007 оны 7 дугаар сарын 3-ны өдөр батлагдаж, мөн оны 7 дугаар сарын 27-ны өдрөөс хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн Хуулийн мэргэшсэн сургуулийн бүтэц, зохион байгуулалт, удирдлагын тухай хууль (зургаан удаа буюу 2008 оны 2 дугаар сарын 29, 2011 оны 7 дугаар сарын 21, 2012 оны 1 дүгээр сарын 26, 2013 оны 3 дугаар сарын 23, 2016 оны 5 дугаар сарын 29, 2021 оны 3 дугаар сарын 23-ны өдөр тус тус нэмэлт, өөрчлөлт оруулсан);
- БНСУ-ын Ерөнхийлөгчийн 2007 оны 9 дүгээр сарын 28-ны өдрийн “Хуулийн мэргэшсэн сургуулийн бүтэц, зохион байгуулалт, удирдлагын тухай хуулийн хэрэгжилтийг хангах тухай” 20302 тоот зарлиг;
- БНСУ-ын Ерөнхийлөгчийн 2009 оны 8 дугаар сарын 28-ны өдрийн “Хуульчийн шалгалтын тухай хуулийн хэрэгжилтийг хангах тухай” 21706 тоот зарлиг;
- Хууль зүйн сайдын 2010 оны 2 дугаар сарын 23-ны өдрийн 695 тоот захирамжаар тогтоосон “Хуульчийн шалгалтын тухай хуулийг дагаж мөрдөх” журам зэргээс бүрдэж байна.

Дараагийн бүлэгт мэргэшсэн хуульч бэлтгэх тогтолцооны сургалтын онцлог, үндсэн шалгуурын талаар өгүүлэх болно.


Гурав. МЭРГЭШСЭН ХУУЛЬЧ БЭЛТГЭХ ТОГТОЛЦООНЫ СУРГАЛТЫН ОНЦЛОГ, ҮНДСЭН ШАЛГУУР

Энэхүү бүлэгт мэргэшсэн хуульч бэлтгэх тогтолцооны сургалтын үйл ажиллагааны онцлог, хуулийн мэргэшсэн сургууль, түүнд тавигдах шаардлага, эрх зүйн сургалтын хөтөлбөрийн агуулга, багтаамж, боловсролын магадлан итгэмжлэлийн талаар өгүүлэх болно.

Мэргэшсэн хуульч бэлтгэх тогтолцоонд (*Бүдүүвч 1*) сургалтын үйл ажиллагаа хамгийн чухал байр суурь эзлэх бөгөөд БНСУ-ын Үндэсний Ассамблейгаас 2007 оны 7 дугаар сарын 3-ны өдөр баталж, мөн оны 7 дугаар сарын 27-ны өдрөөс хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн Хуулийн мэргэшсэн сургуулийн бүтэц, зохион байгуулалт, удирдлагын тухай хуулиар сургалтын үйл ажиллагааг зохицуулж байна. Уг хууль нь зургаан бүлэг, 46 зүйлтэй.

Хуулийн мэргэшсэн сургууль (ХМС) магистрын зэргийн сургалт явуулах бөгөөд элсэлтийн шалгалтад тэнцсэн, бакалаврын зэрэгтэй иргэдийг суралцуулдаг. Мэргэшсэн хуульчийг бакалаврын зэргээс эхлэн бэлтгэх нь үр дүн муутай, ялангуяа практикт ажиллахад эрх зүйн боловсролоос өөр салбарын мэдлэггүй хуульч учир дутагдалтай байсан гэж үзэж төрөл бүрийн салбарын мэргэжилтэй хүнийг эрх зүйн магистрын зэргийн сургалтад хамруулах замаар мэргэшсэн хуульч бэлтгэх болсон.

Бүдүүвч 1. Мэргэшсэн хуульч бэлтгэх тогтолцоо



Эх сурвалж: http://www.megals.co.kr/law_info/leet_law_school_information

3.1. ХУУЛИЙН МЭРГЭШСЭН СУРГУУЛИЙН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, УДИРДЛАГЫН ТУХАЙ ХУУЛИЙН НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

ХМС-ийн бүтэц, зохион байгуулалт, удирдлагын тухай хуулийн зорилго нь ХМС-ийг үүсгэн байгуулах, үйл ажиллагааг нь удирдан явуулах болон эрх зүйн боловсролыг уялдуулан зохицуулах замаар шилдэг хуульчдыг бэлтгэх явдал юм.¹⁷ ХМС-ийн сургалтын үйл ажиллагаа нь нийгмийн хүлээлт, эрэлт хэрэгцээг хангасан, олон талт соёл, хүн, нийгмийн харилцааны талаар гүнзгий ойлголттой, эрх чөлөө, тэгш байдал, шударга ёс, үнэт зүйлийг эрхэмлэсэн, аливаа маргааныг мэргэжлийн ёс зүйг баримтлан үр дүнтэй шийдвэрлэх, хууль зүйн чанартай туслалцаа үйлчилгээ үзүүлэхүйц мэдлэг, чадвартай хуульчдыг

¹⁷ Хуулийн мэргэшсэн сургуулийн бүтэц, зохион байгуулалт, удирдлагын тухай хууль, 1.1.

бэлтгэхэд чиглэдэг¹⁸ байна. Төрөөс мэргэшсэн хуульчдыг бэлтгэхэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх¹⁹ бөгөөд Дээд боловсролын тухай хуулийн хоёрдугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан их дээд сургуулиуд²⁰ болон мөн хуулийн 30 дугаар зүйлд²¹ заасан магистрын зэргийн мэргэшсэн сургууль, мэргэшсэн хуульчид бэлтгэдэг байгууллага, холбоодтой мэргэшсэн хуульчдыг бэлтгэх чиглэлээр хамтран ажилладаг.

Хуулийн мэргэшсэн сургуулийн бүтэц, зохион байгуулалт, удирдлагын тухай хуулийн нэгдүгээр бүлгийн “Бүтэц, зохион байгуулалт” хэмээх 4 дэх зүйлд “Хуулийн мэргэшсэн сургуулийг үүсгэн байгуулагч²² нь эрх зүйн онол, практик, мэргэжлийн сургалт, судалгааны ажлыг эрхэмлэсэн ХМС байгуулан ажиллуулж болно” гэж заасан байна.

ХМС-ийн зөвшөөрөл олгох, татан буулгах, өөрчлөх асуудлыг Боловсролын сайд хариуцах²³ бөгөөд үүсгэн байгуулагч нь Ерөнхийлөгчийн зарлигийн 4.1²⁴ дэх хэсэгт заасан нэр, байршил, оюутны багтаамж зэргийг өөрчлөх хүсэлтэй бол өөрчлөлт хийх шалтгаан, агуулга, өөрчлөлт хийх огноо гэх мэт мэдээллийг тусгасан баримт бичиг бүрдүүлэн Боловсролын сайдад хүргүүлэх шаардлагатай байдаг.²⁵ ХМС байгуулах зөвшөөрөл олгох, татан буулгах, өөрчлөх тохиолдолд Боловсролын сайд асуудлыг Эрх зүйн боловсролын

¹⁸ Хуулийн мэргэшсэн сургуулийн бүтэц, зохион байгуулалт, удирдлагын тухай хууль, 1.2.

¹⁹ Хуулийн мэргэшсэн сургуулийн бүтэц, зохион байгуулалт, удирдлагын тухай хууль, 1.3.

²⁰ Аж үйлдвэрийн их сургууль, Боловсролын их сургууль, Мэргэшсэн их сургууль, Радио, телевизийн их сургууль, Харилцаа холбооны их сургууль, Кибер буюу зайн сургалтын сургууль, Техникийн их сургууль, бусад их, дээд сургууль.

²¹ Тодорхой чиглэлээр мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх шаардлагатай бол зөвхөн магистрын зэргийн сургалт бүхий их, дээд сургууль байгуулж болно.

²² Улсын их сургуулийн хувьд төр, орон нутгийн их сургуулийн хувьд орон нутгийн засаг захиргаа, хувийн их сургуулийн хувьд хуулийн этгээдийг ойлгоно.

²³ “Орон нутгийн болон хувийн их сургуулийг үүсгэн байгуулагч нь хуулийн мэргэшсэн сургууль байгуулахаар төлөвлөж байгаа бол Боловсролын сайдаас зөвшөөрөл авна”, “Улсаас Хуулийн мэргэшсэн сургууль байгуулах бол Хууль зүйн боловсролын холбоогоор хэлэлцүүлнэ”, “Хуулийн мэргэшсэн сургуулийн бүтэц, зохион байгуулалт, удирдлагын тухай хууль”, 1.5.2, 1.5.4.

²⁴ “Хуулийн мэргэшсэн сургуулийн бүтэц, зохион байгуулалт, удирдлагын тухай хуулийн хэрэгжилтийг хангах тухай” 20302 тоот зарлиг, 2009.

²⁵ Хуулийн мэргэшсэн сургуулийн бүтэц, зохион байгуулалт, удирдлагын тухай хууль, 5.2.

холбоогоороо хэлэлцүүлнэ.²⁶ ХМС байгуулах, татан буулгах, өөрчлөх асуудлын чиглэлийг Боловсролын сайдад Ерөнхийлөгчийн 2007 оны 9 дүгээр сарын 28-ны өдрийн “Хуулийн мэргэшсэн сургуулийн бүтэц, зохион байгуулалт, удирдлагын тухай хуулийн хэрэгжилтийг хангах” тухай 20302 тоот зарлигаар²⁷ тогтоон өгсөн байх бөгөөд энэ үйл ажиллагааг дараах байдлаар тусгажээ. Үүнд:

1. 2.1. Улсын болон хувийн их сургууль үүсгэн байгуулагч нь ХМС байгуулахаар төлөвлөж буй тохиолдолд дараах баримт бичгийг бүрдүүлж, Боловсролын сайдад хүсэлтийн хамт хүргүүлнэ. Үүнд: зорилго, нэр, байршил, сургуулийн дүрэм, хүний нөөц болон багшийн орон тоо, зочин профессорын мэдээлэл, хэтийн төлөвлөгөө, барилга байгууламжийн талаарх мэдээлэл, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө, хичээл заах арга зүй, аргачлал, оюутны багтаамж, элсэлтийн талаарх мэдээлэл, сургуулийн үйл ажиллагааг эхлүүлэх огноо, сүүлийн гурван жилийн санхүүгийн тайлан, гурван жил хүрээгүй бол байгуулагдсанаас хойших санхүүгийн тайлан, сургалтын төлбөр, элсэлтийн хураамж зэрэг санхүүгийн эх үүсвэр, тэтгэлэг олгох тогтолцоог оролцуулан дараагийн гурван жилийн санхүүгийн төлөвлөлт, татан буугдсан эрх зүйн бакалаврын хөтөлбөрийн оюутнуудад авах арга хэмжээ²⁸, ХМС байгуулахаар төлөвлөж буй их сургуульд хэрэгжүүлэх эрх зүйн магистр, докторын хөтөлбөрийн цаашдын төлөвлөгөө, ХМС-ийн хөгжлийн хөтөлбөр, судалгааны танхим байгуулах, дадлага ажлын төлөвлөгөө болон Боловсролын сайдаас уг сургуулийн бүтэц, зохион байгуулалт, удирдлагатай холбогдуулан хүссэн шаардлагатай бусад бичиг баримт;
2. 2.2. Боловсролын сайд 2.1-д заасны дагуу үүсгэн байгуулах тухай хүсэлт хүлээн авч хүсэлтийг Эрх зүйн боловсролын хороогоор хэлэлцүүлэх ба сургуулийг татан буулгах, өөрчлөх асуудал үүнд мөн адил хамаарна;

²⁶ Хуулийн мэргэшсэн сургуулийн бүтэц, зохион байгуулалт, удирдлагын тухай хууль, 5.3.

²⁷ Хуулийн мэргэшсэн сургуулийн бүтэц, зохион байгуулалт, удирдлагын тухай хуулийн хэрэгжилтийг хангах тухай 20302 тоот зарлиг, 2009.

²⁸ Хуулийн мэргэшсэн сургуулийн бүтэц, зохион байгуулалт, удирдлагын тухай хууль, “Хуулийн мэргэшсэн сургууль нь эрх зүйн бакалаврын зэрэг олгох сургалт явуулахгүй”, 1.8.1.

3. 3 дугаар зүйл. Улсын болон хувийн сургууль үүсгэн байгуулагч сургуулиа татан буулгах тохиолдолд дараах агуулгыг тусгасан баримт бичиг бүрдүүлж, Боловсролын сайдад хүргүүлэн, татан буулгах зөвшөөрөл хүснэ. Үүнд, татан буулгах шалтгаан, огноо, оюутнууд болон дүнгийн бүртгэлийг зохицуулах арга гэх мэт;
4. 5 дугаар зүйл. Хуулийн мэргэшсэн сургууль байгуулах зөвшөөрөл олгохдоо орон нутгийн их сургуулийн хөгжил, мөн орон нутгийн хөгжилд хувь нэмэр оруулах хүний нөөц бэлтгэх үүднээс орон нутаг бүрд тэнцвэртэй байдлыг ханган тогтооно” гэжээ.

Боловсролын сайд ХМС байгуулах зөвшөөрөл олгохдоо сургалтын зорилго, зорилт, хөтөлбөрийн хэрэгжих боломж зэрэг стандарт шаардлагыг²⁹ харгалзан үзнэ.

ХМС-ийн элсэлтийн квотыг хууль зүйн туслалцаа, үйлчилгээний хүртээмж, хуульчдын эрэлт хэрэгцээ, нийлүүлэлт гэх мэт нөхцөл байдалтай уялдуулан³⁰ тухайн сургуулийн сургалтын үйл ажиллагааны нөхцөл байдал, багшлах бүрэлдэхүүн, материаллаг нөөц ба санхүүгийн чадамж зэргийг харгалзан Ерөнхийлөгчийн зарлигаар тогтоосон хэм хэмжээний хүрээнд Боловсролын сайд тушаалаар батална.³¹ Үүний өмнө Үндэсний Ассамблейн харьяа байнгын хороонд урьдчилан мэдэгдэх³² ба Хууль зүйн сайд болон Шүүх эрх мэдлийн байгууллагын даргатай зөвшилцөнө.³³ Түүнчлэн Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 78 дугаар зүйлд заасны дагуу³⁴ Солонгосын Хуульчдын

²⁹ Хуулийн мэргэшсэн сургуулийн бүтэц, зохион байгуулалт, удирдлагын тухай хууль, 1.6.2.

³⁰ Хуулийн мэргэшсэн сургуулийн бүтэц, зохион байгуулалт, удирдлагын тухай хууль, 1.7.2.

³¹ Хуулийн мэргэшсэн сургуулийн бүтэц, зохион байгуулалт, удирдлагын тухай хууль, 1.7.3.

³² Хуулийн мэргэшсэн сургуулийн бүтэц, зохион байгуулалт, удирдлагын тухай хууль, 1.7.2.

³³ Хуулийн мэргэшсэн сургуулийн бүтэц, зохион байгуулалт, удирдлагын тухай хууль, 1.7.2.

³⁴ 78.1. БНСУ-ын Хуульчдын холбоо нь хуульчийн нэр төрийг хамгаалах, хуулийн үйлчилгээг сайжруулах, хөгжүүлэх, бусад эрх зүйн соёлыг дэмжих, хуульчид болон орон нутгийн хуульчдын холбоодын удирдлага, хяналттай холбоотой ажил эрхлэх зорилгоор байгуулагдана; 78.2. БНСУ-ын Хуульчдын холбоо нь хуулийн этгээд байна.

холбооны тэргүүн, Иргэний хуулийн 32 дугаар зүйл³⁵ болон Олон нийтийн байгууллагын бүтэц, зохион байгуулалт, удирдлагын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу³⁶ БНСУ-ын Хууль зүйн сургуулиудын холбооны³⁷ тэргүүн нар Боловсролын сайдад санал хүргүүлж болно³⁸.

ХМС-ийн үйл ажиллагаа явуулж буй боловсролын байгууллага нь уг сургуулийг нээхээс өмнө эрх зүйн бакалаврын хөтөлбөрийн сургалт явуулж байсан бол анхны элсэлт авсан жилээс эхлэн эрх зүйн бакалаврын зэрэг олгох хөтөлбөрт элсэлт авч болохгүй³⁹. Гэвч ХМС байгуулахаас өмнө тус хөтөлбөрт элссэн оюутнуудын сургалтыг тасалдуулахгүй байх үүднээс хөтөлбөрийг үргэлжлүүлж дуусгана.⁴⁰ Мөн ХМС хуульд тусгайлан заагаагүй бол Дээд боловсролын тухай хууль болон их дээд сургуультай холбоотой бусад хууль тогтоомжийг дагаж мөрдөх үүрэгтэй хэдий ч Хуулийн мэргэшсэн сургуулийн бүтэц, зохион байгуулалт, удирдлагын тухай хуульд өөрөөр заасан бол тус хуулийг мөрдөнө.⁴¹

³⁵ Эрдэм шинжилгээ, шашин, буяны, хүмүүнлэгийн, нийгмийн болон бусад ашгийн бус зорилгоор байгуулагдсан холбоо, санг эрх бүхий байгууллагын зөвшөөрлөөр хуулийн этгээдийн статусаар байгуулж болно.

³⁶ 4.1. Иргэний хуулийн 32 дугаар зүйлд заасны дагуу эрх бүхий байгууллага нийтийн ашиг сонирхлын төлөөх хуулийн этгээд байгуулах зөвшөөрөл хүссэн өргөдөл хүлээн авсан тохиолдолд холбогдох баримтуудыг шалгаж, сангийн хувьд хөрөнгийн орлого, холбооны хувьд гишүүнчлэлийн хураамж, хандиваас бүрдсэн санхүүгийн эх үүсвэр нь үйл ажиллагаа явуулахад боломжтой гэж үзвэл зөвшөөрөл олгоно. 4.2. Нийтийн эрх ашгийн төлөөх хуулийн этгээд байгуулах зөвшөөрөл олгохдоо эрх бүхий байгууллага нь Ерөнхийлөгчийн зарлигаар тогтоосон гишүүнчлэлийн хураамж, ашиг хүртэгчид болон бусад шаардлагатай нөхцөлийг хавсаргаж болно.

³⁷ Хууль зүйн сайдын зөвшөөрлөөр байгуулагдана.

³⁸ Хуулийн мэргэшсэн сургуулийн бүтэц, зохион байгуулалт, удирдлагын тухай хууль, 1.7.2.

³⁹ Хуулийн мэргэшсэн сургуулийн бүтэц, зохион байгуулалт, удирдлагын тухай хууль, 1.8.2.

⁴⁰ Хуулийн мэргэшсэн сургуулийн бүтэц, зохион байгуулалт, удирдлагын тухай хууль, 1.8.3.

⁴¹ Хуулийн мэргэшсэн сургуулийн бүтэц, зохион байгуулалт, удирдлагын тухай хууль, 1.9.2.

3.2. ЭРХ ЗҮЙН БОЛОВСРОЛЫН ХОЛБООНЫ БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Эрх зүйн боловсролын холбоо нь Боловсролын сайдын эрхлэх асуудлын хүрээнд байгуулагдах бөгөөд ХМС байгуулах зөвшөөрөл, ХМС-иудын чадамж, сургууль байгуулах нарийвчилсан стандарт, хуульч бэлтгэх, эрх зүйн боловсрол олгох асуудал болон Боловсролын сайдаас сургалтын чиглэлээр хэлэлцүүлэх бусад асуудлын хүрээнд үйл ажиллагаагаа явуулдаг.⁴² Дээрх асуудлын хүрээнд тус холбоо нь их сургуулийн тодорхой албан тушаалтан, холбогдох төрийн албан хаагч, мэргэжлийн шинжээчдийн санал бодлыг сонсох эсвэл их сургууль, холбогдох байгууллагаас баримт материал, санал, хүсэлт гаргуулах зэргээр хуулийн этгээдтэй бүх талаар хамтран ажиллахын⁴³ зэрэгцээ шаардлагатай гэж үзвэл холбооны тэргүүн дотоод хяналт шалгалтын үйл ажиллагаа ч явуулдаг байна.⁴⁴

Тус холбоо нь нийт 13 гишүүнтэй байх ба тэргүүн болон гишүүдийг Боловсролын сайд томилно.⁴⁵ Гишүүдийг дараах шалгуураар сонгоно.⁴⁶ Үүнд:

- Тухайн салбарын профессор эсвэл дэд профессор дөрвөн хүн;
- 10 ба түүнээс дээш жил ажилласан туршлагатай, Шүүхийн тамгын газрын даргын санал болгосон нэг шүүгч;
- 10 ба түүнээс дээш жил ажилласан туршлагатай, Хууль зүйн сайдын санал болгосон нэг прокурор;
- 10 ба түүнээс дээш жил ажилласан туршлагатай, БНСУ-ын Хуульчдын холбооны ерөнхийлөгчийн санал болгосон хоёр хуульч/өмгөөлөгч;

⁴² Хуулийн мэргэшсэн сургуулийн бүтэц, зохион байгуулалт, удирдлагын тухай хууль, 2.10.1.

⁴³ Хуулийн мэргэшсэн сургуулийн бүтэц, зохион байгуулалт, удирдлагын тухай хууль, 2.14.

⁴⁴ Хуулийн мэргэшсэн сургуулийн бүтэц, зохион байгуулалт, удирдлагын тухай хууль, 2.15.

⁴⁵ Хуулийн мэргэшсэн сургуулийн бүтэц, зохион байгуулалт, удирдлагын тухай хууль, 2.10.2.

⁴⁶ Хуулийн мэргэшсэн сургуулийн бүтэц, зохион байгуулалт, удирдлагын тухай хууль, 2.11.1.

- Боловсролын удирдлагын чиглэлээр 10 ба түүнээс дээш жил ажилласан төрийн нэг албан хаагч;
- Тал бүрийн мэдлэг, туршлагатай (эрх зүйн чиглэлээр багшлах эрх бүхий туслах профессороос дээш албан тушаал хашиж буй болон өмгөөлөгчөөр ажиллах эрхтэйгээс бусад) дөрвөн хүнийг багтааж сонгоно.

Гишүүний бүрэн эрхийн хугацаа хоёр жил байх бөгөөд дахин томилж болох боловч бүрэн эрхийнхээ хугацаанд албан тушаал, ур чадвараа алдсан тохиолдолд гишүүнээр үргэлжлүүлэн ажиллах эрхгүй болдог.⁴⁷ Гишүүнийг дараах нөхцөлд хэлэлцүүлэгт оролцохыг хориглоно. Үүнд:

- Өөрөө эсвэл эхнэр (нөхөр) нь их, дээд сургууль байгуулах, удирдах зөвлөл эсвэл хэлэлцэгдэж буй сургуульд ажилладаг;
- Өөрөө эсвэл эхнэр (нөхөр) нь Иргэний хуулийн 777 дугаар зүйлд⁴⁸ заасан хүрээнд хамааралтай бол;
- Эхнэр (нөхөр) нь хэлэлцэгдэж буй их сургуулийн захирал, хэлэлцэгдэж буй их сургуулийн эрх зүйн факультет эсвэл хуулийн мэргэшсэн сургууль, эрх зүйн бакалаврын сургуулийн багш, хэлэлцэгдэж буй их сургуулийн удирдах албан тушаалтантай ураг төрлийн холбоотой зэрэг болно.⁴⁹

3.3. ХУУЛИЙН МЭРГЭШСЭН СУРГУУЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОНЦЛОГ, ТАВИГДАХ ШААРДЛАГА, СТАНДАРТ

ХМС-ийн бүтэц, зохион байгуулалт, удирдлагын тухай хуулийн “Хуулийн мэргэшсэн сургууль байгуулах стандарт ба үйл ажиллагаа” хэмээх гуравдугаар бүлэгт багшлах бүрэлдэхүүн, барилга байгууламж, боловсролын зэрэг ба сургалтын хугацаа, багц цаг, сургалтын хөтөлбөр, байгууллагын стандарт, түүнийг өөрчлөх асуудал, элсэлтийн үндсэн

⁴⁷ Хуулийн мэргэшсэн сургуулийн бүтэц, зохион байгуулалт, удирдлагын тухай хууль, 2.11.2.

⁴⁸ Энэхүү хууль болон бусад хуульд тусгайлан заагаагүй бол ураг төрлийн холбоо нь дараах хүмүүст хамаарна. Үүнд: Найман үе доторх цусан төрөл, дөрвөн үе доторх хамаатан садан болон эхнэр/нөхөр.

⁴⁹ Хуулийн мэргэшсэн сургуулийн бүтэц, зохион байгуулалт, удирдлагын тухай хууль, 2.13.

шалгуур, оюутны сонгон шалгаруулалт, ур чадварын шалгалтыг зохион байгуулах, суралцагчдын шилжилт хөдөлгөөн, суралцах бүрэлдэхүүний харьцааны талаар тодорхой заасан байна.

ХМС нь Ерөнхийлөгчийн зарлигаар тогтоосон⁵⁰ нэг багшид 15 оюутан оногдох хязгаарын хүрээнд багш нарын тоог баталгаажуулах ба багш нарын тооны тавны нэгтэй тэнцэх хэмжээнд гэрээт болон зочин багш оруулж болно.⁵¹ ХМС-ийн багшийн тоог 20-иос доошгүй байлгахыг шаардах ба⁵² багшлах бүрэлдэхүүний тавны нэгээс доошгүй хувийг өмгөөлөгч, гадаад оронд хуульч мэргэжлээр таваас доошгүй жил ажилласан практик туршлагатай багш нар бүрдүүлнэ⁵³ гэж хуульчилсан.

ХМС нь Ерөнхийлөгчийн зарлигаар баталсан барилга, байгууламжийг⁵⁴ зөвхөн зориулалтын дагуу ашиглах, шаардагдах санхүүжилтийг бүрдүүлэх, тэтгэлэгт хөтөлбөр хэрэгжүүлэх замаар суралцагчдад санхүүгийн дэмжлэг үзүүлэх арга хэмжээ хэрэгжүүлэхийг мөн хуулиар зохицуулсан. ХМС байгуулахад Боловсролын сайд шаардагдах тоног төхөөрөмж, байгууламж, багшлах бүрэлдэхүүн, сургалтын хөтөлбөр зэрэг нэн чухал стандартыг тогтоох ба тэдгээрийг өөрчлөх хүсэлтийн хүрээнд Шүүхийн тамгын газрын дарга, Хууль зүйн сайд, Хуульчдын холбооны ерөнхийлөгч, ХМС-ийн ерөнхийлөгчийн санал бодлыг сонсох, харилцан зөвшилцөх эрх зүйн зохицуулалттай.⁵⁵

⁵⁰ “Хуулийн мэргэшсэн сургуулийн бүтэц, зохион байгуулалт, удирдлагын тухай хуулийн хэрэгжилтийг хангах тухай” 20302 тоот зарлиг, 2009. 9.1, Оюутны тоо 12 байна.

⁵¹ 9.2. Гэрээт багш гэж гэрээт болон зочин багшийг хэлнэ. 9.3. Багш нарын тоонд багтсан гэрээт болон зочин багш нарын хувьд нэг хүнд ногдох зөвшөөрөгдсөн сургалтын цаг нь долоо хоногт 9 цагаас хэтрэхгүй байна. 9.4. Хуулийн мэргэшсэн сургуулийн багш нэг жилд 30 долоо хоногоор тооцож, 7 хоногт 6 цагийн хичээл заана. Шаардлагатай тохиолдолд сургуулийн дүрмээр өөрчлөлт оруулж болно.

⁵² Хуулийн мэргэшсэн сургуулийн бүтэц, зохион байгуулалт, удирдлагын тухай хууль, 3.16.3.

⁵³ Хуулийн мэргэшсэн сургуулийн бүтэц, зохион байгуулалт, удирдлагын тухай хууль, 3.16.4.

⁵⁴ “Хуулийн мэргэшсэн сургуулийн бүтэц, зохион байгуулалт, удирдлагын тухай хуулийн хэрэгжилтийг хангах тухай” 20302 тоот зарлиг, 2009, Лекцийн танхим, багш нарын судалгааны өрөө, номын сан, зохиомол шүүхийн танхим, семинарын танхим, захиргааны оффис, мэдээлэл, харилцаа холбооны хэрэгслийг хэлнэ.

⁵⁵ Хуулийн мэргэшсэн сургуулийн бүтэц, зохион байгуулалт, удирдлагын тухай хууль, 3.21.

ХМС эрх зүйн магистрын хөтөлбөрөөр сургалт зохион явуулах бөгөөд холбогдох журамд заасны дагуу докторын зэрэг олгох сургалт явуулж болно. Магистрын хөтөлбөрт суралцах хугацаа гурав ба түүнээс дээш жил байна. Магистр, докторын сургалтын хөтөлбөрийг амжилттай дүүргэж боловсролын зэрэг хамгаалсан иргэнд Ерөнхийлөгчийн зарлигаар тогтоосны⁵⁶ дагуу зохих зэрэг олгоно.

ХМС-ийн магистрын хөтөлбөрийн сургалтын багц цагийг Ерөнхийлөгчийн зарлигаар тогтоосон⁵⁷ хэмжээнд тухайн сургуулийн холбогдох журмаар зохицуулна. ХМС-ийн бүтэц, зохион байгуулалт, удирдлагын тухай хуульд зааснаар өөр хуулийн сургууль эсвэл гадаадын их, дээд хуулийн сургуулийн ижил сургалтад хамрагдсан багц цагийг Ерөнхийлөгчийн зарлигаар тогтоосон⁵⁸ хэмжээнд дүйцүүлэн тооцож болдог байна. Мөн эрх зүйн бакалавраас дээш зэрэгтэй, ХМС-д суралцаж, хуулийн шаардлагатай мэдлэг эзэмшсэн гэж хүлээн зөвшөөрөгдсөн иргэний хувьд Ерөнхийлөгчийн зарлигаар тогтоосон⁵⁹ хэмжээнд холбогдох багц цагийг тухайн сургуулийн холбогдох журамд заасны дагуу судалсанд тооцож болно.⁶⁰

ХМС сургалтыг тодорхой системтэй зохион явуулж, судалбал зохих хичээл, эзэмшвэл зохих мэдлэг, чадвар, дадлыг Ерөнхийлөгчийн зарлигаар⁶¹ тогтоосон хэмжээнд олгодог байна.

⁵⁶ “Хуулийн мэргэшсэн сургуулийн бүтэц, зохион байгуулалт, удирдлагын тухай хуулийн хэрэгжилтийг хангах тухай” 20302 тоот зарлиг, 2009, Магистр, докторын зэрэг нь боловсролын зэрэг бөгөөд докторын зэрэг хамгаалсан тохиолдолд сургуулийн холбогдох журамд заасны дагуу эрдмийн цол олгож болно.

⁵⁷ “Хуулийн мэргэшсэн сургуулийн бүтэц, зохион байгуулалт, удирдлагын тухай хуулийн хэрэгжилтийг хангах тухай” 20302 тоот зарлиг, 2009, 90 багц цаг.

⁵⁸ “Хуулийн мэргэшсэн сургуулийн бүтэц, зохион байгуулалт, удирдлагын тухай хуулийн хэрэгжилтийг хангах тухай” 20302 тоот зарлиг, 2009, 30 багц цаг.

⁵⁹ “Хуулийн мэргэшсэн сургуулийн бүтэц, зохион байгуулалт, удирдлагын тухай хуулийн хэрэгжилтийг хангах тухай” 20302 тоот зарлиг, 2009, 15 багц цаг.

⁶⁰ Хуулийн мэргэшсэн сургуулийн бүтэц, зохион байгуулалт, удирдлагын тухай хууль, 3.19.1-3.

⁶¹ “Хуулийн мэргэшсэн сургуулийн бүтэц, зохион байгуулалт, удирдлагын тухай хуулийн хэрэгжилтийг хангах тухай” 20302 тоот зарлиг, 2009, 13.1. Хуулийн мэргэшсэн сургууль нь суралцагчдад хуульчийн ёс зүй, үнэт зүйлс, эрх зүйн мэдлэг, мэргэжлийн ур чадвар эзэмшүүлэхийн тулд дараах хичээлдүүдийг заана. Үүнд: хуульчийн ёс зүй, өөрийн орны хууль тогтоомж болон олон улсын эрх зүй, шүүхийн прецедент, эрх зүйн мэдээллийг судлах, шийдвэр, гомдол, нэхэмжлэл гэх мэт эрх зүйн баримт бичиг боловсруулах, шүүх хурлын дадлага хичээл. 13.2.

ХМС-ийн элсэлтийн асуудлыг тус хуулийн “Хуулийн мэргэшсэн сургууль байгуулах стандарт ба үйл ажиллагаа” хэмээх гуравдугаар бүлгийн 22 дугаар зүйлийн “Элсэлт” хэсэгт дурдахдаа элсэгчид нь бакалаврын зэрэгтэй эсвэл холбогдох хууль тогтоомжийн дагуу адилтгах түвшний боловсрол эзэмшсэн нь хүлээн зөвшөөрөгдсөн хүмүүс байна гэж тусгасан байдаг. Оюутны сонгон шалгаруулалтын хувьд 22 дугаар зүйлд заасны дагуу элсэх эрх бүхий иргэдээс үндсэн болон тусгай хэлбэрээр сонгон шалгаруулах ба энэ талаар Ерөнхийлөгчийн зарлигт⁶² нарийвчлан тусгасан. ХМС нь өргөдөл гаргагчийн бакалаврын сургалтын дүн, элсэлтийн шалгалт (цаашид "ур чадварын шалгалт" гэх)-ын дүн болон гадаад хэлний мэдлэгийг элсэлтийн үндсэн баримт бичигт хүлээн авах ба нийгмийн болон сайн дурын ажлын туршлагыг гэрчлэх нэмэлт баримт хүлээн авч болдог.

Хуульчийн ур чадварын шалгалт (LEET)-ыг БНСУ-ын хуулийн мэргэшсэн сургуулиудад хуулийн мэргэжил эзэмшихэд шаардлагатай суурь мэдлэг, сэтгэн бодох чадварыг үнэлэх зорилгоор Сургалтын хөтөлбөр, үнэлгээний хүрээлэн (KICE)-гээс зохион явуулдаг. Энэ шалгалт нь шалгуулагчийн ерөнхий мэдлэгийг үнэлэхээс гадна “хуульч шиг сэтгэх” ур чадварыг тодорхойлоход чиглэгддэг. Шалгалтын асуулт нь сэтгэн бодох чадвараа ашиглан тулгамдсан асуудлыг оновчтой шийдвэрлэх чадвартай эсэхийг шалгах үндсэн чиглэл баримтлах бөгөөд БНСУ-ын төрийн албаны ур чадварын шалгалт (PSAT⁶³), АНУ-ын хуулийн сургуулийн элсэлтийн шалгалт (LSAT⁶⁴)-тай төстэй боловсруулагддаг. Энэ нь эх хэлний мэдлэг, учир шалтгаан, үр дагаврыг эргэцүүлэн дүгнэх чадварын сорил, эссэ бичлэг гэсэн гурван үе шаттай, нийт 305 минутын шалгалт юм (*Хүснэгт 1*). Эх хэлний мэдлэгийн шалгалтаар хуульчид шаардагдах ярианы болон бичгийн харилцааны

Дадлагын сургалтаар дамжуулж суралцагчдад нийгэмд үйлчлэх боломж олгох.

⁶² 14.1.Үндсэн элсэлт гэдэг нь хуулийн 22 дугаар зүйлд заасан элсэх нөхцөл хангасан хүмүүст тулгуурласан сонгон шалгаруулалт юм. 14.2.Тусгай элсэлт гэдэг нь хуулийн 22 дугаар үйлд заасны дагуу элсэх эрхтэй хүмүүсийн дундаас Боловсролын сайдын тогтоосон шалгуурын дагуу хуулийн мэргэшсэн сургуульд элсэхэд бие бялдар, эдийн засаг, нийгмийн шалгуурын хувьд дэмжлэг шаардлагатай хүмүүсийн сонгон шалгаруулалт юм. 14.3.Хуулийн мэргэшсэн сургууль нь жил бүр 100 оюутан тутмын долоогоос доошгүй оюутныг тусгай элсэлтээр элсүүлнэ

⁶³ Public Service Attitude Test.

⁶⁴ Law School Admission Test.

мэдлэгийг үнэлэх зорилготой ба 1,500-2,000 үгийн багтаамжтай хувилбар сонгох тест юм. Энэ тест нь философи, эрх зүй, эдийн засаг, социологи, шинжлэх ухаан технологи, түүх, соёл урлаг, уран зохиол гэх мэт өргөн хүрээний сэдвийг багтаана.

Хүснэгт 1. Хуульчийн ур чадварын шалгалтын агуулга, хэлбэр

Үе шат	Төрөл	Асуултын тоо	Хугацаа/ минутаар	Хэлбэр
I	Эх хэлний мэдлэг	30	70	Хувилбар сонгох
II	Эргэцүүлэн дүгнэх чадвар	40	125	Хувилбар сонгох
III	Эссэ бичлэг	2 сэдэв	110	Бичих

Учир шалтгаан, үр дагаварыг эрэгцүүлэн дүгнэх чадварын тест нь баримт, нотолгоо, онолын үндэслэл, тайлбар, бодлого үйл ажиллагаа, бодит амьдрал гэх мэт шийдвэр гаргахтай холбоотой төрөл бүрийн эх сурвалж ашиглан учир шалтгааныг тогтоох, үнэлэлт дүгнэлт өгөх, шийдвэр гаргах болон чөлөөт сэтгэлгээний чадварыг тогтооход чиглэгддэг. Тест нь 40 асуулттай байх бөгөөд 2021 онд явагдсан хуульчийн ур чадварын шалгалтын эргэцүүлэн дүгнэх чадварын сорилд эрх зүйн хэм хэмжээний 12, хүмүүнлэгийн ухааны 13, нийгмийн ухааны зургаа, логик сэтгэлгээний гурав, байгалийн шинжлэх ухааны зургаан асуулт иржээ. Харин эссэ бичлэгийг эрх зүйн чиглэлээр тухайлан өгөгдсөн сэдвийн хүрээнд хийнэ. Өмнөх жилүүдэд ардчилал болон үндсэн хуулийн талаарх сэдэв ихэвчлэн ирдэг байсан бол 2021 онд авлигатай тэмцэх асуудлын талаарх сэдэв ирсэн байна⁶⁵.

ХМС-д элсэгчдийг шударгаар сонгон шалгаруулахын тулд Ерөнхийлөгчийн зарлигаар баталсан агуулга бүхий элсэлтийн арга хэмжээний төлөвлөгөө⁶⁶ гаргаж, олон нийтэд мэдээлнэ.

⁶⁵ LEET шалгалтын албан ёсны цахим хуудас, сүүлд хандсан 2021.10.04, <https://leet.uwayapply.com/>

⁶⁶ Оюутнуудыг сонгон шалгаруулахад ХМС дараах мэдээлэл агуулсан элсэлтийн төлөвлөгөөг жил бүр гаргаж, элсэлт эхлэхээс өмнө оюутнуудад мэдээлнэ. Үүнд:

Боловсролын сайд ур чадварын шалгалтыг зохион байгуулахад шаардлагатай байгууламж, хүн хүч бүхий байгууллагыг томилох ба хэрэв уг байгууллага нь залилан мэхлэх болон бусад хууль бус аргаар томилогдсон, ур чадварын шалгалтыг хэрэгжүүлэх даалгаврыг хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр гүйцэтгээгүй, шаардлагатай зохион байгуулалт, ажиллах хүн хүчээр хангаагүй бол томилсон шийдвэрийг цуцалж болно. Боловсролын сайд ур чадварын шалгалтын хэрэгжилттэй холбоотой тайлан, мэдээлэл ирүүлэхийг томилсон байгууллагаас шаардаж болно.⁶⁷ Ур чадварын шалгалтын хураамжийг Боловсролын сайд тогтоох ба шалгалт өгөх хүсэлтэй хүмүүс уг хураамжийг⁶⁸ төлнө. Түүнчлэн томилогдсон байгууллагын үйл ажиллагааны стандарт, журам, ур чадварын шалгалтын төлбөрийн хэлбэр, ур чадварын шалгалтыг хэрэгжүүлэхтэй холбогдсон бусад асуудлыг Ерөнхийлөгчийн зарлигаар⁶⁹ тогтоосон байдаг.

ХМС-ийн оюутан суралцагч сургуулийн дотоод журмын дагуу өөр хуулийн мэргэшсэн сургуульд шилжин суралцаж болох ба шилжин суралцаж буй оюутны судалсан багц цагийг шилжин ирсэн сургуулийн багц цагт тооцож болно. Суралцагчдыг төрөл бүрийн мэдлэг, туршлагатай иргэдээс бүрдүүлэхийг зорьдог бөгөөд элсэгчдийн гуравны нэгээс багагүй хувь нь эрх зүйгээс бусад чиглэлээр бакалаврын зэрэг хамгаалсан хүн байх ёстой. Түүнчлэн оюутнуудын гуравны нэгээс багагүй хувь нь тус хуулийн мэргэшсэн сургуулийн үйл ажиллагаа эрхэлдэг боловсролын байгууллагаас өөр сургуульд бакалаврын зэрэг хамгаалсан байхыг шаарддаг байна.⁷⁰

шударга сонгон шалгаруулалтыг зохион явуулах арга хэмжээ, элсэлтийн баримт бичгийн төрөл, ашиглалт, тусгай элсэлт авах тохиолдолд оролцох боломжтой иргэд, тавигдах шалгуур, элсэлтийн төлөвлөгөөнд тусгахаар Боловсролын сайдын тухайлан заасан бусад асуудал.

⁶⁷ Хуулийн мэргэшсэн сургуулийн бүтэц, зохион байгуулалт, удирдлагын тухай хууль, 3.24.3.

⁶⁸ Шалгалтын хураамж 248,000 вон байх ба амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур орлоготой, эмзэг бүлгийн болон өрх толгойлсон эцэг/эх хураамжаас чөлөөлөгдөнө.

⁶⁹ Хавсралтаас холбогдох дугаарын тайлбарыг үзнэ үү.

⁷⁰ Хуулийн мэргэшсэн сургуулийн бүтэц, зохион байгуулалт, удирдлагын тухай хууль, 3.26.1-3.

3.4. ХУУЛИЙН МЭРГЭШСЭН СУРГУУЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТАВИХ ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО, БОЛОВСРОЛЫН МАГАДЛАН ИТГЭМЖЛЭЛ

ХМС-ийн үйл ажиллагаа эрхэлдэг боловсролын байгууллага нь Хуулийн мэргэшсэн сургуулийн бүтэц, зохион байгуулалт, удирдлагын тухай хуулийг хэрэгжүүлэх Ерөнхийлөгчийн зарлигийг⁷¹ удирдлага болгон Хуулийн мэргэшсэн сургуулийн үнэлгээний хороогоор үнэлгээ хийлгэх үүрэгтэй. Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 78 дугаар зүйлд⁷² заасны дагуу БНСУ-ын Хуульчдын холбооны дэргэд Хуулийн мэргэшсэн сургуулийн үнэлгээний хороог байгуулах бөгөөд тус хороо нь үнэлгээний арга, шалгуур, стандартыг⁷³ боловсруулан ХМС-ийн сургалт, эрдэм шинжилгээ, удирдлага зохион байгуулалт, сургалтыг дэмжих бусад үйл ажиллагаа, сургалтын техник хэрэгсэл, тоног төхөөрөмж зэрэг сургалтын үйл ажиллагаатай холбоотой асуудалд үнэлгээ хийнэ.⁷⁴

Үнэлгээний хороо нь 11 (даргыг оролцуулан) гишүүнээс бүрдэх⁷⁵ ба Хуульчдын холбооны ерөнхийлөгч нь хорооны дарга болон гишүүдийг дараах хүмүүсээс томилно. Үүнд:

- Боловсролын сайдаас санал болгосон эрх зүйн салбарын профессор, дэд профессор дөрвөн хүн;
- Шүүхийн тамгын газрын даргаас санал болгосон 10 ба түүнээс дээш жил ажилласан туршлагатай нэг шүүгч;

⁷¹ “Хуулийн мэргэшсэн сургуулийн бүтэц, зохион байгуулалт, удирдлагын тухай хуулийн хэрэгжилтийг хангах тухай” 20302 тоот зарлиг, 2009.

⁷² 78.1. БНСУ-ын Хуульчдын холбоо нь хуульчийн нэр төрийг хамгаалах, хуулийн туслалцаа үйлчилгээг сайжруулах, хөгжүүлэх, эрх зүйн соёлыг дэмжих, хуульчид болон орон нутгийн хуульчдын холбоодын удирдлага, хяналттай холбоотой ажил эрхлэх зорилгоор байгуулагдана. 78.2. БНСУ-ын Хуульчдын холбоо нь хуулийн этгээд байна.

⁷³ Үнэлгээний хороо нь боловсролын үнэлгээнд шаардлагатай стандартыг Боловсролын сайдын зөвшөөрлөөр тогтооно, Хуулийн мэргэшсэн сургуулийн бүтэц, зохион байгуулалт, удирдлагын тухай хууль, 3.33.2.

⁷⁴ Хуулийн мэргэшсэн сургуулийн бүтэц, зохион байгуулалт, удирдлагын тухай хууль, 3.27.

⁷⁵ Дарга, гишүүдийн бүрэн эрхийн хугацаа хоёр жил байх бөгөөд дахин томилж болно. Гишүүн бүрэн эрхийнхээ хугацаанд албан тушаал, ур чадвараа алдвал гишүүний статусаа алдана.

- Хууль зүйн сайдаас санал болгосон 10 ба түүнээс дээш жил ажилласан туршлагатай нэг прокурор;
- 10 ба түүнээс дээш жил ажилласан туршлагатай нэг өмгөөлөгч;
- Боловсролын удирдлагын чиглэлээр арваас дээш жил ажилласан туршлагатай төрийн нэг албан хаагч;
- Бүх талын мэдлэг, туршлагатай (эрх зүйн чиглэлээр багшлах эрх бүхий туслах профессороос дээш албан тушаал хашиж буй болон өмгөөлөгчөөр ажиллах эрхтэйгээс бусад) гурван хүн⁷⁶.

Гишүүд нь дараах тохиолдолд үнэлгээнд оролцох эрхгүй байна. Үүнд:

- Өөрөө эсвэл эхнэр (нөхөр) нь үнэлгээ хийгдэж буй ХМС-ийн үйл ажиллагаа эрхэлдэг боловсролын байгууллага болон их, дээд сургууль байгуулах эрх бүхий байгууллагад ажилладаг;
- Өөрөө эсвэл эхнэр (нөхөр) нь үнэлгээ хийгдэж буй ХМС-ийн захирал, багш, удирдах албан тушаалтны аль нэгэнд хамаарах хүнтэй ураг төрлийн холбоотой зэрэг болно.

Эрхлэн явуулж буй сургалтын үйл ажиллагаагаа Ерөнхийлөгчийн зарлигаар⁷⁷ тогтоосон хэм хэмжээний дагуу ХМС өөрийн үнэлгээ хийж тайланг Үнэлгээний хороонд хүргүүлнэ. Үнэлгээний хороо нь сургалт, эрдэм шинжилгээний үйл ажиллагааг үнэлэхдээ сургалтын стандартын хэрэгжилт, хэвшүүлэлт, элсэлт, сонгон шалгаруулалтын шударга байдал, сургалтын хөтөлбөрийн зохистой харьцаа, төгсөгчдийн замнал, нийгэмд эзлэх байр суурь гэх мэт цогц үнэлгээ хийнэ. Үнэлгээний хороо сургалтын үйл ажиллагааны үнэлгээний дүнг холбогдох их сургуульд мэдэгдэж, Боловсролын сайдад хүргүүлэх бөгөөд хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэлнэ. Үнэлгээ хийлгэж буй сургууль нь үнэлгээний хороонд өөрийн саналаа илэрхийлэх боломжтой.⁷⁸

⁷⁶ Хуулийн мэргэшсэн сургуулийн бүтэц, зохион байгуулалт, удирдлагын тухай хууль, 3.29.

⁷⁷ Хуулийн мэргэшсэн сургууль нь үйл ажиллагаа явуулж эхэлснээс хойш хоёр жил тутамд өөрийн үнэлгээ хийх бөгөөд Үнэлгээний хорооноос тогтоосон журмын дагуу тайланг гаргаж хороонд ирүүлнэ, Хуулийн мэргэшсэн сургуулийн бүтэц, зохион байгуулалт, удирдлагын тухай хууль, 3.32.

⁷⁸ Хуулийн мэргэшсэн сургуулийн бүтэц, зохион байгуулалт, удирдлагын тухай хууль, 3.35.2.

Боловсролын сайд үнэлгээний хорооны эцсийн дүнг хүлээн авсны дараа шаардлагатай гэж үзвэл Үнэлгээний хорооноос холбогдох материал ирүүлэхийг хүсэх эсвэл дараах үндэслэлээр дахин үнэлгээ хийх хүсэлт гаргана.⁷⁹ Үүнд:

- Үнэлгээний хорооны гишүүн, дотоод хяналт шалгалт хариуцсан албан тушаалтан нь хуулийн мэргэшсэн сургуулийн үнэлгээтэй холбогдуулан Эрүүгийн хуулийн 127, 129-132 дугаар зүйлд⁸⁰ заасан гэмт хэрэг үйлдсэн;
- Хуулийн мэргэшсэн сургуулийн бүтэц, зохион байгуулалт, удирдлагын тухай хуулийн 31 дүгээр зүйлд заасны дагуу үнэлгээнд оролцох боломжгүй гишүүн⁸¹ үнэлгээнд оролцсон зэрэг болно.

Боловсролын сайдаас үнэлгээг дахин хийлгэх хүсэлт гаргасан үед онцгой нөхцөл байдал үүсээгүй бол үнэлгээний хороо гурван сарын дотор үнэлгээг дахин хийх бөгөөд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр гурван сараас дээш хугацаагаар хойшлуулбал Боловсролын сайд холбогдох ХМС-ийн үнэлгээг Эрх зүйн боловсролын холбоонд хандан хийлгэх⁸² эрх зүйн зохицуулалттай.

Үнэлгээний хорооны үйл ажиллагааны журмыг Ерөнхийлөгчийн зарлигаар⁸³ тогтоож өгсөн байх ба хороо нь үйл ажиллагаандаа дэмжлэг

⁷⁹ Хуулийн мэргэшсэн сургуулийн бүтэц, зохион байгуулалт, удирдлагын тухай хууль, 3.37.2.

⁸⁰ Төрийн албан хаагч эсвэл төрийн албан хаагч байсан хүн албаны нууц задруулсан бол хоёр жил хүртэлх хугацаагаар хорих эсхүл таван жил хүртэлх хугацаагаар мэргэжлээрээ ажиллахыг хориглоно.

⁸¹ Өөрөө эсвэл эхнэр (нөхөр) нь үнэлгээ хийгдэж буй ХМС-ийн үйл ажиллагаа эрхэлдэг боловсролын байгууллага болон их, дээд сургууль байгуулах эрх бүхий байгууллагад ажилладаг; өөрөө эсвэл эхнэр (нөхөр) нь үнэлгээ хийгдэж буй ХМС-ийн захирал, багш, удирдах албан тушаалтны аль нэгэнд хамаарах хүнтэй ураг төрлийн холбоотой бол.

⁸² Хуулийн мэргэшсэн сургуулийн бүтэц, зохион байгуулалт, удирдлагын тухай хууль, 3.37.4.

⁸³ “Хуулийн мэргэшсэн сургуулийн бүтэц, зохион байгуулалт, удирдлагын тухай хуулийн хэрэгжилтийг хангах тухай” 20302 тоот зарлиг, 2009, Үнэлгээний хорооны үйл ажиллагаа, ХМС-ийн нарийвчилсан үнэлгээний шалгуур болон дэс дараалал зэрэг энэ зарлигт зааснаас бусад шаардлагатай асуудлыг Үнэлгээний хороо тогтооно.

үзүүлэх нэгж байгуулж болно.⁸⁴ Үнэлгээний хороо нь чиг үүргээ хэрэгжүүлэх хүрээнд хуулийн мэргэшсэн сургуулийн холбогдох албан тушаалтан, холбогдох төрийн албан хаагч, шинжээчдийн санал бодлыг сонсох, ХМС эсвэл холбогдох байгууллагаас мэдээлэл, санал авах хүсэлт тавьж болдог. Үнэлгээний хорооны үйл ажиллагааны зардлыг төрийн сангаас гаргана⁸⁵ гэж заасан.

БНСУ-ын дээд боловсролын тогтолцоонд Боловсролын магадлан итгэмжлэлийн асуудал чухал байр суурь эзэлдэг бөгөөд магадлан итгэмжлэлийг таван жилийн хугацаатай явуулдаг.

БНСУ-ын Засгийн газраас Солонгосын их сургуулийн боловсролын зөвлөл (KCUE) болон Солонгосын их сургуулийн магадлан итгэмжлэлийн хүрээлэн (KUAL)-г дээд боловсролын байгууллагыг магадлан итгэмжлэх, үнэлэх байгууллагаар 2011 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр томилж, 2011 оны 11 дүгээр сараас 2015 оны 11 дүгээр сарын хугацаанд (5 жил) дээд боловсролын байгууллагын магадлан итгэмжлэлийг эхлүүлжээ. Боловсрол, шинжлэх ухаан, технологийн яам 2015 оны 11 дүгээр сараас 2020 оны 11 дүгээр сарын хугацаанд (5 жил) хоёр дахь удаагийн магадлан итгэмжлэлийг дээрх хоёр байгууллагыг дахин сонгож, явуулсан байна. Магадлан итгэмжлэлийг аливаа боловсролын байгууллага сайн дурын үндсэн дээр хийлгэдэг бөгөөд байгууллагын болон сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэл гэж хоёр ангилна. БНСУ-ын их сургуулиуд байгууллагын магадлан итгэмжлэлийг хийлгэдэг боловч хуулийн мэргэшсэн их сургуулиудад хөтөлбөрийн магадлан итгэмжлэл зайлшгүй хийлгэхийг дурдсан эрх зүйн эх сурвалж үгүй байна.

Дээд боловсролын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 2.4 дэх хэсэгт заасны дагуу их, дээд сургуулийн үнэлгээ, магадлан итгэмжлэлийн дүнг 2014 оноос эхлэн Засгийн газрын захиргаа, санхүүгийн бодлогод ашиглах болсон.⁸⁶ БНСУ-ын холбогдох байгууллагууд Боловсролын

⁸⁴ Хуулийн мэргэшсэн сургуулийн бүтэц, зохион байгуулалт, удирдлагын тухай хууль, 3.36.1.

⁸⁵ Хуулийн мэргэшсэн сургуулийн бүтэц, зохион байгуулалт, удирдлагын тухай хууль, 3.36.4.

⁸⁶ 한국대학평가원 (Korean University Accreditation Institute), сүүлд үзсэн огноо: 2021.09.10, <https://aims.kcue.or.kr>

магадлан итгэмжлэлийн үйл ажиллагааны үндсэн зорилтуудыг дараах байдлаар томъёолж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Үүнд:

1. Их сургуулийн сургалтын чанарыг сайжруулж, баталгаажуулах

- Магадлан итгэмжлэлийн шалгуурт нийцэж байгаа эсэхийг тодорхой хугацааны туршид шалгаж үнэлэх;
- Жил бүр тоон үзүүлэлтийн нийцлийг шалгаж, санал дүгнэлт гаргах;
- Магадлан итгэмжлэгдсэний дараа их сургуулиуд стандарт хэрэгжилтийг мөрдөж байгаа эсэхэд хяналт тавих.

2. Боловсрол, нийгмийн хариуцлагын чиглэлээр их дээд сургуулиудын гүйцэтгэх үүргийг нэмэгдүүлэх

- Байгууллагын үйл ажиллагааны гүйцэтгэл, нийгмийн хариуцлагын үнэлгээний шалгуурыг тодорхойлох;
- Үнэлгээ/магадлан итгэмжлэлийн үр дүнг олон нийтэд зарлах, сайжруулахад түлхэц үзүүлэх;
- Дээд боловсролын байгууллагад хийсэн үнэлгээний дүнг задлан шинжлэх.

3. Өрсөлдөх чадварыг дээшлүүлж, их сургуулиудын мэргэшүүлэх үйл ажиллагааг дэмжих

- Их сургуулийн үйл ажиллагааны зорилго, сургалтын үзэл баримтлал нь нийцэж буй эсэхийг шалгах;
- Их сургуулиас дэвшүүлсэн зорилготой нь уялдуулж цогц үнэлгээ хийх.

4. Их сургуулийн боловсролыг олон улсын жишигт нийцүүлэх

- Ази, Номхон далайн орнуудын чанарын сүлжээ⁸⁷, Дээд боловсролын чанарын баталгаажуулалтын байгууллагуудын олон

⁸⁷ Asia Pacific Quality Network-APQN

улсын сүлжээ байгууллага⁸⁸ зэрэг дээд боловсролын чанарын баталгаажуулалтын олон улсын байгууллагуудтай хамтын ажиллагаа өргөжүүлэх;

- Дэлхийн олон орны үнэлгээ, магадлан итгэмжлэлийн байгууллагуудтай хамтран ажиллаж, дээд боловсролын олон улсын хамтын ажиллагааны тогтолцоог сайжруулах;
- Академик боловсрол, эрдмийн зэргийг үндэсний хэмжээнд хүлээн зөвшөөрөх мэдээллийн төв байгуулах⁸⁹ зэрэг болно.

БНСУ-ын хувьд боловсролын байгууллагын магадлан итгэмжлэлийн асуудлыг Засгийн газраас эрх олгосон байгууллага эрхлэн явуулах зохицуулалттай гэж ойлгож болохоор байна. Их сургуулиуд нь Өөрийн үнэлгээ хийх тухай хуулийн хүрээнд хоёр жил тутамд нэг удаа үнэлгээ хийх үүрэгтэй бөгөөд Засгийн газраас эрх олгосон байгууллагаар байгууллагын магадлан итгэмжлэлийг хийлгэж болно.⁹⁰ Өөрийн үнэлгээ, магадлан итгэмжлэлийн асуудлыг дараах эрх зүйн баримт бичгийн хүрээнд зохицуулдаг. Үүнд:

- Дээд боловсролын тухай хууль, 11.2. Үнэлгээ хийх (2007);
- Боловсролын байгууллагуудын мэдээллийг олон нийтэд хүргэх тухай хууль (шинэчилсэн найруулга, 2007);
- Боловсролын байгууллагуудын мэдээллийг олон нийтэд хүргэхтэй холбоотой хуулийг хэрэгжүүлэх тухай тогтоол;
- Дээд боловсролын байгууллагуудын өөрийн үнэлгээ хийх журам (Боловсрол, шинжлэх ухаан, технологийн сайдын 21 тоот тушаал, шинэчилсэн найруулга, 2008);
- Дээд боловсролын байгууллагуудыг магадлан итгэмжлэх журам (Ерөнхийлөгчийн 21163 тоот зарлиг, 2008) зэрэг болно.

⁸⁸ The International Network for Quality Assurance in Higher Education-INQAAHE

⁸⁹ 한국대학교평가원 (Korean University Accreditation Institute), сүүлд үзсэн огноо: 2021.09.10, <https://aims.kcue.or.kr>

⁹⁰ 한국대학교평가원 (Korean University Accreditation Institute), сүүлд үзсэн огноо: 2021.09.10, <https://aims.kcue.or.kr>

3.5. ЭРХ ЗҮЙН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙН АГУУЛГА, БАГТААМЖ

ХМС-ийн магистрын хөтөлбөрийн сургалтын хугацааг гурван жил, 90 багц цагийн багтаамжтай байхаар хуульчилсан. Тухайн сургуулийн суралцагчдын тоо, хүчин чадал, сургалтын хөтөлбөрийн онцлогоос хамааран магистрын сургалтын хөтөлбөр ялгамжтай байдаг. Жишээлбэл, Корё их сургуулийн ХМС нь гурван жил буюу зургаан улиралд нийт 94 багц цагийн хичээлийг (үүнээс заавал судлах 32, нэмэлт 6) судлахыг суралцагчдад санал болгодог.⁹¹ Корё их сургуулийн сургалтын хөтөлбөр дараах бүтэцтэй байдаг. Үүнд:

I. Сургалтын зорилго. Хуулийн сургуулийн журам хоёрдугаар зүйл

Хуулийн мэргэшсэн сургууль нь оюутнуудад хууль зүйн ухааны онол, хэрэглээний арга зүй, хуульчийн ёс зүйг заан сургаж, эрх чөлөө, тэгш байдал, шударга ёсыг дээдэлсэн мэргэжлийн хуульчдыг бэлтгэнэ.

II. Сургалтын зорилт. Хуулийн сургуулийн журам гуравдугаар зүйл

1. Хүн, нийгэм, соёлын талаарх ойлголтод үндэслэн улс, нийгэмд хувь нэмрээ оруулах зан чанарын төлөвшил олгох;
2. Аливаа байгууллага, иргэний маргааныг зохих ёсоор шийдвэрлэж, шударга ёсыг эрхэмлэх чанар, мэргэжлийн ур чадвар, мэдлэг, ёс зүйн боловсрол олгох;
3. Шийдвэрийг оновчтой гаргах, салбарын хөгжлийг сайжруулахад шаардагдах академик мэдлэг, боловсрол олгох.

III. Сургалтын хөтөлбөрийн агуулга, процесс:

I шат: Суурь хичээл:

Эрх зүйн суурь хичээл: Үндсэн хуулийн эрх зүй, Эрүүгийн эрх зүй, Иргэний эрх зүй, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх

⁹¹ 고려대학교 법학전문대학원 (Korea University School of Law), сүүлд үзсэн огноо: 2021.09.10, <https://kulawschool.korea.ac.kr>

эрх зүй, Эрүүгийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүй болон холбогдох хичээлүүд.

Дадлагын суурь хичээл: Хууль зүйн судалгаа, баримт бичиг боловсруулалт, холбогдох хичээлүүд.

Мэргэжлийн суурь хичээл: Эрх зүйн үндсэн зарчмууд, судалгааны арга зүйн онол, салбар шинжлэх ухааны хичээлүүд.

Ёс зүйн болон ерөнхий хичээл: Хуульчийн ёс зүй, ерөнхий суурь хичээлүүд



Ерөнхий шалгалт (Мэргэжлийн хичээл судлах эрх авах шалгалт)



II шат: Мэргэжлийн болон мэргэшүүлэх хичээл

Мэргэжлийн хичээл: Онол+мэргэжлийн хичээлийн дадлага.

Мэргэжлийн дадлага хичээл: Хууль зүйн туслалцаа, дадлагын ажил, шүүхийн дадлага.

Мэргэшүүлэх тусгай хичээлүүд: Онол+олон улсын эрх зүйн дадлага.



Төгсөлтийн шалгуур хангах нэгдсэн үнэлгээ (Portfolio Assessment)



Шүүх, прокурор, өмгөөллийн байгууллага, төрийн алба, олон улсын байгууллага, олон нийтийн байгууллагад ажиллах тэргүүлэх зэрэглэлийн мэргэшсэн хуульч бэлтгэгдэх.

IV. Сургууль төгсөхөд тавигдах шаардлага

- Хичээлийн багц цагийг бүрэн судалсан байх;
- Голч дүн 3.0 ба түүнээс дээш байх;
- Бусад хичээл бүрээр төгсөлтийн суурь болзлыг хангасан байх.

V. Сургалтын хөтөлбөр

Бусад нөхцөл:

1. Нийт 20 ба түүнээс дээш багц цаг (тав ба түүнээс дээш гадаад хэлний сургалт) судалсан байх;
2. Суралцах явцдаа гадаад хэлний шалгалт өгч, зохих оноо авсан байх (TOEFL IBT 90, TOEIC 850, TEP 750).

Бусад гадаад хэлийг хүлээн зөвшөөрөх боломжтой бөгөөд элсэх үед мэдүүлсэн шалгалтын оноог мөн хүлээн зөвшөөрнө.

Хүснэгт 2. Олон улсын худалдааны эрх зүйн мэргэжлийн сургалт

Дамжаа/ Улирал	I-I	I-II	II-I	II-II	III-I	III-II
Заввал судлах 3 кр.	Олон улс (ОУ)-ын худалдааны эрх зүй					
Сонгон судлах 12 кр.	БНСУ-ын гэрээний эрх зүй I	БНСУ-ын гэрээний эрх зүй II	АНУ-ын компанийн тухай хууль	АНУ-ын гэрээний эрх зүй	ОУ-ын арилжааны арбитрын эрх зүй ОУ-ын гэрээний эрх зүй Хятадын аж ахуйн нэгжийн тухай хууль	Эрх зүй ба даяаршил I-II ОУ-ын оюуны өмчийн эрх зүй Өрсөлдөөний тухай харьцуулсан хууль ОУ-ын санхүүгийн эрх зүй ОУ-ын далайн тээврийн эрх зүй Хятадын эрх зүйн тогтолцоо
Дадлага 2 кр.	Хуулийн судалгаа	Англи хэлээр үзэх хуулийн баримт бичиг		М&А онол ба практик	Хуулийн ангил хэлний дадлага I	ОУ-ын англи хэлний гэрээний дадлага Хуулийн англи хэлний дадлага II Бизнесийн гэрээний дадлага ОУ-ын арбитрын дадлага

Дөрөв. ХУУЛЬЧИЙН ШАЛГАЛТЫН АГУУЛГА, ЭРЭЛТ ХЭРЭГЦЭЭ

Энэ бүлэгт хуульчийн шалгалтын агуулга, эрэлт хэрэгцээ, шаардлагын талаар авч судална. БНСУ-ын Үндэсний Ассамблейгаас 2009 оны 4 дүгээр сарын 29-ний өдөр баталж, мөн оны 8 дугаар сарын 28-ны өдрөөс хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн Хуульчийн шалгалтын тухай хууль, БНСУ-ын Ерөнхийлөгчийн 2009 оны 8 дугаар сарын 28-ны өдрийн “Хуульчийн шалгалтын тухай хуулийн хэрэгжилтийг хангах тухай” 21706 тоот зарлиг, Хууль зүйн сайдын 2010 оны 2 дугаар сарын 23-ны өдрийн 695 тоот захирамжаар тогтоосон “Хуульчийн шалгалтын тухай хуулийг дагаж мөрдөх” журам зэргийг мөрдлөг болгон хуульчийн шалгалтыг жил бүр зохион явуулдаг байна.

4.1. ХУУЛЬЧИЙН ШАЛГАЛТАД ТАВИГДАХ ШААРДЛАГА, ШАЛГУУР

Хуульчийн мэргэжлийн ёс зүй, хууль эрх зүйн мэдлэг, үйл ажиллагааны ур чадварыг шалгах зорилго бүхий Хуульчийн шалгалт нь Хуулийн мэргэшсэн сургуулийн бүтэц, зохион байгуулалт, удирдлагын тухай хуульд заасны дагуу сургалтын хөтөлбөр, үйл ажиллагаатай залгамж холбоо, харилцан уялдаатайгаар⁹² явагддаг. Хуульчийн шалгалтыг Хууль зүйн сайд шууд хариуцан жилд нэгээс доошгүй удаа зохион байгуулах ба энэ талаар олон нийтэд урьдчилан зарладаг⁹³ бол олон нийтэд зарлахтай холбоотой асуудлыг Ерөнхийлөгчийн зарлигаар⁹⁴ тогтоодог.

Хуульчийн шалгалтад оролцогч нь Хуулийн мэргэшсэн сургуулийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт⁹⁵ заасны дагуу магистрын зэрэг хамгаалсан байх ёстой. “Хуульчийн шалгалтын тухай хууль”-ийн

⁹² Хуульчийн шалгалтын тухай хууль, 1.

⁹³ Хуульчийн шалгалтын тухай хууль, 1.

⁹⁴ Хавсралтаас холбогдох дугаарын тайлбарыг үзнэ үү.

⁹⁵ Хуулийн мэргэшсэн сургууль нь магистрын хөтөлбөр хэрэгжүүлэх бөгөөд сургуулийн журамд заасны дагуу докторын зэрэг олгох хөтөлбөр хэрэгжүүлж болно.

8-р зүйлийн 1 дэх хэсэгт⁹⁶ заасны дагуу хуульчийн ёс зүйн шалгалтыг Ерөнхийлөгчийн зарлигт зааснаар⁹⁷ хуулийн сургуулийн магистрын зэрэг авахаас өмнө өгч болно. “Хуульчийн ёс зүй” хичээлийг ХМС-ийн сургалтын хөтөлбөрт тусган оруулсан байх бөгөөд суралцагч магистрын зэрэг хамгаалахаас өмнө энэ хичээлийг заавал судалж, шалгалтын босго оноог (70 хувь) хангаснаар хуульчийн шалгалтад орох эрхтэй болдог. Шалгалтын дүнг Р/Ф буюу тэнцсэн эсвэл тэнцээгүй гэж үнэлнэ.

Хуулийн мэргэшсэн сургуулийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу гурван сарын дотор хуулийн сургуульд магистрын зэрэг хамгаална гэж тооцоолж буй хүнийг үндсэн шалгалтын шалгуурыг хангасан гэж үзнэ. Харин тогтоосон хугацаанд магистрын зэрэг хамгаалж чадаагүй бол шалгалтад тэнцээгүй буюу шалгалтын дүнг хүчингүйд тооцно.

Дээрх хоёр параграфт заасны дагуу шалгалт өгөх шалгуурыг Ерөнхийлөгчийн зарлигаар⁹⁸ тогтооно.

Хуулийн мэргэшсэн сургуулийн захирал Хууль зүйн сайд болон шалгуулагч хүсэлт гаргасан тохиолдолд шалгуулагчийн шалгалт өгөх чадамжийг баталж болно. Харин шалгалтад дараах иргэд хамрагдах боломжгүй. Үүнд:

- Байнгын асаргаанд байдаг иргэн;
- Хорих ял эдэлсэн (ял эдэлсэнд тооцсон шийдвэрийг оруулна) болон ялыг түдгэлзүүлсэн шийдвэр гарснаас хойш таван жил өнгөрөөгүй иргэн;
- Хорих ялыг түдгэлзүүлж, тэнсэн харгалзах ял оноож ялын хугацаа дууссанаас хойш хоёр жил өнгөрөөгүй иргэн;

⁹⁶ Шалгалтыг сонгох (нөхөх), эссэ (практик чадварын үнэлгээг оролцуулна) бичгээр, хуульчийн ёс зүйн шалгалтыг тусад нь авна.

⁹⁷ 3.1. Хуулийн мэргэшсэн сургуулийн бүтэц, зохион байгуулалт, удирдлагын тухай хуулийн дагуу (цаашид “хуулийн сургууль” гэх) магистрын зэрэг авахаас өмнө хуулийн 8 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу хуульчийн ёс зүйн шалгалт өгөх гэж байгаа хүн хуулийн мэргэшсэн сургуулийн бүтэц, зохион байгуулалт, удирдлагын тухай хуулийн хэрэгжилтийг хангах тухай Ерөнхийлөгчийн зарлигийн 13 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1-д заасан ёс зүйн хичээлийг судалсан байна.

⁹⁸ Хавсралтаас холбогдох дугаарын тайлбарыг үзнэ үү.

- Хорих ялыг түдгэлзүүлж, тэнсэн харгалзах ял оноож ялын хугацаа дуусаагүй иргэн;
- Импичмент болон сахилгын шийтгэлийн улмаас ажлаас халагдсанаас хойш таван жил өнгөрөөгүй иргэн;
- Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн дагуу эрхээ хасуулснаас хойш таван жил өнгөрөөгүй иргэн;
- Сахилгын шийтгэлийн улмаас ажлаас халагдсанаас хойш гурван жил өнгөрөөгүй иргэн;
- Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн дагуу эрхээ бүрмөсөн хасуулсан иргэн зэрэг болно.⁹⁹

Хуульчийн шалгалтыг хэдэн ч удаа өгөх боломжтой буюу хязгаарлалт тогтоогоогүй байсан нь олон хүн шалгалтад тэнцэх оролдлогыг олон жилийн турш хийх¹⁰⁰ сул талтай байсан тул Хуульчийн шалгалтын тухай хуулиар шалгалтыг (8 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан хуульчийн ёс зүйн шалгалтыг эс тооцно) Хуулийн мэргэшсэн сургуулийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу хуулийн мэргэшсэн сургуульд магистрын зэрэг хамгаалсан сарын сүүлийн өдрөөс хойш таван жилийн дотор таван удаа өгөх боломжтой байхаар хуульчлан зохицуулжээ.

Мэргэшсэн хуульч бэлтгэх тогтолцооны шинэчлэлээс өмнө зарим эрэгтэй оюутан хуульчийн улсын шалгалтад тэнцэх хүртлээ цэргийн алба хаах үүргийг хойшлуулах хэрэгсэл болгон ашиглах явдал ихсэх хандлагатай байсан тул одоо мөрдөгдөж буй хуулийн “Шалгалт өгөх хугацаа болон шалгалтын тоог хязгаарлах” хэмээх 7 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Хуулийн мэргэшсэн сургуулийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу магистрын зэрэг хамгаалсны дараа, эсвэл энэ хуулийн 5 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан магистрын зэрэг авахаар төлөвлөж буй хүний хувьд шалгалт өгсний дараа “Цэргийн албаны тухай хууль”, “Цэргийн албан хаагчийн тухай” хуулийн дагуу цэргийн алба хаах үүргийг биелүүлэх хугацааг (1) дэх хэсэгт оруулаагүй болно” гэж тусган зохицуулжээ.

⁹⁹ Хуульчийн шалгалтын тухай хууль, 6.

¹⁰⁰ Matthew J. Wilson, U.S. Legal Education Methods and Ideals: Application to the Japanese and Korean Systems, 18 Cardozo J.Int'l & Comp.L., p. 295, p. 335 (2010).

4.2. ХУУЛЬЧИЙН ШАЛГАЛТЫН ХЭЛБЭР, АГУУЛГА

Хуульчийн шалгалт нь хувилбар сонгох (нөхөх), эссэ бичгийн (практик чадварын үнэлгээг оролцуулна), хуульчийн ёс зүйн шалгалт гэсэн хэлбэртэй байх бөгөөд хуульчийн ёс зүйн шалгалтыг тусад¹⁰¹ нь хувилбар сонгох бичгийн болон эссэ бичлэгээр хослуулан авдаг.

Хуульчийн ёс зүйн шалгалт авахад Хууль зүйн сайд шаардлагатай барилга, байгууламж, хүн хүч бүхий байгууллагыг томилж, шалгалтыг зохион байгуулна. Шалгалт авах байгууллагыг томилоход тавигдах шаардлага, журам, түүнийг хүчингүй болгох, шалгалтад тавих хяналт, хуульчийн ёс зүйн шалгалттай холбоотой бусад асуудлыг Ерөнхийлөгчийн зарлигаар¹⁰² тогтоодог.

Хуульчийн шалгалтын сэдэвт дараах агуулгыг багтаана. Үүнд:

- Нийтийн эрх зүй (Үндсэн хууль, Захиргааны эрх зүйн салбарын сэдвүүд);
- Иргэний эрх зүй (Иргэний эрх зүй, Худалдааны эрх зүй, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүйн холбогдох сэдвүүд);
- Эрүүгийн эрх зүй (Эрүүгийн эрх зүй, Эрүүгийн байцаан шийтгэх эрх зүйн салбар сэдвүүд);
- Мэргэжлийн салбарын эрх зүйн сонгосон нэг сэдэв зэрэг байх бөгөөд мэргэжлийн салбарын эрх зүйн чиглэлээр сонгох сэдвийг Ерөнхийлөгчийн зарлигаар тогтооно.

“Хуульчийн шалгалтын тухай хуулийн хэрэгжилтийг хангах тухай” Ерөнхийлөгчийн зарлигийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар сонгох сэдэвт олон улсын болон олон улсын худалдааны эрх зүй, хөдөлмөрийн, татварын, оюуны өмчийн, эдийн засгийн, экологийн эрх зүй багтсан байна. Мөн шалгалтын сэдэв бүрийг Ерөнхийлөгчийн зарлигийн хоёрдугаар хавсралтад дараах байдлаар оруулжээ.

¹⁰¹ Хуульчийн шалгалтын тухай хууль, 8.1.

¹⁰² Хавсралтаас холбогдох дугаарын тайлбарыг үзнэ үү.

Хүснэгт 3. Хуульчийн шалгалтын сэдэв

Сэдэв	Хамрах хүрээ
Олон улсын эрх зүй	Олон улсын эдийн засгийн эрх зүй
Олон улсын худалдааны эрх зүй	Олон улсын хувийн эрх зүй, Олон улсын бараа борлуулах гэрээний тухай НҮБ-ын конвенц
Хөдөлмөрийн эрх зүй	Нийгмийн хамгааллын тухай хууль болон Үйлдвэрлэлийн ослын нөхөн төлбөрийн даатгалын тухай хууль
Татварын эрх зүй	Үндэсний татварын тухай хууль, Орлогын албан татварын тухай хууль, Аж ахуйн нэгжийн албан татварын тухай хууль, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль
Оюуны өмчийн эрх зүй	Патентын тухай хууль, Ашигтай загварын тухай хууль, Дизайн хамгаалах тухай хууль, Барааны тэмдгийн тухай хууль, Зохиогчийн эрхийн тухай хууль
Эдийн засгийн эрх зүй	Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах тухай хууль, Цахим худалдаанд хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах тухай хууль, Шударга худалдааны тухай хууль, Хэлэлцээрийн нөхцөлийн тухай хууль, Төлбөрийг хэсэгчлэн хийх гүйлгээний тухай хууль, Хаалганаас хаалганд хүргэх худалдааны тухай хууль (<i>Door to door sale</i>)
Экологийн эрх зүй	Байгаль орчны бодлогын тухай хууль, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, Байгаль орчны нөхөн төлбөрийн тухай хууль, Усны орчны нөхөн олговрын тухай хууль, Хог хаягдлын менежментийн тухай хууль, Хөрсний орчны нөхөн олговрын тухай хууль, Байгаль орчны нөхөн олговрын тухай хууль, Дуу чимээ, чичиргээний тухай хууль, Байгаль орчны маргааныг зохицуулах тухай хууль

Шалгалтын сэдвийг шинэчлэх болон өөрчлөх, шалгалтын асуултуудын хамрах хүрээг өөрчлөх тохиолдолд холбогдох шалгалт товлогдсон өдөр хүртэл тооцож, хоёр жилээс доошгүй хугацаа өгнө.¹⁰³

4.3. ХУУЛЬЧИЙН ШАЛГАЛТЫН ХОРОО, ТҮҮНИЙ БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Хууль зүйн сайд нь мэргэшсэн хуульч бэлтгэх тогтолцоотой уялдуулан шалгалтад тэнцсэн эсэх шийдвэрийг гаргах бөгөөд Хуульчийн шалгалтын хорооны (Хуульчийн шалгалтын тухай хуулийн “Хуульчийн шалгалтын хорооны бүтэц, зохион байгуулалт” хэмээх 14 дүгээр зүйл) дүгнэлт болон Улсын дээд шүүх, Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 78 дугаар зүйлд¹⁰⁴ заасны дагуу Солонгосын хуульчдын холбоо, хуулийн мэргэшсэн сургуулийг оролцуулан, Иргэний хуулийн 32 дугаар зүйл¹⁰⁵, Олон нийтийн байгууллагын бүтэц, зохион байгуулалт, удирдлагын тухай хуулийн 4 дүгээр зүйлд¹⁰⁶ заасны дагуу байгуулагдсан хуулийн этгээдийн саналыг сонсоно.

Шалгалтын дүнг гаргахдаа бичгийн шалгалт, эссэ бичлэгийн оноог тодорхой хувиар хөрвүүлэх замаар тооцоолон нийт оноог тодорхойлно. Хэрэв аль нэг шалгалтын онооны доод хязгаарын болзлыг¹⁰⁷ хангаагүй бол шалгалтад тэнцээгүйд тооцно. Хууль зүйн сайд шалгалтад тэнцсэн иргэдийн нэрийн жагсаалтыг зарлаж, шийдвэр гарган гэрчилгээг олгоно.¹⁰⁸

Хуульчийн шалгалт зохион байгуулахдаа Хууль зүйн яамны дэргэд Хуульчийн шалгалтын хороо байгуулан ажилладаг. Тус хороо нь

¹⁰³ Хуульчийн шалгалтын тухай хууль, 9.4.

¹⁰⁴ 78.1. Солонгосын хуульчдын холбоо нь хуульчийн нэр төрийг хамгаалах, хуулийн үйлчилгээг сайжруулах, хөгжүүлэх, бусад эрх зүйн соёлыг дэмжих, хуульчид болон орон нутгийн хуульчдын холбооны удирдлага, хяналттай холбоотой ажил эрхлэх зорилгоор байгуулагдана. 78.2. Солонгосын хуульчдын холбоо нь хуулийн этгээд байна.

¹⁰⁵ Эрдэм шинжилгээ, шашин, буяны, хүмүүнлэгийн, нийгмийн, болон бусад ашгийн бус зорилгоор байгуулагдсан холбоо, санг эрх бүхий байгууллагын зөвшөөрлөөр хуулийн этгээдийн статусаар байгуулж болно.

¹⁰⁶ Хавсралтаас холбогдох дугаарын тайлбарыг үзнэ үү.

¹⁰⁷ Хавсралтаас холбогдох дугаарын тайлбарыг үзнэ үү.

¹⁰⁸ Хуульчийн шалгалтын тухай хууль, 11.

шалгалтын асуултын чиглэл, шалгалт авах аргачлал, стандарт, түүнийг сайжруулах асуудал, үнэлгээ, тэнцсэн талаарх шийдвэр болон шалгалттай холбоотой Хууль зүйн сайдаас өгсөн чиглэлийг хэлэлцэх үндсэн чиг үүрэгтэй.¹⁰⁹

Шалгалтын хорооны гишүүдийг шалгалтын талаар өргөн мэдлэг, туршлагатай хүмүүсээс сонгон бүрдүүлж, Хууль зүйн сайд тухай бүр томилох ба гишүүдийн тоог Ерөнхийлөгчийн зарлигаар¹¹⁰ тогтооно. Шалгалтын хороо нь чиг үүргээ хэрэгжүүлэхдээ ХМС-ийн сургалтын хөтөлбөрийг бүрэн дүүргэсэн төгсөгчийн академик мэдлэг, түүнийг хэрэглэх ур чадварыг цогцоор нь харгалзан үзэхэд анхаарал хандуулах үүрэгтэй. Хуульчийн шалгалтын хороо нь дарга, дэд дарга багтсан 15 гишүүнээс бүрдэх бөгөөд дарга, дэд даргыг гишүүдийн дундаас Хууль зүйн сайд томилно. Гишүүдэд дараах хүмүүс багтана. Үүнд:

- Хууль зүйн дэд сайд, Хууль зүйн сайдын томилсон тухайн салбарын профессор (дэд профессор болон түүнээс дээш албан тушаал хашиж буй хүмүүс) таван хүн;
- Арваас дээш жил ажилласан туршлагатай, Шүүхийн тамгын газрын даргын зөвлөсөн хоёр шүүгч;
- Арваас дээш жил ажилласан туршлагатай хуульч болон Хууль зүйн яаманд хуульчийн шалгалт хариуцсан ажил эрхэлдэг төрийн өндөр албан тушаалтны зэрэглэлд харьяалагдах төрийн албан хаагч хоёр хүн (үүнээс нэг нь прокурор байх);
- Арваас дээш жил ажилласан туршлагатай, БНСУ-ын Хуульчдын холбооны ерөнхийлөгчийн санал болгосон гурван хуульч;
- Ерөнхийлөгчийн зарлигаар томилсон тал бүрийн мэдлэг, туршлагатай хоёр хүн (эрх зүйн үндсэн багшаас дээш албан тушаалтай болон хуульч мэргэжилтэй хүмүүсээс бусад) багтана.

¹⁰⁹ Хуульчийн шалгалтын тухай хууль, 14.

¹¹⁰ Шалгалтын хорооны гишүүдийн тоог гаргахдаа нэг сэдвээр гурваас доошгүй хүн байх ёстойг баримтална. Хуулийн 8 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу томилогдсон байгууллага нь хуульчийн ёс зүйн шалгалт авах тохиолдолд шалгалтын асуулт, шалгалтын хорооны гишүүдийн тоог бие даан шийдвэрлэж болно.

Гишүүдийн бүрэн эрхийн хугацаа хоёр жил байх бөгөөд хууль зүйн профессор, шүүгч, прокурор болон Хууль зүйн яамны өндөр албан тушаалтны зэрэглэлд хамаарах төрийн албан хаагч зэрэг нь албан тушаалаасаа чөлөөлөгдсөн тохиолдолд гишүүний бүрэн эрхийн хугацаа дуусахаас өмнө чөлөөлөгдсөн гэж үзнэ.¹¹¹

4.4. ХУУЛЬЧИЙН ШАЛГАЛТЫН ЖУРАМ ЗӨРЧИГЧДӨД ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА

Шалгалтын үеэр Ерөнхийлөгчийн зарлигт заасан зүй бус үйлдэл¹¹² хийсэн этгээд, шалгалтын мэдүүлгийг хуурамчаар үйлдсэн этгээдэд хариуцлага тооцох бөгөөд энэ талаар тухайн иргэнд даруй мэдэгдэнэ. Түүнчлэн Шалгуулагчийн мөрдөх журмыг¹¹³ зөрчсөн этгээдийг шалгалт өгөхийг хориглох болон шалгалтын оноог хүчингүйд тооцож болдог.

Шалгуулагч нь шалгалтад тэнцсэн иргэдийг зарласан өдрөөс хойш таван жилийн дотор дүнгээ ил болгох талаар Хууль зүйн сайдад хүсэлт гаргах эрхтэй байх бөгөөд энэ тохиолдолд Хууль зүйн сайд дүнг шалгуулагчид мэдэгдэнэ. Хууль зүйн сайд нь шалгалтын хуудас, хариултын хуудас болон шалгалтыг шударгаар зохион байгуулахад саад болохуйц бусад мэдээллийг задруулж болохгүй.¹¹⁴

Ерөнхийлөгчийн зарлигаар тогтоосон шалгалтын хураамжийг¹¹⁵ шалгуулагч төлнө. Шалгалт өгөх өдрөөс өмнө шалгалтад орох хүсэлтээ

¹¹¹ Хуульчийн шалгалтын тухай хууль, 14.

¹¹² Зүй бус үйлдэл нь 1. Өөрийн оронд өөр хүнээр шалгалт өгүүлэхээр захиалах болон бусдын нэрийн өмнөөс шалгалт өгөх; 2. Өөр шалгуулагчийн хариултын хуудсыг харах эсвэл өөрийн хариултын хуудсыг харуулах; 3. Харилцаа холбооны төхөөрөмж эсвэл бусад дохио ашиглан шалгалтын агуулгын талаар бусадтай ярилцах; 4. Зөвшөөрөгдөөгүй материал биедээ авч орох, ашиглах; 5. Бусад аргаар өөрийн болон бусдын шалгалтын дүнд нөлөөлөх үйлдэл зэргийн хэлнэ.

¹¹³ Хавсралтаас холбогдох дугаарын тайлбарыг үзнэ үү.

¹¹⁴ Хуульчийн шалгалтын тухай хууль, 18.

¹¹⁵ 13.1. Хууль зүйн сайдын тушаалаар тогтоосон шалгалтын хураамжийг шалгуулагчид төлөх ёстой. 13.2. Шалгалтын хураамжийг шалгалтын мэдүүлгийн хуудсанд тэмдэг дарах, цахим сүлжээ ашиглан төлбөр хийх, цахим мөнгө ашиглах хэлбэрээр төлж болно. 13.3. Хуулийн 20 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу шалгалт өгөхөөс татгалзсан хүнд шалгалт авах өдрөөс нэг хоногийн өмнө түүнд шалгалтын хураамжийг бүхэлд нь буцаан олгоно.

цуцалсан тохиолдолд дээрх хураамжийг бүхэлд нь буюу хэсэгчлэн буцаан олгоно.¹¹⁶

Хорооны гишүүд, шалгалтын хорооны гишүүдийн дундах төрийн бус албан хаагч, хуульчийн ёс зүйн шалгалт зохион байгуулах байгууллагаар томилогдсон байгууллагын төрийн бус албан хаагч нарт ажил үүрэгтэй нь холбоотойгоор Эрүүгийн хуулийн 127¹¹⁷, 129-132 дугаар зүйлд¹¹⁸ заасны дагуу хариуцлага тооцох нөхцөлд тэднийг төрийн албан тушаалтантай адилтган үзнэ.¹¹⁹

¹¹⁶ Хуульчийн шалгалтын тухай хууль, 20.

¹¹⁷ Төрийн албан тушаалтан, төрийн албан тушаалтан байсан хүн албаны нууцыг задруулсан бол хоёр жил хүртэлх хугацаагаар хорих эсхүл таван жил хүртэлх хугацаагаар мэргэжлээрээ ажиллахыг хориглоно.

¹¹⁸ Албан тушаал, хээл хахуулийн гэмт хэрэг.

¹¹⁹ Хуульчийн шалгалтын тухай хууль, 21.

Тав. МЭРГЭШСЭН ХУУЛЬЧ БЭЛТГЭХ ТОГТОЛЦООНЫ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ЦААШДЫН ЧИГ ХАНДЛАГА

5.1. МЭРГЭШСЭН ХУУЛЬЧ БЭЛТГЭХ ТОГТОЛЦООНЫ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Өмнөд Солонгосын эрх зүйн боловсролын шинэ тогтолцоо нь АНУ-ын хуулийн сургуулийн загварын үндсэн шинжийг агуулсан, гурван жилийн сургалттай байна. Хуулийн мэргэшсэн сургуулийн бүтэц, зохион байгуулалт, удирдлагын тухай хуулийн 6, 7 дугаар зүйлд заасны дагуу ХМС байгуулах, тухайн хичээлийн жилд элсүүлэх суралцагчдын тоог Боловсролын Сайд тогтоох эрхтэй. Ингэхдээ нийгмийн эрэлт хэрэгцээ, нийлүүлэлт, тухайн байгууллагын материал техникийн хангамж, санхүү, хүний нөөцийн чадамжийг харгалзан үзнэ.

ХМС-ийн үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл авсан их сургуулийн эрх зүйн бакалаврын сургалт явуулах эрхийг түдгэлзүүлдэг. ХМС-д элсэх сонирхолтой иргэн бакалаврын цолтой байх шаардлагатай бөгөөд ХМС төгсөгч нь хуульчийн шалгалт өгөх эрхтэй болдог. Төгсөгч нь төгссөнөөс хойш таван жилийн хугацаанд тав хүртэл удаа хуульчийн шалгалт давтан өгөх боломжтой. Мэргэшсэн хуульч бэлтгэх БНСУ-ын тогтолцоог шинэчилснээр эрх зүйн боловсрол шинэ шатанд гарсан гэж үзэж болно. Шинэчлэлийн үр дүнд мэргэшсэн хуульчдын тоо маш их нэмэгдсэн. Тухайлбал, хуульчдын тоо 2009 онд 10,000 орчим байсан бол 2019 онд 26,000 гаруй¹²⁰ болж өсжээ. Мэргэшсэн хуульчдыг нэмэгдүүлэх, өрсөлдөөнийг бий болгох нь хууль зүйн туслалцаа, үйлчилгээний чанар, хүртээмж нэмэгдэх, үнэ өртөг буурах, эрх зүйн мэргэжилтнүүд төрөлжих давуу талтай гэж үзэх эрдэмтэн, судлаачид олон байна. Тухайлбал, өмнө нь хуульчаар төгссөн хүмүүс ихэвчлэн шүүгч, прокурор эсвэл өмгөөлөгч болдог байсан бол тогтолцооны шинэчлэл хийснээр салбарын онцлогт нийцсэн эрх зүйч, мэргэшсэн хуульчид бэлтгэгдэх үндэс суурь бүрдсэн байна.

¹²⁰ Kim, Namhee (2021), "Law School in South Korea: Past, Present, and Future", Waseda Bulletin of Comparative Law, Vol39, p. 35-43.

Эрх зүйн боловсролын хувьд ХМС байгуулсан нь боловсролоор дамжуулан хөдөлмөр эрхлэлтэд гарах үр дүнг дээшлүүлсэн гэж үзэж болно. Хуулийн мэргэшсэн сургуулийн бүтэц, зохион байгуулалт, удирдлагын тухай хуулийн 16 дугаар зүйлд нэг багшид оногдох оюутны тоог тогтоож, мөн зүйлээр багшлах бүрэлдэхүүнд практик туршлагатай багш, мэргэжилтний төлөөллийг оролцуулах шаардлага тавьсан нь сургалтын чанар, үр дүн, онол, практик, сургалт үйлдвэрлэлийн нэгдлийг хангах үндэс суурийг бий болгосон давуу талтай. Түүнчлэн мөн хуулийн 26 дугаар зүйлд оюутны бүрэлдэхүүнийг төрөл бүрийн мэдлэг, туршлагатай элсэгчдээс бүрдүүлэх,¹²¹ бусад их, дээд сургуулийн төгсөгч байх¹²² шаардлагыг тусгасан нь ирээдүйн чадварлаг, мэргэшсэн хуульч бэлтгэх боломжийг олж харсан зохицуулалт болжээ.

Суралцагсдын нийгмийн асуудлыг энэхүү шинэчлэлд анхааран тусгасан бөгөөд санхүүгийн харилцан ялгамжтай байдлыг тэнцвэржүүлэх үүднээс ХМС тус бүр оюутны бүрэлдэхүүний долоо хүртэл хувийг нийгмийн эмзэг давхарга, хөгжлийн бэрхшээлтэй иргэдээс бүрдүүлэхийг Ерөнхийлөгчийн зарлигаар тогтоож өгсөн¹²³ төдийгүй сургалтын төлбөрийг үндэслэлгүй нэмэгдүүлэхийг хориглосноор сургалтын төлбөрийн өсөлтийг хянах тогтолцоо бий болгожээ.

Хуулийн мэргэшсэн сургуулийн бүтэц, зохион байгуулалт, удирдлагын тухай хуульд заасны дагуу ХМС-ийн эрх олгох шалгаруулалтыг 2008 онд явуулсан бөгөөд 41 их сургууль оролцсоноос эцсийн шатанд 25 сургууль тэнцжээ. ХМС-ийн эрх авсан сургууль 2021 оны байдлаар 25 байгаагаас 15 нь Сөүл хот орчмын бүсэд, 10 нь орон нутагт, үүнээс улсын их сургууль 10, хувийн их сургууль 15 байна. Эдгээр сургууль нь Засгийн газраас тогтоосон квотын дагуу жил бүр 40-150 оюутан элсүүлдэг ба нийт элсэгчдийн тоог нэг жилд 2,000-аас хэтрүүлэхгүй байхаар зохицуулжээ.¹²⁴ Элсэлтийн квот сургуулийн хүчин чадал,

¹²¹ Гуравны нэгээс багагүй хувь нь хуулиас бусад чиглэлээр бакалаврын зэрэг хамгаалсан байх.

¹²² Гуравны нэгээс багагүй хувь нь тус хуулийн мэргэшсэн сургуулийн үйл ажиллагаа эрхэлдэг боловсролын байгууллагаас өөр сургуульд бакалаврын зэрэг хамгаалсан байх.

¹²³ Kim, Namhee. (2021), "Law School in South Korea: Past, Present, and Future", Waseda Bulletin of Comparative Law, Vol39, p. 35-43.

¹²⁴ 대한민국의 법학전문대학원, сүүлд үзсэн огноо: 2021.09.15, <https://ko.wikipedia.org>

барилга байгууламж, хичээлийн хөтөлбөр, багшлах бүрэлдэхүүний чадавх гэх мэт олон хүчин зүйлээс шалтгаалан сургууль бүрд элсэлтийн квот харилцан адилгүй олгогддог байна (Хүснэгт 4).

Эрх авсан 25 их сургууль холбогдох шаардлагыг ханган өнөөг хүртэл үйл ажиллагаагаа хэвийн явуулж байгаа тул одоогоор нэмэлт эрх олгогдоогүй байна.

Хүснэгт 4. Элсэгчдийн квот (сургуулиар)

д/д	Сургуулийн нэр	Квот
1	Сөүлийн их сургуулийн хуулийн сургууль	150
2	Чоннам их сургуулийн хуулийн сургууль	120
3	Корё их сургуулийн хуулийн сургууль	120
4	Кёнбук их сургуулийн хууль зүйн сургууль	120
5	Пусан их сургуулийн хуулийн сургууль	120
6	Сунхюнгван их сургуулийн хуулийн сургууль	120
7	Ёнсей их сургуулийн хуулийн сургууль	120
8	Чуннам үндэсний их сургуулийн хуулийн сургууль	100
9	Ханян их сургуулийн хуулийн сургууль	100
10	Ихуа эмэгтэйчүүдийн их сургуулийн хуулийн сургууль	100
11	Чунбук их сургуулийн хуулийн сургууль	80
12	Дун А их сургуулийн хуулийн сургууль	80
13	Чонбук их сургуулийн хуулийн сургууль	70
14	Ённам их сургуулийн хуулийн сургууль	70
15	Гёнхи их сургуулийн хуулийн сургууль	60
16	Вонквангийн их сургуулийн хуулийн сургууль	60

Хүснэгт 4-ийн үргэлжлэл

17	Сөүл хотын их сургуулийн хуулийн сургууль	50
18	Ханкүк гадаад хэлний их сургуулийн хуулийн сургууль	50
19	Ажоу их сургуулийн хуулийн сургууль	50
20	Чун-Анг их сургуулийн хуулийн сургууль	50
21	Инха их сургуулийн хуулийн сургууль	50
22	Канвон их сургуулийн хуулийн сургууль	40
23	Чэжүгийн их сургуулийн хуулийн сургууль	40
24	Соган их сургуулийн хуулийн сургууль	40
25	Конкүк их сургуулийн хуулийн сургууль	40
Нийт		2,000

Дээрх сургуулиудаас хуулийн дараах 10 мэргэшсэн сургуулийг 2008-2020 онд шилдэг үйл ажиллагаа, сургалттай сургуулиар нэрлэжээ. Үүнд:

1. Сөүлийн их сургуулийн хуулийн сургууль;
2. Корё их сургуулийн хуулийн сургууль;
3. Ёнсей их сургуулийн хуулийн сургууль;
4. Сунхюнгван их сургуулийн хуулийн сургууль;
5. Ханян их сургуулийн хуулийн сургууль;
6. Соган их сургуулийн хуулийн сургууль;
7. Эва эмэгтэйчүүдийн их сургуулийн хуулийн сургууль;
8. Пусан их сургуулийн хуулийн сургууль;
9. Кёнхи их сургуулийн хуулийн сургууль;
10. Чунанг их сургуулийн хуулийн сургууль.

Хуулийн мэргэшсэн сургуулиуд нь тухайн байгууллагын байрлал, онцлогоос хамаарч харилцан адилгүй төлбөртэй (*Хүснэгт 5-ыг харна уу*) байх бөгөөд жилийн сургалтын дундаж төлбөр 14 орчим сая вон, элсэлтийн хураамж 8 сая орчим вон байна. Хувийн их сургуулийн элсэлтийн хураамж улсын их сургуулийнхаас 79.8 хувь, жилийн сургалтын төлбөрөөс 61.8 хувиар илүү байна.

*Хүснэгт 5. Хуулийн мэргэшсэн сургуулийн сургалтын дундаж төлбөр¹²⁵
(2020 оны байдлаар)*

Мэргэшсэн хуулийн сургууль	Элсэлтийн хураамж	Жилийн сургалтын төлбөр
Хувийн 15 их сургуулийн дундаж төлбөр	9,489,613 вон	16,497 726 вон
Улсын 10 их сургуулийн дундаж төлбөр	5,275,905 вон	10,195 432 вон
Нийт 25 их сургуулийн дундаж төлбөр	7,804,130 вон	13,976,808 вон

Эх сурвалж: 베리타스알파 교육 전문 저널 / Veritas Alfa, Educational Journal

БНСУ-ын “Хууль зүй” цахим сэтгүүлд 2020 оны 9 дүгээр сарын 8-ны өдөр нийтэлсэн “Хуулийн мэргэшсэн сургуулийн элсэлтийн үр дүн” хэмээх элсэгчдийн насны байдлын талаарх судалгааны дүнгээс үзвэл ХМС-иудад 2020 онд нийт 2,130 оюутан элсэн орсон байх бөгөөд 25-аас доош насны элсэгчдийн тоо Сөүл орчмын сургуулиудад хоёр дахин өндөр байсан бол 35-аас дээш насны элсэгчид орон нутгийн сургуулиудад илүү өндөр хувьтай байна. БНСУ-ын Корё их сургуулийн ХМС-д 121 оюутан элссэн байх бөгөөд үүнээс 25-аас доош насны оюутан 75.6 хувь (89 оюутан) байсан нь улсын хэмжээнд хамгийн өндөр үзүүлэлт байв. Удаах байруудад Сөүлийн их сургууль 67.3 (105/156), Чун-Анг их сургууль 64.8 (35/54), Ёнсей их сургууль 61.1 (77/126), Ханян их сургууль 50 (55/110), Пусаны их сургуулийн хуулийн сургууль 40.2

¹²⁵ 베리타스알파 교육 전문 저널 /Veritas Alfa, Educational Journal/, сүүлд үзсэн огноо: 2021.09.10, <https://www.veritas-a.com/news/article>

(51/127) хувь тус тус байна. Дээрх үзүүлэлтээс харвал 2020 онд залуу элсэгчид Сөүл хот орчмын ХМС-иудыг илүүтэй сонгон суралцжээ гэж дүгнэж болохоор байна. Харин 35 ба түүнээс дээш насны элсэгчид Вонквангийн их сургуулийн ХМС-ийг (64.1 хувь (41/64)) илүүтэй сонгожээ. Түүнчлэн Дун А их сургууль 29.4 (25/85), Канвон их сургууль 19.5 (8/41), Ённам их сургууль 18.3 (13/71), Чонбук их сургууль 8.1 (7/86), Чэжүгийн их сургууль 7.1 (3/42), Кёнгбүк их сургууль 7.0 (9 /129) хувиар тус тус удаах байруудад нэрлэгдсэн бол Корё их сургууль, Сөүлийн их сургууль, Ёнсей их сургууль, Ихуа эмэгтэйчүүдийн их сургууль, Чун-Анг их сургууль, Ханян их сургуульд 35-аас дээш насны нэг ч хүн элсээгүй байна.

Хуульчийн шалгалтад хамрагдах хүсэлтэй иргэдийн дундаж нас 32, шалгалтад тэнцэгсдийн дундаж нас 31 орчим байгаагаас үзвэл хуулийн сургуулийн оюутнуудын дундаж нас 28-29 байна. Хуулийн сургуульд элсэгчдийн нас жил ирэх тусам залуужих хандлагатай байгаа нь 2009-2020 онд 28-аас доош насныхны эзлэх хувь тогтмол өссөн, 2020 онд 29-31 насныхны эзлэх хувь 13.5 хувь болон буурсан, 32 ба түүнээс дээш насныхны эзлэх хувь 12.3 болж буурсан зэргээс харагдаж байна.¹²⁶

Хуульчийн шалгалтад сүүлийн 10 жилийн байдлаар оролцогчид, тэнцэгчдийн тоон судалгааг (*Хүснэгт 6-г харна уу*) авч үзвэл 2012 онд 1,665 иргэн оролцож байсан бол 2021 онд 3,256 болж өссөн байх бөгөөд тэнцсэн үзүүлэлт нь шалгалтад оролцогчдын тоотой уялдан өссөн байна. Эндээс мэргэшсэн хуульчийн нийгмийн эрэлт хэрэгцээ улам бүр өсөж, өрсөлдөөн их болсон гэж дүгнэж болох юм.

5.2. МЭРГЭШСЭН ХУУЛЬЧ БЭЛТГЭХ ТОГТОЛЦООНД ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ, ИРЭЭДҮЙН ЧИГ ХАНДЛАГА

Хуулийн мэргэшсэн сургуулийн бүтэц, зохион байгуулалт, удирдлагын тухай хуулийн нэгдүгээр бүлгийн хоёрдугаар зүйлд ХМС-ийн сургалтын зорилго нь “Олон нийтийн хүлээлт, эрэлт хэрэгцээг хангасан, олон талт соёл, хүн, нийгмийн харилцааны талаар гүнзгий ойлголттой, эрх чөлөө, тэгш байдал, шударга ёс, үнэт зүйлийг эрхэмлэсэн, аливаа

¹²⁶ “2020 로스쿨 입시결과 분석”, 이성진, 2020.09.08, 법률 저널 /The Law Journal/, сүүлд үзсэн огноо: 2021.09.24, <http://www.lec.co.kr>

маргааныг мэргэжлийн өндөр ёс зүйг баримтлан, үр дүнтэй шийдвэрлэх чанартай хууль зүйн туслалцаа, үйлчилгээ үзүүлэхүйц мэдлэг, чадвартай мэргэшсэн хуульчдыг бэлтгэхэд оршино” хэмээн тодорхойлсон байх боловч эрх зүйн боловсролд дорвитой ахиц гарахгүй байна хэмээн судлаачид үзэх болсон.

Хүснэгт 6. Хуульчийн шалгалтад оролцсон ба тэнцсэн хүмүүсийн тоон судалгаа, сүүлийн 10 жилийн байдлаар

Шалгалтын дугаар/ явагдсан он	I 2012	II 2013	III 2014	IV 2015	V 2016	VI 2017	VII 2018	VIII 2019	IX 2020	X 2021
Оролцогчдын өсөлт, бууралт тоогоор	1,665	2,046 +381	2,292 +246	2,561 +269	2,664 +303	3,110 +246	3,240 +130	3,330 +90	3,316 -14	3,256 -160
Оролцогчдын өсөлт, бууралт хувиар	-	Δ22.9	Δ12.0	Δ11.7	Δ11.8	Δ8.6	Δ4.2	Δ2.8	Δ0.4	Δ4.8
Тэнцсэн оролцогчдын өсөлт, бууралт тоогоор	1,451	1,539 +11	1,550 +11	1,565 +15	1,581 +16	1,593 +12	1,599 +6	1,691 +92	1,768 +77	1,706 -62
Оролцогчдын тэнцсэн байдал хувиар	87.15	75.17	67.63	61.11	55.20	51.45	49.40	50.78	53.32	54.06

Эх сурвалж: 법률 저널 /The Law Journal/, сүүлд холбогдсон 2021.09.25, <http://www.lec.co.kr>

Эрх зүйн боловсролын тогтолцоонд нүүрлэж буй нэг том хүчин зүйл нь хуульчийн шалгалтад тэнцэгсдийн үзүүлэлт юм (Хүснэгт 6-г харна уу). Хуульчийн шалгалтад оролцогчид болон тэнцэгсдийн тоон үзүүлэлтийн хувь хэмжээ сүүлийн 10 жилийн байдлаар буурсаар байна. Өөрөөр хэлбэл, 2012 онд хуульчийн шалгалтад оролцогчдын тоо 1,665,

үүнээс тэнцсэн нь 1,451 буюу 87.1 хувь нь тэнцэж байсан бол 2021 оны байдлаар 3,256 иргэн оролцож 1,706 буюу 54.06 хувь нь тэнцсэн байна.

ХМС-ийг амжилттай дүүргэсэн оюутнуудын 75 орчим хувь нь хуульчийн шалгалтад тэнцэж байгаа¹²⁷ боловч тэнцээгүй үлдсэн оюутнууд дараа жилийн шалгалтад нэмэгдэн орох болсон.¹²⁸ Хэдийгээр оролцогчдын тоо жил бүр нэмэгдэж байгаа ч тэнцсэн үзүүлэлт буурсаар байна. Энэ нь оюутнуудыг зөвхөн хуульчийн шалгалтад анхаарлаа төвлөрүүлэхэд хандуулж байгаа төдийгүй ХМС-иудын сургалтын үйл ажиллагаа нь хуульчийн шалгалтад бэлтгэхэд чиглэх хуучин тогтолцоо руу оруулах сул тал бий болгож байна. Үүнд хуульчийн шалгалтад бэлтгэх сургалтын төвүүд ч хамааралтай. Ялангуяа хуульчийн шалгалтад өндөр оноо авах үүднээс хэрэг, маргаан шийдвэрлэх процессыг зохиомлоор цээжлэх болсон нь төрөлжсөн тогтолцооны шинэчлэлийн эрх зүйн боловсрол олгоход чиглэсэн үндсэн зорилгыг алдагдуулж, өрсөлдөх чадваргүй хуульчид бэлтгэгдэх¹²⁹ эрсдэл дагуулж байна.

Түүнээс гадна 2019 байдлаар ХМС-д элсэгчдийн 49 хувь нь “SKY”¹³⁰ их сургуулиудын төгсөгчид буюу хамгийн нэр хүндтэй их сургуулиудад суралцагсад давамгайлсан¹³¹ байна. Үүнтэй уялдаатайгаар том компаниуд “SKY” их сургуулийн төгсөгчдийг ажилд сонгож авах хандлага нэмэгджээ. Тухайлбал, 2016-2018 онд томоохонд тооцогддог хуулийн компаниудад ажилд орсон хуульчдын 77.3 хувь нь “SKY” их сургуулиудыг төгссөн, 80 хувь нь “SKY” их сургуулиудад эрх зүйн бакалаврын зэрэг хамгаалсан тухай тоо баримт ч байна.¹³²

Эрх зүйн бакалаврын зэрэг олгож байсан өмнөх тогтолцоонд хуульчийн шалгалтын механизмын сул талыг шийдвэрлэх замаар шинэчлэл

¹²⁷ Kim, Namhee. (2021), “Law School in South Korea: Past, Present, and Future”, *Waseda Bulletin of Comparative Law*, Vol39, p. 35-43,

¹²⁸ Lee, Jooteak (2017), “The Crisis and Future of Korean Legal Education: Compared with the American Legal Education System”, *Korea University Law Review* p. 41, p. 48-49.

¹²⁹ The SNU Law Research Institute and Seoul National University Asia-Pacific Law Institute (2018), “10 Years after the Adoption of Law School, Evaluation and Improvement”.

¹³⁰ Seoul National University, Korea University, Yonsei University.

¹³¹ The Law Journal (2019), “All 25 Law School Students Come from 49% SKY, 83% in Seoul”, сүүлд үзсэн огноо: 2021.09.12, <http://www.lec.co.kr>

¹³² Hankook ilbo (2018), “Prestigious Universities Dominate Big law Firms, Ranking of Law School Fixed”, сүүлд үзсэн огноо: 2021.09.11, <http://www.hankookilbo.com>

хийсэн боловч ХМС нь хуульчийн шалгалтад дахин бэлтгэх дамжааны сургалтын арга хэлбэрт шилжих¹³³ эрсдэл үүсэж, суралцагчдын дунд сөрөг хандлага бий болж байгаад салбарын эрдэмтэн судлаачид шүүмжлэлтэй хандаж байна. Нөгөөтэйгүүр дөрвөн жилийн эрх зүйн бакалаврын сургалтын тогтолцоог ХМС-ийн гурван жилийн сургалтаар сольсон нь явцуу утгаараа жилд дунджаар 10 сая воноор хуульчийн шалгалтад бэлтгэх сургалт болсон гэж дүгнэхээр байна. Учир нь ХМС нь мэргэшсэн хуульчдыг бэлтгэн гаргаж байгаа ч хуульч эрдэмтэн, судлаачдын тоо буурах хандлагатай байна. Тухайлбал, ХМС-ийн үйл ажиллагаа явагдахаас өмнө буюу 2008 онд солонгосын их, дээд сургуулиудад 70,597 эрх зүйч бэлтгэгдэж байсан бол 2020 оны байдлаар энэ тоо 23,098 болж огцом буурсан.¹³⁴

Шинэ тогтолцоонд шилжсэнээр ХМС-ийн эрх авч чадаагүй сургуулиуд, эрх зүйн тэнхимүүд хаагдаж, багш нарын сонгон шалгаруулалт тодорхой хэмжээгээр хумигдсан. Шүүгч, прокурор болон шүүгч, прокурор байсан өмгөөлөгчид ХМС-ийн эрдэмтэн багшийн байр суурийг эзлэх болж, багш нарын 20 хувийг практик туршлагатай албан хаагч гүйцэтгэж байсан бол энэ тоо 2019 оны 12 дугаар сарын байдлаар Сөүл орчмын ХМС-ийн багш нарын дунд 40 хувьд хүрчээ. Эрдэмтэн, судлаачдын тоо буурах болсон нэг шалтгаан нь энэ үзүүлэлт гэж үзэхээр байна.

БНСУ-ын өнөөгийн ХМС нь хуульчдыг бэлтгэх байгууллага хэдий ч эрдэмтэн, судлаачдыг бэлтгэн гаргадаг боловсролын байгууллагын хэв шинжээ алдах эрсдэл нэгэнт бий болсныг¹³⁵ салбарын судлаачид олонтаа тэмдэглэн шүүмжлэх болсон. Тиймээс америк маягийн ХМС-ийн тогтолцоонд эдийн засаг, соёлын болон сурган хүмүүжүүлэх чиглэлийн урт, богино хугацааны цогц хөтөлбөр нэвтрүүлэн ажиллах цаг үеийн шаардлага¹³⁶ үүсээд байна.

¹³³ “로스쿨 이후 법학의 위기”, 운동호, 2021.04.19, 1423호, 경향 신문 /Kyunghyang newspaper/, сүүлд үзсэн огноо: 2021.09.23, <http://weekly.khan.co.kr>

¹³⁴ “로스쿨 이후 법학의 위기”, 운동호, 2021.04.19, 1423호, 경향 신문 /Kyunghyang newspaper/, сүүлд үзсэн огноо: 2021.09.23, <http://weekly.khan.co.kr>

¹³⁵ “로스쿨 이후 법학의 위기”, 운동호, 2021.04.19, 1423호, 경향 신문 (Kyunghyang newspaper), сүүлд үзсэн огноо: 2021.09.23, <http://weekly.khan.co.kr>

¹³⁶ Kim, Rosa (2012), “The Americanization of Legal Education in South Korea: Challenges and Opportunities”, Brooklyn Journal of International Law, сүүлд үзсэн огноо: 2021.08.25, <https://brooklaw.edu/bjil>

Зургаа. ДҮГНЭЛТ, САНАЛ

БНСУ мэргэшсэн хуульч бэлтгэх тогтолцоондоо шинэчлэл хийснээс хойш 13 дахь жилдээ орж байна. Тус улсад мэргэшсэн хуульч бэлтгэх үйл явц нь одоогоор хүчин төгөлдөр үйлчилж буй Хуульчийн шалгалтын тухай хууль, Хуулийн мэргэшсэн сургуулийн бүтэц, зохион байгуулалт, удирдлагын тухай хууль, БНСУ-ын Ерөнхийлөгчийн “Хуулийн мэргэшсэн сургуулийн бүтэц, зохион байгуулалт, удирдлагын тухай хуулийн хэрэгжилтийг хангах тухай” 20302 болон “Хуульчийн шалгалтын тухай хуулийн хэрэгжилтийг хангах тухай” 21706 тоот зарлиг, Хууль зүйн сайдын “Хуульчийн шалгалтын тухай хуулийг дагаж мөрдөх” журам болон бусад холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд хөгжлийн шатандаа явж байна. Мэргэшсэн хуульч бэлтгэх тогтолцооны шинэчлэлээс өмнө тулгамдаж байсан нийгэм, улс төр, эдийн засгийн сул талыг¹³⁷ арилгах бодлого тууштай баримтлан, шинэ үеийн мэргэшсэн хуульчдыг солонгоруулан хөгжүүлэх, хууль зүйн туслалцааны чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлд ихээхэн анхаарал хандуулан ажиллаж байгаа нь сайн туршлага гэж болохоор байна. Судалгааны үр дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийлээ. Үүнд:

1. БНСУ-ын Засгийн газраас америк маягийн шинэ тогтолцоогоор мэргэшсэн хуульчдыг бэлтгэх, шинэ үеийг төрүүлэх, сургалтын өөр загвар нэвтрүүлэх зорилт дэвшүүлэн ажиллаж байна.
2. Эрх зүйн боловсролын тогтолцоонд хийсэн энэхүү томоохон шинэчлэлийн зорилго нь мэргэшсэн хуульчийн нийгмийн хэрэгцээг хангах, хуульчийн ёс зүйг чангатгах, мэргэшсэн хуульчдыг нэмэгдүүлэх, эрх зүйн боловсролын тогтолцоог чанартай, үр дүнтэй, сургалт-дадлага хослуулсан үйл ажиллагаагаар хангах зэрэгт чиглэгдэж байна.

¹³⁷ Өмнө их сургуулиудаас санал болгож байсан бакалаврын эрх зүйн боловсролын хөтөлбөрөөр төгсөгчдийн дийлэнх олонх нь тухайн салбарын дадлага туршлагагүй, мэдлэгээ ажлын талбарт шууд ашиглах ур чадваргүй төгсөж байсан гэх мэт.

3. БНСУ-д мөрдөж байсан хуучин тогтолцоогоор дөрвөн жилийн бакалаврын сургалтын дараагаар хоёр жилийн мэргэшүүлэх сургалтад хамрагдан мэргэшсэн хуульч бэлтгэдэг байсан бол 2007 оны 7 дугаар сард Хуулийн мэргэшсэн сургуулийн бүтэц, зохион байгуулалт, удирдлагын тухай хууль батлагдсанаар Хуулийн мэргэшсэн сургуульд гурван жилийн хугацаанд магистрын зэрэг хамгаалсны дараа хуульчийн шалгалт өгөх эрх үүсэх зохицуулалттай болон өөрчлөгдсөн байна.
4. Хуулийн мэргэшсэн сургуулиуд дөрвөн жилийн бакалаврын хөтөлбөр төгссөн оюутнуудыг элсүүлэх ба хөтөлбөрт хамрагдсан оюутнуудын олон талт байдлыг хангах үүднээс шинээр элсэгчдийн гуравны нэгээс доошгүй хувийг хуулийн бус өөр төрлийн мэргэжлээр элсүүлэх шаардлагатай болжээ¹³⁸.
5. Хуулийн мэргэшсэн сургуульд элсэхэд англи хэлний мэдлэгийг онцлох болсон нь дэлхийн хөгжил дэвшилд нийцэн ажиллах чадвартай мэргэшсэн хуульчдыг бэлтгэх зорилтод тулгуурлаж байна.
6. Энэхүү шинэчлэл нь хуульчийн ёс зүйтэй холбоотой асуудал, ялангуяа мэргэжлийн үүрэг хариуцлагаа ухамсарлах асуудал дээр онцгой анхаарал хандуулж байх бөгөөд мэргэшсэн хуульчдыг сургаж дадлагажуулахын зэрэгцээ тэдний нийгэмд эзлэх байр суурь, үүргээ ухамсарлах, дасан зохицох чадварыг нь хөгжүүлэхэд чиглэгдэж байна.
7. Сургалтын шинэлэг арга барил, заах арга зүйг нэвтрүүлэн эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийх чадварыг АНУ-ын хуулийн мэргэшсэн сургуулиудын жишгээр эзэмшүүлж байна.
8. Мэргэшсэн хуульчийг бэлтгэх шинэ тогтолцоонд ололт, амжилт, давуу тал олон байгаа хэдий ч алдаа дутагдалтай, эрсдэл үүсгэж болзошгүй хүндрэлтэй сул тал цөөнгүй байна.

¹³⁸ Мэргэшсэн хуульчийг бакалаврын зэргээс эхлэн бэлтгэх нь үр дүн муутай, ялангуяа практикт ажиллахад эрх зүйн боловсролоос өөр салбарын мэдлэггүй төгсөгчид олноор гарч байсан тул төрөл бүрийн салбарын иргэдээс эрх зүйн магистрын зэргийн сургалтад хамруулах замаар мэргэшсэн хуульчийг бэлтгэх тогтолцоонд шинэчлэл хийж мэргэшсэн хуульчдыг бэлтгэн зах зээлийн эргэлтэд оруулж байна.

Монгол Улсад мэргэшсэн хуульч бэлтгэх тогтолцоонд гадаад орны туршлагыг нэвтрүүлэхдээ өөрийн орны онцлог, нийгмийн эрэлт хэрэгцээ, хүлээлт, эдийн засгийн боломж нөхцөлийг харгалзан үзэх нь нэн чухал юм. Манай оронд мэргэшсэн хуульч бэлтгэх тогтолцоог шинэ шатанд гаргах нийгмийн хэрэгцээ шаардлага байна гэж судлаачийн зүгээс үзэж байна. Үүнд:

1. БНСУ-ын сайн туршлагаас суралцах, нэвтрүүлэхдээ өөрийн орны онцлог, нийгмийн шаардлага, эрэлт хэрэгцээнд тулгуурлах;
2. Хуульчийн шалгалтын тогтолцоонд БНСУ-ын сайн туршлагыг нэвтрүүлэх;
3. Мэргэшсэн хуульч бэлтгэх сургалтын тогтолцоонд өөрчлөлт хийх замаар хуульчдын мэдлэг чадвар, нийгэмд эзлэх байр суурь, үүргээ ухамсарлах, дасан зохицох чадварыг нь хөгжүүлэх;
4. Эрх зүйн бакалавраас бусад чиглэлээр бакалаврын зэрэг хамгаалсан иргэдэд хуульч болох боломж нөхцөлийг олгох эрх зүйн зохицуулалтыг эрэлхийлэх, боловсруулах, нэвтрүүлэх замаар тухайн салбарын чиглэлээр мэргэшсэн хуульчийг бэлтгэн гаргах;
5. Эрх зүйн боловсрол олгож байгаа их, дээд сургуулийн сургалтын заах болон эрдэм шинжилгээ, судалгааны арга зүйг шинэ шатанд гаргах, гадаад орны эрх зүйн боловсролын сургалтын сайн туршлагыг нэвтрүүлэх;
6. Англи хэлний сургалтыг эрчимжүүлэх, англи хэлээр мэргэжлийн хичээл явуулах боломж нөхцөлийг судлах, бүрдүүлэх зэрэг болно.

ЭХ СУРВАЛЖ

A. Хууль тогтоомж

1. 법학전문대학원 설치, 운영에 관한 법률, 2007, 한국법률정보센터 (Korean Law Information Center), сүүлд үзсэн огноо: 2021.09.20, <https://www.law.go.kr>
2. 법학전문대학원 설치·운영에 관한 법률 시행령, 2007, 한국법률정보센터 (Korean Law Information Center), сүүлд үзсэн огноо: 2021.09.20, <https://www.law.go.kr>
3. 변호사시험법, 2009, 한국법률정보센터 (Korean Law Information Center), сүүлд үзсэн огноо: 2021.09.24, <https://www.law.go.kr>
4. 변호사시험법시행령, 2009, 한국법률정보센터 (Korean Law Information Center), сүүлд үзсэн огноо: 2021.09.20, <https://www.law.go.kr>
5. 변호사시험법 시행규칙, 2010, 한국법률정보센터 (Korean Law Information Center), сүүлд үзсэн огноо: 2021.09.20, <https://www.law.go.kr>

B. Солонгос хэлээр:

1. 고려대학교 법학전문대학원 (Korea University School of Law), сүүлд үзсэн огноо: 2021.09.10, <https://kulawschool.korea.ac.kr>
2. 대한민국의 법학전문대학원, сүүлд үзсэн огноо: 2021.09.15, <https://ko.wikipedia.org>
3. “로스쿨 이후 법학의 위기”, 윤동호, 2021.04.19, 1423호, 경향 신문 (Kyunghyang newspaper), сүүлд үзсэн огноо: 2021.09.23, <http://weekly.khan.co.kr>
4. 메가 로스쿨 (Mega Lawyers), сүүлд үзсэн огноо: 2021.09.10, <http://www.megals.co.kr>
5. “법학전문대학원 설치·운영에 관한 법률 시행령(안) 입법예고”, 2007.08.21, 뉴질랜드 유학원 (New Zealand Educational Consultancy Centre), сүүлд үзсэн огноо: 2021.09.15, <http://www.nzecc.com>
6. 법무부 (Ministry of Justice), сүүлд үзсэн огноо: 2021.09.23, <https://www.moj.go.kr>
7. 법제처 (Ministry of Government Legislation), сүүлд үзсэн огноо: 2021.09.22, <https://www.moleg.go.kr/lawinfo>
8. “변호사시험법 제정안 국회통과... 수정안은 부결” 임순현, 2009.05.04, 법률 저널 (The Law Journal), сүүлд үзсэн огноо: 2021.09.23, <http://www.lec.co.kr>

9. 베리타스알파 교육 전문 저널 (Veritas Alfa, Educational Journal), сүүлд үзсэн огноо: 2021.09.10, <https://www.veritas-a.com/news/article>
10. 한국대학 평가원 (Korean University Accreditation Institute), сүүлд үзсэн огноо: 2021.09.10, <https://aims.kcue.or.kr>
11. 한국법률정보센터 (Korean Law Information Center), сүүлд үзсэн огноо: 2021.09.24, <https://www.law.go.kr>
12. “2021년 제10회 변호사시험 합격자 결정”, 이상연, 2021.04.21, 법률저널 (The Law Journal), сүүлд үзсэн огноо: 2021.09.23, <http://www.lec.co.kr>
13. “2020 로스쿨 입시결과 분석”, 이성진, 2020.09.08, 법률저널 (The Law Journal), сүүлд үзсэн огноо: 2021.09.24, <http://www.lec.co.kr>

В. Англи хэлээр

1. Beophak Jeonmun (2008), Daehakwon Seolchi Unyeong-E Gwanhan Beo-Pruyl (Graduate Law School Act), Act No. 8544, July 27 2007, Amended By Act No. 8852, (S. Kor.).
2. Dae-Kyu Yoon, (2010). “Law and Democracy in South Korea: Democratic Development Since” 1987, p. 134.
3. Dai-Kwon Choi (2005)8 “A Legal Profession in Transformation: The Korean Experience, in Reorganization and Resistance: Legal Professions Confront a Changing World”, p. 171, p. 193–194 (William L.F.Felstiner Ed).
4. Hankook ilbo (2018), “Prestigious Universities Dominate Big law Firms, Ranking of Law School Fixed”, сүүлд үзсэн огноо: 2021.09.11, <http://www.hankookilbo.com>
5. Kyong-Whan Ahn (2006), “Law Reform in Korea and the Agenda of “Graduate Law School” 24 WIS. INT’L L.J., p. 223-227.
6. Jasper Kim (2009), “Socrates V. Confucius: An Analysis of South Korea’s Implementation of The American Law School Model”, 10 Asian-Pac.L.& Pol’y J., p. 322-327.
7. Kim, Namhee (2021), “Law School in South Korea: Past, Present, and Future”, Waseda Bulletin of Comparative Law, Vol39, p. 35-43.
8. Lee, Jooteak (2017), “The Crisis and Future of Korean Legal Education: Compared with the American Legal Education System”, Korea University Law Review 41, p. 48-49.
9. Matthew J. Wilson (2010), “U.S. Legal Education Methods and Ideals: Application to the Japanese and Korean Systems”, 18 Cardozo J.Int’l & Comp.L., p. 295, p. 335.
10. Nathan Schwartzman (2008), “Female Lawyers Increasing in Korea”, ASIAN CORRESPONDENT.

11. Rosa Kim (2012), “The Amercanization of legal Education in South Korea: Challenges and Opportunity”, *Brooklyn Journal of International Law*, Volume 38-I, pp. 49-75.
12. Setsuo Miyazawa et al. (2008), “The Reform of Legal Education in East Asia”, 4 *Ann.Rev.L.&SOC.SCI.* p. 39-89.
13. The SNU Law Research Institute and Seoul National University Asia-Pacific Law Institute (2018), “10 Years after the Adoption of Law School, Evaluation and Improvement”.
14. The Law Journal (2019), “All 25 Law School Students Come from 49% SKY, 83% in Seoul”, сүүлд үзсэн огноо: 2021.09.12, <http://www.lec.co.kr>
15. Tom Ginsburg (2004), “Transforming Legal Education in Japan and Korea”, 22 *Penn. St. Int’l L.Rev.* p. 433, p. 439.
16. Young-Cheol K. Jeong (2010), “Korean Legal Education for the Age of Professionalism”, 5 *E. Asia L.Rev.*, p. 155-157.

ХАВСРАЛТ. МЭРГЭШСЭН ХУУЛЬЧ БЭЛТГЭХ БНСУ-ЫН ТОГТОЛЦООТОЙ ХОЛБОГДОХ ХУУЛЬ, ДҮРЭМ, ЖУРМЫН ЭШЛЭЛИЙН ТАЙЛБАР

69-р зүүлтийн тайлбар

“Хуулийн мэргэшсэн сургуулийн бүтэц, зохион байгуулалт, удирдлагын тухай хуулийн хэрэгжилтийг хангах тухай” 20302 тоот зарлиг, 2009, 16.1. Боловсролын сайд хуулийн 24 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу дараах байгууллагуудын дундаас ур чадварын шалгалт зохион байгуулах байгууллагыг томилно. Үүнд: хуулийн мэргэшсэн сургуулийн үйл ажиллагаа эрхэлдэг боловсролын байгууллага бүтцэд нь ордог Иргэний хуулийн 32 дугаар зүйл, Нийтийн ашиг сонирхлын төлөөх хуулийн этгээд байгуулах, удирдах тухай хуулийн дөрөвдүгээр зүйлд заасны дагуу байгуулагдсан хуулийн этгээд, Дээд боловсролын тухай хуулийн хоёрдугаар зүйлд заасан их сургуулиуд, Засгийн газрын санхүүжилтгүй эрдэм шинжилгээний байгууллага байгуулах, удирдах, хөгжүүлэх тухай хуулийн наймдугаар зүйлд заасны дагуу байгуулагдсан Засгийн газрын санхүүжилтгүй судалгааны байгууллага, Хуульчийн ур чадварын шалгалт зохион байгуулах зорилгоор Иргэний хуулийн 32 дугаар зүйл, Нийтийн ашиг сонирхлын төлөөх хуулийн этгээд байгуулах, удирдах тухай тухай хуулийн дөрөвдүгээр зүйлд заасны дагуу байгуулагдсан хуулийн этгээд 16.2 Боловсролын сайд хуулийн 24 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу хуульчийн ур чадварын шалгалт зохион байгуулах гадны байгууллагыг томилохдоо тухайн байгууллагын хүний нөөцийн боломж, хүрэлцээ, хуульчийн ур чадварын шалгалт авах төлөвлөгөөг бичгээр гаргуулж болно. 16.3 Хуулийн 24 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу хуульчийн ур чадварын шалгалт зохион байгуулахаар томилогдсон байгууллага (цаашид “томилогдсон байгууллага” гэх) жилд нэг буюу түүнээс дээш удаа хуульчийн ур чадварын шалгалт зохион байгуулж, шалгалт авах төлөвлөгөөг зарлах ёстой. 16.4. Томилогдсон байгууллага шалгалт зохион байгуулах тохиолдолд шалгалтын хураамжийг цахим сүлжээ ашиглан төлбөр хийх, цахим мөнгө ашиглах хэлбэрээр төлж болно.

94-р зүүлтийн тайлбар

“Хуульчийн шалгалтын тухай хуулийн хэрэгжилтийг хангах тухай” 21706 тоот зарлиг 2009, 2.1. Хууль зүйн сайд Хуульчийн шалгалтын тухай хуулийн дөрөвдүгээр зүйлийн дагуу хуульчийн шалгалтыг зохион байгуулах бөгөөд шалгалтын тов, байршил, шалгалт авах арга, сэдэв, шалгуулагчид тавигдах шаардлага, бүртгүүлэх дэс дараалал, шалгалтад тэнцэгсдийг зарлах огноо зэргийг гурван сарын өмнө албан ёсны хэвлэл, цахим хуудас болон өдөр тутмын сонингоор дамжуулан зарлана.

2.2. Хууль зүйн сайд нэг дэх хэсэгт заасны дагуу олон нийтэд зарласны дараа уг хуулийн наймдугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу шалгалт зохион байгуулах бол шалгалтын тов, байршил, бэлтгэл ажлын талаар 10 хоногийн өмнө албан ёсны хэвлэл, цахим хуудас болон өдөр тутмын сонингоор дамжуулж зарлана. Зарлалд дурдсан мэдээллийг зайлшгүй шаардлагын улмаас өөрчилсөн бол шалгалт зохион байгуулахаас тав хоногийн өмнө албан ёсны хэвлэл, цахим хуудас болон өдөр тутмын сонингоор дамжуулж зарлана.

2.3. Хууль зүйн сайд нь хуулийн наймдугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу хуульчийн ёс зүйн шалгалт зохион байгуулах гадны байгууллагыг томилсон тохиолдолд тус байгууллага нь шалгалт зохион байгуулагдахаас жилийн өмнө 12 дугаар сарын 31-ний дотор энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан хэлбэрээр хуульчийн ёс зүйн шалгалт авах төлөвлөгөөг зарлана.

98-р зүүлтийн тайлбар

3.2. Хуулийн тавдугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу шалгалт өгөх эрхээ баталгаажуулахын тулд тухайн сургуулийн захирлаас магистрынн зэрэг хамгаалсан эсвэл хамгаалахаар төлөвлөж буй тухай баримт бичиг авсан байна. Хуульчийн ёс зүйн шалгалт өгөх шалгуурыг хангахын тулд хуульчийн ёс зүйн хичээлийн багц цагийг судалсан тухай дүнгийн хавсралт авсан байна. 3.3. Шалгалтад хамрагдах хүсэлтэй иргэд шалгалтын бүртгэлийн хугацаанд энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу шалгалт өгөх эрхээ баталгаажуулах баримт бичгийн нэг хувийг Хууль зүйн сайдад ирүүлэх ёстой. Хууль зүйн сайд хуулийн наймдугаар

зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу хуульчийн ёс зүйн шалгалт зохион байгуулах гадны байгууллагыг томилсон бол хуульчийн ёс зүйн шалгалт өгөх эрхээ баталгаажуулсан баримт бичгийг тухайн байгууллагаас тогтоосон журмын дагуу ирүүлэх ёстой. 3.4. Энэ зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасны дагуу шалгалт өгөх эрхээ баталгаажуулсан баримт бичгийг ирүүлэхдээ магистрын зэрэг хамгаалсан болон хамгаалахаар төлөвлөж буй оюутнуудын нэрийн жагсаалт, хуульчийн ёс зүйн хичээлийн кредит цагийг судалсан оюутнуудын нэрийн жагсаалт хэлбэрээр хүргүүлж болно.

102-р зүүлтийн тайлбар

Хууль зүйн сайд хуулийн наймдугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу хуульчийн ёс зүйн шалгалт зохион байгуулах байгууллагыг томилоход дараах зүйлийн аль нэгэнд хамаарах байгууллагууд дундаас хуульчийн ёс зүйн шалгалт зохион байгуулахад шаардагдах бүтэц, хүний нөөц бүхий байгууллагыг томилно. Үүнд:

1. Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 78 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу байгуулагдсан Солонгосын хуульчдын холбоо;
2. Засгийн газрын санхүүжилттэй эрдэм шинжилгээний байгууллага байгуулах, удирдах, хөгжүүлэх тухай хуулийн наймдугаар зүйлийн 8 дахь хэсэгт заасны дагуу байгуулагдсан Засгийн газрын санхүүжилттэй судалгааны байгууллага;
3. Хуулийн мэргэшсэн сургууль болон хуулийн мэргэшсэн сургуулийн үйл ажиллагаа эрхэлдэг боловсролын байгууллагын захирал гишүүнээр нь байдаг Иргэний хуулийн 32 дугаар зүйл, Нийтийн ашиг сонирхлын тухай хуулийн этгээд байгуулах, удирдах тухай хуулийн дөрөвдүгээр зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу байгуулагдсан хуулийн этгээд;
4. Хуульчийн ёс зүйн шалгалт зохион байгуулах зорилгоор Иргэний хуулийн 32 дугаар зүйл, Нийтийн ашиг сонирхлын тухай хуулийн этгээд байгуулах, удирдах тухай тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу байгуулагдсан хуулийн этгээд.

4.2. Хууль зүйн сайд хуулийн наймдугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу хуульчийн ёс зүйн шалгалт зохион байгуулах гадны байгууллагыг томилохдоо тухайн байгууллагын хүний нөөцийн боломж, хүрэлцээ хуульчийн ёс зүйн шалгалт авах төлөвлөгөөг бичгээр гаргуулж болно.

4.3. Хууль зүйн сайд хуулийн 8 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу хуульчийн ёс зүйн шалгалт зохион байгуулах байгууллагыг томилохдоо энэ тухай нийтэд мэдээлнэ.

5.1. Хуулийн 8 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу хуульчийн ёс зүйн шалгалт зохион байгуулахаар томилогдсон байгууллага (цаашид “томилогдсон байгууллага” гэх) жилд нэг буюу түүнээс дээш удаа хуульчийн ёс зүйн шалгалтыг зохион байгуулна.

5.2. Хуульчийн ёс зүйн шалгалт өгөх иргэн Хууль зүйн сайдын тогтоосон шалгалтын хураамжийг шалгалт зохион байгуулагчид тогтоосон журмын дагуу төлнө.

6.1. Хуульчийн ёс зүйн шалгалт зохион байгуулахаар томилогдсон байгууллага дараах зүйлүүдийн аль нэгэнд хамаарах тохиолдолд Хууль зүйн сайд хуульчийн ёс зүйн шалгалт зохион байгуулах эрхийг цуцалж болно. Харин дараах шалтгааны улмаас эрхийг шууд цуцална. Үүнд: Залилан мэхлэх болон бусад хууль бус аргаар томилогдсон байгууллага, Хуульчийн ёс зүйн шалгалт хэрэгжүүлэх үүргээчийн ёс зүйн шалгалт зохион байгуулахаар томилогдсон байгууллага дараах зүйлүүдийн аль нлэхэд шаардлагатай зохион байгуулалт, хүний нөөцөөр хангаагүй тохиолдолд.

6.2. Хууль зүйн сайд (1) дэх хэсэгт заасан шалгалт зохион байгуулах эрхийг хүчингүй болгох үндэслэл байгаа эсэхийг шалгахын тулд шаардлагатай тохиолдолд тухайн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой асуудлаар тайлан, мэдээлэл гаргуулах, шаардлагатай санхүүгийн тайлан, бичиг баримт зэргийг холбогдох эрх бүхий албан тушаалтнаар шалгуулж болно.

6.3. Хууль зүйн сайд (1) дэх хэсэгт заасны дагуу шалгалт зохион байгуулах эрхийг хүчингүйд тооцсон бол энэ тухай нэн даруй олон нийтэд мэдээлнэ.

6.4. (1) дэх хэсэгт заасны дагуу шалгалт зохион байгуулах эрхийг хүчингүйд тооцсон бол тухайн байгууллага өөрт хадгалагдаж буй хуульчийн ёс зүйн шалгалттай холбоотой бүх баримт бичгийг эрх цуцлагдсан өдрөөс хойш нэг сарын дотор Хууль зүйн сайд эсвэл Хууль зүйн сайдын томилсон байгууллагад шилжүүлсэн байх ёстой.

106-р зүүлтийн тайлбар

4.1. Эрх бүхий байгууллага нийтийн ашиг сонирхлын төлөөх хуулийн этгээд байгуулах зөвшөөрөл хүссэн өргөдөл хүлээн авсан тохиолдолд холбогдох баримтуудыг шалгаж, сангийн хувьд хөрөнгийн орлого, холбооны хувьд гишүүнчлэлийн хураамж, хандиваас бүрдсэн санхүүгийн эх үүсвэр нь үйл ажиллагаа явуулахад боломжтой гэж үзвэл зөвшөөрөл олгоно.

4.2. Нийтийн эрх ашгийн төлөөх хуулийн этгээд байгуулах зөвшөөрөл олгохдоо эрх бүхий байгууллага нь Ерөнхийлөгчийн зарлигаар тогтоосон гишүүнчлэлийн хураамж, ашиг хүртэгчид болон бусад шаардлагатай нөхцөлийг хавсаргаж болно.

107-р зүүлтийн тайлбар

Хуульчийн шалгалтын тухай хуулийг дагаж мөрдөх журам:

7.1. Ерөнхийлөгчийн зарлигийн 4 дүгээр хавсралтын 2-р заалтын дагуу бичгээр өгсөн шалгалтын нийтийн эрх зүй, иргэний эрх зүй, эрүүгийн эрх зүйн шалгалтын тэнцэх доод оноо нийт онооны 40 хувь байна. Энэ нь сэдэв тус бүрийн сонгох бичгийн шалгалтын оноон дээр шалгалтын комиссоос өгсөн оноотой дүйцүүлж эссэ бичгийн шалгалтаар авсан оноог нэмсэн оноо эсвэл Ерөнхийлөгчийн зарлигийн 5 дугаар зүйлд заасан аргачлалаар сонгох бичгийн шалгалтын оноон дээр эссэ бичгийн шалгалтын оноог нэмж тооцоолсон онооны аль нэг нь шалгалтын сэдэв тус бүрийн нийт онооны 40 хувь байхыг хэлнэ.

7.2. Хавсралтын 4.2 дахь хэсгийн дагуу бичгээр өгсөн шалгалтын тэнцэх хамгийн бага онооны дунд мэргэжлийн салбарын эрх зүйн холбоотой

сэдвийн бичгийн шалгалтын хамгийн бага оноо нь нийт бичгийн шалгалтын онооны 40 хувь байна. Энэ нь 6-р зүйлийн аргачлалаар тооцоолсон бичгийн шалгалтын оноо эсвэл бичгийн шалгалтын сэдэв тус бүрээр авсан онооны аль нэг нь нийт онооны 40 хувь ба түүнээс дээш байна гэсэн үг юм.

113-р зүүлтийн тайлбар

Шалгалтыг шударгаар зохион байгуулахын тулд Ерөнхийлөгчийн зарлигаар тогтоосон “Шалгуулагчийн дагаж мөрдөх журам”-д заасан хугацаанд шалгалт авах танхимд суудлаа эзэлсэн байх, шалгалт үргэлжлэх хугацаанд зохион байгуулагчийн зааврыг дагаж мөрдөх ёстой бөгөөд зөвшөөрөлгүйгээр шалгалтын танхимаас гарахгүй байх, хариултыг зориулалтын бичгийн хэрэгсэл ашиглан бичих, хариултын хуудсан дээр өөр мэдээлэл бичихгүй байх, шалгалт эхлэхээс өмнө шалгалтын асуултуудыг нээхгүй байх, шалгалт эхлэхээс өмнө эсвэл шалгалт дууссаны дараа хариулт бичихгүй байх, шалгалтыг шударгаар явуулахтай холбоотой журмыг биелүүлэх байх зэргийг тусгасан.

ХОЛБООНЫ БҮГД НАЙРАМДАХ ГЕРМАН УЛСЫН ХУУЛЬЧ БЭЛТГЭХ ТОГТОЛЦОО

Д.СҮНЖИД (Dr.jur)

Улаанбаатар хот
2021 он

ГАРЧИГ

НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР	126
ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ	127
Нэг. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ	128
Хоёр. ЕВРОПЫН ХОЛБООНЫ УЛСУУД ДАХЬ БОЛОНЪЯГИЙН ТОГТОЛЦОО	130
2.1. Болонъягийн тогтолцоог ХБНГУ-д хэрэгжүүлэх асуудал	131
2.2. Хагены загвар	132
2.3. Манхаймын загвар	133
Гурав. ХБНГУ-ЫН БОЛОВСРОЛЫН ТОГТОЛЦОО	134
3.1. Дунд сургуулийн тогтолцоо	134
3.2. Их сургууль ба Мэргэжлийн дээд сургуулийн ялгаа	135
Дөрөв. ИХ СУРГУУЛИЙН ХУУЛИЙН АНГИД ЭЛСЭХ ШАЛГУУР	137
Тав. ХУУЛЬЧ БОЛОХ ҮЕ ШАТ (<i>эрх зүйч мэргэжлээр бакалаврын боловсрол эзэмших</i>)	138
5.1. Хуульч болох үе шат	138
5.2. Өөр мэргэжилтэй зэрэгцүүлэн эрх зүйн боловсрол олгох	139
Зургаа. ХИЧЭЭЛИЙН ХӨТӨЛБӨР, КРЕДИТ ЦАГ	141
6.1. Суурь хичээлийн хөтөлбөр	141
6.2. Гүнзгийрүүлэн мэргэшүүлэх хөтөлбөр	143

Долоо. ТӨГСӨЛТИЙН ШАЛГАЛТЫН БҮТЭЦ, АГУУЛГА, ҮНЭЛГЭЭ	145
7.1. Явцын шалгалт	145
7.2. Төгсөлтийн шалгалт буюу хуульчийн улсын нэгдүгээр шалгалт	145
7.3. Зэрэг, цол	147
7.4. Мэргэжлийн дадлага	147
7.5. Хуульчийн улсын хоёрдугаар шалгалт	153
7.6. Шалгалт дүгнэх оноо	155
7.7. Улсын шалгалт хариуцсан нэгж	155
 Найм. МАГАДЛАН ИТГЭМЖЛЭХ СТАНДАРТЫГ БАТЛАХ СУБЪЕКТ, ҮЙЛ ЯВЦ, ХУУЛИЙН СУРГУУЛИЙГ МАГАДЛАН ИТГЭМЖЛЭХ ЯВЦ	156
8.1. Магадлан итгэмжлэл гүйцэтгэх агент	156
8.2. Хөтөлбөрийн магадлан итгэмжлэл	157
8.3. Чанарын магадлан итгэмжлэл	158
8.4. Их дээд сургуулийн багш нараас магадлан итгэмжлэх ажлын хэсэгт сонгон шалгаруулах удирдамж	159
8.5. Магадлан итгэмжлэх зөвлөл, түүний бүрэлдэхүүн	161
 АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ	164
 ХАВСРАЛТ	166

НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР

<i>Abitur</i>	Гимназиас гадна <i>Realschule, Hauptschule</i> төгсөгчид зохих түвшний шалгалт өгсний дүнд цааш үргэлжлүүлэн суралцаж, их дээд сургуульд элсэн орох шалгалт.
<i>Einheitsjurist</i>	Үгчилбэл нэгдмэл хуульч, утгачилбал нэгдсэн тогтолцоогоор бэлдсэн хуульч буюу ямар ч хуульчийн ажил хийх ур чадварыг бүрэн эзэмшсэн хуульч.
<i>Klausur</i>	Бичгийн шалгалт.
<i>Repetitorium</i>	Мэдлэгээ гүнзгийрүүлэх, давтах, шалгалтад бэлтгэх хичээлийн нэг хэлбэр бөгөөд 40-60 оролцогчтой зохион байгуулдаг. Их сургуулиас санал болгох үнэгүй сургалтаас гадна улсын шалгалтад бэлдэхдээ төлбөртэйгөөр ийм хэлбэрийн сургалт авах нь түгээмэл байдаг.
<i>Refendar</i>	Дадлагажигч. Хуульчийн улсын нэгдүгээр шалгалт өгөөд тэнцсэний дараа 1.5-2 жилийн хугацаанд хийх хуульчийн дадлагажигчийг хэлнэ. Ийнхүү дадлага хийсний дараа хуульчийн улсын хоёрдугаар шалгалт өгөх эрхтэй болно.
<i>Tutor</i>	Бодлого, тохиолдлыг задлан шинжлэх, дүгнэх, шийдэх байдлаар явагддаг хичээлийн давтлагын хэлбэр. Энэ хэлбэрийн хичээлийг профессор биш докторант, туслах профессор удирдан явуулах нь түгээмэл байдаг. Энэ сургалтын хэлбэр нь цөөн тооны оюутан бүлгээр хуваагдан хичээллэх бөгөөд эхний семестрүүдэд санал болгодог.
<i>Volljurist</i>	Үгчилбэл бүрэн хуульч, утгачилбал жинхэнэ хуульч. Герман Улсын хуульч бэлтгэх тогтолцоо хоёр шатлалтай бөгөөд хуульчийн улсын нэгдүгээр болон хоёрдугаар шалгалт өгч, тэнцсэн тохиолдолд жинхэнэ хуульч гэж нэрлэдэг.

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ХБНГУ	Холбооны Бүгд Найрамдах Герман Улс
UNESCO	НҮБ-ын боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллага
ИЭЗ	Иргэний эрх зүй
НЭЗ	Нийтийн эрх зүй
ЭЭЗ	Эрүүгийн эрх зүй
<i>Bachelor (LL.B.)</i>	Хууль зүйн бакалавр
<i>Master (LL.M.) Magister iuris (Mag. iur.)</i>	Хууль зүйн магистр
<i>Dipl.jur</i>	Дипломтой хуульч

Нэг. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

ХБНГУ-д (цаашид Герман гэх) хуучны Пруссийн засгийн газраас авч хэрэгжүүлж байсан нэгдмэл сургалтын тогтолцоо нь 1877 оноос эхлэн шүүгч, өмгөөлөгч, прокурор болон бусад бүх л хуулийн мэргэшлийн үндэс суурь болсоор иржээ. Энэхүү тогтолцоо нь улсын шалгалтаар төгсдөг их сургуулийн дөрвөн жилийн сургалтыг хоёр жил болгон богиносгосон, хуульч бэлтгэх дадлагын практик сургалтаас бүрддэг. Германд хуульч болохын тулд хоёр шатны шалгалт өгөх ёстой бөгөөд нэгдүгээр улсын шалгалтыг их сургууль төгсөхдөө өгнө. Нэгдүгээр улсын шалгалт нь заавал үзэх ёстой салбар гурван эрх зүй, их сургуульд сонгон суралцсан хичээл буюу гүнзгийрүүлэн судалсан салбар хичээлийн агуулгаас бүрдэнэ. 2002 онд хийсэн шинэтгэлийн хүрээнд сонгон суралцах хичээлээр авдаг байсан их сургуулийн шалгалтыг нэгдүгээр улсын шалгалтын нэг хэсэг болгож өөрчилсөн байна.

Ийнхүү их сургууль төгсөж нэгдүгээр улсын шалгалтад тэнцэн, хуульч бэлтгэх дадлагад амжилттай хамрагдсан бол хоёрдугаар улсын шалгалт өгөх эрхтэй болох бөгөөд түүнд тэнцсэнээр мэргэшсэн хуульч болно. Энэхүү тогтолцооны гол давуу тал нь оюутанд шинжлэх ухааны гүнзгий мэдлэг эрчимтэй олгож, эрх зүйн ээдрээтэй маргааныг шийдвэрлэхэд сургах ба хоёр шатны шалгалт нь суралцагчийн чадварыг үнэлэх оновчтой шалгуур хэмээн үздэг. Хуульч бэлтгэх сургалтыг 1970-1980 онд нэг үе шаттай болгох оролдлого хийсэн ч энэ нь төдийлөн амжилтад хүрээгүй байна. Харин сургалтыг орчин үеийн чиг хандлагад нийцүүлэх чиглэлээр хэд хэдэн шинэтгэл хийгджээ.

Германы хуульч бэлтгэх тогтолцоо нь шүүгчийн ур чадварыг суралцагчдад эзэмшүүлсэн байх ёстой хэмээх үзэл баримтлалд суурилдаг. Өөрөөр хэлбэл, шүүгчээр ажиллах ур чадвар эзэмшсэн хуульч бусад бүх төрлийн хуульчийн ажлыг хангалттай гүйцэтгэх ур чадвартай гэж үздэгтэй холбоотой. Үүнийг *Einheitsjurist* буюу хуульч бэлтгэх нэгдмэл тогтолцоо гэж нэрлэдэг. Ийм үзэл баримтлалд суурилдаг тул Холбооны Шүүгчийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн

зохицуулалт нь хуульч бэлтгэх эрх зүйн үндэслэл болдог байна.¹ Олон улсын эрх зүйн холбогдол бүхий хөтөлбөрөөр 2002 оноос их сургуулийн сургалтын агуулгыг баяжуулж, өмгөөлөл төвтэй хичээлүүдийг нэмж оруулжээ.

Герман Улсын 16 муж улсад хуульчийн шалгалтын тусдаа журам үйлчилдэг хэдий ч эдгээр журам, зохицуулалтын үндсэн агуулга адил, холбооны улс даяар нэгдмэл зарчим баримталдаг.

¹ 5 дугаар зүйл. Шүүгчийн албаны шалгуур. 1. Шүүгчийн алба хашихын тулд их сургуульд эрх зүйн боловсрол эзэмшсэн байх, үүний дараа дадлагын алба дүүргэж, улсын хоёр дахь шалгалт өгсөн байна. Эхний шалгалт нь тухайн их сургуулийн мэргэшүүлэх гүнзгийрүүлсэн салбар эрх зүйн шалгалт байх ба заавал өгөх улсын салбар эрх зүйн шалгалтаас бүрдэнэ. https://www.gesetze-im-internet.de/drig/_5.html

Хоёр. ЕВРОПЫН ХОЛБООНЫ УЛСУУД ДАХЬ БОЛОНЪЯГИЙН ТОГТОЛЦОО²

Европын Зөвлөл болон ЮНЕСКО хамтран 1997 онд Европын бүс нутагт дээд боловсролын гэрчилгээг хүлээн зөвшөөрөх тухай Лиссабоны конвенц боловсруулж, баталсан бөгөөд Германы парламент 2007 оны 5 дугаар сарын 16-ны өдөр тус конвенцыг соёрхон баталжээ. Үүний дараа 1999 оны 6 дугаар сарын 19-ний өдөр Европын Холбооны боловсролын асуудал эрхэлсэн сайд Болонъя хотноо их сургуулийн тогтолцоог шинэчлэх тухай нэгэн шинэ мэдэгдэл хийсэн байна. Тус мэдэгдэл нь улс төр, шинжлэх ухааны салбарт илүү нэгдмэл буюу оюуны болон соёлын, мөн нийгэм, эдийн засгийн хувьд ижил төстэй чиг хандлагад суурилсан Европыг байгуулах хүсэл тэмүүлээс үүдэлтэй юм.

Энэ хүрээнд 2010 он гэхэд Европ дахь их сургуулийн боловсролын зэргийг аль болох адил төстэй болгох, бакалаврын буюу магистрын сургалтын хөтөлбөрийг ижилсүүлэх, хөрвөх чадварыг нэмэгдүүлэх зорилго тавьжээ. Гурван жилийн хугацаатай 180-240 кредит цагийн бакалаврын сургалт төгссөнөөр Европын хөдөлмөрийн зах зээлд шаардагдах мэргэшлийн ур чадвар эзэмших бол гүнзгийрүүлэн суралцах үе шат нь 60-120 кредит цагийн магистр, гурваас дөрвөн жилийн хугацаатай докторын сургалт байна. Болоньягийн тогтолцоонд шилжсэнээр Европын улсуудын их сургууль хоорондын шилжилт хөдөлгөөн нээлттэй, боловсролын хөтөлбөр, тогтолцоо, чанар адил төстэй болох давуу тал үүсэхээс гадна их сургуулиудын хамтын ажиллагааг дэмжих давуу тал бий болно гэж үзжээ. 1999 онд 29 улс санаачлан нэгдэж байсан Болоньягийн мэдэгдэлд Европын холбооны гишүүн орнуудаас гадна бусад орон нэгдэж, 2020 оны байдлаар нийт 48 улс гарын үсэг зураад байна.

² Б.Тэмүүлэн, Б.Буянхишиг, “ХБНГУ-ын эрх зүйн боловсролын тогтолцоо Олон улсын хурлын илтгэлийн эмхэтгэл”, 2013, 77 дахь тал
http://buyana2013.blogspot.com/2013/08/blog-post_16.html#more үзсэн огноо 2021.08.15.

2.1. БОЛОНЪЯГИЙН ТОГТОЛЦООГ ХБНГУ-Д ХЭРЭГЖҮҮЛЭХ АСУУДАЛ

Германы эрх зүйн боловсрол олгодог их сургуулиудын 85 хувь Болонъягийн тогтолцоог хэрэгжүүлж эхлээд бакалавр, магистрын зэрэг олгох сургалтын тогтолцоонд шилжжээ. Харин эрх зүйн боловсрол олгох тогтолцооны хувьд одоогийн хүчин төгөлдөр үйлчилж буй хоёр шатлалтай сургалтыг өөрчлөх эсэх дээр түүнээс үүсэх давуу болон сул талыг дэнслэн үзсэний эцэст Германы бүх муж санал нэгтгэйгээр үндэсний сургалтын тогтолцоогоо хэвээр үлдээх шийдвэр гаргасан байна.

2005 онд болсон муж улсуудын Хууль зүйн сайд нарын чуулганы үеэр 2002 оны Эрх зүйн боловсролыг шинэчлэх тухай хуулиар Болонъягийн загварын давуу талыг Германы эрх зүйн боловсролд аль хэдийн нэвтрүүлсэн гэж дүгнэжээ. Өөрөөр хэлбэл, сайд нарын дээрх уулзалтаар дотоодын эрх зүйн тогтолцооны онцлог хэвээр хадгалагдаж буй өнөөгийн нөхцөлд 2002 оны үндэсний хуулийн хэрэгжилтэд үнэлэлт өгөлгүйгээр боловсролын тогтолцоог дахин шинэчлэх тухай хөндөж болохгүй хэмээх санал давамгайлж байв. Улмаар 2008 оны муж улсуудын Хууль зүйн сайд нарын ээлжит уулзалтаар Болонъягийн тогтолцоог эрх зүйн сургалтад шууд хүлээн авах боломжгүй гэж мэдэгджээ. Улс төрийн бодлогын хүрээнд ч энэ тогтолцоог эрх зүйн боловсролын тогтолцоонд нэвтрүүлэхээс татгалзсан байна. Эрх зүйн боловсрол нь өөрчлөгдөж буй нийгмийн шаардлагад нийцэх ёстой ч сургалтын хэлбэрийг эрс өөрчлөх нь чанарын үзүүлэлтэд сөргөөр нөлөөлнө гэж үзжээ.

Түүнчлэн 2011 оны муж улсуудын Хууль зүйн сайд нарын ээлжит чуулганд салбарын мэргэжилтнүүдээс эрх зүйн боловсрол олгох тогтолцоог бакалавр болон магистрын зэрэг олгох шатлалд шилжүүлэн өөрчлөх тухай олон хувилбарт санал бүхий тайланг танилцуулсан ажээ. Энэхүү чуулганаар хуульчийн мэргэжил эзэмшихэд хоёр шатлал бүхий тогтолцоо хэвээр үлдэх шаардлагатай, ингэснээр Герман Улсын хуульч бэлтгэх боловсролын тогтолцооны өндөр чанар ирээдүйд ч хадгалагдаж чадна гэж үзсэн байна. Түүнчлэн эрх зүйн боловсролын тогтолцоог өөрчлөхгүйгээр харин энэхүү сургалтад бакалавр, магистрын зэрэг олгох сургалтын зарим элементийг нэвтрүүлэх замаар одоо хэрэгжиж буй сургалтын тогтолцоонд дэмжлэг үзүүлэх боломжтой хэмээн хууль

зүйн сайд нар дүгнэсэн байна. Мөн нэгдүгээр улсын шалгалт өгөх хүртэл суралцагчдад ямар зэрэг, дэв олгохыг эрх зүйн сургалтын алба нь шийдэх боломжтой хэмээн дүгнэжээ.³ Тиймээс эрх зүйн бакалаврын зэргийг ихэвчлэн өөр мэргэжлийн сургалттай хослуулан олгох болжээ. Тухайлбал, эдийн засагч-эрх зүйч, гадаадын эрх зүйн гэх мэт хосолсон сургалт явуулж байна.

2.2. ХАГЕНИЙ ЗАГВАР

Хаген хотын эчнээ их сургууль Герман Улсын эрх зүйн боловсролын тогтолцоонд 2003 оны намрын семестрээс Болоньягийн загварт нийцсэн эхний их сургууль болсон юм. Эрх зүйн бакалавр (*Bachelor (LL.B.)*) долоон семестр, дагалдах гурван семестр суралцсанаар магистр (*Master (LL.M.)*) зэрэгтэй төгсөнө. Энэ сургалт нь сонгодог хуульч бэлтгэх зорилгогүй, тиймээс төгсөгчид нь ч сонгодог хуульчийн алба хаших боломжгүй.

Хуульчийн эхний улсын шалгалт авах боломжийг 2016 оны намрын семестрээс эхлэн энэ сургуульд нээсэн. Тус сургуулийн эрх зүйн бакалавр нь эдийн засгийн эрх зүйн чиглэлээр мэргэшиж төгсөх бөгөөд үүний хамт хуульчийн улсын нэгдүгээр шалгалтыг өгч хуульч хэмээх нэршил авах боломжтой. Гэсэн хэдий ч эдгээр төгсөгч улсын хоёрдугаар шалгалтад орох эрхгүй юм.

Хаген хотын зайны их сургуулийн хуульчийн давтан сургалтын сэдэв нь эвлэрүүлэн зуучлах, өмгөөлөгчийн ажилд бэлтгэх, өмгөөллийн, спортын, татварын эрүүгийн, патентын өмгөөлөгчийн эрх зүй болон европын аж ахуйн нэгжийн эрх зүйн хамгаалалт, европын патентын нэгдмэл шалгалтад бэлтгэх болон японы иргэний эрх зүй байдаг.

³ https://www.justiz.nrw.de/JM/jumiko/beschluesse/2011/fruehjahrskonferenz11/I_1.pdf

2.3. МАНХАЙМЫН ЗАГВАР

Манхайм (Mannheim) хотын их сургууль 2008 оны намрын семестрээс эхлэн эрх зүйн боловсролын тогтолцоогоо Болоньягийн загварт нийцүүлсэн бөгөөд тус сургуульд хууль зүйн бакалавр эзэмшсэн хүн Хуульчийн улсын нэгдүгээр шалгалтад орж тэнцвэл хуульч цол авах эрхтэй. Суралцагчид бакалаврын сургалтын хүрээнд иргэний эрх зүйг иж бүрэн судлахын зэрэгцээ микро эдийн засгийн мэдлэгийг сургалтын гуравны нэгтэй тэнцэхүйц хугацаанд эзэмшдэг. Улсын нэгдүгээр шалгалтад иргэний, нийтийн, эрүүгийн эрх зүйгээр бичгийн шалгалт өгдөг. Бакалаврын сургалтын дараа эдийн засгийн чиглэлээр магистр (*Master of Sc.*) хамгаалах боломжтой, мөн хамгийн сайн үнэлгээтэй төгсөгчдийн таван хувьд иргэний эрх зүйн чиглэлээр докторт суралцах боломж олддог байна.

Хаген болон Манхайм хотын их сургуулийн эрх зүйн боловсрол олгох сургалтын шинэчлэл Болоньягийн загварт нийцсэнээрээ онцлог хэдий ч Германы уламжлалт эрх зүйн боловсрол олгох тогтолцоо биш тул улсын нэгдүгээр шалгалт өгч хуульч цол авах боломжтой ч улсын хоёрдугаар шалгалт өгөх эрх хаалттай тул жинхэнэ хуульч болж, хуульчийн сонгодог ажил эрхлэх боломжгүй юм. Тийм ч учраас эдийн засгийн чиглэлээр хосолсон сургалтын агуулгаар төгсгөдөг байна.

Гурав. ХБНГУ-ЫН БОЛОВСРОЛЫН ТОГТОЛЦОО

3.1. ДУНД СУРГУУЛИЙН ТОГТОЛЦОО⁴

Германд хүүхэд зургаан нас хүрмэгц бага сургуульд (*Grundschule*) элсэж орох үүрэгтэй. Бага сургууль дөрвөн жил үргэлжлэх ба зөвхөн Берлин Бранденбургт зургаан жил суралцдаг. Бага сургууль төгсмөгц тухайн хүүхэд ерөнхий боловсролын дунд сургууль (*Hauptschule*), ерөнхий боловсролын бүрэн дунд сургууль (*Realschule*) болон гимнази буюу ахлах сургуулийн (*Gymnasium*) аль нэгэнд орж, үргэлжлүүлэн сурах шаардлагатай.

Аль сургуульд орох нь хүүхдийн бага сургуульд үзүүлсэн амжилт, сурлагын явцаас ихээхэн хамаарах ба цааш үргэлжлүүлэн сурах сургуулийн сонголтод бага сургуулийн багш нар давамгайлан оролцдог.

- 3-6 насны хүүхдүүд цэцэрлэгт элсэнэ.
- 1-4 дүгээр ангийг бага анги гэх бөгөөд 6-10 настай хүүхдүүдэд бүгдэд нь ижил боловсрол олгоно.

Үүнээс хойш хүүхдүүд өөрсдийн мэдлэг чадвар, гэр бүлийнх нь хүсэл сонирхол зэргээс шалтгаалан дараах гурван төрлийн сургалтын аль нэгээр үргэлжлүүлэн суралцдаг байна. Үүнд:

- *Hauptschule* (5-9 дүгээр ангийг ийнхүү нэрлэнэ);
- *Realschule* (5-10 дугаар ангийг ийнхүү нэрлэнэ);
- *Gymnasium* (5-12 дугаар ангийг ийнхүү нэрлэнэ).

Аль ч сургуулийг сонгосон багадаа есөн жилийн боловсрол эзэмшсэн байх ёстой. Ерөнхий боловсролын дунд сургуулийн (*Hauptschule*) сургалтын хөтөлбөр нь хүүхдүүдэд мэргэжлийн сонголт хийх, мэргэжлийн боловсрол олгоход түлхүү чиглэсэн байх бөгөөд онолын хажуугаар практик дадлагыг чухалчилдаг. Сургалт нь таван жил

⁴ www.aplus.mn

үргэлжилж есдүгээр анги төгсмөгц дунд боловсролын гэрчилгээ олгоно. Үүний дараа байгууллага, үйлдвэрт дадлага хийн мэргэжил эзэмших, цаашлаад техник мэргэжлийн сургуульд орох боломжтой. Муж бүр боловсролын асуудлаар тус тусдаа эрх зүйн зохицуулалттай тул ялгаатай байх тохиолдол бий. Тухайлбал, Нордрайн-Вэстфаленд энэхүү сургалтын хөтөлбөр тав биш зургаан жил үргэлжилдэг бол Берлинд *Hauptschule*, *Realschule* хоёрыг нэгтгэсэн ерөнхий боловсролын хосолмол бүрэн дунд сургууль буюу *Integrierte Sekundarschule* гэж байдаг.

Ерөнхий боловсролын бүрэн дунд сургуульд (*Realschule*) бага сургууль төгссөний дараа зургаан жил суралцана. *Hauptschule* буюу ерөнхий боловсролын дунд сургуулиас ялгаатай нь сурагчдын бие даан сурах чадварыг чухалчлах ба мэргэжлийн чиг баримжаа олгоход түлхүү анхаардаг. Төгсөгчид мэргэжлийн гимнази, мэргэжлийн ахлах сургууль зэрэгт элсэн орох боломжтой.

Гимнази буюу ахлах сургуульд (*Gymnasium*) нийт 8-9 жил суралцсаны дараа их, дээд сургуульд элсэн орох шалгуур болох төгсөлтийн шалгалт (*Abitur*) өгнө. Гимнази төгссөний дараа их, дээд сургууль, мэргэжлийн академи зэрэгт суралцаж дээд боловсрол эзэмших боломж бүрдэнэ. Гимназид суралцагчдыг өөрийн идэвх зүтгэлээр бие даан суралцах өндөр чадвартай байхыг шаардахын зэрэгцээ суралцагчдын энэ талын чадварыг хөгжүүлэхэд анхаардаг.

Гимназиас гадна *Realschule*, *Hauptschule* төгсөгчид нь зохих түвшний шалгалт өгсний дүнд цааш үргэлжлүүлэн суралцаж, мөн их дээд сургуульд элсэн орох шалгалт (*Abitur*) өгөх боломжтой.

3.2. ИХ СУРГУУЛЬ БА МЭРГЭЖЛИЙН ДЭЭД СУРГУУЛИЙН ЯЛГАА

Их сургууль (*Universitaet*) онолд илүү суурилдаг бол мэргэжлийн дээд сургууль (*Fachhochschule*) практик хэрэглээнд түлхүү анхаардаг. Их сургууль ба мэргэжлийн дээд сургууль сургалтын хөтөлбөрөөрөө ялгарна. Тухайлбал, заавал үзэх, сонгон үзэх хичээлийг муж улсын эсхүл сургуулийн дотоод дүрэм, журмын хүрээнд их сургууль нь сонгодог бол мэргэжлийн дээд сургууль хатуу тогтоосон сургалтын хуваариар хичээл

орох бөгөөд нэг анги 30 оюутантай байна. Их сургуулийн хувьд лекцэд 100, магадгүй үүнээс ч илүү олон тооны оюутан сууна.

Их сургуульд элсэгчдийн шалгуур өндөр байдаг бол мэргэжлийн дээд сургуулийнх харьцангуй дундаж байна. Мэргэжлийн дээд сургууль төгсөгч магистрт суралцахыг хүсвэл 30 кредит цаг нэмж үзэх шаардлагатай. Тиймээс хуульч бэлтгэх эрх зүйн сургалтыг их сургуулиуд санал болгох бөгөөд дээд сургуульд эрх зүйн боловсролыг тухайлан мэргэшсэн чиглэлээр л олгох ч ихэвчлэн эдийн засгийн эрхзүй гэх мэт тодорхой салбараар мэргэшиж, бакалавртай дүйцэх зэрэгтэй төгсдөг.

Дөрөв. ИХ СУРГУУЛИЙН ХУУЛИЙН АНГИД ЭЛСЭХ ШАЛГУУР

Хуулийн сургуульд элсэгчдийн тоог өмнө нь сургалтын албаны төв нэгжээс улс даяар тогтоон зохион байгуулж, хуваарилдаг байсан бол 2001 оноос их сургуулиуд нь энэ ажлыг хийх болсон. Тиймээс гимнази төгсөгч их сургуулиудаас сонголт хийж, элсэх хүсэлт гаргах эрхтэй бөгөөд тухайн сургууль баталсан шалгуурынхаа дагуу элсүүлэх эсэхээ шийдвэрлэдэг. Гимназийн төгсөлтийн онооны голч дүн сайн байх нь элсэлтийн үндсэн шалгуур болно. Тухайлбал, Мьюнхэн, Берлин, Хайделбэрг хотын их сургуульд хуулийн факультетын элсэгчдийн онооны дунджийг 1.7-2.3 байхаар тогтоосон байдаг. Зөвхөн голч оноо төдийгүй дадлага, сайн дурын ажилд оролцсон байдал, мөн элсэхээр хүлээлгийн жагсаалтад хүлээсэн байдал, суралцах семестр зэрэг нөхцөлийг харгалздаг.

Тэрчлэн хуулийн сургуульд элсэхээр хүсэлт гаргагчийн хувийн болон гэр бүлийн нөхцөл байдалд хүндрэлтэй асуудал байгаа эсэх нь түүнийг элсүүлэхэд харгалзах үндэслэл болдог (урт хугацааны эмчилгээтэй эсэх, хөгжлийн бэрхшээл, гэр бүлийн хойшлуулшгүй нөхцөл байдал, мэргэжил сонгох хязгаарлагдмал нөхцөл гэх мэт). Ихэнх их сургууль элсэгчдийн тоонд хязгаар тогтоодог. Зарим муж тухайлбал, Вюрцбург, Пассау, Грайфсвальд хотын их сургууль элсэгчдийн тоонд хязгаар тавьдаггүй.

Тав. ХУУЛЬЧ БОЛОХ ҮЕ ШАТ

(эрх зүйч мэргэжлээр бакалаврын боловсрол эзэмших)

5.1. ХУУЛЬЧ БОЛОХ ҮЕ ШАТ

Хуулийн сургуульд 4.5 жил суралцах бөгөөд энэ хугацаанд суурь болон үндсэн сургалтын хөтөлбөрийг эзэмшдэг. Эхний хоёр жилдээ суурь хичээлийн агуулга орж, дараагийн 2.5 жилд үндсэн сургалтыг гүнзгийрүүлэх, мөн сонгосон салбараар мэргэших хичээлийн агуулга орно. Энэхүү сургалтын үргэлжлэх хугацаа нь хувь суралцагчийн суралцах хурдаас шалтгаалах бөгөөд ялангуяа шалгалтад бэлтгэх хугацаа, шалгалтыг давтаж өгөх шаардлагатай болох эсэхээс шалтгаална. Ердийн суралцах хугацаа 8-9 семестр үргэлжилдэг ч 10-11 семестр суралцаж төгсөх нь цөөнгүй тохиолддог. Үүн дээр нэмээд шалгалт өгөх хүлээлгийн хугацаа нь нэг семестр байна.

Ихэнх сургалтын хэлбэр уламжлалт лекцийн арга байх бөгөөд багш нар нь профессор байна. Үүний зэрэгцээ эхний семестрүүдэд хууль хэрэглээний хичээл (*tutor*) ордог. Хэрэглээний энэ хичээлээр цөөн тооны оюутан бүлэгт хуваагдаж, тохиолдол, бодлого шийдвэрлэх техникийг эзэмшдэг. Ахисан семестрүүдэд семинарын оронд давтлагын хичээл орох бөгөөд энд мөн л салбар эрх зүйн тохиолдол шийдвэрлэх хууль хэрэглээг заана. Дасгал ажлын хичээлээр (*Uebung*) долоо хоног бүр нэг эрх зүйн тохиолдлыг ярилцах ба энэ нь явц дундын шалгалт өгөхөд шаардлагатай хууль хэрэглээний техникийг эзэмшүүлэхийн тулд цөөн тооны оюутанд давтлага өгдөг хичээлийн хэлбэр юм. Үүнээс гадна дасгал ажлын хичээлийн гэрчилгээ авахын тулд нэг бичгийн шалгалт амжилттай өгч, нэг бие даалтын үнэлгээгээр тэнцсэн байх ёстой.

Эрүүгийн, иргэний, нийтийн эрх зүйн ахисан шатны дасгал ажлын хичээлийн гэрчилгээ авсан байх нь улсын шалгалтад орох урьдчилсан шалгуур болдог. Семинарын хичээлээр тодорхой сэдвийн хүрээнд семинарын ажил бичиж, бусад оролцогчдод амаар илтгэл тавьж, танилцуулна. Семинарын хичээлд оролцох нь сайн дурын сонголт хэдий ч ихэнх их сургуульд суралцах хугацаандаа нэг семинарын хичээлд оролцохыг заавал суралцах хичээл буюу үүрэг болгосон байдаг.

Бүдүүвч 1. Бавари муж улсын Мьюнхэн хотын Людвиг-Максимилианы их сургуулийн хуулийн сургуулийн суралцах үе шат

Суурь үе шат	Үндсэн буюу дундын үе шат	Бататгах буюу давтах үе шат	Гүнзгийрүүлэх буюу мэргэшүүлэх үе шат
<ul style="list-style-type: none"> – ИЭЗ, НЭЗ, ЭЭЗ ерөнхий анги – Ромын эрх зүй, эрх зүйн түүх, эрх зүйн философи, эрх зүйн социологи 	<ul style="list-style-type: none"> – Ерөнхий ангийг гүнзгийрүүлж ахисан түвшинд судална. ИЭЗ, ЭЭЗ, НЭЗ-н ахисан түвшний хөтөлбөр 	<ul style="list-style-type: none"> – Шалгалтад бэлтгэх – Бичгийн шалгалт, давтлагад суух, дасгал ажиллах 	<ul style="list-style-type: none"> – Мэргэшүүлэх салбар сонгон судлах

Сургалтын суурь үе шатанд ИЭЗ, ЭЭЗ, НЭЗ-н хичээлээр тус бүр бичгийн шалгалт өгөх ба бие даалтын ажил гүйцэтгэнэ. Дундын буюу явцын шалгалт авах бөгөөд энэ нь үргэлжлүүлэн суралцаж чадах эсэхийг тогтоох, мөн сургалтын чанарыг шалгах зорилготой. ИЭЗ, НЭЗ, ЭЭЗ-н хүрээнд бичгээр шалгалт өгнө. ИЭЗ, НЭЗ-н явцын шалгалтыг хоёрдугаар семестрт, ЭЭЗ шалгалтыг гуравдугаар семестрт авдаг. Тэнцээгүй тохиолдолд дахин нэг удаа давтан өгөх эрхтэй. Үндсэн гурван салбар эрх зүйн бичгийн шалгалтад тэнцсэн байх нь мэргэшүүлэх гүнзгийрүүлсэн сургалтад хамрагдах урьдчилсан шалгуур болдог.⁵

5.2. ӨӨР МЭРГЭЖИЛТЭЙ ЗЭРЭГЦҮҮЛЭН ЭРХ ЗҮЙН БОЛОВСРОЛ ОЛГОХ

Эрх зүйн бакалаврын сургалтаар дан ганц эрх зүйн мэргэжил олгох төдийгүй ихэвчлэн өөр чиглэлийн тухайлбал, эдийн засгийн чиглэлийн сургалттай хослон явуулдаг. Хосолсон сургалтын гол зорилго нь эрх зүйн олон төрлийн мэдлэгийг суралцагчдад хүргэх бус эдийн засгийн харилцааны салбараар мэргэшсэн эдийн засгийн хуульч бэлтгэхэд чиглэдэг. Энэхүү сургалтыг төгсөгчдөд хуульчийн нарийн ур чадвар шаардсан ажил хийх эрх нээлттэй бус, мөн улсын шалгалтгүйгээр хуульчийн мэргэжлээр ажиллах эрхгүй. Аж ахуйн нэгж, компанид зөвлөхөөр, мэргэжилтнээр ажиллах боломж нээлттэй. Өөрөөр хэлбэл,

⁵ https://www.jura.uni-muenchen.de/info_erstsemester/studienablauf/index.html

компанийн мэргэжилтэн, зөвлөх зэрэг ажлыг хийх боломжтой, шүүгч, прокурор, өмгөөлөгч, нотариатаар ажиллах эрхгүй юм.

ХБНГУ-ын 2007 оны Эрх зүйн туслалцаа үзүүлэх тухай хуулиар эрх зүйн сургалтыг дүүргэсэн боловч улсын нэгдүгээр шалгалт өгөөгүй суралцагчид шүүхээс гадуур маргааныг эвлэрүүлэн зуучлах, шүүхийн маргаанд эрх зүйн зөвлөгөө өгөх, хязгаарлагдмал эрхтэйгээр шүүхэд төлөөлөх боломжийг нээсэн байна.⁶

Дээд сургуулиуд сүүлийн үед хэвлэл мэдээллийн болон эдийн засгийн эрх зүйн сургалтын чиглэлийг санал болгох болсон. Ийм сургалтаар дипломын хуульч *Dipl. jur* гэсэн зэрэг олгоно. Түүнчлэн үндсэн мэргэжил эзэмшихийн зэрэгцээ хоёр дахь мэргэжлээ эрх зүйгээр суралцахыг зарим их сургууль санал болгодог. Тухайлбал, философи, улс төр судлал, эдийн засгийн үндсэн мэргэжлээр суралцан, хоёр дахь мэргэжлээ эрх зүйчээр сонгон суралцаж хосолмол мэргэжлээр төгсөж болдог. Ийнхүү хосолмол сургалт буюу хоёр дахь мэргэжлээр эрх зүйн салбарыг сонгосон бол хуульчийн шалгалт өгөх эрх үүсэхгүй. Харин үндсэн мэргэжил нь эрх зүйгээр сурч төгссөн бол хуульчийн нэг ба хоёрдугаар шалгалт өгөх эрх үүснэ.

Бусад мэргэжлээр их дээд сургуульд суралцагсад мөн хууль зүйн агуулга ордог. Тухайлбал, түүхийн ангид эрх зүйн харьцуулсан түүх, ромын эрх зүй, хэл шинжлэлийн салбарт тухайн улсын эрх зүйн тогтолцоо болон соёл, анагаахын сургуульд эмчийн хариуцлага, эмнэл зүйн салбарт мансууруулах бодисын талаар зохицуулсан эрх зүй, архитекторын ангид барилгын эрх зүй, нийгмийн боловсролын салбарт гэр бүлийн эрх зүй, сургуулийн эрх зүй, гадаад иргэний эрх зүй, эдийн засгийн информатик мэргэжлийн салбарт мэдээллийг хамгаалах эрх зүй ордог байна. Тюрингэн, Бавари зэрэг зарим муж улсад өөр чиглэлийн мэргэжилд тухайлбал, сурган хүмүүжүүлэх чиглэлийн салбарт эрх зүйн агуулгыг нэмэлтээр оруулдаг. Мөн улс төр, нийгмийн ухаан, багш бэлтгэх сургалтын агуулгын 25 хувь нь эрх зүй байдаг байна.

⁶ <https://www.gesetze-im-internet.de/rdg/index.html>

Зургаа. ХИЧЭЭЛИЙН ХӨТӨЛБӨР, КРЕДИТ ЦАГ⁷

Энэ хэсэгт Германы хуульч бэлтгэдэг 45 их сургуулийн хууль зүйн факультетын хичээлийн хөтөлбөрийг тоймлон тайлбарлая.

6.1. СУУРЬ ХИЧЭЭЛИЙН ХӨТӨЛБӨР

Эхний хоёр семестрт гол салбар болох эрх зүйн хичээлийн суурийг заана. Үүнд иргэний эрхзүйн ерөнхий анги, үүргийн эрх зүй, үндсэн хуулийн эрх зүй, эрүүгийн эрх зүйн ерөнхий анги хамаарна. Ихэнх их сургууль эдгээр салбарыг дагалдуулж семинарын эсхүл дасгал хичээлийн цөөн бүлгээр суралцах сургалтыг заавал үзэх хичээл болгон оруулдаг бөгөөд энэ хичээлээр бодлого, тохиолдлыг шийдвэрлэх техник заадаг. Их сургуулийн зургаадугаар семестрийг хүртэл дагнасан эрх зүйгээр лекц ордог бөгөөд их сургуулиас хамааран ялгаатай байдаг хэдий ч үндсэндээ дараах салбар эрх зүйг нийтлэгээр бүх их сургуульд заадаг. Үүнд:

- Үүргийн эрх зүй;
- Эд юмсын эрх зүй;
- Гэр бүлийн болон өв залгамжлалын эрх зүй;
- Хөдөлмөрийн эрх зүй;
- Иргэний процессын эрх зүй;
- Худалдааны эрх зүй;
- Хувийн эрх зүйн хуулийн этгээдийн эрх зүй;
- Эрүүгийн эрх зүйн тусгай анги;
- Эрүүгийн процессын эрх зүй;

⁷ <http://www.europaeische-juristenausbildung.de/Laender/deutschland.htm>

- Захиргааны эрх зүйн ерөнхий анги;
- Барилгын эрх зүй;
- Цагдаагийн эрх зүй;
- Нутгийн удирдлагын эрх зүй;
- Захиргааны процессын эрх зүй;
- Европын эрх зүй;
- Олон улсын эрх зүй;
- Төрийн ерөнхий онол;
- Эрх зүйн философи;
- Эрх зүйн социологи;
- Эрх зүйн түүх.

Жишээлбэл, Мюнхен хотын Людвиг-Максимилианы их сургуулийн эрх зүйн суурь хичээл дараах агуулгатай.⁸ Үүнд:

- *Эрх зүйн философи*: юу зөв бэ, юуг зөв гэж үзэх ёстой вэ;
- *Эрх зүйн социологи*: эрх зүйн нийгэмд үзүүлэх бодит нөлөөлөл;
- *Эрх зүйн түүх*: анх үүссэн үеэс одоог хүртэл хамран, голчлон ромын болон германы эрх зүйг заана, *эрх зүйн техник* нь хууль зүйн техник, арга зүй;
- Суурь гурван эрх зүй болох иргэний эрх зүй (худалдааны, хувийн эрх зүйн хуулийн этгээдийн эрх зүй, хөдөлмөрийн эрх зүй);
- Эрүүгийн эрх зүй;
- Нийтийн эрх зүй (төрийн эрх зүй, захиргааны эрх зүй);
- Иргэний процессын эрх зүй, эрүүгийн процессын эрх зүй, үндсэн хуулийн ба захиргааны процессын эрх зүй хичээлийг заана.

⁸ https://www.jura.uni-muenchen.de/studium/studienberatung/beratung_hauptfach/studberatung_examen/infobroschuere_19.pdf

6.2. ГҮНЗГИЙРҮҮЛЭН МЭРГЭШҮҮЛЭХ ХӨТӨЛБӨР

Их сургуулийн долоо, наймдугаар семестрт (зарим их сургуулийн тав, зургаадугаар семестрт) сонгон мэргэших салбараар гүнзгийрүүлсэн сургалт зохион байгуулдаг. Энэхүү сонгон мэргэших салбар нь зорьсон мэргэжлээрээ ажиллахад мэргэшүүлэх чиг баримжааг эртнээс олгох, их сургууль өөрийн ялгарах онцлогийг бий болгож, өрсөлдөх чадвараа нэмэгдүүлэхэд чиглэдэг. Хууль зүйн сургалтын шинэчлэлийн явцад Шүүгчийн тухай хуулийн 5а заалтад зааснаар хууль зүйн сургуулийн оюутан зөвхөн хуулийн салбар эрх зүйгээр хязгаарлагдахгүй, бусад ур чадвар эзэмшсэн байх ёстой тул хэлэлцээр хийх менежмент, ярилцлага удирдах, уран илтгэх, маргааныг эвлэрүүлэх, эвлэрүүлэн зуучлах, мэдүүлэг авах, харилцааны ур чадвар зэрэг хичээл үздэг. Бакалаврын сургалтад 180 кредит цагийн хичээл үзэхээс 108 нь заавал үзэх, 72 нь сонгон суралцах (мэргэшүүлэх) хичээл байна.

Гүнзгийрүүлэн мэргэшүүлэх салбаруудыг дурдвал, Европын ба олон улсын эрх зүй, хөдөлмөрийн эрх зүй, Германы ба олон улсын эдийн засгийн эрх зүй, татварын эрх зүй, криминологи, гэр бүлийн ба өв залгамжлалын эрх зүй зэрэг болно. Жишээлбэл, Мюнхен хотын Людвиг-Максимилианы их сургуулийн эрх зүйн гүнзгийрүүлэн мэргэшүүлэх сургалт дараах чиглэлээр явдаг.⁹ Суурь сургалтын шалгалтыг амжилттай өгсний дараа гүнзгийрүүлэн мэргэшүүлэх сургалтад 10 чиглэлээс сонгох боломжтой (*Хүснэгт 1-ийг харна уу*).

⁹ https://www.jura.uni-muenchen.de/studium/studienberatung/beratung_hauptfach/studberatung_examen/infobroschuere_19.pdf

Хүснэгт 1. Гүнзгийрүүлэн мэргэшүүлэх сургалтын чиглэл

Мэргэшүүлэх чиглэл	Сэдэв
1 дүгээр мэргэшүүлэх чиглэл	Эрх зүйн үндэс
2 дугаар мэргэшүүлэх чиглэл	Эрүүгийн шударга ёс, эрүүгийн эрх зүй, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх
3 дугаар мэргэшүүлэх чиглэл	Өрсөлдөөний эрх зүй, оюуны өмч, хэвлэл мэдээллийн эрх зүй
4 дүгээр мэргэшүүлэх чиглэл	Аж ахуйн нэгжийн эрх зүй: хуулийн этгээдийн компанийн эрх зүй, хөрөнгийн зах зээлийн эрх зүй, дампуурлын эрх зүй
5 дугаар мэргэшүүлэх чиглэл	Аж ахуйн нэгжийн эрх зүй: хөдөлмөрийн эрх зүй, нийгмийн хамгааллын эрх зүй
6 дугаар мэргэшүүлэх чиглэл	Аж ахуйн нэгжийн эрх зүй: улс хоорондын, олон улсын, европын татварын эрх зүй
7 дугаар мэргэшүүлэх чиглэл	Олон улсын, европын, гадаад улсын хувийн болон процессын эрх зүй
8 дугаар мэргэшүүлэх чиглэл	Нийтийн эдийн засгийн эрх зүй, дэд бүтцийн эрх зүй
9 дүгээр мэргэшүүлэх чиглэл	Олон улсын болон европын нийтийн эрх зүй
10 дугаар мэргэшүүлэх чиглэл	Эмнэлгийн эрх зүй

Мэргэшүүлэх сургалт бүр заавал үзэх, гүнзгийрүүлэн заавал үзэх, нэмж үзэх хичээл гэсэн гурван төрлийн хичээлээс бүрддэг.

Долоо. ТӨГСӨЛТИЙН ШАЛГАЛТЫН БҮТЭЦ, АГУУЛГА, ҮНЭЛГЭЭ

7.1. ЯВЦЫН ШАЛГАЛТ

Герман Улсад уламжлал ёсоор бүх лекцийн төгсгөлд клаузур буюу бичгийн шалгалт авдаг байсан нь өөрчлөгдөж, үүний оронд дасгал ажлын хичээлийн гэрчилгээ шаардах болсон байна. Эхний семестрийн дараа анхан шатны дасгал ажлын хичээлд бүртгүүлж болно. Эрүүгийн, иргэний, нийтийн эрх зүйн дасгал ажлуудын хичээлийг дуусгасны дараа эдгээр салбар эрх зүйн ахисан шатны дасгал ажлын хичээлд оролцох боломжтой. Дасгал ажлын хичээлийг тэнцсэн үнэлгээтэй дуусгахын тулд эхлээд нэг бичгийн шалгалт, мөн нэг бие даалтын ажилд амжилттай тэнцэж байж дасгал ажлын хичээлийн гэрчилгээ авна. Сүүлийн жилүүдэд өрнөсөн шинэчлэлийн явцад зарим их сургууль энэхүү гэрчилгээг шаардахаа больж, үүний оронд бичгийн шалгалт буюу клаузурьг авсан хэвээр байна. Тухайлбал, Заарбрюкэн хотын их сургууль зургаадугаар семестр хүртэл бүх лекцээр бичгийн шалгалт өгсөн байх ёстой (нэг семестрт долоон лекц) бөгөөд тэнцээгүй шалгалтын хичээлийг дараагийн семестрт нөхөж үзэх ёстой болдог.

7.2. ТӨГСӨЛТИЙН ШАЛГАЛТ БУЮУ ХУУЛЬЧИЙН УЛСЫН НЭГДҮГЭЭР ШАЛГАЛТ

Их сургуулийн эрх зүйн сургалтын явцад үзсэн бүх салбар эрх зүйн агуулгыг их бага хэмжээгээр багтаасан, өргөн хүрээг хамарсан их сургуулийн төгсөлтийн шалгалт буюу нэгдүгээр улсын шалгалт өгнө. Муж улс бүрд харилцан адилгүй журамласан зохицуулалт үйлчилдэг. Нийтлэг зохицуулалт нь таван цаг үргэлжлэх бичгийн шалгалтыг иргэний, эрүүгийн, нийтийн эрх зүйн тохиолдлуудыг шийдэх байдлаар бичгээр өгдөг. Шлезвиг-Холштайн зэрэг зарим мужид эрх зүйн салбар бүрд нэг бичгийн шалгалт өгөх ёстой бол Берлинд нэг эрх зүйн салбарт

тухайлбал, иргэний эрх зүйгээр гурав, нийтийн, эрүүгийн эрх зүйгээр тус бүр хоёр бичгийн шалгалт өгөх ёстой.

Үүнээс гадна Нордрайн-Вестфален мужид сонгосон салбар эрх зүйн шалгалтыг амаар илтгэж танилцуулах маягаар өгөх ёстой байдаг бол Заарланд мужид сонгосон салбар хичээлийн хүрээнд хоёр хүртэлх бичгийн шалгалт өгдөг байна. Бичгийн шалгалтын тоо цөөхөн байдаг муж улсад улсын шалгалтын нэг хэсэг болгон бие даалтын ажил бичих ёстой. Улсын шалгалтын агуулга нь шүүх эрх мэдлийн хүрээний хууль хэрэглээ, хууль зүйн зөвлөгөө өгөх, захиргааны үйл ажиллагааны практикийг хамааруулна. Үүний зэрэгцээ гол шаардлагатай ур чадвар болох хэлэлцээр хийх чадвар, уран илтгэлийн, яриа, хэлэлцээр удирдах чадвар, маргааныг таслан шийдвэрлэх, зуучлах, мэдүүлэг авах болон харилцааны ур чадварыг шалгадаг. Мөн гадаад хэлний мэдлэгийг ч шалгаж болно.¹⁰

Өмнө дурдсан хуульчийн боловсролын шинэтгэлийн явцад 2003 оноос хойш оюутны өөрийн сонгосон гүнзгийрүүлэх хичээлийн салбараас улсын шалгалтад оруулдаг болсон байна. Улсын шалгалтын 70 хувь нь заавал үзэх ёстой салбар эрх зүй, 30 хувь нь их сургуулийн хэсэг буюу сонгон үзсэн, гүнзгийрүүлэн мэргэших салбар хичээлээс бүрдэнэ. Улсын шалгалтыг боловсрол олгогч байгууллага бус (их сургууль бус) хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас авдаг уламжлал хэвээр үргэлжилж байна.

Энэхүү шалгалтыг өгөхийн тулд суралцагч нь нэг жилийн турш уг шалгалтад бэлтгэх хэрэгтэй болдог бөгөөд энэ хугацаанд төлбөртэй давтлага (*Repitatorium*) авах нь түгээмэл ажээ. Их сургуульд суралцах явцдаа олон тооны шалгалт өгдөг хэдий ч их сургуулийн төгсөлтийн шалгалт өгсөн нийт суралцагчийн 15 орчим хувь нь л авах ёстой нийт 18 онооны тал хувийг буюу есөн оноо авч чаддаг ажээ. Шалгалт өгсөн суралцагчдын 30 орчим хувь шалгалтдаа тэнцдэггүй гэсэн статистик байдаг.

¹⁰ Бавари мужийн Хуульчийн боловсрол олгох, хуульчийн шалгалт авах журмын 2 дугаар зүйл, <https://www.justiz.bayern.de/landesjustizpruefungsamt/ausbildungs-pruefungsordnung/>

7.3. ЗЭРЭГ, ЦОЛ

Улсын нэгдүгээр шалгалт нь хуульч болох эхний хагас алхам учир уламжлалын дагуу ямар нэг зэрэг, цол өгч байгаагүй. Энэ нь шууд ажлын талбарт гарч буй хүмүүст нэлээд сөрөг үр дагавартай байсан. Ялангуяа гадаад улсад ажиллах хүмүүст энэ нь сөргөөр нөлөөлдөг байжээ. Тиймээс 1990 оноос хэд хэдэн муж улс хуульчийн нэгдүгээр шалгалтад амжилттай тэнцсэн хүмүүст цол олгож эхэлсэн байна. Их сургууль төгссөн хуульч (*jurist*), реферандар (*refendar*), дипломтой хуульч (*dipl.jur*) гэх мэт цол олгож эхэлжээ. Зарим муж улс хууль зүйн магистр (*Magister iuris (Mag. iur.)*), хууль зүйн бакалавр (*Bachelor of Laws (LL.B.)*) гэдэг ч цол өгдөг. Энэ нь муж улс бүрд харилцан адилгүй байдаг.

7.4. МЭРГЭЖЛИЙН ДАДЛАГА

Хуульчийн улсын хоёрдугаар шалгалтад бэлтгэх үе шатанд илүү процессын эрх зүйгээр практик дадлага олгохыг зорьдог. 1.5-2 жилийн хугацаанд шүүх, прокурор, захиргааны байгууллага, өмгөөлөгчийн алба зэрэг нэгж тус бүрд тойрон өртөөлж дадлага хийх ёстой бөгөөд эрүүгийн, иргэний, захиргааны гурван гол салбар эрх зүйгээс алба болгон дээр нэгийг нь тухайлан судалж хаах ёстой. Туршлагатай хуульч дадлага ажлыг төлөвлөгөөний дагуу ганцаарчлан удирддаг. Нэг муж улсын тогтолцоогоор жишээлэн тайлбарлая.¹¹

¹¹ Хууль зүйн үндэсний судалгааны хүрээлэн, Судалгааны тайлангийн эмхэтгэл 2014-2015 он, “Мэргэшсэн хуульч бэлтгэх тогтолцоо”, 2017, 668-670 дахь тал, <https://www.landesrecht.sachsen-anhalt.de/bsst/document/jlr-JAPVSTpG3>, §33-44.

Хүснэгт 2. Хуульчийн дадлага хийх чиглэл, байгууллага, суралцах ур чадвар

№	Дадлага хийх салбар эрх зүй	Хийх байгууллага	Хугацаа	Хийх ажил	Бэлтгэх илтгэл/ бичиг баримт	Дагалдах сургалт
1	Иргэний эрх зүйн дадлага	Анхан буюу давж заалдах шатны шүүх	4 сар	Шүүхийн шийдвэр, шүүгчийн захирамж, тогтоолын төсөл боловсруулах, ноглох баримт цуглуулах, сүүлийн хоёр сард шүүгчийн удирдлага дор сард хоёр удаа (нийт 4 удаа) шүүх хуралдаан удирдах.	Сард нэг цагийн хугацаанд бэлтгэж илтгэх нэг илтгэл, урт хугацааны бэлтгэл шаардах нэг илтгэл хэлэлцүүлнэ. Мөн эрх зүйн дөрвөн дүгнэлт боловсруулна.	3 долоо хоногийн 12 цагийн чиглүүлэх сургалт явуулна (7 хоногт 4 цаг, 1 цагийн хичээл 45 мин үргэлжилнэ). Шүүгч удирдан ажлын байран дээр зохион байгуулах бүлгийн таван цагийн сургалт байна.
2	Эрүүгийн эрх зүйн дадлага	Прокуро-рын байгууллага	4 сар	Яллах дүгнэлт, яллах тогтоол, хэрэг хэрэгсэхгүй болгох мөн хэргийг давж заалдах албан бичгийн төсөл боловсруулах, дадлагын удирдагчийн хяналт дор сэжигтэн,	Сард нэг цагийн хугацаанд бэлтгэж илтгэх нэг илтгэл, урт хугацааны бэлтгэл шаардах нэг илтгэл хэлэлцүүлнэ.	Хоёр долоо хоногийн 8 цагийн чиглүүлэх сургалт заана (7 хоногт 4 цаг, 1 цагийн хичээл 45 минут үргэлжилнэ).

Хүснэгт 2-ын үргэлжлэл

<p>гэргээс мэдүүлэг авах, шүүх хуралдаанд прокурорыг төлөөлөн оролцох.</p>	<p>Сард нэгээс доошгүй бичгийн ажил боловсруулна.</p>	<p>Прокуророос удирдан ажлын байран дээр бүлгээр зохион байгуулах сургалт долоо хоногийн 5, нийт 10 цаг байна.</p>
<p>3 Захиргааны эрх зүйн дадлага</p>	<p>Захиргааны байгууллага 4 сар</p>	<p>Бусад албан байгууллагагай амаар, бичгээр харилцах, бичиг баримт боловсруулах, үндэслэлтэй шийдвэр гаргах.</p>
<p>Хоёр долоо хоногийн 20 цагийн чиглүүлэх сургалт заана (7 хоногт 10 цаг, 1 цагийн хичээл 45 минут үргэлжилнэ).</p>	<p>Сард нэг цагийн хугацаанд бэлтгэж илтгэх нэг илтгэл, урт хугацааны бэлтгэл шаардах нэг илтгэл хэлэлцүүлнэ. Мөн эрх зүйн дөрвөн дүгнэлт бичиж, боловсруулна.</p>	<p>Прокуророос удирдан ажлын байран дээр бүлгээр зохион байгуулах сургалт долоо хоногийн 6, нийт 12 цаг байна.</p>

4	Салбар эрх зүй, өмгөөллийн үйл ажиллагаа	Өмгөөл- лийн товчоо	9 сар	Шүүхээс өмнө эрх зүйн маргааныг эвлэрүүлэн зуучилж шийдэх эсэх, шүүхийн шаганд хууль зүйн туслалцаа үзүүлэх, эрх зүйн туслалцаа хүсэгчид үндэслэл бүхий эрх зүйн зөвлөгөө өгөх, нэхэмжлэл бичих, нэхэмжлэлийн хариу тайлбар бичих, давж заалдах, хяналтын шатанд гомдол бичих, шүүхээс гадуур албан бичиг боловсруулах, өмгөөллийн ажлын дотоод бичиг хэрэг, зохион байгуулалттай танилцах.	Сард нэг цагийн хугацаанд бэлтгэж илтгэх нэг илтгэл, урт хугацааны бэлтгэл шаардах нэг илтгэл хэлэлцүүлнэ. Нэг илтгэл, эрх зүйн гурван дүгнэлт боловсруулж, бичнэ.	Нэг долоо хоногийн таван цагийн чиглүүлэх сургалт заана (7 хоногт 5 цаг, 1 цагийн хичээл 45 минут үргэлжилнэ). Өмгөөлөгч удирдан ажлын байран дээр бүлгээр зохион байгуулах, долоо хоногийн зургаан цагийн сургалт байна.
---	---	---------------------------	-------	--	---	--

5	Өөрөө сонгох (иргэн, эрүү, захиргаа, эдийн засаг, татвар, нийгмийн халамж, хөдөлмөр, европын эрх зүй зэргээр хийх дадлага байж болно).	Шпайер хотын захиргааны дээд сургуульд дадлага хийх боломжтой. Гадаад улсад энэ дадлагыг гүйцэтгэх боломжтой.	3 сар
---	---	---	-------

Дадлага хийх явцад бичгийн найман шалгалт өгнө. Дадлага хийж дууссаны дараа аман шалгалт өгнө. Энэхүү шалгалтын хүрээнд юуны түрүүнд баримт бичиг боловсруулж, илтгэнэ. Үүний дараа иргэний, эрүүгийн, захиргааны эрх зүй мөн өмгөөллийн товчооны дадлага гэсэн сэдвээр гүнзгийрүүлсэн ярилцлага зохион байгуулна.¹²

¹² <https://jurcase.com/rechtsreferendariat-sachsen-anhalt-leitfaden/>

Дадлагын ажил нь их сургуульд үзсэн онолын мэдлэгээ бататгах, практик ур чадвар олгоход чиглэдэг учир энэ хугацаанд шүүгч, прокурор, өмгөөлөгч, захиргааны байгууллагын төрийн албан хаагчийн гүйцэтгэх ажил үүрэгтэй холбоотой дадлага хийнэ. Дадлагын явцдаа тухайн хэргийг хууль зүйн талаас зөв тодорхойлон, тус хэрэгт холбогдох асуудлыг олон талаас нь дүгнэхэд суралцахаас гадна эрх зүйн агуулга төдийгүй уг асуудлын эдийн засаг, нийгэм дэх ач холбогдлыг үнэлэхэд суралцах ёстой. Хэрэг, маргаан, шийдвэрийн цаад учир шалтгааныг мэдэхэд хувийн болон нийгмийн олон талаас нарийвчлан судалж, дүн шинжилгээ хийх ур чадварт суралцана. Шүүх, прокурор, өмгөөллийн товчоонд тодорхой тооны бүлгээр дадлагажуулдаг бол захиргааны байгууллагад ганцаарчилсан байдлаар дадлагыг зохион байгуулдаг. Дадлагын туршид дасгал ажлын буюу ажлын байран дахь дагалдах сургалт зохион байгуулдаг.

Захиргааны байгууллагад хийх дадлагыг Шпайер хотын Захиргааны их сургууль дээр гурван сарын хугацаагаар эсхүл захиргааны хэргийн шүүхэд хоёр сарын хугацаагаар хийх боломжтой. Захиргааны шүүхийг сонгосон тохиолдолд үлдсэн нэг сарын хугацаанд захиргааны байгууллагыг сонгон дадлага хийнэ.

Өмгөөллийн товчоонд хийх дадлагын явцад дадлагын нийт хугацааны 17 дахь сараас дадлагажигч өөрийн хүсэлтээрээ нотариатын байгууллага, хувийн аж ахуйн нэгж, мэргэжлийн холбоо болон бусад сургалтын байгууллагад шилжин дадлага хийх боломжтой. Дадлагажигч бичгийн шалгалтуудаа амжилттай өгсөн тохиолдолд дадлагын нийт хугацааны 20 дахь сараас өөрийн хүсэлтээр гурав хүртэл сарын хугацаанд гадаад улсад дадлага хийх боломжтой.¹³

Хуульчийн дадлагыг муж улсын давж заалдах шатны шүүхийн ерөнхий шүүгч удирдах бөгөөд Хууль зүйн яамны эрх зүйн боловсрол хариуцсан нэгжийн зөвшөөрлөөр үндэслэл бүхий нөхцөл байгаа тохиолдолд энэхүү дадлагын үргэлжлэх хугацааг өөрчлөх, тав дахь өртөө буюу дадлагажигч өөрөө сонгох дадлагын албаны жагсаалтыг батлах, нэмэх, гадаад улсын дадлага хийх боломжтой байгууллага, албыг тодорхойлох зэрэг эрхтэй байдаг. Дадлагын хугацааны сургалтын төлөвлөгөө,

¹³ <https://www.landesrecht.sachsen-anhalt.de/bsst/document/jlr-JAPVSTpG3>, §17.

суралцах сэдэв, суралцах арга зүйг тухайн байгууллагын сургалт хариуцсан нэгжээс нэгтгэн боловсруулдаг.

Дадлагын өртөө тус бүрд бичгийн ажлыг сард нэгээс доошгүй удаа дадлагажигч боловсруулах бөгөөд сард нэг цагийн хугацаанд бэлтгэж илтгэх нэг илтгэл, урт хугацааны бэлтгэл шаардах нэг илтгэл хэлэлцүүлэх ёстой гэсэн шаардлага тавьдаг.

Дадлагын ажил үргэлжлэх хугацаанд зургаан сар тутамд муж улсын давж заалдах шатны сургалт хариуцсан нэгжийн дарга, муж улсын захиргааны байгууллагын сургалт хариуцсан нэгжийн дарга, мужийн прокурорын сургалт хариуцсан нэгжийн дарга, шүүхийн зөвлөлийн сургалт хариуцсан нэгжийн төлөөлөл, Хууль зүйн яамны эрх зүйн боловсрол хариуцсан нэгжийн төлөөлөл оролцсон уулзалт зохион байгуулна. Энэхүү уулзалтад дадлагажигчдын бүлгийн ахлагч (дундаасаа сонгосон нэг дадлагажигч төлөөлөн ярилцах, мэдээлэл дамжуулах үүрэгтэй) оролцоно. Дадлагын сургагч багш нар дадлагажигчдын гүйцэтгэлийг дүгнэж, сургалтын гэрчилгээг олгоно. Энэ гэрчилгээнд тухайн дадлагажигчийн дадлагын хугацаанд олж авсан ур чадвар, мэдлэг, сургалтын явцад үзүүлсэн амжилт, хувийн шинж чанарын талаар мэдээлэл хавсаргана.

Ихэнх муж улсад хуульчийн улсын хоёрдугаар шалгалтад бэлтгэх явц нь нийтийн эрх зүйн хүрээний хөдөлмөрийн харилцааны хэлбэрээр зохион байгуулагддаг. Зарим муж улсад дадлагыг төрийн хугацаатай алба хэмээн тооцож тодорхой хөлс өгдөг. Нийт 14 муж улсад энэхүү дадлага хийх харилцааг нийтийн албаны харилцаа гэж хүлээн зөвшөөрдөг бөгөөд амьжиргааг дэмжих хөлс олгодог. 2020 оны байдлаар Саксон Анхалт мужид 1,311 евро, Нордрейн-Вестфален мужид сарын 1,325.17 евро байв. Муж улс бүр харилцан адилгүй хөлс олгох бөгөөд үндсэн хөлс дээр нэмж гэр бүлийн нэмэгдэл олгодог байна.

7.5. ХУУЛЬЧИЙН УЛСЫН ХОЁРДУГААР ШАЛГАЛТ

Энэхүү шалгалтыг улсын том шалгалт, хуульчийн хоёрдугаар улсын шалгалт, ассессорын шалгалт гэх мэтээр нэрлэдэг. Хуульчийн улсын нэгдүгээр шалгалтыг амжилттай өгч тэнцсэн хуульч хоёрдугаар

шалгалтын хүрээнд олон тооны, өргөн хүрээтэй бичгийн шалгалт, мөн аман шалгалт өгч, нэг хэргийн илтгэл тавина. Энэ шалгалтыг хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас авдаг. Дадлага хийж дууссан хуульч бичгийн 7-11 (Заарланд-7, Бавари-11) шалгалт өгнө. Бичгийн шалгалт өгснөөс хойш дөрвөн сарын дараа аман шалгалт өгнө. Улсын хоёрдугаар шалгалт материаллаг эрх зүйгээс гадна процессын эрх зүйн хүрээг өргөнөөр хамрах ба хамгийн сүүлийн үеийн шүүхийн шийдвэр, үндэслэлд тулгуурладаг.

Улсын хоёрдугаар шалгалтад тэнцсэнээр хуульч нь шүүгч, төрийн захиргааны өндөр албан тушаал хаших ур чадвартайд тооцогдох бөгөөд өмгөөлөгч, прокурор, мөн төрийн бусад өндөр албан тушаал хаших, хуульчийн бусад мэргэжлийн ажил эрхлэх бүрэн боломжтой болно. Улсын хоёрдугаар шалгалтад тэнцсэн хуульчийг *assessor iuris (ass. iur.)* гэж нэрлэдэг. Ердийн өдөр тутмын хэллэгээр бол жинхэнэ хуульч (*volljurist*) гэж нэрлэдэг байна.

Муж улсуудын дунджаас авч үзэхэд нийт шалгуулагчаас 15 хувь нь л бүрэн хангалттай болон түүнээс дээш дүн авдаг бөгөөд нэг жилдээ хоёр шалгалтыг маш сайн буюу онц дүнтэй шалгуулагч 0,1 хувь, сайн дүнтэй шалгуулагч 2–3 хувь л байдаг байна. Бүрэн хангалттай үнэлгээ нь дунджаас дээгүүр үнэлгээ болно. Дунд буюу хангалттай үнэлгээ нь хуульчийн ур чадварын дундаж шаардлагыг хангасан гэсэн үг юм. Муж улсуудын дунджаар улсын нэгдүгээр шалгалтад тэнцээгүй шалгуулагч 32 орчим хувь, улсын хоёрдугаар шалгалтад тэнцээгүй шалгуулагч 18 орчим хувь байдаг байна.

Улсын хоёрдугаар шалгалтад амжилттай тэнцсэн төгсөгчид өмгөөлөгч, шүүгч, прокурор, нотариат, төрийн захиргааны дээд албан тушаалд ажиллах боломжтой. Ийм үнэлгээтэй төгсөгчид сонирхсон ажлын байрандаа өрсөлдөөнгүй орох боломж нээгдэнэ. Төрийн албан хаагчаар ажиллахын тулд дунджаас дээгүүр үнэлгээ авсан байх ёстой. Олон улсын хууль зүйн товчоонд ажиллахад ч мөн ийм дүнтэй байхыг шаарддаг тул шалгалтад тэнцсэн нийт хуульчийн цөөхөн хувь нь л ийм ажил хийх боломжтой байдаг ажээ. Нийт төгсөгчийн 75 хувь нь өмгөөлөгчөөр ажилладаг. Энэ нь үнэлгээний дүнгээс хамаарч шүүгч, прокурор, төрийн албан хаагч болох боломж хязгаарлагдмал байдагтай холбоотой.

Шалгалтдаа тэнцээгүй тохиолдолд дахин нэг удаа шалгалт өгөх боломжтой. Шалгалтад тэнцсэн хэдий ч авсан дүнгээ дээшлүүлэхийг хүсвэл төлбөртэй шалгалт өгөх боломжийг зарим муж улс олгодог. Улсын хоёрдугаар шалгалт өгч “*volljurist*” буюу жинхэнэ хуульч болохын тулд хамгийн багадаа долоон жилийн хугацаа зарцуулдаг.

7.6. ШАЛГАЛТ ДҮГНЭХ ОНОО

Хуульчийн хоёр шалгалтыг 18 оноогоор дүгнэнэ. Холбооны улсын хэмжээнд хуульчийн улсын нэг болон хоёрдугаар шалгалтыг үнэлэх нэгдсэн журам үйлчилнэ.¹⁴

- 16-18 оноо, маш сайн;
- 13-15 оноо, сайн;
- 10-12 оноо, бүрэн хангалттай;
- 7-9 оноо, хангалттай;
- 4-6 оноо, тэнцсэн;
- 1-3 оноо, бүрэн бус;
- 0 оноо, хангалтгүй.

7.7. УЛСЫН ШАЛГАЛТ ХАРИУЦСАН НЭГЖ

Улсын эхний шалгалтыг зарим мужийн давж заалдах шатны шүүх, зарим муж улсын хууль зүйн шалгалтын алба хариуцдаг. Шалгалтад шүүгч, прокурор, захиргааны хуульч зэрэг төрийн албанд ажиллаж буй хуульч, өмгөөлөгч болон профессор оролцоно. Улсын хоёрдугаар шалгалтыг муж улсын хууль зүйн шалгалтын алба хариуцах бөгөөд энэ алба нь муж улсын Хууль зүйн яаманд харьяалагддаг. Улсын хоёрдугаар шалгалтын шалгагчид нь шүүгч, прокурор, захиргааны албан хаагч, нотариатч, өмгөөлөгчөөс бүрдэнэ.

¹⁴ http://www.justiz.bayern.de/media/pdf/ljpa/japo/auszug_aus_der_vo_des_bmj.pdf

Найм. МАГАДЛАН ИТГЭМЖЛЭХ СТАНДАРТЫГ БАТЛАХ СУБЪЕКТ, ҮЙЛ ЯВЦ, ХУУЛИЙН СУРГУУЛИЙГ МАГАДЛАН ИТГЭМЖЛЭХ ЯВЦ¹⁵

“Герман Улсын дээд сургуульд заах хичээлийн хөтөлбөр, сургалтын чанарыг баталгаажуулах магадлан итгэмжлэлийг нэгдмэлээр зохион байгуулах муж улсуудын хоорондын 2017 оны 6 дугаар 12-ны өдрийн гэрээ”-г муж улсуудын Соёлын сайд нарын чуулганаар 2017 оны 12 дугаар сарын 7-ны өдөр, муж улсуудын Сайд нарын удирдлагын чуулганаар 2017 оны 6 угаар сарын 1-нд баталсан. Энэхүү гэрээнд Герман Улсын нийт 16 муж нэгдэн орсон ба 2018 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр үйлчилж байна. Уг гэрээний гол зорилго нь их, дээд сургуулийн сургалтын хөтөлбөр, чанарын баталгааг бүрдүүлэх эрх зүйн үндэслэлийг тодорхойлоход оршино. Энэ хүрээнд системийн (дээд сургуулийн чанарын дотоод баталгаа) болон хөтөлбөрийн (нэг бүрчилсэн сургалтын хөтөлбөр) магадлан итгэмжлэлийг хийхээс гадна бусад туршилтын нөхцөлийг магадлан итгэмжилдэг.

8.1. МАГАДЛАН ИТГЭМЖЛЭЛ ГҮЙЦЭТГЭХ АГЕНТ

Муж улсуудын хоорондын гэрээний 5.3.5 дахь заалтын дагуу магадлан итгэмжлэх зөвлөлөөс Герман Улсад магадлан итгэмжлэлийн үйл ажиллагаа явуулах агентад зөвшөөрөл олгодог. Энэхүү зөвшөөрөл олгох шийдвэрийг магадлан итгэмжлэх зөвлөлөөс гаргах бөгөөд сүүлийн шийдвэр 2018 оны 2 дугаар сарын 20-ны өдөр гарчээ. Энэхүү зөвшөөрөл нь цаашдаа Европын чанарын баталгааны бүртгэлд (*European Quality Assurance Register (EQAR)*) бүртгэлтэй агентад олгогдох боломжтой. Герман Улсад хууль тогтоомжийнхоо дагуу өмнө нь үйл ажиллагаа явуулж байсан магадлан итгэмжлэлийн агентад зориулан шилжилтийн

¹⁵ <https://www.akkreditierungsrat.de/index.php/de/faq/tag/art-16-stakkstv>

зохицуулалтыг баталсан.¹⁶ Одоогоор зөвшөөрөл авсан 11 агент үйл ажиллагаа явуулж байна.¹⁷

8.2. ХӨТӨЛБӨРИЙН МАГАДЛАН ИТГЭМЖЛЭЛ

Муж улсаас баталгаажуулсан их, дээд сургуулийн бакалавр, магистрын сургалтын хөтөлбөрийг магадлан итгэмжилдэг. Магадлан итгэмжлэлийн үйл явц нь хэд хэдэн үе шаттай ба хөндлөнгийн үнэлгээнд тулгуурлах зарчим баримтална. Эхний үе шат буюу үнэлэх үе шатанд их, дээд сургуулийн үнэлгээ хийлгэх ажлыг магадлан итгэмжлэх зөвшөөрөлтэй бие даасан агентад даалгана. Энэхүү агент нь мэргэжлийн агуулгын чиглэл болон сургалтын хөтөлбөрийн онцлогийн талаар мэдлэг, туршлага бүхий хүмүүсээс бүрдсэн ажлын хэсэг байгуулна. Үнэлгээний ажлын хэсэгт их дээд сургуулийн мэргэжлийн салбарын хоёр багш, энэ салбарын мэргэжлийн нэг төлөөлөл, ойролцоо салбарын мэргэжлээр суралцдаг нэг оюутныг оруулах ёстой.

Муж улсуудын хоорондын гэрээний дөрөвдүгээр зүйлийг үндэслэн 2017 оны 12 дугаар сарын 7-ны өдрийн муж улсуудын соёлын сайд нарын чуулганаар баталсан жишиг дүрмээр сургалтын хөтөлбөр, чанарын болон бусад магадлан итгэмжлэлийн эрх зүйн харилцааг зохицуулдаг.¹⁸ Энэхүү жишиг дүрмийн дагуу сургалтын хөтөлбөр магадлан итгэмжлүүлэх тохиолдолд 20 хүртэл хуудас бүхий тайланг их, дээд сургууль бэлтгэж магадлан итгэмжлэх агентад хүргүүлнэ. Агентаас энэ дүрэмд заасан шалгуурын дагуу магадлан итгэмжлэх шаардлага хангаж буй эсэхийг дүгнэн хянаад уг тайланг үнэлгээний ажлын хэсэгт шилжүүлнэ. Үнэлгээний ажлын хэсгээс тайлантай танилцаж, дүн шинжилгээ хийх бөгөөд их, дээд сургуулийн төлөөлөлтэй ярилцлага зохион байгуулна. Эцэст нь сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн шийдвэрийн зөвлөмжийн талаар дүгнэлт бэлтгэнэ.

¹⁶ <https://www.akkreditierungsrat.de/index.php/de/akkreditierungssystem/agenturen/agenturen>

¹⁷ <https://www.akkreditierungsrat.de/de/akkreditierungssystem/agenturen/agenturen>

¹⁸ <https://www.akkreditierungsrat.de/sites/default/files/downloads/2019/Musterrechtsverordnung.pdf>

Магадлан итгэмжлэх зөвлөлөөс тухайн их, дээд сургуулийн сургалтын хөтөлбөрийг магадлан итгэмжлэх эсэх шийдвэрээ агентын хяналт шалгалтын тайлан, үнэлгээний ажлын хэсгийн дүгнэлтэд үндэслэн гаргана. Хэрэв магадлан итгэмжлэх зөвлөл үнэлгээний ажлын хэсгийн дүгнэлтээс ихээхэн зөрүүтэй шийдвэр гаргахаар байвал шийдвэр гаргахаасаа өмнө тухайн их, дээд сургуулийн байр суурийг сонсох учиртай. Магадлан итгэмжлэх ажиллагаа дууссаны дараа гарсан шийдвэрийг үнэлгээ хийсэн бүрэлдэхүүний нэрсийн хамт цахим хуудсандаа нийтэлнэ. Сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэл найман жилийн хугацаанд хүчинтэй. Нэг сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн хураамж 350 евро байна.

Магадлан итгэмжлэх зөвлөл эцсийн шийдвэрээ захиргааны акт хэлбэрээр гаргана. “Сургалтын хөтөлбөрийг магадлан итгэмжлэхгүй” гэсэн шийдвэр гарсан тохиолдолд тухайн их, дээд сургууль уг шийдвэрийг хүлээн зөвшөөрөхгүй бол захиргааны шүүхэд хандаж шийдвэрлүүлэх боломжтой.

8.3. ЧАНАРЫН МАГАДЛАН ИТГЭМЖЛЭЛ

Системийн буюу чанарын магадлан итгэмжлэлээр их, дээд сургуулийн чанарын тогтолцоог магадлан итгэмжилдэг. Эдгээр магадлан итгэмжлэх үйл явц нь хэд хэдэн үе шаттай байх бөгөөд мөн хөндлөнгийн үнэлгээнд тулгуурлах зарчим баримтална. Эхний үе шат буюу үнэлэх үе шатанд их, дээд сургуулийн үнэлгээ хийлгэх ажлыг магадлан итгэмжлэх зөвшөөрөлтэй бие даасан агентад даалгана. Энэхүү агент нь мэргэжлийн агуулгын чиглэл, сургалтын хөтөлбөрийн онцлогийн талаар мэдлэг, туршлага бүхий хүмүүсээс бүрдсэн ажлын хэсэг байгуулна. Үнэлгээний ажлын хэсэгт их дээд сургуулийн мэргэжлийн салбарын гурван багш, энэ салбарын нэг төлөөлөл, нэг оюутныг оруулах ёстой.

Муж улсуудын хоорондын гэрээний дөрөвдүгээр зүйлийг үндэслэн 2017 оны 12 дугаар сарын 7-ны өдөр муж улсуудын Соёлын сайд нарын чуулганаар баталсан жишиг дүрмийн дагуу чанарын магадлан итгэмжлэлийг явуулах ба их, дээд сургууль 50 хүртэл хуудас бүхий тайланг бэлтгэж магадлан итгэмжлэх агентад хүргүүлнэ. Агентаас энэ

дүрэмд заасан шалгуурын дагуу магадлан итгэмжлэх шаардлага хангаж буй эсэхийг дүгнэн хянаад 100 хүртэл хуудастай тайланг бэлтгэнэ. Үнэлгээний ажлын хэсэг уг тайлантай танилцаж, түүнд дүн шинжилгээ хийх бөгөөд их, дээд сургуулийн төлөөлөлтэй ярилцлага зохион байгуулна.

Сургалтын явц, чанарын талаар зарим сургалтын хөтөлбөрийг түүвэрлэн ажиглалт хийнэ. Эцэст нь сургуулийн дотоод чанарын магадлан итгэмжлэлийн шийдвэрийн зөвлөмжийн талаар дүгнэлт бэлтгэнэ.

Магадлан итгэмжлэх зөвлөл их, дээд сургуулийн чанарын тогтолцоог магадлан итгэмжлэх эсэхээ агентын хяналт шалгалтын тайлан, үнэлгээний ажлын хэсгийн дүгнэлтэд үндэслэн шийдвэрлэнэ. Хэрэв магадлан итгэмжлэх зөвлөл үнэлгээний ажлын хэсгийн дүгнэлтээс ихээхэн зөрүүтэй шийдвэр гаргахаар бол шийдвэр гаргахын өмнө их, дээд сургуулийн байр суурийг сонсох учиртай. Магадлан итгэмжлэх ажиллагаа дууссаны дараа шийдвэрийг үнэлгээ хийсэн бүрэлдэхүүний нэрсийн хамт цахим хуудсандаа нийтэлнэ. Сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэл найман жилийн хугацаанд хүчинтэй. Сургуулийн чанарын магадлан итгэмжлэл 3500 евро байна.

Магадлан итгэмжлэх зөвлөл эцсийн шийдвэрээ захиргааны акт хэлбэрээр гаргана. “Сургуулийн чанарын баталгааг магадлан итгэмжлэхгүй” гэсэн шийдвэр гарсан тохиолдолд тухайн их, дээд сургууль уг шийдвэрийг хүлээн зөвшөөрөхгүй бол захиргааны шүүхэд хандаж шийдвэрлүүлэх боломжтой.

8.4. ИХ ДЭЭД СУРГУУЛИЙН БАГШ НАРААС МАГАДЛАН ИТГЭМЖЛЭХ АЖЛЫН ХЭСЭГТ СОНГОН ШАЛГАРУУЛАХ УДИРДАМЖ

Дээр дурдсан муж улсуудын хоорондын гэрээний 3.3 дахь заалтыг үндэслэн Дээд сургуулиудын захирлын чуулганаар магадлан итгэмжлэх ажлын хэсэгт их, дээд сургуулийн багш нарыг сонгох үйл ажиллагааны удирдамжийг батлан гаргасан ба тэрхүү удирдамжаар сонгон шалгаруулах харилцааг зохицуулна. 2018 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн 24 дэх удаагийн уулзалтаар энэхүү удирдамжийг

баталгаажуулсан байна.¹⁹ Тус удирдамжийн дагуу их, дээд сургууль нь мэргэжлийн салбарыг харгалзан сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэх ажлын хэсэгт орох багшийн нэрийг санал болгох бөгөөд нэр дэвшүүлсэн багш нараас агент ажлын хэсгийн бүрэлдэхүүнд санал болгоно.

Их, дээд сургууль нэр дэвшүүлсэн багшийнхаа талаар татгалзах ямар нэг үндэслэл байгаа эсэхийг мэдээлэх бөгөөд агент энэ татгалзахуйц үндэслэлийг нягталж үзсэний үндсэн дээр бүрэлдэхүүнийг товлож, ажлын хэсэг байгуулна. Энэхүү ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг сонгох эцсийн шийдвэрийг агент (бүтцийн дотоод зөвлөл) гаргадаг тул мөн агент тухайн ажлын хэсгийн шинжлэх ухаанч, бүрэн, чанартай ажлын гүйцэтгэлийг хариуцдаг. Шинжлэх ухааны салбарыг төлөөлж буй тул их, дээд сургуулийн багш нь салбарын шинжлэх ухааны сургалтын хөтөлбөрийг үнэлэх чадамжтай байх ёстой. Тиймээс их, дээд сургуулийн багшийг магадлан итгэмжлэх ажлын хэсэгт сонгохдоо дараах шалгуур тавьдаг. Үүнд:

1. Магадлан итгэмжлэх сургалтын хөтөлбөрийн чиглэлээр шинжээч байж чадах, мэргэшсэн, их, дээд сургуульд багшилж байгаа, эрдэм шинжилгээ, судалгаа идэвхтэй явуулдаг;
2. Сургалтын хөтөлбөрийн хөгжил, зохион байгуулалт, хэрэгжилт, мониторингийн талаар туршлагатай;
3. Их дээд сургуулийн сургалтын үйл ажиллагааг хөгжүүлэх ажилд идэвхтэй оролцдог;
4. Өөрийн сургалтын салбарт нөлөөллийн ажил хийдэг, салбарын хөгжлийг дэмждэг болохоо батлан харуулсан;
5. Сургалтын хөтөлбөр санал болгож буй их дээд сургуулийн салбарын бүтэц, онцлогийг мэддэг байх;
6. Өмнө магадлан итгэмжлэх үйл ажиллагаанд оролцож байсан бол давуу тал байж болно;

¹⁹ https://www.akkreditierungsrat.de/sites/default/files/downloads/2019/HRK_Gutachter_VerabschiedetesVerfahrenzurBennungvonGutachternausderWissenschaft.pdf

7. Мэргэжлийн салбарыг төлөөлөхүйц хүлээн зөвшөөрөгдсөн;
8. Олон төлөөлөлт байдлыг хангаж чадахуйц буюу нас хүйс, бүс нутаг, олон улсын төлөөлөл гэх мэт байдлыг хангасан.

Чанарын магадлан итгэмжлэлийн ажлын хэсгийг сонгох үе шат хөтөлбөрийн магадлан итгэмжлэх явцтай адил. Харин чанарын магадлан итгэмжлэх ажлын хэсэгт оруулах их, дээд сургуулийн багшид дараах шалгуурыг тавьдаг ажээ. Үүнд:

1. Их сургууль удирдах, их дээд сургуулийн дотоод зохион байгуулалт, чанарын баталгааг хангах талаар ажлын туршлагатай;
2. Сургалтын хөтөлбөрийн хөгжил, зохион байгуулалт, хэрэгжилт, мониторингийн талаар туршлагатай;
3. Өмнө магадлан итгэмжлэх үйл ажиллагаанд оролцож байсан бол давуу тал байж болно;
4. Тухайн сургуулийн онцлогийг мэддэг байх;
5. Мэргэжлийн салбарыг төлөөлөхүйц хүлээн зөвшөөрөгдсөн;
6. Олон төлөөлөлт байдлыг хангаж чадахуйц буюу нас хүйс, бүс нутаг, олон улсын төлөөлөл гэх мэт байдлыг хангасан.

8.5. МАГАДЛАН ИТГЭМЖЛЭХ ЗӨВЛӨЛ, ТҮҮНИЙ БҮРЭЛДЭХҮҮН

Магадлан итгэмжлэлийн сан нь муж улсуудын дундын байгууллага бөгөөд захиргааны чиг үүрэг хэрэгжүүлдэг Захиргааны процессын хуульд заасан захиргааны байгууллага юм. Үйл ажиллагаа явуулах эрх зүйн үндэс нь Зохицуулалтын жишиг журам, Магадлан итгэмжлэлийн талаарх муж улсуудын хоорондын гэрээ юм. Магадлан итгэмжлэх зөвлөлийн сангийн дотоод нэгжүүдийг дурдвал, магадлан итгэмжлэх бүх үйл явцыг хариуцах чиг үүрэгтэй Магадлан итгэмжлэх зөвлөл, шийдвэр гаргах чиг үүрэгтэй Удирдах зөвлөл, эрх зүйн үндэслэл, эдийн засгийн тооцоог хянах чиг үүрэгтэй Сангийн зөвлөлөөс бүрдэнэ. Энэхүү сангийн санхүүжилт нь муж улсын хандив, төлбөр хураамжаас бүрдэнэ.

Холбогдох хуульд зааснаар (Магадлан итгэмжлэх зөвлөлийн сангийн тухай хууль, 7 дугаар зүйл)²⁰ магадлан итгэмжлэх зөвлөл дараах бүрэлдэхүүнтэй байна. Үүнд:

- Их, дээд сургуулийн найман багш (үүнээс дөрөв нь хүмүүнлэг, нийгэм, байгалийн, инженерийн шинжлэх ухааны төлөөлөл байх): их, дээд сургуулийн багш нарыг тухайн сургуулийн Захирлын зөвлөлийн хурлын санал болгосноор муж улсын Соёлын сайд нарын чуулганаар баталдаг. Тиймээс их, дээд сургуулийн захирлын зөвлөлийн хурал нь багш нарыг санал болгохдоо янз бүрийн их, дээд сургууль төдийгүй олон төрлийн мэргэжлийн төлөөллийг илэрхийлж чадахуйц байдлыг харгалздаг;
- Их, дээд сургуулийн захирлын зөвлөлийн нэг төлөөлөл: Их дээд сургуулийн захирлуудын чуулганаас;
- Холбооны улсын дөрвөн төлөөлөл: Соёлын сайд нарын чуулганаас;
- Мэргэжилтний таван төлөөлөл (үүнээс нэг нь хөдөлмөр, хамтын гэрээний харилцаа хариуцдаг муж улсын яамны төлөөлөл байх): хөдөлмөр, хамтын гэрээний салбарын төлөөллийг муж улсуудын дотоод хэргийн сайд нар, ажлын албанд танилцуулснаар Соёлын сайд нарын чуулганаас, бусад мэргэжилтнийг Соёлын сайд нарын чуулган ба их дээд сургуулиудын захирлын зөвлөл хамтдаа;
- Оюутны хоёр төлөөлөл: Их дээд сургуулийн захирлуудын чуулганаас;
- Магадлан итгэмжлэх туршлага бүхий гадаад улсын хоёр төлөөлөл: Соёлын сайд нарын чуулган ба их дээд сургуулиудын захирлын зөвлөл хамтдаа;
- Саналын бус зөвлөх эрхтэй үнэлгээний агентын нэг төлөөлөл: төлөөллийг магадлан итгэмжлэлийн зөвлөл үнэлгээний зөвшөөрөл бүхий агентын төлөөллөөс сонгоно.

²⁰ https://recht.nrw.de/lmi/owa/br_bes_text?anw_nr=2&gld_nr=2&ugl_nr=221&bes_id=6928&aufgehoben=N&menu=1&sg=

Магадлан итгэмжлэх зөвлөлийн ажиллах хугацаа дөрвөн жил байна. Зөвлөлийн гишүүд дундаасаа их, дээд сургуулийн багш нар, их дээд сургуулийн захирлын зөвлөлийн төлөөлөл эсхүл холбооны улсын дөрвөн төлөөллөөс зөвлөлийн дарга ба орлогчийг дөрвөн жилийн хугацаагаар сонгоно. Зөвлөлийн дарга ба орлогч нь нэг чиглэлийн төлөөлөл байж болохгүй өөрөөр хэлбэл, дарга нь их сургуулийн багш сонгогдсон бол орлогч нь холбооны улсын төлөөлөл ч юм уу өөр чиглэлийн хүн байх ёстой.

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

А. Илтгэл, судалгааны тайлан:

1. Б.Тэмүүлэн, Б.Буянхишиг, “ХБНГУ-ын эрх зүйн боловсролын тогтолцоо, Олон улсын хурлын илтгэлийн эмхэтгэл”, 2013, 77 дахь тал, http://buyana2013.blogspot.com/2013/08/blog-post_16.html#more, сүүлд үзсэн огноо 2021.08.15.
2. Хууль зүйн үндэсний судалгааны хүрээлэн, Судалгааны тайлангийн эмхэтгэл 2014-2015 он, “Мэргэшсэн хуульч бэлтгэх тогтолцоо”, 2017, 668-670 дахь тал.

Цахим эх сурвалж:

<https://www.gesetze-im-internet.de/drig/5.html>

<https://www.gesetze-im-internet.de/rdg/index.html>

http://www.justiz.bayern.de/media/pdf/ljpa/japo/japo_ab_1_1_2015.pdf

https://www.justiz.nrw.de/JM/jumiko/beschluesse/2011/fruehjahrskonferenz11/I_1.pdf

www.aplus.mn

https://www.jura.uni-muenchen.de/info_erstsemester/studienablauf/index.html

https://www.jura.uni-muenchen.de/studium/studienberatung/beratung_hauptfach/studberatung_examen/infobroschuere_19.pdf

<http://www.europaeische-juristenausbildung.de/Laender/deutschland.htm>

<https://www.justiz.bayern.de/landesjustizpruefungsamt/ausbildungspruefungsordnung/>

https://www.bundesjustizamt.de/DE/SharedDocs/Publikationen/Justizstatistik/Juristenausbildung_2018.pdf;jsessionid=15810D076015416D65A5FB4F9F987A9F.2_cid503?__blob=publicationFile&v=2

http://www.justiz.bayern.de/media/pdf/ljpa/japo/auszug_aus_der_vo_des_bmj.pdf

<https://www.akkreditierungsrat.de/index.php/de/faq/tag/art-16-stakkstv>

https://www.jura.uni-muenchen.de/info_erstsemester/studienablauf/index.html

https://backend.deqar.eu/reports/ZEvA/20190826_1547_berlin_hu_rewi_gutachten_evalag_170222_final.pdf

https://de.wikipedia.org/wiki/Juristenausbildung_in_Deutschland#cite_note-14

<https://www.spiegel.de/lebenundlernen/uni/jurastudium-voraussetzungen-dauer-und-aussichten-nach-dem-examen-a-1136207.html>

https://www.bundesjustizamt.de/DE/Themen/Buergerdienste/Justizstatistik/Juristen/Ausbildung_node.html

<https://www.landesrecht.sachsen-anhalt.de/bsst/document/jlr-JAPVSTpG3>

https://recht.nrw.de/lmi/owa/br_bes_text?anw_nr=2&gld_nr=2&ugl_nr=221&bes_id=6928&aufgehoben=N&menu=1&sg=

Хавсралт. Хуульчийн улсын нэг, хоёрдугаар шалгалтын хэлбэр, үнэлгээ²¹

№	Муж улс	Улсын нэгдүгээр шалгалтын хэлбэр	Үнэлгээний хувь	Улсын хоёрдугаар шалгалтын хэлбэр	Үнэлгээний хувь
1	Баден-Вюртемберг <i>Baden-Württemberg</i>	Бичгийн зургаан шалгалт аман шалгалт	70% 30%	Бичгийн найман шалгалт аман шалгалт: баримт бичиг танилцуулах, шалгалтын ярилцлага	70% 30% 6% 24%
2	Бавари <i>Bayern</i>	Бичгийн зургаан шалгалт аман шалгалт	75% 25%	Бичгийн 11 шалгалт аман шалгалт	75% 25%
3	Берлин <i>Berlin</i>	Бичгийн долоон шалгалт аман шалгалт: баримт бичиг танилцуулах, шалгалтын ярилцлага	63% 37% 13% 24%	Бичгийн долоон шалгалт аман шалгалт: баримт бичиг танилцуулах, шалгалтын ярилцлага	60% 40% 16% 24%

²¹ https://www.bundesjustizamt.de/DE/SharedDocs/Publikationen/Justizstatistik/Juristenausbildung_2018.pdf;jsessionid=15810D076015416D65A5FB4F9F987A9F.2_cid503?__blob=publicationFile&v=2

4	Бранденбург <i>Brandenburg</i>	Бичгийн долоон шалгалт аман шалгалт: баримт бичиг танилцуулах, шалгалтын ярилцлага	63% 37% 13% 24%	Бичгийн долоон шалгалт аман шалгалт: баримт бичиг танилцуулах, шалгалтын ярилцлага	60% 40% 16% 24%
5	Бремен <i>Bremen</i>	Бичгийн зургаан шалгалт аман шалгалт	2/3 1/3	Бичгийн найман шалгалт аман шалгалт: баримт бичиг танилцуулах, шалгалтын ярилцлага	70% 30% 8% 22%
6	Доод Саксон <i>Niedersachsen</i>	Бичгийн зургаан шалгалт аман шалгалт	64% 36%	Бичгийн найман шалгалт аман шалгалт: баримт бичиг танилцуулах, шалгалтын ярилцлага	60% 40% 12% 28%
7	Заарланд <i>Saarland</i>	Бичгийн зургаан шалгалт аман шалгалт	70.59% 29.41%	Бичгийн долоон шалгалт аман шалгалт: баримт бичиг танилцуулах, шалгалтын ярилцлага	70% 30% 10% 20%

8	Мекленбург-Өрнө Померан <i>Mecklenburg-Vorpommern</i>	Бичгийн зургаан шалгалт аман шалгалт	2/3 1/3	Бичгийн найман шалгалт аман шалгалт: баримт бичиг танилцуулах, шалгалтын ярилцлага	2/3 1/3 1/6 5/6
9	Райнланд-Пфальц <i>Rheinland-Pfalz</i>	Бичгийн зургаан шалгалт аман шалгалт	2/3 1/3	Бичгийн найман шалгалт аман шалгалт: баримт бичиг танилцуулах, шалгалтын ярилцлага	70% 30% 6% 24%
10	Саксон <i>Sachsen</i>	Бичгийн зургаан шалгалт аман шалгалт	2/3 1/3	Бичгийн найман шалгалт аман шалгалт: баримт бичиг танилцуулах, шалгалтын ярилцлага	66.66 33.33 6.66 26.66
11	Саксон-Анхальт <i>Sachsen-Anhalt</i>	Бичгийн зургаан шалгалт аман шалгалт	60% 40%	Бичгийн найман шалгалт аман шалгалт: баримт бичиг танилцуулах, шалгалтын ярилцлага	60% 40% 10 30
12	Тюрингэн <i>Thüringen</i>	Бичгийн зургаан шалгалт аман шалгалт	65% 35%	Бичгийн найман шалгалт аман шалгалт: баримт бичиг танилцуулах, шалгалтын ярилцлага	65% 35% 7% 28%

13	Умард Райн-Вестфален <i>Nordrhein-Westfalen</i>	Бичгийн зургаан шалгалт Аман шалгалт Илтгэл тавих	60% 30% 10%	Бичгийн найман шалгалт аман шалгалт: баримт бичиг танилцуулах, шалгалтын ярилцлага	60% 40% 10% 30%
14	Хамбург <i>Hamburg</i>	Бичгийн зургаан шалгалт 10 минут илттэл тавих, шалгалтын асуулт	75% 25%	Бичгийн найман шалгалт аман шалгалт: баримт бичиг танилцуулах, шалгалтын ярилцлага	70% 30% 8% 22%
15	Хессен <i>Hessen</i>	Бичгийн зургаан шалгалт аман шалгалт	2/3 1/3	Бичгийн найман шалгалт аман шалгалт: баримт бичиг танилцуулах, шалгалтын ярилцлага	60% 40% 10% 30%
16	Шлесвиг-Хольштайн <i>Schleswig-Holstein</i>	Бичгийн зургаан шалгалт аман шалгалт	2/3 1/3	Бичгийн найман шалгалт аман шалгалт: баримт бичиг танилцуулах, шалгалтын ярилцлага	70% 30% 8% 22%

